

ЖОН БИВЭР

“USA TODAY”-ИЙН БЕСТСЕЛЛЕР ЗОХИОЛЧ



**БУРХАНААС ХҮЛЭЭЖ АВСАН
ХҮЧИН ЧАДЛАА ҮРЖҮҮЛ**

Эрхэм найз минь

Хүн бүр их хэргийн төлөө Есүс Христ дотор бүтээгдсэн, Бурханы их гарын бүтээл мөн. Та Бурханы хүүхэд байхаар нигүүлслийн үнэ төлбөргүй бэлгээр дахин төрсөн бөгөөд ялгаагүй тэр л нигүүлсэл таныг аливаа нэгэн зорилгын төлөө хүчирхэгжүүлсэн билээ. Тэгвэл тэрхүү зорилгыг биелүүлэхэд чинь Бурхан танд ямар гээчийн хүчин чадалтай бэлэг, чадвар хайрласныг та мэдэх үү?

Бэлэг авьяас, бэлэг, чадвар нь таны өөрийн төлөө бус, харин танаар дамжин бусдад хүртээгдэхийн төлөө өгөгддөг учиртай. Бурханы бусдад түгээхийг хүссэн зүйлийг та дотроо тээж явна. Хүн бүр "бусдын тусын тулд, Хаанчлалыг өргөжүүлэн тэлэхийн төлөө" гэсэн шийдлээр өөрт өгөгдсөн бэлгээ таньж, итгэмжтэйгээр "юм болгох" ёстой.

Бэлгээ мэдэж, түүнийхээ дагуу ажилладаг хүн юутай ерөөлтэй. Хүний бэлгээр ажиллах гэж оролддог хүн бөөн сэтгэлийн зовлон, бөөн дарамт. Бид нэг гартаа итгэмжтэй чанар, нөгөө гартаа Бурханы нигүүлслээр жигүүрлэн, Түүний тосолгоо дор явбал, энэ аялал маань зөрчил тэмцэлтэй бус, амар тайван аялал байна.


Та Бурханы нигүүлсэл, тосолгоо хоёроор хүчирхэгжсэн, бэлэгтэй хүн. Одоо шийдэмгий зангаараа өөртөө ташуур өгөөд, Бурханы төлөө аугаа үйлсийг бүтээ.

Би тантай мөр зэрэгцэн алхаж явна.



Жон Бивэр.

JohnBevere@ymail.com



MessengerX.com



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org



ЖОН БИВЭР

“USA TODAY”-ИЙН БЕСТСЕЛЛЕР ЗОХИОЛЧ



**БУРХАНААС ХҮЛЭЭЖ АВСАН
ХҮЧИН ЧАДЛАА ҮРЖҮҮЛ**

X: Multiply Your God-Given Potential, (Mongolian), by John P. Bevere

© 2021 Messenger International

MessengerInternational.org

Originally published in English as *X: Multiply Your God-Given Potential*

ISBN 978-1-937558-25-3 (hardcover edition)

ISBN 978-1-937558-24-6 (electronic edition)

Additional resources in Mongolian are available for free download and video streaming at **MessengerX.com** and on the **MessengerX app**

To contact the author : JohnBevere@ymail.com

This book is a gift from Messenger International and is NOT FOR SALE

Printed in Mongolia

X: Бурханаас хүлээж авсан хүчин чадлаа үржүүл (Монгол) Жон Бивэр

© 2021 Мессенжер Интернэйшнэл

MessengerInternational.org

Номын англи нэр: *X: Multiply Your God-Given Potential*

ISBN 978-1-937558-25-3 (цаасан ном)

ISBN 978-1-937558-24-6 (цахим ном)

Монгол хэл дээрх бусад хэрэгтэй материалаа **MessengerX.com** болон **MessengerX app**-аас шууд үзэх эсвэл утсандаа татаж авах боломжтой.

Зохиолчтой холбогдох имэйл: JohnBevere@ymail.com

Энэхүү ном нь Мессенжер Интернэйшнэл байгууллагаас Монголчуудад өгч буй бэлэг юм.

Тиймд ХУДАЛДАХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.

Монгол улсад хэвлэв.



App Store is a trademark of Apple Inc., registered in the U.S. and other countries.

Google Play and the Google Play logo are trademarks of Google LLC.

Бахархалт бэрүүддээ зориулав.

Лиза, бид хоёр та гуравтаа маш их хайртай. Бэрүүдээ магтаад
барахгүй болохоор, ганц нэгхэн чанарыг нь л сайшаахаас:

Жулиана:

Миний ууган хүү Аддисонтой
2009 оны 10-аар сарын 25-нд гэрлэсэн.

Чи - мөнхөд миний анхны бэр байх хайр татмаар, ухаалаг бэр.

Жессика:

Аустинтай 2018 оны 9-ээр сарын 24-нд гэрлэсэн.

Чи - явсан газраа баяр хөөр авчирдаг, эелдэг, хайр булаам бэр.

Кристиан:

Ардентай 2018 оны 11-ээр сарын 18-нд гэрлэсэн.

Чи - манай отгон хүүг хайраараа эрхлүүлж яваа, нигүүлслээр
дүүрэн, өр зөөлөн бэр.

Эцэст нь *ирээдүйн Хатагтай Алек Бивэрт:*

Аав нь чамтай хэдий уулзаагүй байгаа ч,
сэтгэлдээ ихэд хайрлан,
уулзах өдрөө тэсэн ядан хүлээж байна.

Лиза, бид хоёрт дан баяр баясал авчирдаг,
мөнхийн бэрүүддээ
гэр бүлийг маань үржүүлж,
өнөр өтгөн болгож өгсөнд талархъя.

АГУУЛГА

- Номын тухай **9**
- 1 Цэгүүдээ холбох **11**
 - 2 Бурханы өгдөг чадвар **25**
 - 3 Өөрийгөө шударгаар үнэл **39**
 - 4 Нярав **49**
 - 5 Итгэмжтэй **65**
 - 6 Хичээнгүй байдал ба үржил **81**
 - 7 Их үржил **95**
 - 8 Стратегийн санаа **109**
 - 9 Хөрөнгө оруулах **123**
 - 10 Өөрчлөгч хүчин зүйл **141**
 - 11 Намайг дуурай **155**
 - 12 Үржлийн саад (I хэсэг) **171**
 - 13 Үржлийн саад (II хэсэг) **183**
 - 14 Бэлгээ нээж олоод, хөгжүүл **195**
 - 15 Тослогдсон **211**
 - Хавсралт **221**
 - Талархал **223**
 - Зүүвэр **224**

НОМЫН ТУХАЙ


Энэ номоос та зорилгоо олж, гал хүслээ бадрааж, хүчин чадлаа ухаарч мэдэх Библийн ойлголт, стратегийг олно. Бүлэг бүрийн төгсгөлд ойлгож мэдсэн зүйлээ өөрөө дээрээ тулган бататгахад чинь туслах зорилготой, хэрэгжүүлэх асуулт бий.

Хэрэв та үржлийн талаар илүү сурахыг хүсч байгаа бол, хувиараа болоод бүлгээрээ үзэж болох видео хичээл, хөтөлбөр тэргүүтэй олон төрлийн нэмэлт онлайн хичээл, материалыг маань үзээрэй. **MessengerX.com** хаяг дээр дагалдагч бэлтгэлийн арвин их материалын сан бий. Материалаа газар газрын, хэл хэлний, санхүүгийн боломжтой боломжгүй (Энэ талаар энэ номдоо дэлгэрэнгүй өгүүлнэ) сая, сая хүнд хүртээмжтэй болгох нь бидний зорилго. Манай хаягаар зочилж, дэлхий даяарх “мессенжер” багт нэгдээрэй.

Мөн асуулт байгаа бол, надад юмуу манай Мессенжер Интернэйшнэл багийнханд чөлөөтэй хандана уу.

За амжилт!

Жоноос



*ЭЗЭНээс эмээхүй нь
Мэргэн ухааны эхлэл.*

*Ариун Нэгэнийг мэдэх нь ухаарал.
Үчир нь өдөр хоног чинь надаар уртсах.
Амьдралын он жилүүд чамд нэмэгдэх.
Чи мэргэн бол өөртөө л мэргэн байгаа хэрэг.*

— Сургаалт үгс 9:10-12

1

Цэгүүдээ холбох

2012 он юм даг. Миний бие Лос - Анжелесын нэгэн чуулганд Бүтэн сайн өдөр номлох хуваарьтай байлаа. Ер нь бол ийм үед би Хагас сайных нь үдээс хойш нисч очоод, Хагас сайны орой, Бүтэн сайны өглөө нь номлочихоод, оройдоо багтаад гэртээ харьчихдаг зантай. Гэтэл энэ удаа хэвшлээ эвдэж таарав.

“Стан” гэдэг хамтран зүтгэгч маань миний Лос - Анжелесын аяллыг мэдчихээд, алдарт Ривиера каунтри клуб дээр гольф тогломоор байгаа эсэхийг маань асуулаа. Тэнд тоглож үзэх чинь миний энэ насны нэгэн мөрөөдөл учраас, би ч уухайн тас: “Тэгье л даа, асуух юун?” хэмээн хөөрөв.

Тэгэхээр, эхлээд үүнээс өмнөх үйл явдлыг өгүүлье. Гучин таваас олон жил аялан, Бурханы Үгийг түгээж явахдаа би үе үе яриан дундуураа гольфд өгсөн хайраа дэлгэчихээд байдаг зантай. Тэгээд ч тэрүү энэ олон жилийн хугацаанд огт санаандгүй явж байгаад, буянтай хүмүүсийн ачаар дэлхийн аль шилдэг клубд тоглож явлаа. Гэтэл энэ удаа ч бас ийм тохиол болов.

Гэхдээ энэ бол ёстой л *хосгүй* урилга байлаа. Ривиера чинь хэн дуртай нь тоглоод байдаггүй, тусгай хүмүүст зориулагдсан, хувийн клуб. Тэр талбай дээр жил бүр (хуучнаар Лос - Анжелесын нээлттэй тэмцээн) эдүгээ Женесис Инвитэйшн нэр дор явагддаг Мэргэжлийн гольфийн холбооны тэмцээн зохиогддог. Түүнчлэн хэд хэдэн удаагийн Америкийн нээлттэй тэмцээн, Мэргэжлийн гольфийн холбооны аварга, Америкийн сонирхогчдын тэмцээн зэрэг нэр хүндтэй, чухал тэмцээн уралдаан явагдана.

За, тэгээд Стан намайг мөрөөдлийн минь талбайд аваачихаар

Хагас сайны өглөө эртлэн ирлээ. Үүнээс гадна Аарон Баддели гэдэг найз маань жилийн өмнө ЭлЭй-ийн Нээлттэй тэмцээнд аваргалсан нь баяр дээр баяр нэмсэн үйл явдал болоод байлаа. Тиймээс би дотроо 2011 оны тэмцээнд ялалт авчирсан мөнөөх хосгүй, хосгүй цохилтыг дууриаж цохихоор бэлдэж явав. Товчхондоо Стан, бид хоёрын хувьд ёстой л мартагдашгүй, зугаатай өглөө байв.

Намайг Лос - Анжелесын төвд байдаг зочид буудалд маань хүргэж өгөх замдаа Стан надад: “Жон, найз нь сүүлийн үед нэг асуудлаар зовних боллоо. Тэр талаар чамаас сонсмоор байна?” гэж ирээд л сэтгэлээ уудаллаа.

— “Тэг л дээ, хө.”

Тэгтэл Стан хүүхэд шиг чин сэтгэлээсээ: “Жон, би бизнесээ босгох гэж сүүлийн хэдэн арван жил чөлөө завгүй, хичээнгүй хөдөлмөрлөлөө. Одоо 9 сая орчим долларын хөрөнгөтэй. Байнгын үйлчлүүлэгч нартай, үйл ажиллагаа маань ч жигдэрсэн. Энэ олон жил нөр их хөдөлмөрлөсний үр дүнд гэргий, үр хүүхэд маань санхүүгийн баталгаатай болсон” гэж ярьлаа.

Тэгснээ: “Одоо би тавь гарлаа. Цаашид ингэж үхэн хатан ажиллах хэрэг байна уу? Дараагийн арван жил хөрөнгөө 35 сая долларт хүргэх гэж зүдрэх хэрэг байна уу?” гэж асуух нь тэр.

Гэтэл Ариун Сүнс надад тэр даруй мэргэн хариулт хайрлав. “Стан, ингэж төсөөлье л дээ. Тухайлбал, би чамд: “Стан, би арван долоон ном бичих гэж олон жил нөр их хөдөлмөрлөлөө. Номууд маань наяс олон хэл дээр орчуулагдаж, хэдэн сая хувиар борлогдлоо. Би сүүлийн хорин таван жилд арван долоон сая км газар нисч, цагийн зөрүүнээс болж нойр хоол солигдож, олон янзын соёлд орж, хачин жигтэй хоол унд идэж, давчуу буудлаар хоноглож үзлээ. Юуны төлөө? Сайн мэдээг дэлхийд түгээх гэж л тэр. Одоо үйлчлэл маань сайхан жигдэрч, санхүү маань тогтворжлоо. Лиза ч, хөвгүүд ч энэ тал дээр айх юмгүй болсон. Тэгэхээр, би цаашид ингэж ажиллаад байх хэрэг байна уу?” гэж хэлбэл, яах уу?”

Дүрслэл маань Станы орой руу оржээ. Тэрбээр мушилзсанаа: “Тэгвэл ч чи Есүстэй уулзах өдрөө балрах биз” гэж хэлэв.

Тэгэхээр нь би шууд: “Стан, чи надад бизнесийнхээ талаар яг л ингэж хэллээ шүү дээ” гэлээ.

Станы намайг даапаалж байсан царай цочирч хөшөөд, хараагаа хурдны замаас салган, над руу харснаа, итгэж ядсан дуугаар: “Юу гэсэн үг үү?” гэж асуув.

— “Стан, Бурхан хүүхэд бүртээ бэлэг өгсөн. Бэлэг нь Бурханы Хаанчлалыг байгуулахын л төлөө оршдог. Тийм боловч, бид нярвууд учраас, тэр бэлгийг тухай бүр гурван арга замаар ашиглах сонголт хийнэ:

“Бид бэлгээ хаанчлалыг байгуулахад хэрэглэж болно.”

“Бид бэлгээ өөрийгөө байгуулахад хэрэглэж болно.”

“Бид бэлгээ тэр чигээр нь хэрэглэлгүй, үл хэрэгсэж болно.”

Стан анхаарлаа салгаагүй тул би цааш нь: “Тухайлбал, би бичих, номлох бэлэгтэй. Харин чи бизнесийн бас өгөх бэлэгтэй. Чи миний талаарх дүрслэлийг шоолсон! Гэтэл чи өөрөө яг ийм юм ярьж байна. Хаанчлалыг байгуулахад, чиний бэлэг минийхээс дутахгүй чухал. За, яг нарийндаа - чинийх илүү чухал ч байж магад. Гэхдээ чи цэгүүдээ холбоогүй байна!” гэж ярьлаа.

Бид нилээд ярилцав. Энэ хооронд Станы бодол, хандлага нүдэн дээр маань хувьсаж байгааг харах жигтэйхэн урамтай байлаа.

Зургаан сарын дараа би Станы байр байдлыг мэдэхээр залгасан юм. Тэр яриаг би хэзээ ч мартахгүй.

— “За сайн уу, хө?”

— “Үнэнээ хэлэх үү?” гэсэн Станы хариулт намайг жаахан барьц алдуулав.

— “Тэг л дээ!”

— “Зургаан сарын өмнө чиний хэлсэн үг надад амар заяа үзүүлэхээ больсон. Гэхдээ сайн утгаараа шүү.”

— “За тэгээд яасан, хө?”

Стан инээд алдаад: “Би хаанчлалын төлөө 35 саяын бизнес босгохоор шулуудсан” хэмээн шулуухан мэдэгдэв.

— “Сайн байш дээ!”

Стан өөрийгөө Бурханы хаанчлалын ажилд үзэгч бус, харин чухал оролцогч гэдэг бодит байдлыг ойлгожээ. Тэрбээр олон хүний зугтдаг энэ алсын харааг өөрийн болгоод, онцгой чадвар нь дан зуурдын бус, харин мөнхийн юмст хэрэгтэй болохыг мэджээ. Түүний бэлэг нь түүнээс ч, гэр бүлээс нь ч давсан, том зорилгын төлөө өгөгдсөнийг эдүгээ Стан ухаарчээ. Стан тийм илэн далангуй, чин сэтгэлээсээ, даруу байсанд үнэхээр талархмаар. Тэгж чадсан учраас л Стан амьдралыг нь өөрчилсөн мөнөөх үнэнийг өвлөжээ. Станы гэрчлэлээр өөрийнх нь гэлтгүй, өөр олон хүний амьдрал өөрчлөгдсөн юм.

Энэ ном ч бас Станы үржүүлэх хөдөлгүүр болсон ухаарлыг танд авчрах гэсэн ганц л зорилготой. Миний бие энэ олон жил маш олон

итгэгч хүнтэй уулзаж ярилцаж явахдаа, тэдний олонх нь - үнэндээ дийлэнх нь яг Стан шиг бодолтой явдгийг мэдээд цочирдож билээ. Мэдээж олонх нь Стан шиг уудлаж ярихгүй ч, ямар ч холбоогүй цэгүүд нь яриан дундуур нь ил болдог.

Та ч бас зорилгынхоо талаар нэг иймэрхүү бодолтой яваа бол, энэ ном таны гарт очсон нь сайн хэрэг. Таны үлгэр загвар ч өөрчлөгдөх болтугай.

Стан шиг өөртөө шударга хандбал, цэгүүд чинь холбогдоход л тустай. Хаанчлалыг байгуулахын төлөө өгөгдсөн бэлгээ даруу хандлагаар л нээж, үржүүлэх ёстой юм байна гэдэгт та бат итгэнэ. Та өөрийнхөө пастортай л адил эсвэл надтай л адил Бурханаар дуудагдсан. Таны дуудлага аугаа Билли Грахамын юмуу аль нэг алдартай үйлчлэгчийнхтэй л адил хүчин төгөлдөр.

Бүгдээрээ таны онцгой дуудлагыг дэмжиж өгдөг бэлгээ хэрхэн нээх, хөгжүүлэх тэгээд хамгийн гол нь үржүүлэх талаар ярилцана. Энэ ном доторх Бурханы Үг болоод түүхүүд таны үр нөлөөг үлэмж өсгөх итгэлийг чинь байгуулна. Энэ бүхэн уг номыг бичиж, хянан тохиолдуулж байхад маань өөрт маань тохиолдсон учраас л, би үүнийг ийм итгэлтэй яриад байгаа хэрэг.

ЗОРИЛГЫН ТӨЛӨӨ, ЗОРИЛГОТОЙ ТӨРСӨН

За, юун түрүүнд маш алдартай нэгэн Бичээсийг үзэцгээе:

Нигүүлслийн учир итгэлээрээ аврагдсан нь та нараас бус харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр чинь биш тул хэн ч үл сайрхах болно. (Ефес 2:8-9)

Энэ хоёр эшлэлийн фокус *Бурханы нигүүлсэл* гэдэг үг дээр тогтоно. Бид Бурханы бэлэг болгож өгсөн нигүүлслээр аврагдсан нь тодорхой байна. Энэ үнэнийг Хорин нэгдүгээр зууны чуулган мундаг түгээдэг. Бид хичнээн их ажиллалаа гээд, ариун амьдарлаа гээд, гавьяа золио гаргалаа гээд Аугаа хүчирхэг Бүтээгч Бурхантайгаа өнө мөнх хамт орших аз завшааныг олж авахгүй. Дээрх алдарт эшлэл нь энэхүү чухал үнэнийг илчилдэг цорын ганц биш боловч, гол эшлэлийн нэг мөнөөс мөн. Гэхдээ бид дараагийн эшлэлийг нь үл тоодог ажээ:

Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн Түүний бүтээл мөн. Биднийг эдгээрийн дотор яваасай гэж Бурхан урьдаас бэлтгэсэн билээ. (Ефес 2:10)

Есдүгээр эшлэлийн араас “*учир нь*” гэдэг үг залгаж байгааг тэмдэглэнэ үү. Энэ үг нь хоёр мэдэгдлийг хооронд нь холбох *гагнаас* болж байна. Өөрөөр хэлбэл, эхний санаа нь хараахан дуусалгүй, цаашаа хөвөрнө гэсэн үг. “*Учир нь*” гэдэг үг нь “*үүний учир*” гэсэн утгатай бөгөөд 10-аар эшлэлгүйгээр 8, 9-ээр эшлэл бүрэн болохгүй ажээ.

10-аар эшлэл дээр биднийг сайн үйлс бүтээх зорилгын төлөө бүтээгдсэн гэсэн. Үндсэндээ дээрх гурван эшлэл дээр Паул:

“Бид нэгдүгээрт - нигүүлслээр *хэн нэгэн* буюу Бурханы хүүхэд болохоор аврагдсан. Хоёрдугаарт тэр л нигүүлслээр *ямар нэгэн үйл хэргийн төлөө хүчирхэгжсэн*” гэж л хэлжээ.

Бид үнэний нэг талыг нь дөвийлгөөд, нөгөө талыг нь орхигдуулж хэрхэв ч болохгүй. Гэхдээ учир зүйн талаас нь үзбэл, хүн юм хийхээсээ өмнө эхлээд өөрийгөө хэн болохыг мэдэх хэрэгтэй. Учир нь *хэн гэдгээс л хэрхэн үйлдэх* маань хөвөрнө.

“Юм хийх” гэдэг хэсгээс булзах амархан. Булзах нь хаанчлалыг байгуулах ёстой гэдэг хүч хөдөлмөрийн дарамтаас чөлөөлдөг. Гэтэл үнэндээ хүч хөдөлмөр л биднийг эрч хүчтэй болгодог. Есүс “Миний хоол бол Намайг илгээсэн Түүний хүслийг үйлдэн, ажлыг нь гүйцэлдүүлэх явдал” (Иохан 4:34) гэсэн. Мөн “Эцэг Намайг илгээсний адил Би бас та нарыг илгээнэ” (Иохан 20:21) гэсэн. Есүсийн энэ хоёр үгийг зэрэгцүүлбэл, биднийг илгээдэг Есүсийн хүслийг хийж, гүйцэлдүүлэх нь бидний хоол хүнс болох нь тодорхой харагдаж байна. Хоол хүнс биднийг тамир тэнхээтэй болгодог. Хүн юм идэхгүй бол, тамирдаад, шальтай юм бүтээж чадахгүй.

Энэ үнэнийг сүнсний амьдрал дээр буулгаж үзье. Бид өөрсдийг маань илгээгч Есүсийн хүслийг хийхгүй бол, сульдана. Өдөөлтөд өртөмтгий болно.

Миний бие Есүстэй дөчөөд жил хамт алхахдаа, хүмүүсийн “үйлдэлгүй” байдал нь тэдний итгэлээсээ алдуурч одох нэгэн шалтгаан болдгийг анзаарсан билээ. Тэд дуудлага дээрээ залхуу, хойрго болж, нэг л мэдэхнээ архидан согтуурч, ёс бусыг үйлдэж, дэлхийн амьдралд нүд алдаж, соруулна. Сүнсний тамир тэнхээгүй болно. Тэгэхээр, нэг ёсондоо:

Үйлдэл биднийг хүчжүүлдэг байх нь.

Би дээрх гурван Бичээсийн үнэнийг тодорхойлмоор байна: Та Бурханы хүүхэд болохын тулд Бурханы бэлэглэсэн нигүүлслээр дахин төрсөн бөгөөд тэр л нигүүлсэл таныг их үйлсийн төлөө давхар хүчжүүлжээ. Бурхан бидний үйлсийг урьдаас төлөвлөсөн хэмээн Бичээс хэлдэг. Давид:

“Төрхөө олоогүй хөврөл байхад минь Таны нүд харж л байсан. Надад тогтоогдсон өдрүүд болоогүй байхад Бүгд номд тань бичигдсэн байжээ” (Дуулал 139:16) гэсэн.

Бурхан танаар хийлгэх юмсаа таныг төрөхөөс ч өмнө тусгайлан бэлджээ. Үнэндээ Бурхан тэр номдоо эдгээр номыг ч бичсэн! Тэр номд бидний амьдралын эгшин бүр бичигдсэн учраас, аварга том ном байж таараа. Бурханы бидэнд төлөвлөж оноосон даалгавар нь Түүний хаанчлалыг байгуулах ажлыг л төгрөглөн өрнөнө. Бурхан биднийг амьдралд маань зориулсан Өөрийнх нь төлөвлөгөөг биелүүлж амьдраасай гэж үнэн голоосоо хүсдэг ч, бидний талаас яг таг биелүүлж амьдарна гэсэн баталгаа байхгүй. Ефес 2:10 дээр “*яваасай*” гэж хэлсэн байгааг харж байна уу? “*Бид тэдгээрийн дотор баараггүй явна*” гэж хэлээгүй, харин “*биднийг тэдгээрийн дотор яваасай*” хэмээн хүсдэг гэжээ. Энэ үед л тоглоомонд бидний чөлөөт хүсэл орж ирнэ. Бурхан бидний ажлыг урьдаас зохицуулсан боловч, Түүний төлөвлөгөөн дор алхах эсэх нь биднээс л шалтгаалах.

Итгэгч хүмүүс шүүх сэнтийн урд Есүсийн өмнө зогсох үед Есүс мөнөөх номоо нээгээд: “За, чи Аав, Бид хоёрын чамд хандсан анхдагч төлөвлөгөөний дагуу амьдарч чадсан эсэхийг харьцуулья” хэмээн айлдана байх. (Энэ шүүх нь Христэд итгэдэг хүмүүсийн хувьд нэг бол ажил хөдөлмөрөө үнэлүүлэн шагнуулах эсвэл хайхрамжгүй амьдарсныхаа төлөө гарз хохирол үзэх шүүх юм. Энэ шүүхийн тухайд Бичээсийн хоёр ч хэсэг дээр “*номууд нээгдэв*” гэсэн байдаг. Даниел 7:10, Илчлэл 20:12-ыг үзнэ үү.) Бидний амьдралын талаарх тэр номыг биднийг хүн биеийг олж төрөхөөс ч өмнө Бурхан Өөрөө бичсэн гэдэгт би итгэдэг. Харин бидний хувьчлан хүлээж авсан, онцгой дуудлагын тал дээр - бид юу хийснээрээ бус, харин юу хийхээр дуудагдсанаараа л шүүгдэнэ.

Үүнийг бүү март.

Сонсоод, тэвдэж байна уу? Тэгвэл тэвдэх хэрэггүй! Урьдаар

гурван чухал зүйлийг мэдэж авна уу: Нэгдүгээрт - таны дуудлагын тал дээр Бурхан танаас ч их хүсэл тэмүүлэл тээж явдаг учраас, төлөвлөгөө шийдлээ танаас нуухгүй. Таны дуудлагаа олж мэдэхийг хүсч байгаагаас чинь ч илүү Бурхан танд дуудлагыг чинь мэдүүлэх хүсэлтэй! Хоёрдугаарт - дуудлага төгөлдөрших нь ганц удаагийн явдал бус, уртын аялал учраас, тэвчээрийг чинь сорьж, сонжиж байгаа юмстай тэмцэж сур. Гуравдугаарт - энэ ном танд дуудлагаа олж, хөгжүүлэх Бичээсийн ч, амьдралын ч ухааныг заана.

Жишээгээр тайлбарлая. Тухайлбал би хот төлөвлөгч байгаад хотын төвд орон сууцтай, амралт зугаалгын газартай, худалдаа үйлчилгээтэй, нүсэр цогцолбор барихыг хүсэв. Хот төлөвлөгчийнхөө хувьд, би өөрөө тус төслийн үндсэн дизайнераар ажиллаж, чадварлаг гүйцэтгэгч, архитекторуудтай хамтран мастер төлөвлөгөө гаргана. Би цогцолбортоо тоглоомын талбай, хөгжөөнт тоглоом, биеийн тамир, спортын талбай, усан оргилуур, амарч суух, алхаж аялах газрыг багтаахыг хүснэ. Түүнчлэн цогцолбороо дээрээ тансаг орон сууцтай, доороо том, том дэлгүүр, зоогийн газар, кино театрттай, давтагдашгүй цогц төв байлгахыг зорив.

Дизайн батлагдмагц, би мастер төлөвлөгөөнийхөө аль хэсгийг аль барилгын компаниар гүйцэтгүүлэхээ шийднэ. Тэгээд янз бүрийн барилгын компани хөлслөн, гүйцэтгэлийн хугацааг нь тогтоож өгнө. Ийнхүү төсөл маань эхэлнэ.

Барилгын компаниуд миний хүсэлтийг ёсчлон гүйцэтгэбэл, нүсэр төсөл маань саадгүй, сайхан урагшилна. Гэтэл зарим барилгын компани төслийн ажлаа ойшоохгүй бол, яах вэ? Тэд ажлаа хүлээн авсан хэрнээ барилгаа барихгүй, өөр юм хийгээд байвал, яах уу? Ажлаа хаячихаад, загасчлаад, гольфдоод, тэмцээн уралдаанд оролцоод гүйгээд байвал, яах уу? Ажлаа тоохгүй, унтаж идээд байвал, яах уу? Би анх гэрээ байгуулсан, тэдгээр барилгын компанид найдаад л суугаад байвал, төсөл маань цаг хугацаандаа дуусахгүй. Үнэндээ хэзээ ч дуусахгүй.

Цаг хугацаа, авъяас чадвараа хэрхэх нь тухайн барилгачдын л сонголт. Тийм боловч хот төлөвлөгч - миний бие ийм том сааталд баригдаж, төслөө хэзээ дуусах нь тодорхойгүй нөхцөлд оруулахыг хэрхэв ч хүлээн зөвшөөрөхгүй. Тиймээс би өөр барилгын компани олоод, ажлаа хийлгүүлнэ.

Тэгвэл ямар үр дүн гарах уу? Нөгөө анхны барилгын компани тэрхүү үзэсгэлэнтэй цогцолборыг сүндэрлүүлсэн барилгачдын

алдрыг хүртэх эрхгүй болно. Тэд хотын төвийг чимсэн, энэ түүхэн барилга байгууламжийг барилцаж явлаа хэмээн үр хүүхэд, ач зээ, найз нөхөддөө бахархах эрхгүй болно. Хүүхдүүд нь энэ барилгыг аав, ээж маань барьсан гэж гайхуулах эрхгүй болно. Түүнчлэн тэд ажлынхаа хөлсийг ч авах эрхгүй болно.

Яг энэ зарчмыг Бичээс ахин дахин үлгэрлэн өгүүлдэг. Бурханд хаанчлалаа байгуулах мастер төлөвлөгөө бий. Тийм боловч, Бурхан төлөвлөгөөг нь биелүүлэхээс хойш суугч хүмүүстэй байнга тулгарч байсныг түүх гэрчилнэ. Тиймээс Бурхан анхдагч төлөвлөгөөндөө байнга зохицуулалт хийх шаардлагатай болдог байв. (Бидний Бурхан эхлэл, төгсгөлийг атгадаг, цаг хугацаанд баригдашгүй Бурхан болохоор, хүний ухаанд л тааруулж ярьж байгааг минь ойлгоорой.) Тиймээс төлөвлөгөөгөө өөрчлөх нь Бурханы хувьд цочирдмоор хэрэг биш. Ажилчид нь ямар сонголт хийхийг Бурхан хэзээний мэддэг тул тэдний орны хүнийг хэдийнээ бэлтгэсэн байдаг.

Энэ талаар Бичээсээс хэд, хэдэн жишээ үзье л дээ. Тухайлбал, Абрахамын аав - Терад ийм явдал тохиожээ. (Миний отгон хүү Арден саяхан надад энэ үнэнийг сануулсан юм.) Бурхан Абрахамыг Канаан газар руу дуудахаас өмнө Абрахам Халдейн Ур нутгийн хүн байсныг бид бүгдээрээ шахуу мэднэ. Тэгвэл Абрахамын аав Тераг нарийн ажиглах юм бол, үнэндээ Бурхан тэр эрхмийг л анхлан Канаан руу дуудсан байсныг харин цөөхөн хүн мэдэх байх.

Тера өөрийн хүү Абрам, Хараны хүү, өөрийн ач хүү Лотыг өөрийн бэр, Абрамын эхнэр Сараи нарын хамт авч Халдейн Ураас Канаан нутгийг зорин хөдлөөд, Харанд ирж тэндээ суужээ. Тера хоёр зуун тав наslaад, Харанд үхэв.
(Эхлэл 11:31-32)

Эндээс бид хоёр зүйлийг эргэцүүлэх ёстой. Нэгдүгээрт - хүн гэв гэнэт л гэр бүлээ аваад, Ур нутгаасаа 1000 гаруй километрийн тэртээх Канаан гэдэг газар руу нүүдэл суудал хийхгүй. Тэмээн аялал нь удаанаас гадна хүнд аялал. Хүүхэд, хүүхнүүдээ авч явсан болохоор хэдэн сарын явдал болоо байх. Тухайн үед Тера Канаан бол гэр бүлээрээ ажиллаж, амьдрахад таатай, жигтэйхэн сайхан газар болохыг интернэтээс зураг хөрөгтэй нь олж уншаагүй. Олон нийтийн сүлжээнээс мэдээлэл авна гэсэн ойлголт байгаагүй. Тэгэхээр, ямар нэгэн шалтгаан байсан болоод л Тера гуай энэ онцгой, алсын нүүдлээ хийсэн байж таараа.

Хоёрдугаарт - Тера Канааныг зорьсон атлаа яагаад Харанд суурьшив? Яагаад аян замаа дуусгасангүйв? Тера ажлаа дуусгахаас төвөгшөөсөн үү? Аяншиж ядарсан гэр бүлийнхээ санал гомдол, тал бүрээс бөмбөгдөх хүсэл бодол, замын бэрх, саадад бугаад өгсөн байж болох уу? Тэрбээр Харанд байгаа боломжийг олж үзчихээд, дан ганц Бурханы Үгээс болж тэр бүхнийг алдахыг хүсээгүй байж болох уу?

Энэ бүхнээс үзбэл, Тера гуай нь “олон үндэстний эцэг” байлгах Бурханы анхдагч сонголт байжээ гэж дүгнэж болохоор байгаа биш үү? Мөн эдүгээ Абрахамын хүртсэн *“итгэлийн эцэг”* гэдэг нэр хүндийг (Ром 4:16-17-г үзнэ үү) Бурхан анх Терад зэхээд байсан байж болох уу?

Тера цааш явалгүй, Харанд суурьшихаар шийджээ. Уг нь тэрбээр яваад л байсан бол, өнөөдөр бид Терагийн Бурхантай хийсэн адал явдал, гэрээний тухай уншиж байх байж. Тера Израилийн өвөг болж, Есүс “Абрахамын үр” (Галат 3:16) хэмээгдэх бус, “Терагийн үр” хэмээгдэх байж.

Бурханы мастер төлөвлөгөөнд өөрчлөлт орсон өөр нэгэн жишээ нь шүүгч бөгөөд тэргүүн тахилч Елигийн түүх болой. Ели бөгөөд түүний үр удам Бурханы өмнө ард түмнээ төлөөлөх үүрэгтэй байжээ. Гэтэл Елитэй уулзсан эш үзүүлэгч ийнхүү мэдэгдэв:

Тиймээс Израилийн Бурхан ЭЗЭН ийнхүү тунхаглаж байна. “Чиний гэр болон чиний эцгийн гэр Миний өмнө мөнхөд явна хэмээн Би айлдсан билээ.” Харин одоо ЭЗЭН тунхаглан “Тэгэх нь Надаас хол байг! Намайг хүндэтгэгчдийг Би хүндэтгэнэ. Харин Намайг үл тоомсорлогсдыг Би үл хайхарна. Харагтун, Би чиний тэнхээг, чиний эцгийн гэрийн тамирыг тасалж, гэрт чинь өвгөн настан үгүй болох өдөр айсуй. (1Самуел 2:30-31)

Елигийн дуулгаваргүй байдал нь түүнд ч, үр удамд нь ч нөлөөлжээ. Ели Бурханы өмнө хүндтэй амьдарсан бол, тахилчийн үйлчлэл Елигийн үр удамаас авагдахгүй байх байж.

Өөр нэгэн жишээг Израилийн бүх хаадаас үзэж болно. Эхнийх нь Давидын хүү Соломон. Бурхан түүнд “Нэгэнт чи үүнийг үйлдэж, Миний гэрээг бас чамд тушаасан журмыг минь сахиагүй учир Би чамаас хаанчлалыг зайлшгүй таслан авч, зарцад чинь өгөх болно” (1Хаад 11:11) хэмээн айлдсан. Хэрэв Соломон үнэнч хэвээр үлдсэн

бол, хүү Рехобоам нь хаанчлалаа алдахгүй байх байжээ. Хаанчлалын дийлэнх хувь Иеробоамд өгөгдсөн ч, тэр ч бас үнэнч байж чадаагүй бөгөөд Бурхан түүнд:

“Би чамайг ард түмний дундаас өргөмжилж, Миний ард түмэн болох Израилийг захирах удирдагчаар томилж, Давидын ургийнхнаас хаанчлалыг таслан авч чамд өгсөн боловч чи Миний зарц Давид шиг байсангүй. Давид, Миний тушаалуудыг сахиж, Миний мэлмийн өмнө зөв зүйтэйг үйлдэхээр Намайг бүх зүрх сэтгэлээрээ дагасан билээ” (1Хаад 14:7-10) гэж хэлэхийг айлджээ.

Иеробоам эрх дархаа зөв эдлэж, бэлгээ өөртөө бус, Бурханы хаанчлалын төлөө хэрэглэсэн бол, хаанчлал нь бат тогтох байв. Израилийн хаан Баашад ч яг ийм үг ирсэн (1Хаад 16:1-7-г үзнэ үү). Мөн хаанчлалыг хүлээн авсан бусад хаад ноёдын хувьд ч ялгаагүй.

Тэгэхээр, би нэг л зүйл хэлье: Бурханы дуудлагад итгэмжгүй хандах амьдрал маань бидэнд төдийгүй, үр удамд маань ч нөлөөлнө. Яахав, Терад ийм гашуун явдал тохиогоогүй боловч, бусдад нь тохиосон шүү дээ.

Эш үзүүлэгч нарын хувьд ч ялгаагүй. Елиша Елиад үйлчлээд, Елиагийн хувиас хоёр дахин их хувь хүлээн авсан. Гэтэл олон жилийн дараа Елишагийн зарц, эш үзүүлэгчдийн бэлгийн залгамж халааг авах ёстой байсан Гехаз анхаарлаа чухал зүйлээсээ алдаад, сүйрсэн. Тэрбээр уяман өвчин тусаад, үйлчлэлээ орхисон (2Хаад 5:20-27-г үзнэ үү). Тэгээд Гехазийн оронд нэр нь дурьдагдаагүй, өөр шинэ зарц Елишад туслахаар гарч иржээ.

Шинэ гэрээнд Искаротын Иудас гэж бий. Тэрбээр дуудлагаа болоод өөрт нь даалгасан бэлгийг буруугаар ашигласан тул орыг нь өөр хүн залгах хэрэгтэй болсон. Петр дээд өрөөнд байхдаа дагалдагч нарт “...Дуулал номд... “Харгалзах үүргийг нь өөр нэгэн аваг” гэж бичигджээ. Иймээс Эзэн Есүс бидний дунд амьдарч байх үеийн туршид бидэнтэй цуг дагаж явсан эрчүүдээс... бидэнтэй хамт байгсдаас нэг нь бидний хамт, Түүний амиллын гэрч болох хэрэгтэй байна” (Үйлс 1:20-22) гэсэн байдаг.

Даанч харуусмаар! Олон хүн амьдралынхаа дуудлага, бэлгийг зүй зохистой хэрэглээгүй, захиран зарцуулаагүйгээсээ болоод үлэмж харуусалд автана гэж бодохоор аймшигтай.

Гэхдээ эерэг талаас нь харбал, эрхэм уншигч та зорилгын төлөө, зорилготой төржээ. Өнө мөнхийн бүтээн байгуулалтанд таны амь амьдрал өндөр үүрэгтэй. Энэ нь хэн нэг эр, эм хүний хүсэл бус, үүнийг Бурхан Өөрөө шийдсэн болой.

ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭСЭХИЙГ ТАНЫ ШИЙДВЭР Л МЭДНЭ

Үр нөлөөтэй байх эсэх чинь Бурханаас бус, танаас л шалтгаална. Энэ бол цочирдмоор үнэн. Та амьдралынхаа бүх ололт амжилтыг “Бурханы дархан эрх мэдэл” дотор авдарлачихсан хүн бол, миний энэ үг хүндэтгэлгүй сонсогдож магадгүй. Гэхдээ энэ мэдэгдэл маань Бурханыг доромжилж, эрх мэдлээс нь хумслах гэсэн явдал огт биш. Энэ нь Бурхан бидэнд итгэж буйн гэрчлэл, Өөрийнх нь хайрласан чөлөөт хүслийг охид, хөвгүүд нь хэрэгжүүлээсэй гэсэн хүсэл болой.

Бүгдээрээ бүлгийнхээ эхэнд умшсан Бичээсээ дахин нэг үзье:

Учир нь өдөр хоног чинь надаар уртсах. Амьдралын он жилүүд чамд нэмэгдэх. Чи мэргэн бол өөртөө л мэргэн байгаа хэрэг (Цэц ухаан *чиний өдөр хоногийг үржүүлэн*, амьдралд чинь он жил нэмэх. Цэцэн болбол, чамд л ашиг тустай. (Сургаалт үгс 9:11-12)

Маш хүчтэй, урмын үг байна! *Өдөр хоногийг үржүүлэх* гэж юу гэсэн үг вэ? Амь амьдралыг чинь уртасгана гэсэн үг л лав биш. Учир нь “амьдралд чинь олон жил нэмнэ” гээд хэдийнээ хэлчихсэн байна. Тиймээс энэ нь өдөр бүр амьдралын чинь үр нөлөөг нэмэгдүүлнэ гэсэн утгатай байхаас гарцаагүй. Өөрөөр хэлбэл, та Бурханы цэц ухаангүй хүнээс илүү чанартай амьдарна.

“Сүх мохож, хэн ч эс ирлэвээс илүү хүч зарцуулах, Харин мэргэн ухаан амжилт авчрах” (Номлогчийн үгс 10:10) гэдэг үгийг та сонсоо л байх. Энд цэц ухааныг тодруулжээ. Та мохой сүхээр (цэц ухаангүйгээр) тийм ч үр дүн, бүтээлтэй байж чадахгүй. Тонгоруулж хэлбэл, хурц сүхээр (цэц ухаанаар) хичнээн л бол, хичнээн мод унагана. Нэг л ижил хүчээр хүчин зүтгэлээ шууд үржүүлэх нь байна.

Бурханы цэц ухаан амин чухал. Номынхоо дундуур би нэгэн найзынхаа түүхийг хуваалцнамз. Найз маань олон жил нэг л их хуульчирхаг атлаа нэг ч үр бүтээлгүй итгэгч явсаар, цөхөрчээ. Тэгээд олон сар Бичээст гүн суралцав. Энэ явдал нь түүнд үр нөлөөтэй амьдрах цэц ухаан хайрласан бөгөөд... за за, ер нь дараа нь түүний тухай ярихаар, та зүгээр л ангайна.

Ганц найз маань гэлтгүй, “цэц ухааныг олох шиг амин чухал зүйл үгүйг” (Сургаалт үгс 4:7) бид бүгдээрээ л сурсан. Би ч энэ үгд хайртай. Үүнд үнэхээр итгэсэн хүн цэц ухааныг олохын төлөө байдаг л цаг зав, эрч хүчээ зориулна. Гэхдээ Сургаалт үгс 9:11-12-аар эшлэлийн хамгийн чухал үнэн нь *“Цэцэн болбол, чамд л тустай!”* гэдэг санаа юм.

Энэ номоороо өгүүлэх Бурханыхаа цэц ухааныг би сайн, муу туршлагаараа дамжуулан олон жил эрж, хайж, сонссон билээ. Гэхдээ ганц би ч гэлтгүй, олон хүн Бурханы цэц ухаанаар амьдарч эхлэхдээ ер бусын арвин үр жимс ургуулснаа надад ярьдаг. Миний олж авах гэж өч төчнөөн жил зөрчилдсөн ухааныг та гялс олж өвөртлөөд, надаас ч цэцэн цэлмэг амьдарч, надаас ч өндөр явах болтугай. Хаанчлалын асуудал дээр бид бүгдээрээ нэг тал учраас, та ашиг хүртсэн бол, надад ч ашигтай байна. Та надаас хол явбал, хоёулаа нэг учраас, би ч явсантай адил. Бид Хааныхаа алдрын төлөө гэдэг ганц л зорилгоор ажиллаж байна.


ДАЛД НУУЦ

Тэгэхээр, дараагийнхаа бүлэгт орохын тулд “Таны ур чадварыг урьд хожид байгаагүйгээр тулгал асаах чадалтай мөртлөө хүмүүсийн бараг мэддэггүй нэгэн далд нууцыг та сонирхож байна уу?” гэдэг шилжилт асуулт тавья.

Та мэдээж сонирхох байх! Тэгэхээр ийм байна - цаана чинь нэгэн далд нууц байна. Тэр далд үнэнийг одоо бүгдээрээ олж илрүүлцгээе.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

1. Ефес 2:10-аар эшлэлийн дагуу, Бурхан танаар хийлгэх зүйлсээ таныг мэндлэхээс ч өмнө төлөвлөсөн байжээ. Тэр төлөвлөгөөг нь та эрэн хайсан уу? Эрэл хайгуулд чинь юу саад хийв?
2. Та зорилгын төлөө, зорилготой төрсөн. Станы түүхээр үлгэрлэбэл, та өөрийнхөө бэлэг, чадварыг хэрхэн үзэж байна? Та тэдгээрийг Бурханы хаанчлалын бүтээн байгуулалтанд чухал гэж үздэг үү? Эсвэл Стан шиг л цэгүүдээ холбоогүй явна уу?
3. Бурханы хүслийг биелүүлэх нь биднийг хүч оруулдаг. Амьдралдаа хийж байгаа зүйл чинь таныг хүч оруулж байна уу? Та хийж байгаа ажилдаа дурлаж байна уу? Үгүй бол, танд юу дутаад байх шиг байна?



*Бидэнд өгөгдсөн нигүүлслээр
бэлгүүд маань ялгаатай.*

— Ром 12:6

2

Бурханы өгдөг чадвар

Найз Жийм маань арван найман жил ахлах сургуулийн охидын сагсан бөмбөгийн багийг дасгалжуулсан хүн. Энэ хугацаандаа тэд муждаа нэг ч удаа аваргалж, цом өргөж үзээгүй. Жил бүр нэг бол дүүргийн шувтаргын тоглолтонд ялагдана эсвэл мужийн аваргын төлөөх тэмцээнд шалгарлаа ч, эхнийхээ тойргоо ч дуусгалгүй хасагдчихна.

Жийм надад: “Би гутарсандаа дасгалжуулагчийнхаа ажлыг хаямаар байсан ч, яг тэр үед Бурханы нигүүлслийн хүчийг олж мэдсэн” хэмээн хуучилж билээ.

Тэгээд Жийм цаашид өнгөрсөн арван найман жил шигээ өөрийнхөө хүчинд бус, *Бурханы нигүүлсэлд* бүрэн найдахаар хатуу шийджээ. Тэрбээр Бурханаас заавар асуутал, Бурхан: “Бэлтгэлийнхээ бүтцийг өөрчил. Зааланд ерэн минут зарцуулалгүй, хувцас солих өрөөндөө дөчин таван минутын турш Библиэ уншиж, үг хуваалцаж, залбираад, үлдсэн дөчин таван минутыг нь зааланд өнгөрөө” гэж заажээ.

Жийм надад: “Жон, яг үнэндээ энэ арга надад бүтэхгүй санагдсан. Бид ур чадвар дээрээ ажиллаж, илүү их тоглох шаардлагатай байсан. Үнэндээ бүтэн ерэн минут ч хангалтгүй. Гэвч тэр бол яахын аргагүй Бурханы Үг байсан л даа” гэв.

Тэгээд цааш нь: “Би шинэ стратегиэ охиддоо хэлтэл, тэд энэ санааг хэтэрхий шашинжсан, дэмий санаа гэж үзсэн л дээ. Зарим нь анх сонсоод шууд л бухимдсан боловч, миний чин зүрхний үгийг сонсоод, арга буюу хүлээн зөвшөөрсөн” гэж яриу.

Тэгснээ Жийм нүүр дүүрэн мишээснээ: “Тэр жил бид анх удаа мужийнхаа сагсан бөмбөгийн аварга болсон. Бүр дараа жил нь ч дахиж хожсон” гэж хэлсэн юм.

Жийм хоёр дахь удаагийн тэмцээнийхээ талаар ярихдаа: “Финал дээр манайхан ганц онооны шидэлт болгоноо алдсан болохоор бас л өндөлзүүлсэн, эвгүй тоглолт болсон шүү. Тэр шидэлтээс хамаарсан бол, бид яагаад ч ялахгүй байсан! Гэтэл статистик үзсэн чинь тэр тоглолт дээр манай баг гурван онооны шидэлтээрээ рекорд тогтоосон юм билээ. Гурван онооны шидэлт маань алдсан бүх шидэлтийг маань нөхөөд, дээрээс нь ялалтын оноо авчирсан байж” хэмээн өгүүлж билээ.

ХҮЧ БОЛОГЧ

Жийм тэнгэрийн цэц ухааныг олжээ. Энэ нь үнэндээ элч Паулын олж мэдсэн - статистикаас үзбэл, Хорин нэгдүгээр зууны чуулгануудын ерэн хувийнх нь зайлсхийдэг, тэр ойлголт юм. Тэгэхээр, тэр нь “Библийн *нигүүлсэл* нь Бурханы авралын бэлэг төдийгүй мөн бидний амьдралд хандсан Бурханы *хүч*” гэдэг ойлголт болой. Паулын үгийг л үз. Энэ үг нь Бурханы Өөрийнх нь айлдсан үг гэдгийг анхаараарай: “Миний *нигүүлсэл* чамд хангалттай. Учир нь *мөхөсдөлд [Миний] хүч* бүрэн төгс болдог” (2Коринт 12:9).

Энд ямар ч саармаг юм алга. *Бурхан нигүүлслээ* Өөрийнхөө хүч хэмээв. Дээрх эшлэлд байгаа *мөхөсдөл* гэдэг үг нь “чадваргүй байдал” гэсэн утгатай. Эзэн Паулд бас та, бид хоёрт: “Чиний төрөлх чадвараас давсан нөхцөл дунд Миний хүч (нигүүлсэл) тултал ажиллана” хэмээн айлджээ.

Жийм охидоо аварга болгох гэж чадах мэдэх бүхнээрээ арван найман жил хүчлэн зүтгэсэн ч, юунд хүрсэн? Дандаа л дутуудсан. Тийм боловч Жийм эцсийн эцэст “*Бурханы нигүүлсэл бидний төрөлх чадварыг хол хаядаг*” гэдэг цэц ухаанд хүрсэн болохоор тэр их гуниг, гутрал нь талаар болоогүй аж.

Өөр нэгэн захидалдаа Паул “Би аль ч элчээс илүү хөдөлмөрлөсөн” хэмээн маш чангаар мэдэгдсэн. Пөөх, Паул ингэж бичлээ гэж үү? Тэр жагсаалтад хэн, хэн багтаж байгааг бод доо: Петр, Иаков, Иохан, Барнаб, Апол тэргүүтэй томчууд шүү дээ. Биеэ тоосон мэт дуулдаж байгаа ч, Паулын дараа, дараагийн үгийг үзэх юм бол, түүнд биеэ тоосон явдал огт байгаагүйг харна:

Харин Бурханы нигүүлслээр би одоогийн би болсон. Түүний надад үзүүлсэн нигүүлсэл хоосон байгаагүй. Харин ч би тэд

бүгдээс илүү зүдэж зүтгэсэн юм. Гэхдээ би биш, харин надтай хамт байдаг Бурханы нигүүлсэл билээ. (1Коринт 15:10)

Паул өөрийнхөө хүчээр сайрхаагүй, Бурханы хүчийг гайхуулсан тул түүнд биеэ тоосон явдал нэгээхэн ч байсангүй. Тэрбээр тэнгэрийн даалгавраа биелүүлэхдээ нигүүлсэлд л найджээ. Олон жил гутарч явсан дасгалжуулагч Жийм эцэстээ ухааралд хүрээд, эдүгээ өөрийнхөө чадварт бус, харин Бурханы хүчинд (нигүүлсэлд) найдах болжээ. Тэрбээр амьдралынхаа тал бүр дээр энэ л цэц ухаанаа дэлгэж, сүхээ ирлэв!

Үүнийг мэдсэн болохоор, одоо бүгдээрээ хувийнхаа даалгавар руу орцгооё. Бурханы Үг “Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн Түүний бүтээл мөн. Биднийг эдгээрийн дотор яваасай гэж Бурхан урьдаас бэлтгэсэн билээ” (Ефес 2:10) гэдэг. Таныг төрөхөөс ч өмнө Бурхан Өөрөө танд даалгавар бэлтгэжээ. Энэ нарийн ур хийцтэй дуудлага л таныг өөр бусад ажил, тоглоомоос илүү жинхэнэ ололт амжилтанд хүргэнэ! Энэ хэмжээлшгүй хүчин чадалтай эд л таны зорилго болой. Үнэндээ дуудлагаа биелүүлэх тал дээр бид нэгэн чухал үнэнийг мэдэх хэрэгтэй:

*Бурхан танд төрөлх чадвараас чинь давсан
хувь тавилан бэлтгэсэн!*

Үүнийг тодруулж өгмөөр байна. Хүн бид тэнгэрийн даалгавраа төрөлх чадвараараа биелүүлэх ямар ч боломжгүй. Яаж мэдэж байгаа юм гэжүү? Яагаад гэвэл *Бурхан алдраа хэнтэй ч хуваалцахгүй* хэмээн хатуу мэдэгдсэн (Исаиа 48:11). Бид тэнгэрийн хувь тавилангаа эрийнхээ сайнд, хүнийхээ сүйхээгээр биелүүлчихбэл, Бурхан алдраа бидэнтэй хуваалцах ёстой болно. Гэтэл Бурхан тийм юм хийхгүй! Бурхан таныг Өөрийнх нь нигүүлсэлд найдаасай гэсэндээ зориуд төрөлх чадвараас чинь хол давсан дуудлага хүлээлгэв!

ГОЦ ЧАДВАР

Тэгэхээр бид нигүүлслийн гоц бэлэг гэж байдаг эсэхийг асуух хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, нигүүлсэл биднийг төрөлх чадвараас маань давсан хүчээр амьдруулдаг шиг, онцгой даалгаврын төлөө чадваржуулахаар Бурханаас өгөгддөг гоц хүчин чадвар гэж байх уу?

Үүнд хэд хэдэн жишээгээр хариулъя. Рожер Федерер гартаа цохиур, бөмбөг хэзээ ч аваагүй бол, дэлхийн хамгийн аугаа тоглогчдын нэг болохгүй байсан. Багажгүй мужаан хотынхоо алдартай мужаантай болохгүй. Микеланжело цүүц, багс, будаг бариагүй байсан бол, эдүгээ түүнийг хэн ч мэдэхгүй байх байсан. Тэгвэл тэнгэрийн дуудлага дээр ийм юм байх уу?

Хоёр богино түүх үүнийг тодорхой болгох байх. Би анх үйлчлэлээ эхлүүлж байхдаа нэгэн ер бусын, онцгой магтаалын удирдагчтай уулзаж байлаа. Тэр эрхэм 1900-гаад оны дундуур дэлхийд алдартай сайн мэдээ дэлгэрүүлэгчийн хүндэтгэл, магтаалыг удирддаг байв. Алдарт сайн мэдээ дэлгэрүүлэгчийг 1970 онд өөд болоход, сайх магтаалын удирдагч өөрийн гэсэн үйлчлэлээ эхлүүлсэн юм.

Тэрбээр 1980-аад онд манай чуулганд байнга зочилдог байсан бөгөөд би ч тэр бэлэгтэй хүнийг өөрийн эрхгүй шимтэн сонсоно! Миний хувьд тэр эрхэм төгөлдөр хуурыг жинхэнэ уйлуулдаг байлаа. Яах ийхийн зуургүй гурван мянга таван зуун хүнийг хөл дээр нь босгоод, дуулуулж, бүжүүлчихнэ. Түүнийг Бурханыг магтаж байхад, уур амьсгал тэг чигээрээ өөрчлөгдөж, Бурханы оршихуйгаар эрчлэгддэг байв.

Тэр эрхмийг сүүлийн хэдэн удаа манайд зочлоход нь түүнд үйлчлэх завшаан олдсон юм. Би ч энэ завшаанаа эдлэн, түүний Бурханаас хүлээж авсан чадварынх нь талаар мэдье гэсэн бүхнээ л асуулаа. Гэтэл түүний ээж - Бурханы үнэнч эмэгтэй өдөр бүр олон цагаар залбирдаг байжээ. Магтаалын удирдагч: “Жон, намайг ээжийнхээ хэвэлд байхад, гэрт маань нэгэн хүн ирсэн гэдэг. (Ээж маань түүнийг тэнгэрэлч байсан гэж итгэдэг байлаа.) Ээжийн маань хэзээ ч харж байгаагүй тэр эрхэм: “Хүү чинь багаасаа л төгөлдөр хуурыг чадварлаг эзэмшиж, олныг Бурханы оршихуй руу удирдана” гэж хэлсэн гэдэг” хэмээн хуучилж билээ.

Тэгээд дараа нь надад хэзээ ч мартахааргүй түүхээ ярьсан юм. Тэрбээр хөлд ороод байхдаа, өмнө хэзээ ч заалгаж, тоглож, хийж үзээгүй атлаа аав, ээжийнхээ төгөлдөр дээр суугаад, шууд л төгс тоглож гарчээ. Зүгээр нэг “Маамуу нааш ир” биш, харин туршлагатай төгөлдөр хуурчийн л тоглож чадах, хүнд хөгжмийн бүтээлээс даржээ. Мэдээж ямар ч нот харалгүй тоглосон.

Тэр өдрөөс хойш тэрбээр ямар ч нот цаасгүй, зөвхөн сонголоороо атлаа маш ур чадвартай тоглох болжээ. Түүнд аливаа дууг сонсоод л шууд тоглох чадвар заяаж.

Тэгээд хүүхэд байхаасаа л нутгийнхаа чуулганы хүндэтгэлийн цуглаанд үйлчилж эхэлжээ. Эцэстээ энэ бэлэг нь түүнд алдарт сайн мэдээ дэлгэрүүлэгчийн үйлчлэлд тоглох үүдийг нээж өгсөн байна.

Түүнд яриангүй тэнгэрийн чадвар өгөгдсөн байлаа.

Өөр нэгэн нэрд гарсан, бэлэгтэй хүн нь ямар ч уран зураг заалгалгүйгээр, дөрвөн настайгаасаа ер бусаар зурж эхэлсэн Акиане Крамарик билээ. Акиане зургаан настайгаасаа онцгой хараагаа даган маш хүнд уран зураг зурж эхэлсэн байна. Тэрбээр найман настайдаа миний бичгийн ширээний ард өлгөөтэй байдаг, алдарт “*Энхийн Ханхүү*” бүтээлээ зурсан юм.

Түүнд тэнгэрийн чадвар өгөгдсөн нь тодорхой байна.

Яагаад зөвхөн зарим нь л ийм бэлэг хүлээж авдаг юм бэ? Эсвэл асуултаа өөрөөр тавих ёстой юм уу?

Бид үнэндээ: “Бурхан бэлгээ бүх хүүхэддээ өгдөг үү, олонхд нь өгдөг үү эвсэл заримд нь өгдөг үү?” гэж асуух ёстой. Бүгдээрээ бүлгийнхээ эхэнд уншсан эшлэлээ дахин харцгаая:

Бидэнд өгөгдсөн *нигүүлслээр* бэлгүүд маань ялгаатай.
(Ром 12:6)

Бичээсийн энэ эшлэлд маш чухал атлаа онцгой үгс байна. Нэгдүгээрт - *нигүүлсэл* гэдэг нь *карис* гэдэг Грек үг болохыг бид хэдийнээ үзсэн. *Карис* дээрээ *ма* үеийг нэмбэл, *карисма* гэдэг өөр нэгэн Грек үг үүснэ. Энэ нь сая бидний үзсэн эшлэлд дурьдагдсан *бэлэг* гэдэг үг бөгөөд бүгдээрээ үүн дээр төвлөрч ярилцъя.

Карисмаг Шинэ гэрээнд ямар утга агуулгаар хэрэглэснийг нягтлахаар олон жил Грек толь бичиг эргүүлж байхдаа, би дараах тодорхойлолтыг гаргаж ирсэн юм:

Карисма нь хувь хүнийг онцгой чадвараар хүчжүүлдэг, нигүүлслийн онцгой бэлэг.

Үнэндээ энэ чадвар нь хувь хүнд Бурханы даалгадаг тэнгэрийн хүчин чадал бөгөөд ямагт хүний давамгай чигтэй, төрөлх чадварыг давдаг. Зарим бэлэг нь хараажийн гоц байдаг бол, бусад нь зүгээр л хүний төрөлх чадвар шиг харагддаг атлаа үнэндээ ер бусын бэлэг байна. Зарим бэлэг нь хүнийг төрөхөд өгөгдсөн бол, зарим нь тодорхой үед Эзэний Үгээр өгөгддөг байна.

БИЧИХ КАРИСМА

Тэгэхээр, бүгдээрээ *карисмаг* олборлох ажлаа миний амьдралын жишээгээр эхлүүлье. (Би энэ талаараа *Өнө мөнхөөр хөтлөгдөхүй* номдоо товч бичсэн.)

Бичих нь миний амьдралын *карисма* юм. Та манай үйлчлэлтэй саяхнаас танилцаж байгаа бол, би сургуульд байхдаа Англи хэл, зохион бичлэг, гадаад хэл дээрээ “ногоон нойл (нуль)” байсныг сайн мэдэхгүй байх. Заримдаа Англи хэлний багш маань надтай дахин нэг жил зууралдахаас айсандаа л намайг тэнцүүлсэн байх гэж бодогдох!

Ганц, хоёр нүүр юм бичих даалгавар өгөхөөр, гялалзуулаад л хаячих юмыг чинь би хэдэн цагаар зууралдана. Хоёр өгүүлбэр бичээд л, нөгөөхөө хэдэн минут гөлөрчихнө. Тэгээд агшин өнгөрөх тусам, өгүүлбэр маань улам л утгагүй, хөөрхийлэлтэй санагдаж, ой гутна. Эцэстээ цаасаа базаад хаяв ч, дахиад л эхлүүлнэ. Ийм дүр зураг хэдэнтэй давтагдаж, хичнээн ч цаас, цаг, мэдрэл барагдлаа. Заримдаа бүтэн цаг бичив ч, эхний параграфтаа дуусгаж ч чаддаггүй байж билээ.

Итгэхгүй байвал, би танд ЭсЭйТи дүнгээ хэлье л дээ. ЭсЭйТи бол их, дээд сургуульд элсэхэд өгдөг шалгалт юм. Миний үед *тоо, аман* гэсэн хоёр ерөнхий шалгалт өгдөг байлаа. *Аман* гэдэг нь үндсэндээ Англи хэлний уншиж, бичих чадвар шалгадаг шалгалт. Дээд оноо нь 800. Гэтэл би Англи хэл дээрээ 370 оноо авсан. (Тийм ээ, та зөв уншлаа.) Хувиар тооцох юм бол, 42 оноо буюу “F” (Эф) дүн болно. Би гуч гаруй жил аялахдаа, ЭсЭйТи - *аман* шалгалт дээрээ надаас бага оноо авсан ганцхан хүнтэй л таарч явлаа.

Одоо цаашаа гүйлгээд, гучаад насанд минь тохиолдсон явдлыг үзье. 1991 оны нэгэн өглөө намайг эзгүй, зайдуу газар залбирч байтал, Бурхан надад: “Миний хөө, чи ном бич” хэмээн айлдав.

Харин би: “Бурхан минь, Та үрээ танихгүй өнөр болохоороо, өөр нэгэн хүүхэдтэйгээ намайгаа андуурчээ. Та миний талаар Англи хэлний багшаас маань асуубал, арга буюу татгалзана даа” хэмээн дотроо инээв.

Гэтэл ямар ч хариугүй, нам гүм байлаа.

Тэгэхээр нь би Бурханыг хүлээн зөвшөөрчихлөө гэж үзэв. Би бодохдоо, Бурхан надтай маргаагүй учраас, өөрийгөө тэр асуудлаас мултарчихлаа гэж бодсон боловч, зүрх маань мэдрээд л байлаа.

Арван сарын дараа хоёр долоо хоногийн зайтай хоёр өөр мужид

явтал, хоёр өөр эмэгтэй хүрч ирээд: “Жон Бивэр, хэрэв чи Бурханы бичээрэй гэсэн үгийг бичихгүй бол, Бурхан үгээ өөр хүнд өгөөд, харин чи хожим хариуцлагаа хүлээх болно” гэсэн яг ижилхэн үг хэлсэн юм.

Флоридад эхний эмэгтэйгээс сонссон үгээ Техаст хоёр дахь эмэгтэйгээс сонсохдоо, би Бурханаас эмээж, ажилдаа оров. 1992 онд iPad (Айпад) байхгүй, үзэг цаасаар л бичдэг байсан болохоор, би дэвтрийн ганц хуудас аваад, дээр нь том үсгээр ГЭРЭЭ хэмээн гарчиглаад, ингэж бичив:

*“Аав аа, би бичиж гадаахгүй.
Тиймээс Таны үгэнд эргэхын тулд
надад Таны нилүүрлэл хэрэгтэй
байна! Би бичих ёстой юм бол,
үг бүр маань Таны Ариун Сүнсээр
хөглөгдөж, Таны төсөлгөөгөөр
төслөгдсөн байх болтугай.
Тэр үг эргүүд, эмэгтэйлүүд,
хүүхэд, хөшигд, пуулган, хөт,
үндэстнүүдийг өөрчлөх болтугай.
Харин би Танд бүх хүндэтгэл,
магтаал, алдар, талархалыг
нь эргэж байна. Би Тантай энэ
гэрээг Есүсийн нэрээр байгуулан
тамгалж байна.
Таны хүч бөгөөд зарц Жон Бивэр.”*

Одоо цааш гүйлгээд, гучин жилийн дараахыг буюу өнөөдрийг авч үзье. Эдүгээ миний бичсэн хорь гаруй ном хэдэн арван сая хувиар хэвлэгдээд байна. Олон ном маань Америкт ч, олон улсад ч, нийгмийн бөгөөд Христэч зах зээлийн аль альд бестселлерийн номын жагсаалтад багтлаа. Дэлхийн зуу гаруй хэлээр орчуулагдаж, хэд хэдэн улсад нийгмийн болоод Христэч ангилалд хамгийн олон хувиар хэвлэгдсэн ном болов.

Бараг ном болгоны маань 20-30 хувь миний өмнө огт сонсоогүй, уншаагүй, бодоогүй санаа байдаг. Бичиж байхад л орж ирдэг гэх үү. Би хэд хэдэн удаа албан өрөөндөө юмуу зочид буудалд байхдаа, бичсэн зүйлээ хараад алмайрч байснаа санадаг юм. Заримдаа “Пөөх, ямар хүчтэй үг вэ!” гэж дуу алдаад л, босон харайна.

“За, юун онгиороо юм” гэж үү?

Тэгвэл би хэлье. Энэ бүх агуулга *надаас* төрөөгүй. Миний бие Тэнгэрээс гадуурх хамгийн анхны уншигч нь болсон учраас л, эдгээр ном дээр миний нэр бичигдсэн гэдэгт би бүрэн итгэдэг! Энэ бүх үг Ариун Сүнснээс л ирдгийг би мэднэ. Яг л элч Паулын “Би аль ч элчээс илүү хөдөлмөрлөсөн” гэдэг үг жаахан онгиргон сонсогддогтой л адил. Үнэхээр ч Паул өрсөлдөх дуртай, аминч, өөртөө дурласан хүн шиг л сонсогдохгүй байна уу? Тийм боловч, Паул хэрэг дээрээ өөрийнхөө чадвараар бус, харин Бурханы нигүүлслийн бэлгээр онгирч байсныг Бичээсээс мэдэж болно.

Тэр өглөө залбирч байхад минь Бурхан надтай ярих үедээ амьдралд маань *бичих карисмаг нэвтрүүлсэн* байх гэж би итгэдэг. Гэхдээ намайг Бурханыг дуулгавартай дагах шийдвэр гаргатай, *идэвхижүүлээгүй* юм. Яг энэ талаар зарим хүн надтай санал нийлэхгүй байж мэдэх учраас, энэ тийм маргаад байх чухал зүйл биш гэдгийг шууд л хэлье. Яахав, би буруу итгэж байж болох учраас, хүмүүс юу гэж хэлж болох талаар ярилцъя.

Зарим хүн намайг 1979 онд дахин төрөх үед л бэлэг маань өгөгдсөн гэх байх. Би 1979 оноос 1992 онд Бурхантай гэрээ байгуулах хүртлээ юм бичиж үзээгүй учраас, энэ санааг баглан хэлэх туршлага надад байхгүй. Гэхдээ нэг зүйлийг баттай хэлж чадна: Би энэ бүлгийнхээ эхэнд өгүүлсэн төгөлдөр хуурч шиг бэлэгтэй төрөөгүй. Тийм боловч төгөлдөр хуурчийн жишээ нь зарим бэлэг нь үнэхээр хүнийг эхийнхээ хэвэлд бүрэлдэхээс л өгөгддөг гэсэн гол санааг батална. Жишээлбэл, Иохан Баптист эхийнхээ гэдсэнд байхдаа л Мариагийн гэдсэн дэхь амьд Христийг таньсан учир (Лук 1:41-ийг үзнэ үү), түүнийг эхийнхээ хэвэлд байхдаа л Бурханы Сүнсээр дүүрснийг Бичээс хэлдэг. Гучин жилийн дараа Есүс баптисм хийлгэхээр Иохан дээр ирэх үед (Иохан 1:29-ийг үзнэ үү) Иоханы доторх мөнөөх бэлэг Есүсийг (хэн хүнээс түрүүлж) таньсан байдаг.

Нөгөөтэйгүүр, зарим бэлэг хожуу ирдэг. Кишийн хүү Саул анхнаасаа л эш үзүүлдэг байгаагүй. Эрийн цээнд хүрч, Самуел түүнийг Израилийн анхны хаанаар тослон томилсны дараа л Саул эш үзүүлж эхэлсэн. Самуел түүнийг хөгжим дарж, эш үзүүлж байгаа хэсэг хүмүүстэй учрах талаар зөгнөсөн байдаг. Самуелын тэр хэсгийг шууд эш татъя: “Тэгэхэд ЭЗЭНий Сүнс чиний дээр бууж, чи тэдэнтэй хамт эш үзүүлж, өөр хүн болж өөрчлөгдөнө” (1Самуел 10:6).

Бичээсийн энэ хоёр гэрчлэлээс бид зарим бэлэг нь эхийнхээ хэвэлд байхад нь өгөгддөг бол, зарим нь хожим өгөгддийг мэдлээ.

ЯРИХ КАРИСМА

Миний амьдралын өөр нэгэн карисма нь ярих юм. Энэ талаарх яриа маань бидний ойлголтыг улам бэхжүүлэх байх аа.

Манай Лиза анх цуглаан дээр миний номлолыг яаж сонсож байсан нь санаанаас гардаггүй юм. Даруухнаар хэлэхэд, зүгээр л гамшиг - тоглоогүй шүү. Таван минут ярив уу, үгүй юу Лизагийн хоёр нүд анилдан, номлол дуустал нам унтчихаж билээ. Би ч номлоно гэж алж өгсөн л дөө. Лизатай зэрэгцэж суусан, хамгийн сайн найз Эми нь амаа ангайж, шүлсээ гоожуулсаар зүүднийхээ хаант улсаар аялсан! Би ч үнэндээ олны өмнө ярина гэж балладаг байв.

Тэр үед би нутгийнхаа чуулганы пастор, пасторынхаа гэргий хоёрт тусладаг байлаа. (Манай чуулган дөрвөн зуу гаруй бүтэн цагийн ажилтантай, Америкийн нэр нөлөө бүхий чуулганы нэг байв.) Миний хувьд пасторынхаа гэр бүлд болоод манай чуулганд зочилсон үйлчлэгч нарт үйлчилнэ. Би Хаанчлалд амаараа үйлчилнэ гэхээсээ, арын албанд зүтгэх үүрэг хариуцлагатай маань хэнд ч тодорхой байв (Энэ талаараа хожуу ярина аа).

Тийм боловч, Бурхан надад Түүний Үгийг даян дэлхийд тунхаглана гэдгийг маань харуулчихсан байсан учраас, би өөрийнхөө үйлчлэлийг эхлүүлэх гэж оролдож байлаа. Гэхдээ нэг алдаа гаргасан нь хүнийхээ хүчээр хийх гэж зүтгэсэн явдал байв. Тэгээд ч тэр үед би өөр хүний үйлчлэлд зүтгэх - “бусдын юмд итгэмжтэй байх” (Лук 16:12-ыг үзнэ үү) улирал дундаа явж байжээ. Тиймээс, чөлөө зав гармагц л хамаг эрч хүчээ өөрийнхөө үгийг туурвиж, үйлдвэрлэж, суртчилан таниулахад зарцуулж байв. (Уг нь тэр үед би илүү сайн үйлчлэгч, илүү сайн эр нөхөр байхын төлөө мэрийсэн бол дээр байх байсан ч, заримдаа хүн заавал алдаж байж л сурах юм даа).

Товчхондоо, би “Ишмаелын үйлчлэлийг” л төрүүлж байв. Яагаад ингэж нэрлэв гэж үү? Миний түүхтэй ижил нэгэн түүх Бичээст гардаг. Бурхан Абрамыг (Абрахамыг) далан тавтай байхад нь хүүтэй болж, цаашлаад олон үндэстний эцэг болно хэмээн амласан. Энэ амлалтаас хойш арван жилийн дараа Абрахам наян тав хүрсэн ч, ямар ч үр хүүхэд заяасангүй. Тиймээс Абрахам, түүний гэргий Сарай хоёр Бурханд амлалтаа биелүүлэхэд нь “туслах” төлөвлөгөө боловсруулсан. Хүмүүний энэ дэмий хүчин зүтгэлээс Ишмаел төрөв. Тиймээс би ийм маягийн хүчин зүтгэлийг “Ишмаел үйлчлэл” гэж тодорхойлдог юм.

Итгэмээргүй боловч, тэр үед заримдаа хүмүүс надад мөнгө өгдөг байв. Тэрийг нь би өөрийнхөө үндэслэн байгуулсан “Бивэр үйлчлэлдээ” зарцуулна. Тэр үйлчлэл маань “Бурханы гайхамшигт гэрлийг дэлхийд цацруулах” гэсэн уриатай байв. Үүнийг бичиж байхдаа, өөрийнхөө төлөвшөөгүй, мунхаг зангаас ичэх шиг. Үнэндээ, Лиза, Эми хоёрыг бүүвэйлчихдэг мөнөөх хичээл маань манай “Ишмаелын” эхний дөрвөн бүлэг бүхий номлолтой хуурцаг дээр бий! Тэр хичээлийн хуурцгийг сонсоод хичнээн хүн зүйрмэглэж, унтсан бол? Бие арзайх шиг!

За тэгээд итгэнэ үү, байна уу - гэхдээ байдал шал дордов. Тэр үед эдүгээ тэнгэрт байгаа, аугаа евангелист Ти. Эл. Осборн гуай миний баатар байлаа. Тэрбээр гэргийнхээ хамт тавь илүү сая хүнийг аврал руу дагуулсан хүн. Би ч яг түүн шиг номлохыг хүснэ. Түүний номлолыг олон цагаар дуустал нь сонсож, дуу хоолойнх нь өнгө, өргөлт, сургаал, хүчирхэг тунхаг, тэр бүү хэл хошигнолыг нь ч хуулан дуурайна. Би анхдагч бишээс гадна өрөөлийн тун тааруу хуулбар байв.

Ти. Эл. гуай үнэхээрийн суут илтгэгч байлаа. Түүнийг манай чуулганд заахад нь би үг бүрийг нь алдалгүй сонсоно. Тэрбээр нэг удаа Африкт зохион байгуулсан нүсэр аян дээр нь Бурханы хүч хүмүүсийг ёстой л ханаруулж байсан тухай ярьж байхдаа, ямар нэгэн ер бусын гайхамшиг үзэв үү гэлтэй: “Wow! (Ваав!)” хэмээн дуу алдав. Хүмүүс суудлынхаа ирмэг дээр тогтон, түүний дараачийн үгийг тосон чагнана. Гэтэл Ти. Эл. гуай чив чимээгүй болсноо: “Энэ нээрээ үнэхээр гайхамшигтай үг шүү. Араас нь ч уншсан, ялгаагүй л - “Wow! (Ваав)” гэж хэлдэг байгаа. Хүмүүс ч пир хийв. Түүн шиг ийм донжтой ярьдаг хүн үнэхээр байсангүй.

Гэтэл хөөрхий гэнэн би тэрийг нь хуулаад, юм л бол “Ваав!” гэж уулга алддаг болов. Нэг удаагийн онцгой тохиолдол дээр бүр яг Ти. Эл гуай шиг хэлэв. Онцлог нь хэн ч инээгээгүй юм. Гэтэл би үүнийг нь ойлгосонгүй.

Тийнхүү би өөрийнхөө хүчээр удаа дараалан бүтэлгүйтсээр, эцэстээ бууж өгөв. Тэгтэл гайхамшигтай сайхан өөрчлөлт гарч эхлэх нь тэр. Би дахиад л тухайн үед хийж байсан үйлчлэлдээ дурлаж эхлэв. Чөлөөт цагаа гэр бүл, найз нөхөддөө зориулдаг болов. Гүрдийж чардайхаа больсон учраас, амьдрал маань дүүрэн, баялаг, бүтэн болов. Сэтгэл амарсан хойноо, хамаг хүчин зүтгэл маань хоосон байсныг ч ухаарах нүдтэй болж, “Бивэр үйлчлэлийг” ч нурааж хаяхад хорогдох юмгүй болов. Бурхан амласнаа нэг л өдөр биелүүлнэ - гэхдээ миний санаачилгаар биш гэдгийг би ойлгожээ.

Тийнхүү намайг энх, амгаланг олсон чинь - тийм ээ, та таачихлаа - хэдхэн сарын дотор Бурхан ажилдаа шуурхайлав. Намайг Америкийн хамгийн хурдан өсч яваа нэгэн чуулган залуусынхаа цуглаанд пастораар үйлчлэхийг урилаа.

Тэр эхний Бүтэн сайныг хэзээ ч марташгүй. Манай чуулганы пастор чинь дэлхийд алдартай хүн. Тэр үед Бүтэн сайн өдрийн цуглаан болгон пиг дүүрдэг учраас, танхимд аятайхан суудал олж суух гэсэн хүмүүс халуун наранд хэдэн цагаар ч хамаагүй дугаарладаг байлаа. Дээрээс нь манай чуулган дотоод, гадаадын зочдоор тасрахгүй.

Чуулган болгон пиг. Магтаал ч ер бусын. Тэгээд тэр өдөр пастор тайзан дээр гарч ирэхдээ, хамгийн түрүүнд шинэ пасторыг буюу намайг танилцуулснаа, гэнэт намайг гарч ирээд, хүмүүст хандан ганц, хоёр үг хэлээч гэж хүсэв.

Гэтэл энэ үед гэргий маань жигтэйхэн бажгадсныг би мэдээгүй юм. Өөрөө би сөхөөрөх ч завдалгүй гарсан болохоор, бажгадаж ч амжсангүй. Тэгээд *цэвэр шоконд оров!* Намайг хоёр мянга найман зуун хүнд хандаж үг хэл гэсэн шүү дээ. Лиза миний урьдын явдлуудыг мэддэг болохоороо, юу л болдог бол гэхээс цэлдэн хөх болжээ. Тэр аймшигтай үр дагавраас дараа нь яаж сэргэнэ? Угаасаа энэ ярианы дараа надаар дахиж том цуглаан дээр үг хэлүүлэхгүй нь тодорхой учраас, магадгүй энэ миний эхний бөгөөд эцсийн номлол болох байх. Намайг тайз руу явж байхад, Лизагийн дотор энэ мэтийн түмэн айдас шуурч байжээ. Намайг Ти. Эл. Осборн гуайг дуурайгаад, ялангуяа нөгөө хүмүүсийг хачин эвгүй нам гүм болгодог, хаанаас нь ч уншсан “Ваав!” - гаа л битгий хэлээсэй хэмээн зовнин залбирснаа хожим Лиза надад хэлж билээ.

Намайг тайзан дээр гарч очтол, тэргүүн пастор микрофон өгөв. Чуулган тэр аяараа миний удахгүй хэлэх үгийг баяр хөөртэйгээр дэмжин, минут хэртээ зогсон, алга ташиж, уухайлж, хашхирцгаав. Миний дөрөв, таван минутын үгийг хоёр мянга найман зуун хүн босоогоороо сонсож дуусгалаа. Дараа нь би микрофоноо пасторгаа буцааж өгөөд, суудалдаа эргэж суув. Адреналинаас болоод тэр үү эсвэл Бурханы оршихуйгаас болоод тэр үү эсвэл аль алиас нь болоод тэр үү, таван минут хэртээ хамаг бие маань салганав.

Сая болж өнгөрсөн зүйлд гэргий маань ангайжээ. Тэрбээр цуглааны дараа: “Жон, би *нөхрийн маань биеийг хэн эзлэхивээ* ээ л гэж бодсон шүү” гэж хэлж билээ.

Анхныхаа үйлчлэлийн үеэр манайх Техаст амьдардаг байсан бол, мөнөөх чуулган маань Флоридад байдаг байв. Тэгээд Лиза олон жилийн турш асуусан хүн бүрт “Биднийг Флоридагийн хилийг давахад, Жон өөр хүн болж хувирсан” хэмээн тайлбарладаг байж билээ. Саулын амьдрал дээр Бурханы бэлэг бууж ирснийг үүнтэй төстэй хэлсэн байдаг даа (1Самуел 10:6).

Тэр цагаас хойш би сонсогч нарт ихэвчлэн ямар ч бэрхшээлгүй номлож, зааж, илтгэсээр явна (Бэрхшээлтэй үеийнхээ талаар би дараа дараагийнхаа бүлгээр тайлбарлана). Ийнхүү би Ишмаелын үеийнх шигээ зовж, зүдэрч байж ярихаа больсон юм. Ишмаелын үе, Исаакийн үе нь шөнө, өдөр шиг л ялгаатай үр дүнтэй байлаа.

Одоо тэр Флоридагийн Бүтэн сайнаас хойш гүйлгээд, 8-10 жилийн дараах цаг үе рүү очъё. Тэр үед Мессенжер Интернэйшнэл маань амжилттай байгуулагдаад байлаа. Нэг өдөр манайх гараждаа хаврын их цэвэрлэгээ хийж байв. Хайрцаг, савнуудаа ухаж байтал, нөгөө Лиза, Эми хоёрыг бүүвэйлсэн хичээлийн маань эх бичлэг гараад ирэх нь тэр. Би ч шууд л аваад хогийн савандаа хийх гэтэл, гэнэт Ариун Сүнс: “Хүү минь, наад эхээ битгий хая” гэж айлдахыг дууллаа.

Би ч өөдөөс нь шууд л: “Яагаад? Энэ хичээлийг хэн ч сонсохгүй. Устгабал таарна” гэж хэлэв.

Тэгтэл дахиад л: “Битгий хая” гэдэг үг сонсогдлоо.

Би ч Бурханаас сонссоноо мэдсэн атлаа: “Яагаад?” хэмээн эсэргүүцэв.

Гэтэл Эзэн: “Наадах чинь чамайг хамгаална” хэмээн зүрхэнд маань тодоос тод айлдав.

- “Хамгаална аа?”

Тэгтэл Бурхан цэц ухаанаа тайлав: “Хүү минь, чи Надгүйгээр ямар аймшигтай номлогч болохоо бүү мартаасай.”

Жил өнгөрөх тусам би тэр “хамгаалагч” хүчин зүйлийг улам л ойлгож байна. Өнгөрөгч гучаад жилд энэ бэлэг хүчтэй ажиллан, арвин их үр жимс гаргаж байна. Үй олон удаа уур амьсгал солигдож, илчлэлийн өмнө магтаалын тэсрэлт болж, хүмүүс бөөн бөөнөөрөө аврагдаж, янз бүрийн гайхамшиг бий болохыг би гэрчлэн харсан. Амьдрал, чуулган нь мөнхөд өөрчлөгдсөн тухай ч олон хүн ярьдаг. Би энэ их баялаг үр жимсийг үзээд, миний гавьяа гэж бодож болох ч, надад үнэхээр “Би биш, Бурхан надаар дамжин нигүүлслээрээ ажилласан юм” (2Коринт 15:10) гэж хэлсэн Паулын үгээс өөр зүйл бодогддоггүй. Энэ олон жил би Бурханы *карисмагүйгээр* хэн байснаа хэзээ ч мартаагүй.


ТА БЭЛЭГТЭЙ ЮУ?

Бусдад үйлчлүүлж, бусдыг байгуулахаар Бурхан надад энэ хоёр бэлгийг өгсөн билээ. Миний зөрчил танил санагдаж байна уу? Магадгүй үүнийг уншаад та амьдралынхаа *карисмаг* олох гэсэн зөрчил чинь хэвийн зүйл болохыг ойлгосон байх. Эсвэл та эдгээр түүхийг уншихдаа, *Надад ямар ч бэлэг алга* хэмээн улам их гонсойж, унжийв уу? Тэгвэл танд бэлэг бий гэдгийг би баттай хэлнэ. Энэ нь дараагийн хоёр бүлгээр улам тодорхой болно.

Би танд “Бурхан бэлгээ бүх хүүхэддээ өгдөг үү, олонхд нь өгдөг үү эвсэл заримд нь өгдөг үү?” гэдэг асуултад хариулахаа амласан. Үүнд “бүгдэд нь!” гэж хариулна. Үүнийгээ ч тун удахгүй Бичээсээр батлая. Бүгдээрээ энэ асуултад дэлгэрэнгүй хариулт авахаар барахгүй, та номоо дуусгахаасаа өмнө *карисмагаа* хэрхэн олж илрүүлж, хөгжүүлж, хэрэглэхийг баттай ойлгож аваад, тийнхүү Бурханы Хаанчлалыг байгуулах үйлсийнхээ үр нөлөөг үржүүлнэ.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

1. Библийн нигүүлсэл нь Бурханы авралын бэлэг төдийгүй, бидний амьдралд зориулсан Бурханы хүч юм. Та Бурханы хүчийг юу гэж үздэг байв? Энэ бүлгийг уншсан хойноо нигүүлслийн талаарх бодол чинь хэрхэн өөрчлөгдөв?
2. Бурхан танд таны төрөлх чадвараас давсан хувь тавилан зэхсэн. Яагаад Бурхан тэгэх болов? Танд элбэгээр өгөгдсөн Бурханы нигүүлслийн хүчийг хэрхэн хэрэгжүүлэх вэ?
3. Бурхан бэлгээ бүх хүүхэддээ өгдөг үү, олонхд нь өгдөг үү эвсэл заримд нь өгдөг үү? Та ямар чадвар, бэлэг хүлээж авсан бэ? Бэлгийнхээ ашиг тусыг бусдын төлөө хэрхэн гаргая гэж бодож байна?



*Өөрийнхөө талаар бодох ёстойгоосоо
илүүгээр бүү бод.*

— Ром 12:3

3

Өөрийгөө шударгаар үнэл

Тэгэхээр би амьдралынхаа *карисмаг* олж авч, хэрэгжүүлэх гэж хэрхэн зүдэрснээ хуваалцсан болохоор, одоо надад огт *байдаггүй* бэлгийн талаар товч ярьмаар байна.

Дэндүү олон зүйл байгаа тул бүгдийг тоочино гэвэл, залхмаар урт жагсаалт болно байх. Жагсаалтыг маань дуулж, хөгжимдөх ур чадвар тэргүүлнэ. Намайг гэртээ дуулахаар гэргий, хүүхдүүд маань дотроо аялахыг эелдгээр атлаа хатуу санал болгодог.

Ахлах сургуулийн биеийн тамирын хувцасны өрөөний шүршүүрт би ганц удаа л дуулж билээ. Намайг дуугаа хураа хэмээн хөвгүүд сүргээрээ сүртэй нь аргагүй орилолдож, нэг нь бүр савтай шампуниа чулуудаж билээ.

Аав, ээж хоёр маань хэдэн хүүхэддээ бүгдэд нь төгөлдөр хуур заалгасан бөгөөд манай багш хотдоо нилээд алдартай, мэргэжлийн төгөлдөр хуурч хүн байлаа. Багшлахдаа ч дутахгүй мундаг. Гэвч надад төгөлдөр хуур заах гэж бүтэн дөрвөн жил ноцолдсон хойноо аав, ээж хоёртой уулзаад, хүүдээ төгөлдөр хуур битгий сургаач гэж гуйж билээ. Тийм л найдваргүй байж би!

Би ч хамаг учир нь төгөлдөр хууртаа байсан гэж үзсэн учраас, хэдэн жилийн дараа өөр хөгжим оролдож үзэв. Тэгээд сонгодог гитар худалдаж аваад, алдартай багштай ч боллоо. Багш надтай тун тэвчээртэй, хичээнгүй ажиллаж, би ч хамаг л хүчин чадлаараа мэрийж байсан ч, нэг л болж өгөхгүй байв. Тэгээд жил хагасын дараа надад хөгжмийн ур чадвар байхгүй гэдгээ хүлээн зөвшөөрч билээ.

Хэтийн үр дүн гарсан уу? Үндсэндээ өчнөөн жил өнгөрсөн ч, юу ч өөрчлөгдөөгүй гэж хэлж болно. Ном бичсэн түүхээс маань тэс өөр. Ер нь би амьдралдаа дуу хөгжмийн талаараа цоороогүй юм.

ӨӨРТӨӨ ҮНЭЛГЭЭ ӨГӨХ

Ийнхүү би өөрт байхгүй бэлгээ тоочоод л байвал, тоочоод л байна. Гэхдээ та гол санааг нь ойлгосон байх аа. Бид бүгдээрээ л сайн хийж чаддаггүй юмаа ерөнхийдөө гадарладаг. Заримдаа бүр хүн юун дээр бэлэгтэй болохоо бэлэггүй талаа сайн мэддэг шигээ амархан мэдчихдэг байсан бол ч гэж бодогдох.

Үүнийг санангаа Паулын дараах зааврыг харцгаая:

Надад соёрхогдсон нигүүлслээр би та нарын хүн нэгбүрд чинь хэлье. Өөрийнхөө талаар бодох ёстойгоосоо илүүгээр бүү бод. Харин Бурханы хүн бүрд ногдуулсан итгэлийн хэмжээний дагуу эрүүл ухаанаар бод. Нэг биед олон эрхтэн байдгийн адил мөн бүх эрхтэнд ижил үйл ажиллагаа байдаггүйн адил, бид олуулаа Христэд нэг бие бөгөөд хүн бүр нэг нэгэндээ эрхтэн юм. Бидэнд өгөгдсөн нигүүлслээр бэлгүүд маань ялгаатай. (Ром 12:3-6)

Паул энэ үгээ *сэрэмжлүүлэг* болгон хэлжээ. Тухайлах юм бол: “Өөрийнхөө талаар бодох ёстойгоосоо илүүгээр бүү бод” гэжээ. Өөрөөр хэлбэл, өөрийгөө шударгаар үнэл гэж байна. Юугаа үнэлэх гэж? *Тухайн цаг үед* Бурхан таны амьдралд ямар бэлэг өгөөд байгааг үнэлэх.

Яагаад *тухайн цаг үед* гэж хэлэв гэж үү? Маш энгийн. Өмнө умшсан Библийн жишээг харъя. Тухайлбал Саул Самуелтай уулзахаасаа өмнө: “Би эш үзүүлж чадахгүй” л гэж шударгаар хэлэх байсан. Энэ нь тухайн цаг үедээ үнэн л байх байв. Тийм боловч, Саулыг Самуелтай уулзсаны дараа амьдрал дээр нь Бурханы бэлэг бууж ирсэн бөгөөд тухайн цаг үедээ Саул: “Би эш үзүүлж чадна” л гэж шударгаар хэлэх байв.

Хөөрхий би Ишмаел үйлчлэлийг төрүүлэх гэж ухнатаж байхдаа, энэ эшлэлийг илүү нарийн уншсан ч болоосой. Шударгаар хандсан бол, *тухайн цаг үед* надад олон нийтэд номлох биш, харин пастортаа үйлчлэх бэлэг байсныг ухаарах байж. Гэтэл би залбирч байхад минь маш тодорхой дуулдсан бас удирдагч нарын маань зөгнөж хэлсэн *ирж яваа юмсыг* хүнийхээ төрөлх чадвараар төрүүлэх гэж оролджээ. Гэвч цаг нь болоогүй байсан бөгөөд хэрэв би Бичээс

дээрх уг тушаалыг анхаарч, даалгавраа шударгаар гүйцэтгэсэн бол, маш их цаг, хөрөнгө мөнгө, эрч хүч хэмнэх байсан нь тодорхой. Түүнчлэн би *тухайн цаг үед* надад өгөгдөөд байсан бэлгээ ч хамаагүй үр нөлөөтэй хэрэглэх байжээ.

Төрөл бүрийн бэлгийн тал дээр Паул маш тодорхой хэлсэн: “Нэг биед олон эрхтэн байдгийн адил мөн бүх эрхтэнд ижил үйл ажиллагаа байдаггүйн адил” (Ром 12:4). Хүний бие дээр авч ярьбал, энэхүү энгийн ухаан маш ойлгомжтой болж ирнэ. Бодоод үз: хурууны хийж чадах юмсыг хамар хийж чадахгүй. Хамрын хийж чадах юмсыг чих хийж чадахгүй. Чихний хийж чадах юмсыг гэдэс хийж чадахгүй. Гэдэсний хийж чадах юмсыг элэг хийж чадахгүй гэх мэт. Гэхдээ хамгийн гол санаа нь:

*Өөрийнхөө бэлгийг олж аваад,
хэрэглэж байгаа хүн жаргалтай бөгөөд ерөөлтэй бол,
өрөөлийн бэлгээр ажиллах гэж оролдож байгаа хүн
золгүй бөгөөд зовлонтой.*

Нэг өглөө сэртэл эрхий мэргэн чинь: “Түйцээ! Ам чи, олон жил ярьлаа. Одоо миний ээлж” гэж хэлбэл, хачин юм болох биш үү? Эрхий мэргэн ам шиг авиа дуу гаргах хүчин чадалгүй учраас, үүн шиг хөгтэй юм байхгүй. Тийм боловч, эрхий хуруунд байдаг онцгой чадварыг ам гүйцэтгэж чадахгүй. Тухайлбал ам: “Өнөөдөр би үсэг шивнэ!” гэвэл мөн л хөгтэй хэрэг болно.

Тэгвэл дараагийн асуултыг тавья: Бид яагаад “тайзны бэлгийг” бүхнээс дээгүүр тавьдаг вэ? Яагаад номлогч нарыг, чуулган удирддаг магтаалын удирдагч нарыг хамгийн өндөр бэлгийг эрхшээсэн мэт үздэг вэ? Энэ талаар Коринтын чуулганд Паул “Бүр мөхөс мэт санагдах эрхтэн харин ч биед илүү хэрэгтэй байдаг” (1Коринт 12:22) хэмээн мэдэгджээ.

Нэгэн бодитой жишээ хэлье. Хүний хөл ер нь анхааралд их өртдөг. Хүмүүс: “Яасан гоё урт нарийхан хөлтэй юм бэ?!” гэх юмуу эсвэл “Яасан гоё булчинлаг хөлтэй юм бэ?!” гэдэг.

Намайг өсвөрийн хүүхэд байхад манай үг дуу цөөтэй, хуучинсаг, журамтай ааваас маань гарамгүй нэгэн үйлдэл гарсныг би санадаг юм. Аав маань өөр дээрээ хүний анхаарал татах ёстой дургүй хүн. Гэтэл тэр өдөр аав маань гэнэт: “Миний хүү чинь лут хөлтэй юм аа” гэж хэлсэн юм.

Би ч цочсондоо аавыгаа чухам юу хэлэх гээд байгааг нь гайхан, муухан мушилзсаар, аав руугаа дэмий л ширтлээ. Гэтэл аав: “Учрыг нь мэдмээр байна уу? Миний хүү чинь аавыгаа дуурайсан бакь хөлтэй байхгүй юу” гэв.

Би ч аавынхаа огцом үгэнд барьц алдсандаа, шоглох, санал нийлэхээ мэдэхгүй, дэмий л мишээгээд: “Надад гоё хөлөө өвлүүлсэнд баярлалаа, аав аа” гэж л хэлсэн юм.

Тийм ээ, хөл үнэхээр анхааралд өртдөг. Гэхдээ хүн хөлгүйгээр ч амьдарч чаддаг шүү дээ. Энэ талаар та юу гэж бодож байна? Авто ослоор нэг хөлгүй болсон ч, жирийн хүн шиг л амьдарч, ажиллаж яваа нэгэн хүнийг би мэднэ.

Тэгвэл элэгний хувьд өөр шүү. Элэггүй хүн амьдарч чадахгүй. Хөлнөөс ч чухал эрхтэн. Тийм боловч хүмүүс хэзээ ч: “Пээш, ямар янзтай элэгтэй юм бэ!” гэж ярьдаггүй л байхгүй юу. Тийм үг байхгүй!

Тиймээс дахин Паулын үгийг харцгаая: “Бүр мөхөс мэт санагдах эрхтэн харин ч биед илүү хэрэгтэй байдаг.”

Тэгвэл би дахиад асууя: “Бид яагаад “тайзны бэлгийг” бүхнээс дээгүүр тавьдаг вэ?” Тэдгээр нь “ил” эрхтнүүд бөгөөд хэрэгцээтэй боловч, Бурханы Үгээс үзбэл, амин эрхтнүүд биш ажээ.

(Нэгдүгээр бүлэгт гардаг) Стан гэдэг найз маань бизнесийн ертөнц дэхь хүмүүст нөлөөлөхөөс гадна хөрөнгө мөнгө үйлдвэрлэж, бусдад өгөх бэлэгтэй. Гэтэл чуулган дотор тогтсон, бичигдээгүй хуулийн дагуу авч үзбэл, түүний бэлгийг тайзны бэлэгтэй дүйцэхгүй гэж тооцно. Чуулганд ямар хууль давамгайлдаг билээ? “Тайзан дээрх хүмүүс л жинхэнэ дуудагдсан, сонсогдсон хүмүүс!”

Бодоод үз. Хүн: “Тэр (эрэгтэй, эмэгтэй) хүн дуудлагатай” гэж ярьбал, бусад нь шууд л пасторын, магтаалын удирдагчийн, залуусын удирдагчийн, Христэч зохиолчийн, илгээлтийн эзний дуудлагын талаар л боддог. Энэ үгийг сонсоод тун цөөхөн хүн л “Тэр хүн эрүүл мэндийн салбарт дуудагдаад, хорт хавдрыг анагаах шинэ эмчилгээний арга судлаж байгаа”, “Тэр эмэгтэй улсын их хуралд сонгогдоод, хаанчлалын өргөжин тэлэлтийг хамгаалах хууль санаачилж байгаа”, “Тэр эрэгтэй боловсролын салбарт ажиллаж, хүүхэд багачуудад Бурханы мэдлэг, цэц ухааны үрийг тарьж яваа”, “Тэр эмэгтэй зах зээлийн салбарт төөрөгсдөд хүрч, хаанчлалын бүтээн байгуулалтыг санхүүжүүлэхээр бизнесийн салбарт дуудагдсан” гэж бодно байх.

Авъяас бэлгийн талаарх ийм үзэл бодол нь ямар үр дагаварт хүргэдэг нь тодорхой: Олон жил Стан өөрийгөө надаас ялгаагүй “дуудагдсанаа” мэдэлгүйгээр, чуулганд явжээ. “Чуулганд хамааралтай бэлгүүд л тэргүүн шугаманд, бусад нь дагуул” гэдэг бичигдээгүй ойлголтоос болж, Стан шиг хүмүүс Бурханаас өгөгдсөн үнэт бэлгээ үнэгүүдүүлдэг байна. Үүнийг өөрчлөх ёстой! Бид бүгдээрээ дуудагдсан бөгөөд хаанчлалын даалгаврыг биелүүлэхэд маань хэрэгтэй онцгой бэлгийг бүгдээрээ тээдэг.

Бүхэлдээ Паул Коринтын чуулганд ингэж хэлжээ:

Харин эдүгээ Бурхан Өөрөө хүссэнчлэн эрхтэн тусбүрийг биед байрлуулжээ. Хэрэв бүгдээрээ нэг эрхтэн байсан бол бие нь хаана байх билээ? Харин эдүгээ олон эрхтэн байдаг ч нэг бие байна. Нүд “Чи надад хэрэггүй” гэж гарт эсвэл толгой “Та нар надад хэрэггүй” гэж хөлд хэлж чадахгүй юм. Бүр мөхөс мэт санагдах эрхтэн харин ч биед илүү хэрэгтэй байдаг. Бидэнд тийм ч эрхэм биш санагддаг биеийн эрхтнүүдээ бид илүү эрхэмлэн хувцасладаг бөгөөд хүндлэлгүй харагддаг эрхтнүүддээ илүү хүндэтгэлийг үзүүлдэг. Бидэнд хүндэтгэлтэй харагдах эрхтнүүдэд энэ нь хэрэггүй аж. Харин Бурхан биеийг ийнхүү нэгтгэсэн бөгөөд дутмагдуу эрхтнүүдэд илүү эрхэмлэл өгдөг. Ингэснээр биед хагарал үгүй, харин эрхтнүүд нь бие биендээ адилхан халамжтай байх юм. (1Коринт 12:18-25)

Магадгүй бид чуулганд юмуу цуглаанд хандсан Паулын үгийг хязгаарласнаасаа болоод, чуулганд хамаатай бэлгийг бусад бэлгээс илүү дээдэлдэг байж болох юм. Мэдээж чуулганы уур амьсгал дотор номлох юмуу заах бэлэг нь илүү эрэлт хэрэгцээтэй байна. Тийм боловч хаанчлалын ажил хаа сайгүй өрнөж байгаа учраас, энэ нь бидний эрс тэс шилжилт гэж харах ёстой өөр нэгэн загвар юм. “Чуулганыг” Грекээр *екклесиас* гэдэг. Энэ нь “гадагш дуудагдсан” гэсэн үг. Мөн Грек толь бичиг дээр “Тусгаар улсын олон нийтийн үйл хэрэгт дуудагдагсад юмуу чуулагсад, дуудагдсан хүмүүс, бүрэн дуунаар сайн дураараа цугласан бүлэг иргэд”¹ хэмээн нэмж тайлбарлажээ.

Бид чинь барилга байшин дотор цуглахаараа л чуулган болдог гэж үү? Бид чинь залбирч, магтаж, номлож, үйлчлэхээр цуглахдаа л чуулган болдог гэж үү? Энэ загвар хүмүүсийг чуулган хэмээх

тайз - засал дотор нэг янзаар, нийгэмд нөгөө янзаар авирлахад хүргэж байна. Бид чинь жилийн 365 хоногт, долоо хоногийн 7 өдөрт, хоногийн 24 цагт хаанчлалыг байгуулах бэлгээр зэвсэглэсэн чуулган шүү дээ.

Саяхан олон тэрбумын хөрөнгөтэй нэгэн хүнтэй уулзлаа. Тэрбээр “Бурханы аялал” гэдэг үйл ажиллагааг зохион явуулдаг ажээ. Тэгээд багтайгаа янз бүрийн хотод зохион байгуулагдаж байгаа чуулган, конференцэд нисч очин, оролцоод, зорьсон үйлчлэгч нартайгаа уулздаг байна. Зорилго нь: Тэрбээр таван талт үйлчлэлийг хурцалж, цаашлаад ажилдаа улам боловсрохыг хүсдэг ажээ. Тэр эрхэм, бид хоёрыг манай нэг сайн найз уулзуулсан юм. Би тэр эрхэмтэй Далласын конференцэд заах үеэрээ уулзав. Биднийг гурван цагийн турш сайхан хооллож, хөөрөлдөөд, салах үед надад би тэр уулзалтаас сайх эрхмээс ч илүү олз омогтой гарч явах шиг санагдаж билээ.

Тэрбээр анх ажлаа эхлүүлэхдээ, бизнесийн ертөнцөд хөлөө олохгүй гуйвж яваад, нэг өдөр нүд нь нээгдсэн тухайгаа ярьсан юм. Яагаад хаанчлалын үйл ажил хаа сайгүй өрнөхгүй, зөвхөн чуулган, конференц дотор л болдог юм бэ гэсэн асуултаас түүний ухаарал төржээ. Тэрбээр зах зээлийн талбарт дуудагдсанаа мэдээд байгаа атлаа яагаад ч юм итгэгч биш хүмүүсээс ялгаагүй авирлана. Түүнийг дэлхийгээс юу ч тусгаарлахгүй.

Тэгээд тэрбээр зах зээлийн талбар дээр яг л тайзан дээр байгаа үйлчлэгч шиг “Бурхантай хамт алхаж”, Ариун Сүнсний дуу хоолойг сонсоно” хэмээн шийджээ. Үндсэндээ тэрбээр дуудлагын асуулттай нүүр тулаад, өөрийгөө ямар ч пастораас дутахгүй Бурханаар дуудагдсан хэмээн шийджээ. Дараа нь Бурханаас өгөгдсөн бэлгээ тодорхойлоод, түүгээрээ ажиллах зорилго гаргав. Чимээгүй цагаараа ч, бизнесийн уулзалт дээрээ ч Бурханы дуу хоолойг сонсоно. Тэгээд мэдээж Бурхан түүний зах зээлийн үйл хэрэг дээр мэдлэг, цэц ухааны үгийг өгчээ.

Үр дүн нь ч илэрхий байв: тэрбээр одоо зөрчилдөх юмгүй болов! Тэрбээр Бурханаас хүлээн авсан боловч, ихэвчлэн ямар ч ач холбогдолгүй санагддаг байсан, онцгой Үгээс хуваалцав. Тийм боловч, тэрбээр бизнесийн уламжлалт ухаантай зөрчилдсөн, дагахад таагүй тэнгэрийн тэр зааврыг дагахаар шийджээ. Үүнээс нь болж үйлчлүүлэгч нарынх нь зүгээс ч, баг хамт олных нь зүгээс ч бөөн бөөн асуулт, гайхсан царай, зовнил, тэр бүү хэл эсэргүүцэл ирдэг байсан талаараа ч ярив. Гэхдээ Бурханы Үгд тууштай итгэж,

бат зогссоных нь үр дүн тэрбум, тэрбумын үнэтэй байжээ. Түүний ер бусын түүх намайг бишрүүлэв.

ҮНДЭСТНҮҮДИЙГ ДАГАЛДУУЛАХ

Өнөөдөр бид бэлгийн талаарх чуулганы үзлийг өөрчлөх юм бол, ямар үр дүн гарах бол? Хүн бүр хаанчлалын бүтээн байгуулалтад дуудагдсан, бэлэгтэй, үнэ цэнэтэй гэдэг үгийг биднийг сонссон хүн бүрт үр дүнтэй хүргэбэл, ямар үр дүн гарах бол? Мэдэж ядах юмгүй - хүн бүр Билли Грахам, Орал Робертс, Тереза эх, элч Паул шиг зорилго, улайрлаар ажиллана. Би мөнөөх тэрбумтантай уулзахдаа, яг ийм зорилго, улайрлыг олж харсан билээ. Тэрбээр Бурханаас өгөгдсөн даалгавраа бас үүнийг биелүүлэхэд бэлэг нь ямар чухал болохыг мэдэж байв.

Үндэстнүүдийг дагалдуулахын тулд бид энэ загварыг мэдэж байх ёстой. Энэ санааг лавшруулж үзье. Есүс “Чуулганд явагсдыг бий болго” гэж хэлээгүй, харин “бүх үндэстнийг дагалдуул” (Матай 28:19) хэмээн тушаасан. Грекээр “үндэстнүүдийг” этнос гэдэг. Үүнийг “Угсаа гарал, соёл, нийтлэг уламжлалаараа нэгдсэн хүмүүсийн бүлэг”² хэмээн тодорхойлдог. Үүнд мэдээж үндэстэн, овог аймаг, газар нутаг, ястнууд багтана. Гэхдээ бас дугуйчид, жүжигчид, эмч нар, бизнес эрхлэгчид, нисгэгчид, хуульчид, хүүхдээ асардаг ээжүүд, төрийн алба хаагч нар, тамирчид гэх зэрэг бүх төрлийн, нийтлэг чигийн хүмүүсийг багтааж болно. Бид амьдралын ийм олон хүрээний эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг дагалдуулах үүрэгтэй.

За тэгвэл, цаашаа дахиад нэг алхам ахицгаая. Есүс “Үндэстэн доторх хүмүүсийг дагалдуул” гэж хэлээгүй, харин “үндэстнүүдийг дагалдуул” гэсэн. Үүний ялгааг гаргах нь чухал. Бид Бурханы Үгээр дамжин эдгээр өөр, өөр хүрээнд ажиллах аргаа өөрчлөх ёстой. Мэдээж нэн түрүүнд энэ өөр, өөр хүрээний хүмүүст хүрэх ёстой. Гэхдээ болоогүй ээ, бүр цаашаа явах хэрэгтэй. Бид хүмүүсийг төрдийгүй мөн тэдний ажиллагааны горимыг Аав, Хүү, Ариун Сүнсний арга зам дотор булхана. Тухайлбал яг л түрүүчийн тэмбумтан шиг зах зээлийн талбар дээрх хүмүүсийн сэтгэлгээг өөрчлөхөд нь оролцоно гэсэн үг. Энэ бол мөсөн уулын орой л юм.

Заккайг аваад үз. Тэрбээр нутагтаа хамгийн зартай, татвар хураагчдын толгойлогч байсан. Үндсэндээ тэр газрын мафийн

загалмайлсан эцэг гэх үү. Тэгээд мэдээж татвар хураагч хүн яадаг билээ - хувийнхаа ашиг сонирхлын төлөө албан тушаалаа урвуулан ашигладаг учраас, ард олныхоо жигшил зэвүүг хүргэнэ. Мэдээж иргэдээсээ хулгайлж, луйвардаж, залилаж, сүрдүүлж, дарангуйлдаг л байсан байж таараа. Тэрбээр нэр нөлөө бүхий, зартай этгээд байсан тул доодхи хүмүүс нь ч түүнийг даган дуурайдаг л байсан байж таараа.

Би ч аялж явахдаа хэд хэдэн улсад ийм үзэгдэл харсан. Улсынх нь удирдагч завхарсан учраас, бүх ажил нь хээл хахуулиар урагшилна. Доодхи албан тушаалтнууд нь яг адилхан. Сүүлдээ бүр нисэх онгоцны буудал дээрх гаалийн ажилтанд нь мөнгө атгуулахгүй бол, улсаас нь явах зөвшөөрөл олгохгүй.

За, Заккай руугаа буцъя. Есүс түүнийг нэрээр нь дуудаад, ердөө: “Заккай!... бушуу буугаад ир! Би өнөөдөр танай гэрт зочлох ёстой!” гэж хэлсэн нь сонирхолтой.

Заккай Эзэнтэний өмнө зогсоод: “Хараач Эзэн, өөрийнхөө хөрөнгөний хагасыг би ядууст өгнө. Хэрэв би хэн нэгнээс залилан авсан байвал түүнийгээ дөрөв дахин нугалж эргүүлэн өгнө” (Лук 19:5-8) гэж хариулсан.

Тэр нутгийн татвар яасан? Татварын газрынх нь даргын ажиллах загвар дэлхийн бохир арга барилаас хаанчлалын арга барил руу шилжсэн! Одоо тэр нутгийн төр/бизнесийн ажил тэнгэрийн арга загвараар газар дээр өрнөх болсон! Нийгэм нь өөрчлөгдсөн. Энэ өөрчлөлт цуглаан дээр ч болоогүй, Есүс конференц хийж байхдаа Заккайг араасаа дага гэж ятгасан учраас ч, болоогүй. Зүгээр л хотынх нь төвд өрнөсөн. Заккай Есүстэй уулзахад, түүний ажиллагааны арга шууд өөрчлөгдсөн. Биднийг янз бүрийн улсад хүмүүстэй уулзахад (буюу бидний нөлөөллийн хүрээнд) ийм л зүйл болох ёстой. Учир нь бидний дотор Есүс байна.

Яг одоо би олон нийтийн сүлжээгээр бодигийн тамирчдад хүчтэй нөлөөлдөг, ЭнЭфЭл-ийн хуучин тамирчныг дагалдуулж байгаа. Тэрбээр манай улсад (*этнос* бүлэгт) хаанчлалын соёлыг нэвтрүүлэх аргаар бодигийн итгэдэг, итгэдэггүй тамирчдад нөлөөлж байна. Тэрбээр тэр хүмүүст хаанчлалын арга зам, арга барилыг бодитоор харуулах маягаар нөлөөлж байна.

Бэлэг маань мэдээж чуулганы байранд цугласан ариун хүмүүст зориулагдсан гэдэг хөдлөшгүй үнэнийг би үгүйсгэхгүй. Гэхдээ энэ бол үнэний тал хувь нь.


Хэрэв та нийгмийг ариунаас тусад нь үзэж байвал, наад

сэтгэлгээгээ өөрчлөх хэрэгтэй. Та мэс засалч, сувилагчийнхаа хувьд эмнэлгийнхээ өрөөнд орно уу, багшийнхаа хувьд сургуулийнхаа танхимд орно уу, машинистынхаа хувьд үйлдвэрт орно уу - хаашаа орсон ч, тухайн уур амьсгалдаа Аав, Хүү, Ариун Сүнсний нэрээр ариуныг авчрах бэлэгтэй. Өөрөөр хэлбэл, Есүс Заккайг болоод өөр олон хүнийг өөрчилсөн шиг, тэнгэрийг газар дээр буулгах тулгуур, эрх мэдэл нь танд бий. Та нөлөөллийнхөө талбар дээр тэнгэрийн ажиллагааны горимыг үржүүлэхээр дуудагдсан.

Тэгэхээр албан газар руугаа юмуу сургууль руугаа явна гэдэг чинь жинхэнэ адал явдал бус уу?

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

1. Бичээс биднийг өөрийгөө үнэлэх тал дээрээ бодитой байхыг сэрэмжлүүлсэн. Энэ даалгаврыг тухайн цаг үедээ л хамаатуулж хийх ёстой. Миний нөгөө цаг нь болоогүй байхад үйлчлэлээ эхлүүлэх гэж оролдсон түүхийг санаж байна уу? Та ийм алдаанаас хэрхэн сэргийлэх вэ? Танд яг одоо юу хийх бэлэг байна?
2. Өөрийнхөө бэлгийг олж аваад, хэрэглэж байгаа хүн жаргалтай бөгөөд ерөөлтэй бол, өрөөлийн бэлгээр ажиллах гэж оролдож байгаа хүн золгүй бөгөөд зовлонтой. Та өөрийнхөө дуудлагаас өөр талбар руу гүйх өдөөлтөд орж байсан уу? Байсан бол, яагаад?
3. Бэлэг маань дан ганц байшин доторх, ариун хүмүүсийн төлөө бус мөн гагцхүү бидний л нөлөөлж чадах хүрээнийхэнд зориулагдсан. Таны өдөр тутмын амьдрал Бурханы хаанчлалыг байгуулахад аль зэрэг чухал гэж та үзэж байна? Та аман бэлгээ хаанчлалын зорилгын төлөө ямар арга замаар хэрэглэж чадах вэ?



*Биднийг Христийн зарц нар ба
Бурханы нууцын нярвууд гэж тооцог.*

— 1Коринт 4:1

4

Нярав

Бид нигүүлсэл, бэлэг гэдэг үгсийг авч үзсэн болохоор одоо *нярвын ажил* руу орцгооё. Энэ үгийн утгыг тогтоочихбол, дараа нь дээрх гурван үгээ нэгтгээд, амьдралынхаа үүргийг олж мэдье.

Мириам - Вебстерийн тайлбар толь дээр *нярвын ажлыг* “өөрийнх нь мэдэлд даатгагдсан зүйлийг хариуцлагатайгаар, няхуур авч явах үйлдэл” хэмээн тодорхойлжээ. Орчуулах явцад үгийн эх утга гээгдэх тохиолдол их гардаг учир, Грек эх үгийг нь заавал шалгах хэрэгтэй байдаг. Тэгвэл нярвын ажил дээр ийм доголдол гардаггүй. Яагаад гэвэл Грек, Англи үгсийнх нь утга нилээд ойр байдаг. Дээрх эшлэл дээр *нярвыг ойкономос* гэжээ. Үүнийг “Ямар нэгэн зүйлийн төлөө эрх мэдэл, үүрэг хариуцлага хүлээсэн хүн - үүрэгтэн, хариуцлагатан, зохион байгуулагч, менежер”³ гэж тодорхойлдог.

Дээрх хоёр тодорхойлолт дээр гурван нийтлэг тал тодорхой харагдаж байна:

- Өрөөлийн өмчийг харгалздаг.
- Өөрийнх нь эрх мэдэлд даатгагдсан зүйлийг авч яван, захиран зарцуулах эрх мэдэлтэй.
- Өмчийн эзний өмнө хариуцлага хүлээдэг.

Бурхан бүх зүйлийг бүтээсэн бөгөөд өмчилдөг! Дуулал 24:1 дээр “Газар хийгээд түүнийг дүүргэдэг бүхэн, Дэлхий хийгээд түүнд оршигч бүгд ЭЗЭНийх юм” хэмээн тунхагладаг. Тэгэхээр бид энэ бүх талбарын нярав болж байна. Бид газар, ус, агаар, баялаг, амьтад, загас, шувуу, дэлхийг бүхлээр нь захиран, авч явах ёстой. Бид хүний сүнс, сэтгэл санаа, оюун, бие махбодын сайн сайханд анхаарч, халамжлах ёстой. Үүнд бүхий л бурханлаг бөгөөд сайн сайхан мэдлэг, цэц ухаан,

ойлголт багтана. Энэ мэтчилэн үргэлжлүүлээд байж болох ч, үндсэндээ бид газар дээрх ил, далд бүх зүйлд үүрэг хариуцлагатай юм.

Тэгэхээр, Паул нярвын талаар чухам юу хэлснийг цааш нь лавшруулж үзье. Тэрбээр “Бурханы нууцуудын нярав” байх талаар бичжээ. Дэ Ливинг Транслэйшн дээр “Бурханы нууцуудыг тайлбарлах *эрхийг хүлээн авсан*” гэдэг. Илчлэл буюу хараахан илчлэгдээгүй байгаа нууцгай үнэнийг - нууцуудыг дамжуулах нь Паулын амьдралын нэгэн бэлэг (карисма) байсан. Тиймээс энд өгүүлсэн *нярвын ажил* нь мөнгө, цаг, баялгийг захиран зарцуулах тухай бус (гэхдээ мэдээж эдгээр нь ялгаагүй л нярвын чухал ажил мөн), харин амьдралд байгаа бэлгээ (карисмагаа) захиран зарцуулах тухай ажээ. Энэ бүхэн бидэнд хамаатай юу?

Петр: “Хүн бүр хүлээн авсан *бэлгээрээ* бие биендээ Бурханы олон төрлийн *нигүүлслийн* сайн *нярвууд* шиг үйлчил” (1Петр 4:10) хэмээн бичсэн. Бидний тодруулсан бүх үг бүгдээрээ энэ ганц эшлэлд байна (бэлэг: карисма, нярвууд: ойкономос, нигүүлсэл: карис). Петр ч бас Паултай адил бидэнд даатгагдсан карисмагийн нярав байх талаар хэлжээ. Нэг мэдэгдэлд олон зүйл илчилсэн байгаа учраас, бид ч нарийн шалгах хэрэгтэй.

Петр “хүн бүр” бэлэг хүлээн авсан талаар хэлжээ. Тэрбээр “Үйлчлэгч бүр, пастор бүр, магтаалын удирдагч бүр” гэх зэрэг аль нэг аман бэлгийг онцлон заагаагүй, харин “хүн бүр” гэж хэлсэн байгааг тэмдэглэнэ үү. Та дахин төрсөн л бол, танд ямар нэгэн бэлэг заавал итгэмжлэгдэн, даалгагдсан л байгаа. Энэ бол хоёр бүлгийн өмнөх асуултад маань өгөх Бичээсийн хариулт болой. *Танд бэлэг юмуу бэлгүүд байгаа бөгөөд тэдгээр нь таныг онцгой чадвараар хүчжүүлэх нигүүлслийн онцгой соёрхол* гэдгийг батлан хэлье.

Тэгэхээр, би танд бэлэг чинь хичнээн чухал болохыг Паулын жишээгээр үлгэрлэн харуулмаар байна. Паул нярвын ажлыг маш нухацтай авч үзсэн - үнэндээ аминчлан чухалчилсан. Хожим Коринтын чуулганд тэрбээр ингэж бичжээ:

Учир нь надад энэ алба тохоогдсон тул би сайнмэдээг тунхагласнаараа сайрхах юм алга. Учир нь би сайнмэдээг эс тунхаглаваас золгүй еэ! Би үүнийг хүслээрээ хийвэл шагнал хүртэнэ. Хүслийн минь эсрэг байлаа ч *нярвын үүрэг нь надад даалгагдсан* юм. (1Коринт 9:16-17)

Энэ эшлэл дээрх *би золгүй еэ* гэдэг үг шууд анхаарал татаж байна. Энэ бол бидний ойлголтоос хол давсан, жинтэй үг юм. Золгүйг Грекээр

оуай гэдэг. “Гамшиг, аймшиг”⁴ гэсэн утгатай. Өөр нэгэн тайлбар тольд “гашуудал, хилэнгийн халаглал”⁵ гэж тайлбарласан байдаг. Шинэ гэрээ энэ үгийг хэрэглэх бүрийдээ нэр дурьдагдсан хүмүүсийг хүлээж буй туйлын ноцтой, аймшигт шүүхийн талаар хэлсэн байдаг. Паул “би золгүй еэ” гэж хэлэхдээ, дуудлагаа өөр дээрээ хараал дуудахтай адилтгажээ. Үүнд анхаарахгүй өнгөрч огт болохгүй. Тэгэхээр, Бурханы бидэнд өгсөн бэлгийг үл тоох нь аюултай зүйл ажээ.

Бурхан өөрт нь маш үнэ цэнэтэй зүйл даалгасныг Паул мэдэж байсан. Тэгэхээр, хэрэв Паул үүнийг нь зөв зүйтэй захиран зарцуулахгүй бол, хүмүүс үүнээс нь ашиг тус хүртэхгүйгээр барахгүй, Бурханаас тэдэнд өгөхийг хүссэн зүйлийг бүр мөсөн алдах нь байна. Тэр бэлэг нь өөрт нь бус, харин түүгээр дамжин бусдад өгөгдсөн болохыг Паул мэдэж байсан. Өөрөөр хэлбэл, Паул Бурханы бусдад өгөхийг хүссэн зүйлийг тээж явсан учраас, нярвын ажлыг хайхрахгүй аваас, би “золгүй еэ” гэсэн учиртай юмсанж.

Тэгвэл, энэ үгийг өөрсөд дээрээ тулгаж үзье. Тэмдэглэх хэрэгтэй хоёр сонирхолтой зүйл байна. Нэгдүгээрт - Паулын бэлэг нь “ил” бэлэг байсан. Бурхан зарим далд бэлэгт ил бэлгээс ч өндөр хүндэтгэл хүлээлгэсэн байдгийг санаж байна уу? Тэгвэл, Паул ил бэлгээ тэгтэл чухалчилж байхад, бид нэн ялангуяа Бурханы бидэнд өгсөн далд бэлэгт хайхрамжгүй хандаж бүр ч болохгүй.

Хоёр дахь зарчим нь бүр чухал: Таны амьдралд байгаа бэлэг нь танд зориулагдсан бус, харин танаар *дамжин* бусдад *зориулагдсан*. Бичих бэлэг нь миний төлөө бус, таны төлөө зориулагдсан болой. Номлох бэлэг нь миний төлөө бус, таны төлөө зориулагдсан болой. Удирдах бэлэг нь миний төлөө бус, харин миний удирдаж байгаа хүмүүс тэргүүтэй бусдын төлөө зориулагдсан юм.

БЭЛГЭЭ ХЭРХЭН ХЭРЭГЛЭХЭЭ БИД ӨӨРСДӨӨ Л СОНГОНО

Амьдралд байгаа бэлгээ зөвөөр хэрэглэх эсвэл буруугаар хэрэглэхээ бид өөрсдөө л шийднэ. Бэлгийг хаанчлалыг байгуулах анхдагч тэнгэрийн зорилгоор нь хэрэглэхгүй байсан ч, бэлэг маань ажилласаар байна. Адольф Гитлер аугаа удирдагч байсан бөгөөд Герман, Еврей, Орос, Франц, Британи тэргүүтэй олон сая

хүнд ашиг тустай замаар улс үндэстнээ удирдаж болох л байсан. Тэрбээр энэ бэлгээ Бурханы алдрын төлөө, өөрийнхөө болоод ард түмнийхээ ашиг тусын төлөө хэрэглэсэн үү? Эсвэл хор хөнөөл тарихын төлөө хэрэглэсэн үү? Бурханлаг бус зорилгоор Еврейчүүд тэргүүтэй олон үндэстнийг хүйс тэмтрэн, тамлаж, алаагүй юу? Тэрбээр амьдрал дахь удирдах бэлгээ буруугаар хэрэглээгүй юу? Хариулт нь хэлэлцэх ч шаардлагагүй, тодорхой юм.

Адольф Гитлерийн нярвын ажил нь тодорхой байгаа бол, тийм ч тодорхой бус өөр алдартнуудыг авч үзье л дээ. Эхлээд миний энэ яваа насандаа сонсож явсан, хамгийн аугаа хоолойтой, алдарт Уитни Хьюстон. Хьюстоны амьдрал дээр Бурханы мутар байгаа нь илэрхий байв. Сонсогч нар нь дашраараа сэтгэлийн хөг алдарна. Тэрбээр үнэхээрийн газрын бус, тэнгэрлэг, үлэмжийн хоолойтой байлаа.

Хоёр дахь нь Куин рок группийн гоцлол дуучин Фредди Меркури. Тэрбээр зохиох болоод дуулах бэлгээрээ цэнгэлдэх дүүрэн хүмүүсийг хүссэн чигтээ ханаруулна. Тэрбээр үнэхээрийн хосгүй - зарим нь бүр ер бусын ч гэх байх - бэлэгтэй хүн байв. Тоглолт бүр дээрээ олныг хүссэнээрээ зална. Өдий олон жил өнгөрчихөөд байхад л дуунууд нь дуулагдсаар.

Тэгвэл Уитни, Фредди нар бэлгээ сайн захиран зарцуулсан уу? Мэдээж тэгсэн гэж маргах хүмүүс гарах л байх. Тэгвэл энэ асуултыг Есүсийн үгээр шүүж үзье.

Мэргэн ухаан *үйлсээрээ* зөвтгөгддөг (Мэргэн ухаан зөв болох нь *үр дүнгээрээ харагддаг*). (Матай 11:19)

Гэсэн хэдий ч мэргэн ухаан нь бүх хүүхдээрээ зөвтгөгддөг (Мэргэн ухаан зөв болох нь *дагадаг хүмүүсийнх нь амьдралаар харагддаг*). (Лук 7:35)

Бүгдээрээ дээрх хоёр суутны нярвын ажлын богино болоод уртын үр дүнг шалгаж үзье. Уитни хүмүүсийг Бурханы оршихуй руу удирдсан уу? Түүний дууг сонсоод хүмүүс бурханлаг байдал руу тэмүүлсэн үү? Түүний дуу гэрлэлтийн гэрээг бэхжүүлсэн үү эсвэл хийсвэр уянгын хүлээлэг үүсгэн, сэтгэл дундуур байдлыг хөхүүлэн дэмжсэн үү? Фредди сонсогч нарыг зөвт байдал руу чиглүүлэхэд бэлгээ хэрэглэсэн үү? Хүмүүсийг Бүтээгчээ хүндэтгэ хэмээн заасан уу? Уитни ч, Фредди ч энэ дэлхийгээс хэрхэн явсан билээ? Тэдний өв соёл мөнх настай байна уу, богино настай байна уу? Мөнхөд тогтох уу эсвэл энэ дэлхийтэй хамт үгүйрэх үү?

Есүс биднийг үр дүнг нь шалгаарай хэмээн ятгажээ. Уитни, Фредди хоёрын нярвын ажлын үр дүнг та өөрөө дүгнэх биз ээ. Тийм боловч, эцсийн шүүхийг Бүтээгч маань Өөрийн биеэр ирэхдээ л хэлнэ. Шүүх өдөр хүн бүр тайлангаа тавина.

Хэрэв та Уитнигийн юмуу Фреддигийн бишрэн шүтэгч бол, ийм ярианд эгдүүцэж байгаа байх. Тэгвэл шүүхээр тэдний нярвын ажил хэрхэн дүгнэгдэх талаар арай дэлгэрүүлж үзье л дээ. Тэдний үлдээсэн өв өнөөгөөс арван сая жилийн дараа хэрхэгийг бодъё. Уитни, Фредди хоёр тэр үед Бурханы өгсөн бэлгийг захиран зарцуулснаа эргэж хараад, юу гэж дүгнэх бол? Өнө мөнхийн үзлээр шалгабал, одоогийн үзэл бодол чинь өөрчлөгдөж мэдэх.

Амьдрал тэр чигээрээ үзэл бодлоос тогтоно. Бид амьдралыг наян жилийн уртаар хэмжбэл, нэг янзаар харна. Харин өнө мөнхийн үзэл санаагаар харбал, амьдрал өөрөөр үзэгдэнэ.

Ингэж төсөөлье л дөө: Та кафед оройн зоогт уригджээ. Хүссэн бүхнээ иддэг кафе. Томуу ширээн дээр зүйл, зүйлийн амттан өржээ. Та маргаашийг боддоггүй хүн бол, яах уу? Магадгүй ширээн дээрх амттаныг бүгдийг нь идэх байх. Харин маргаашаа боддог хүн бол, тэр ширээнээс ганц амттан идэх юмуу эсвэл идэхгүй өнгөрөх байх. Яагаад? Яагаад гэвэл та эрүүл саруул, урт наслахыг хүсдэг учраас, маргааш нь гэдэс гүзээгээ өвтгөөд, дээрээс нь долоо хоногт таван килограм нэмэхийг хүсэхгүй!

Уитни, Фредди хоёрын үр жимсийг өнө мөнхийн өндөрлөгөөс харбал, нярвын ажлаа аль хэр ухаалаг хийсэн нь тодорхой болж ирнэ.

Гитлер, Уитни Хьюстон, Фредди Меркуриг яаж ч үнэлж дүгнэх нь бидэнд халгүй. Тийм боловч биднийг өөр нэгэн бодитой аюул хүлээж байна: Та, бид хоёр бас Шүүгчийнхээ өмнө зогсоод, хүлээн авсан бэлгээ тайлагнах болно. Бидний бэлгийг наян жилийн үзлээр бус, өнө мөнхийн үзлээр нэвт шувт шүүнэ. Бэлэг маань Өөрийнх нь хаанчлалыг байгуулаарай гэсэн Бурханы мөнхийн үгийн гэрлээр шалгагдах болно. Өв маань тэсээд үлдэх үү эсвэл дэлхийн системтэй хамт замхрах уу?

СЭДЛЭЭ НЯГЛАХ

Нэгдүгээр бүлэгт ярилцсан зүйлээ дахин давтъя. Та нярав учраас, бэлгээ тухай бүр гурван арга замаар ашиглаж болно:

- “Та бэлгээ хаанчлалыг байгуулахад хэрэглэж болно.”
- “Та бэлгээ өөрийгөө байгуулахад хэрэглэж болно.”
- “Та бэлгээ тэр чигээр нь хэрэглэлгүй, үл хэрэгсэж болно.”

Хоёр дахь зарчим нь тун зальжин учраас, онцгой анхаарах хэрэгтэй шүү. Олон хүн өөрийгөө бусдыг байгуулж, хаанчлалын төлөө зүтгэж байна гэж боддог ч, хэрэг дээрээ хувийнхаа ашиг сонирхлын сэдлээр хийсэн байдаг.

Би ч бас энэ алдаанд санаандгүй унаж л явлаа. Олон жилийн өмнө үйлчлэлээ дөнгөж эхлүүлж байхдаа, би багийнхандаа бас ойр тойрныхоо хүмүүст дандаа л таатай, сайхан үг хэлдэг байсан юм. Худлаа байсан ч хамаагүй, жаргалтай, гоё үг хэлээд л байна. Хүмүүс ч намайг хайраар дүүрэн, сайн хүн гэж магтдаг болов. Үүнд нь оодорсон би улам ч наалинхайтсаар.

Гэтэл нэг өдөр Бурхан надад: “Хүмүүс чамайг хайраар дүүрэн, халамжтай, эелдэг хүн гэдэг гэл үү?” гэв.

Уг нь би ийм үгийг сайшаал гэж хүлээн авдаг боловч, тухайн үед Ариун Сүнс тийм өнгө аясаар хэлээгүйг мэдэрлээ. Тиймээс болгоомжтойгоор: “Тийм ээ” гэж хариулав.

Гэтэл Ариун Сүнс тэр даруй: “Чи яагаад хүмүүст гоё үг хэлдгээ мэдэх үү?” гэлээ.

Би бүр ч болгоомжтойгоор: “Яагаад?” гэж асуув.

— “Яагаад гэвэл чи хүмүүст гологдохоос айдаг. Тиймээс чиний хайрын төв нь чи байна уу, хүмүүс байна уу?”

Сэдэл маань аргалахын аргагүй ил гарсан болохоор, би Бурханы үнэн үгийг үг дуугүй хүлээн зөвшөөрлөө.

Тэгтэл Ариун Сүнс: “Хэрэв чи хүмүүст үнэхээр хайртай байсан бол, дургүйг нь хүргэж байсан ч, хамаагүй зөвийг хэлэх л байсан” хэмээв.

Энэ үг хүмүүст хандах хандлагыг маань зассан юм. Гэхдээ энэ харилцан ярианаас бид хамгийн гол нь “Хүн - бид амьдралд маань өгсөн Бурханы бэлгийг буруугаар хэрэглэж боломжтой юу?” гэдгийг л тодруулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, хүмүүс биднийг бэлгээ хаанчлалын төлөө л хэрэглээд байна гэж харж болох ч, үнэндээ бид амин хувийнхаа сэдлээр хэрэглэж байж болох уу? Үүнд мэдээж тийм гэж хариулах бөгөөд би дахиад л өөрийнхөө нэгэн жишээг хэлээд, дараа нь түүнийгээ Бичээсээр багапгая.

Ер нь бол, би конференц, цуглаан дээр юу заах талаар Эзэнээс шууд үг авдаггүй боловч, Сүнсний удирдамжийг зүрхээрээ байнга чагнадаг. Тэгтэл нэг удаа номлолын өмнө Эзэнээс маш тодорхой, шууд үг хүлээн авав.

Би Мидвестэд болох конференц дээр үйлчлэх хуваарьтай байлаа. Тэгээд хуваарьт өдрийнхөө өглөө зочид буудалдаа сэртэл, Ариун Сүнс: “Чи өнөө оройн конференц дээр *Сатаны урхийг* заа” гэж айлдахыг тодорхой сонсов (Энэ бол 1994 онд миний бичсэн,

биднийг шархлуулсан хүмүүсийг эрх чөлөөтэйгээр уучлах талаар өгүүлдэг, гомдлын тухай ном билээ).

Тэгээд би Ариун Сүнсний заавартай өдөржин зөрчилдөв. *Сатаны урхийг* би олон жил заасан. Энэ бол шилдэг борлуулалттай ном. Ном маань дэлхий даяар түгээд удаж байгааг хэлэх үү - ер нь бол бүгд л энэ талаар мэднэ. Ариун Сүнсний зааврыг хүндээр тусгаж авсан өөр нэгэн шалтгаан нь тухайн үед би шинэ ном дээрээ ажиллаж байлаа. Хүн олон сар бичихээр, шинэ үнэн зүрхэнд нь илүү шинэлэг, хүчтэй амьсгалдаг. Товчхондоо, би хуучин үг ярихыг хүссэнгүй. Гэтэл Ариун Сүнс үгээ шууд хэлчихсэн байдаг.

Орой нь танхимд иртэл, өнөө орой таныг сонсохоор олон хүн алс холоос зорьж ирсэн л гэлээ. Би ч тэр холын зочид *Сатаны урхийг* уншчихсан л байгаа. Тиймээс яаж нөгөө л хуучин үгээ ярина аа хэмээн яс хавталзлаа.

Танхимд явж ортол, эрч хүчээр халуу оргиж байв. Хүмүүс ч догдлоостой. Энэ бүхэн өглөөний үгийг бүр ч хүнд санагдуулав. Би үнэхээр хүмүүсийг гонсойлгохыг хүссэнгүй. Тэгээд зөрчилдөө бууж өгөөд, “шинэ” үгээ номлохоор шийдсэн бөгөөд үүндээ ч сэтгэл хангалуун үлдэв. Номлол маань ч хүчтэй байж, хүмүүс ч эрч хүчтэй хүлээн авлаа. Зарим нь намайг чухал, чухал үг хэлэх бүрийд суудлаасаа босон харайж, дэмжиж байв. Би ч Бурханыг “аргалчихлаа” л гэж бодлоо. Эсвэл өглөө буруу, зөрүү сонсчихсон ч юм билүү. Ямар ч байсан сэтгэл хачин их хангалуун байлаа. Цуглааны дараа амралтын өрөөнд хүн болгон л надад хүчирхэг үгийн төлөө талархаж, баяр хүргэв.

Ерөнхийдөө, би тэр хотоос жигтэйхэн хангалуун хөдөлсөн бөгөөд бараг л Бурхан Өөрөө ч зүрхэнд минь мишээгээд байх шиг санагдаж байлаа. Гэтэл маргааш өглөө нь тэс өөр байдал угтав. Нүдээ нээгэл, зүрхийг маань бул чулуу шиг дарамт таглачихсан, хамаг бие сульдчихсан, сэтгэл санаа гэж авах юмгүй сэрэв. Би ч Бурханы үгэнд ороогүйгээс тэр гэдгийг шууд л мэдлээ. Би шууд орноосоо босоод, сөгдөн гэмшиж, уучлал эрэн, Есүсийн цусаар намайг цэвэрлэхийг гуйв.

Гэтэл ямар ч тайтгарал ирсэнгүй. Зочид буудлаасаа гарах хүртэл, онгоцны буудал дээр очиход, хойшилсон нислэгээ хүлээж байхад, Вест Коаст руу нисэх замд - ер нь өдөржин дарамттай, гунигтай байв. Тэсэхийн аргагүй гуниг, дарамт, сэтгэл санааны хямрал. Эцэст нь онгоц газардахаар Сан Диего дээгүүр эргэлдэж байтал гэнэт дарамт ховхорч, хөнгөрөөд явчихав.

Би ч: “Аав аа, би өглөө гэмшиж, уучлал гуйсан. Тэгээд Та яагаад миний баяр хөөр, амар тайван, хангалуун сэтгэлийг одоо л сэргээж байгаа юм бэ?” гэж асуулаа.

Гэтэл Эзэн: “Дуулгаваргүй байдал ямар аюултай болохыг ойлгуулах

гэсэндээ Би чамд жинг нь үүрүүлсэн юм. Өчигдөр оройн цуглаан дээр Би чамаар дамжуулан нэгэн пасторт *Сатаны урхийг* сонсгохыг хүссэн. Түүний амьдрал, үйлчлэл хүнд цагаар туулж яваа. Чи дуулгаваргүй авирласан - дуулгаваргүй байдалд үр дагавар бий. Чиний үүрсэн жин чинь дахиж битгий дуулгаваргүй загнаарай гэсэн анхааруулга. Чи одоо шинэ хотод ирж байна - одооноос үгэнд ороорой” хэмээн айлдав.

Дуулгаваргүй загнасан оройны хувьд, тэнд цугласан хүмүүс, конференцийн багийнхан, удирдагч нар бүгд маш баяртай байсан. Тэд намайг дахин урьж номлуулахдаа, тэр оройны цуглаанаар ямар үр дүн гарсныг тайлагнаж билээ. Тэгэхээр, тэр орой Бурханы бэлэг надаар дамжин ажиллахдаа, гол тэнгэрийн зорилгоо гүйцэлдүүлж чадаагүй боловч, ажиллах нь ажиллажээ.

Тиймээс ийм зүйл болох боломжтойг харав уу? Тэгвэл тэнгэрийн бэлгийг буруугаар хэрэглэсэн, Бичээсийн нэгэн түүхийг авч үзье. Тэр хүн бол Мосе. Тэрбээр Израилийг Амлагдсан газар руу удирдахаар дуудагдсан бөгөөд даалгавраа биелүүлэхийн төлөө ер бусын гайхамшиг бүтээх, бэлэгтэй хүн байлаа.

Нэг удаа Бурхан Мосед “хаданд тушаабал, хүмүүсийг ундаалах ус ундарна” гэжээ. Гэтэл Мосе ууртайгаар хадыг дэлсээд, Бурханы тэнгэрлэг зааврыг шууд зөрчсөн.

Тийм боловч, цөлд байсан сая, сая хүнийг хангалттай ундаалах ус гардгаараа л гарсан. Мосегийн намтар түүхд бичигдэж үлдэх бас нэгэн нүд хужирлам гайхамшиг! Хүмүүс ч удирдагчийнхаа бас нэгэн бэлгийг биширсэн. Тийм боловч, “конференц” дууссаны дараа Мосе бэлгээ зааврын дагуу хэрэглээгүй гэдэг “пактаар” Бурхан дээр дуудагдав. Тэгээд энэ буруугаасаа болоод Амлагдсан газарт хөл тавих эрхээ хасуулсан юм. Бас л аймаар түүх шүү.

Өөр нэгэн жишээ нь Балаам болно. Түүний Израилийн дээр эш үзүүлсэн үгс нь өнөө хэр Бичээст байгаа. Бурханы мөнхийн Үгд эш үзүүллээ бичүүлнэ гэдэг үнэхээрийн биширмээр, мундаг гэрчлэл! Гэхдээ түүх үүгээр дуусаагүй: Бурхан Балаамд битгий яв, хүмүүсийн хүслийг битгий биелүүл, “Чи тэдэнтэй явахгүй” (Тооллого 22:12) хэмээн онцлон хориглоод байхад л Балаамын бэлэг ажилласан. Түүний бэлэг ч бас тэнгэрийн анхдагч зорилгоос гадуур ажиллажээ.

Тэгэхээр, Бурхан даалгасан бэлэгтээ бичил зохицуулалт хийдэггүй нь байна. Бурхан бэлгүүдээ бидэнд даалгаагүй байсан бол, биднийг *нярав* гэж нэрлэхгүй. Учир нь нярав хүнд хүлээж авсан юмсаа захиран зарцуулах эрх нь өгөгдсөн байдаг бөгөөд нярав

байнгын хараа хяналт дор байхгүй. Үүнийг Бичээс дээр Есүсийн өгүүлсэн, шударга бус няравын сургаалт үлгэр багатгана:

Шавь нартаа Тэрээр мөн ийнхүү айлдав. —Нэгэн баян хүн няравтай байжээ. Өнөөх нярав нь түүний эд хөрөнгийг үрэн таран хийж байгааг эзэн нь сонсов. Тэгээд түүнийг дуудаж “Чиний талаар би юу л сонсоод байна даа? Ажил үүргийнхээ дансыг нааш өг. Чи цаашдаа нярав байж чадахгүй нь” гэжээ. (Лук 16:1-2)

Өнөөдөртэй харьцуулахад, Библийн цаг үед нярвууд түгээмэл байсан тул бид дээрх түүхийн чухал, чухал зарчмыг ойлгохгүй, өнгөрөөж мэдэх. Баян эр ар гэрт нь юу болж байгааг хэсэгтээ тоогогүй. Тэрбээр няравынхаа үйл хөдлөл бүрийг өдөр тутам хянаагүй. Хожим өөр нэгэн хүн түүнд ар гэрт нь юу болоод удаж байгааг дуулгажээ.

Үүнийг Эхлэл ном дээрх Иосефийн түүхээс ч харж болно. Иосеф анх Египетэд ирээд Потифарын гэрийн зарц болж байсан бол, сүүлдээ тэр айлын ерөнхий нярав болтлоо дэвшсэн байдаг. “Тэрээр өөрт байсан бүхнээ Иосефын гарт даатгаад, идэх хоолноосоо өөр юунд ч санаа тавихаа больжээ” (Эхлэл 39:6). Потифар Иосефийн ажлыг нэг бүрчлэн зааварчилж, хянаагүй. Тэрбээр Иосефт няравын ажлыг бүрэн даалгажээ.

Тэгвэл та, бид хоёрт Бурханы даалгасан бэлгийн хувьд ч ялгаагүй юм. Элч Петр бидэнд амьдрал дээрх Бурханы зүйл бүрийн бэлэг - *карисмагийнхаа* сайн нярав байхыг үүрэгдсэн.

ДАЛД МӨНХИЙН БЭЛЭГ

За цаашаа явцгаая. Нэгдүгээрт - Петрийн үгийг сэргээн санацгаая: “Хүн бүр хүлээн авсан бэлгээрээ бие биендээ Бурханы олон төрлийн нигүүлслийн сайн нярвууд шиг *үйлчил*.” Нярвуудынхаа хувьд бид үйлчилж, бэлгээ хэрэглэх шаардлагатай. Бэлэг нь бидний төлөө бус, бусдын төлөө гэдгийг дахин хэлье. Үйлчлэхийг *диаконео* гэдэг бөгөөд үүнийг “ажлаа гүйцэтгэхийн төлөө төвлөрөн үйлчлэх, хүлээх”⁶ гэж тодорхойлжээ. Бид бэлгээрээ үйлчлэх хандлагаа хадгалах ёстой. Бэлгүүд маань бидэнд үнэ төлбөргүй өгөгдсөн учраас, бид зориуд үүнийг бусдын амьдралыг барьж байгуулах зорилгоор хэрэглэх ёстой юм.

Бид “*хүлээн авсан бэлгээрээ* бие биендээ Бурханы олон төрлийн

нигүүлслийн сайн нярвууд шиг *үйлчлэх*” ёстой ажээ. *Олон төрлийн* гэдэг нь “зүйл зүйлийн”⁷ гэсэн утгатай. Бурханы хүмүүстээ өгсөн төрөл бүрийн бэлгийг жагсаана гэвэл, дуусашгүй олон хуудас болно. Үнэндээ ийм жагсаалт ч гаргах боломжгүй байх. Зарим бэлэг нь хаанчлалыг байгуулах ажилд тодорхой харагддаг бол, дийлэнх нь тодорхойлж хэлэхэд амаргүй байдаг. Жишээ хэлье.

Саяхан нэг алдартай пастор өөрийнх нь жил тутмын конференцийн өмнө өрнөсөн нэгэн харилцан ярианы талаар ярьсан юм. Тус жил тутмын конференц нь олон хүнийг хамардаг, алдартай үйл ажиллагаа билээ. Тэгээд багийнхан нь танхимаа засч байтал, мөнөөх пастор маань чуулганых нь гишүүн болох нэгэн эмч чуулга уулзалтын зочид төлөөлөгчдийн суудал дээр танилцуулах хуудас тавьж байхыг харжээ.

Тэгэхээр нь эмч дээр очоод: “Эмч ээ, та наадахаа хийх хэрэггүй. Наадахыг чинь хийдэг сайн дурынхан, дадлагын ажилтнууд байгаа” гэж хэлж л дээ.

Гэтэл эмч: “Би жил бүр энэ конференцэд оролцох гэж эмнэлгийнхээ ажлаас чөлөө авдаг. Би Бурханы хаанчлалыг байгуулахын төлөө өчүүхэн ч гэсэн ажил хийж чаддаг учраас, жилийн энэ долоо хоног надад юу юунаас илүү чухал шүү” хэмээн эелдгээр боловч, хатуу зассан тухай пастор ярьж билээ.

Харин би тэр түүхийг сонсоод, эмчийг өрөвдөв. Тэрбээр Бурханы хаанчлалыг байгуулахад оролцох бэлгийнхээ үнэ цэнийн цэгүүдийг холбоогүй ажээ. Зарим бэлэг нь шууд холбогддог бол, дийлэнх нь дам холбогддог ч, ялгаагүй чухал байдгийг дахин хэлье.

Тэр эмч нэгдүгээр бүлэгт гарсан Стантай адил ажээ. Эмч нар байхгүй бол, яах уу? Бурханы хаанчлалыг байгуулахаар төрөл бүрийн салбарт дуудагдсан хүмүүс, өвчин тусчихбал яах уу? Эмч нар байхгүй бол, тэд эмнэлгийн тусламж авч чадахгүй, хар залуугаараа хальцгаана.

Энэ холбоог нэгэн жишээгээр төсөөлөн дүрсэлж үзье. Нэгэн эмч гэртээ хүүхдээ асардаг ээжийн амийг аварчээ. Тиймээс хэвтэрч орж, нас барахаас аврагдсан мөнөөх эмэгтэй сурган хүмүүжүүлэх бэлгээрээ үр хүүхдээ бурханлаг арга замаар өсгөжээ. Нэг хүүхэд нь шинийг санаачлах бэлэгтэй бөгөөд ээж нь ч үүнийг нь урамшуулна. Охин нь компьютерийн софтверийн зэрэгтэй төгссөн хойноо софтвер бүтээдэг компанид ажилд оржээ.

Охин том болоод бэлгээ бүрэн хэрэглэн, зах зээлд хамгийн үр нөлөөтэй харилцааны арга замыг бүтээжээ. Тийм боловч шинэ бүтээл нь суртчилгааны салбар дээрх хамтран зүтгэгчгүйгээр хол явахгүй.

Хамтран зүтгэгч нь бэлгээрээ тэрхүү шинэ софтвэйрийн хүчин чадлыг худалдагч, худалдан авагч нарын хэн хэнд танилцуулна.

Гэтэл нэгэн жижиг компанийн эзэн эмэгтэй мөнөөх бүтээгдэхүүнийг нь авч хэрэглэжээ. Тэдний худалдааны багт нь ажилладаг нэгэн залуу бэлгээ хэрэглэн, мөнөөх софтвэйрийн багцыг Дэлхийн үндэстнүүдийг дагалдуул гэдэг нэртэй үйлчлэлд зарж чаджээ.

Тухайн үйлчлэлийн АйТи-гийн (IT) чиглэлийн бэлэгтэй хүн мөнөөх софтвэйрийн хүчин чадлыг хараад, худалдаж авахыг санал болгосон юмсанж. Тэгээд тэрбээр софтвэйрийг хэрэглээнийхээ системд нэвтрүүлэв.

Үүний үр дүнд тухайн үйлчлэл дэлхийн пастор, удирдагч нарт хавьгүй үр дүнтэй хүрэх хүчин чадалтай болжээ. Үр дүн нь? Тэр харилцааны софтвэйрийн багцаар дамжуулан эрчүүд, эмэгтэйчүүд бөөн бөөнөөрөө аврагдаж, дагалдагч болцгоов.

Шүүх сэнтий дээр Есүс мөнөөх өвчтэй ээжийг эмчилсэн эмчид түүний нөлөө дэлхийн хичнээн улсын хичнээн хүнд хүрснийг нь үзүүлнэ. Төсөөлж байна уу энэ явдлыг? Эмч ч: “Үгүй байх аа, би биш байх. Би тэр үндэстнүүдэд очоогүй” хэмээн эргэлзэнэ.

Тэр үед Есүс түүнд өөрийнхөө бэлэгт итгэмжтэй байсных нь үр дүнд даян дэлхийн үй олон хүнийг авралд хүргэж, итгэгчдийг багжуулсан гинжин урвал явагдсаныг нь хэлнэ. Есүс тэр эмчид: “Чи анагаахынхаа салбарт хүмүүсийн төлөө гэхээсээ илүү Эзэнийхээ төлөө мэт чин үнэнчээр зүтгэсэн учраас, үр жимс чинь бүгдэд харагдахаар багсайжээ. Чиний дуулгавартай байдал олон хүнд нөлөөлсөн. Итгэмжтэй зарц минь, чи сайн байлаа!” хэмээн айлдах байх.

Олон хүн: “Библи дээр ийм зүйл гардаг билүү?” хэмээн асуух л байх. Тэгвэл үүнийг унш:

Та нар юу ч хийсэн, хүмүүсийн төлөө бус, Эзэний төлөө чин зүрхнээсээ хийгтүн. Учир нь та нар Эзэнээс өв залгамжлалын шагналыг хүлээн авахаа мэддэг. Та нар Эзэн Христэд үйлчилж байгаа юм. (Колоссай 3:23-24)

Энэ бол нэг л жишээ. Ийм маягийн гинжин урвал нь олон төрөл байж болох.

Бүгдээрээ манай найз пасторын бодит түүх рүү эргэе л дээ. Хэрэв тэр эмч жилийн ганцхан долоо хоногт л үйлчилж байгаадаа цөхрөөд буугаад өгсөн бол, яах уу? (Бэлгийнхээ талаарх мэдлэггүй байдал нь дундуур сэтгэл дээр нь тос нэмжээ) Магадгүй, тэрбээр

бүр жилийн тавин хоёр долоо хоногт нь сэтгэл хангалуун байхын тулд эмчийн ажлаа ч орхиж мэдэх. Тэгээд чуулганд заах юмуу дагалдагчийн сургалтын хөтөлбөр боловсруулах ажилд орлоо гэж бодъё. Тэгвэл шүүх сэнтийн өмнө юу болох уу? Тэрбээр даалгагдсан бэлгээ орхиж явсан болохоор аугаа шагнал хүлээж авах болов уу?

Бэлэг нь чуулганы уур амьсгалаас гадуурх талбар дээр цэцэглэж болохыг ойлгоогүй учраас, чуулганд бүтэн цагаар үйлчлэх үү, байх уу хэмээн зөрчилдөж байгаа эрэгтэй, эмэгтэй хүн зөндөө харагддаг.

Хаанчлалд далдаас үйлчлэх байр сууриа эзлэхэд мэдлэг, сүнсний мэдрэмж, төлөвшил хэрэгтэй.

Тэгэхээр, үнэн болбоос: Та бэлгээ эрүүл мэнд, боловсрол, засгийн газар, биеийн тамир - спорт, зах зээл, урлаг, хэвлэл мэдээлэл, гэр бүл тэргүүтэй ямар ч талбарт хэрэглэсэн бай, хаанчлалыг байгуулж байгаа хэрэг болой. Мастер Төлөвлөгч маань ийм л маягаар урлажээ.

Бид шүүх сэнтий дээр Есүсийн өмнө зогсох хүртлээ дуулгавартай байдал, амжилт хоёрынхоо холбоог ойлгохгүй байж ч мэдэх. Паул: “Үүнтэй адил сайн үйлс нь илэрхий юм. Заримынх нь илэрхий бус ч, далдлагдсаар байхгүй” (1Тимот 5:25) гэж бичсэн.

Тиймээс, бэлэг чинь ил бэлэг байна уу, далд бэлэг байна уу хамаагүй, та “Эзний хувааж өгснөөр... Бурхандуудсанаар... явах” (1Коринт 7:17) үүрэгтэй.

СЭДЭЛ ЧУХАЛ

Бүгдээрээ нярвынхаа ажлын загвар болгон үзэж байгаа Паулынхаа үг рүү эргэцгээе:

Учир нь надад энэ алба тохоогдсон тул би сайнмэдээг тунхагласнаараа сайрхах юм алга. Учир нь би сайнмэдээг эс тунхаглаваас золгүй еэ! Би үүнийг хүслээрээ хийвэл шагнал хүртэнэ. Хүслийн минь эсрэг байлаа ч нярвын үүрэг нь надад даалгагдсан юм. (1Коринт 9:16-17)

Доогуур нь тодруулж зурах ёстой удаах хэсэг нь “шагнал” маань бидний “дуртай сэтгэлтэй” буюу “хандлагатай” шууд холбоотой гэдэг үнэн болой. Товчхондоо, *амиа бодоогүй* хандлагатай бол, шагналаа хүлээн авна. Амиа бодсон хандлагатай байвал, шагнал хүлээн авахгүй.

Амиа бодоогүй, амиа бодсон байдал нь зүйл бүрээр илэрдэг

болохоор тодорхой жишээ хэлнэ гэвэл, дуусахгүй. Тиймээс хэдхэн харьцуулалт үзье. Амиа бодоогүй хандлага нь: *Надад даалгагдсан чадвараар бусдад үйлчлэх нь завшаан юм* гэдэг бол, амиа бодсон хандлага нь: *Би энэ чадвараар ямар ашиг хонжоо олох бол?* гэдэг. Шууд хэлэхэд, эхнийх нь *Би чиний төлөө юу хийх үү?* гэдэг бол, хоёр дахь нь *Надад ямар ашиг байна?* гэдэг.

Амиа бодоогүй хандлага нь мөн: *Надад ашиг гарахгүй байсан ч, би хамгийнхаа сайнаар хичээнэ* гэдэг бол, амиа бодсон хандлага: *Надад ямар ч ашиггүй юм бол, би яахаараа хичээх ёстой юм?* гэдэг.

Амиа бодоогүй хандлага нь мөн: *Би ажлаа үргэлжлүүлэх ёстой. Цаана чинь аврагдаагүй олон хүн байна* гэдэг бол, амиа бодсон хандлага нь: *Би амжилттай байна. Тиймээс жаахан азная* гэдэг.

Паул хандлага буюу сэдэл хичнээн чухал байх талаар: “Биднийг Христийн зарц нар бөгөөд Бурханы нууцын нярвууд гэж тооц” (1Коринт 4:1) хэмээн бичээд, араас нь шууд:

“Та нараар эсвэл хүний шүүхээр шүүлгэх нь миний хувьд тун ялихгүй зүйл. Би өөрөө ч гэсэн өөрийгөө шүүдэггүй. Өөрийнхөө эсрэг мэдэх юм надад байхгүй ч үүгээрээ би зөвтгөгдсөн юм биш. Харин намайг шүүгч нь Эзэн мөн. Иймд цагаас өмнө, Эзэнийг иртэл юуг ч бүү шүүгтүн. Эзэн *харанхуйд нуугдсан* юмсыг гэрэлд гаргах бөгөөд зүрхний санааг илрүүлнэ. Тэгээд Бурханаас хүн бүрд *магтаал ирэх болно* (1Коринт 4:3-5) гэжээ.

Паул найз нөхдийнхөө юмуу эрхтэн дархтнуудын өргөмжлөл, шүүмж, тэр бүү хэл өөрийнхөө санал бодлыг ч тоогоогүй. Эдгээр нь хожим хүн бүрийн нүүр тулах тэнгэрийн шалгалтын хажууд юу ч биш юм. *Есүс* нярвын ажлыг юу гэж шалгах нь л юу юунаас чухал.

Шүүхийн өмнө бидний дуулгавартай *үйлдэл* юмуу *үйлс* мэдээж чухал байхыг батлан хэлье. *Есүс* “Харагтун, Би удахгүй ирнэ. Хүн бүрд үйлдсэнийх нь дагуу буцаан төлөх шагнал минь Надтай хамт байгаа” (Илчлэл 22:12) хэмээн тодорхой мэдэгдсэн. Шүүх дээр “аль нэг нь” бус, харин “аль, аль нь” буюу *сэдэл ч, үйлс ч* шалгагдах болно.

Зарим хүн Паулыг *Есүс* Христийн аврагч нигүүлслийг хүлээн аваагүйгээсээ болоод нүглийнхээ төлөө тайлан тооцоогоо тавих үл итгэгчдийн шүүхийн талаар буюу “аугаа их цагаан сэнтийн” шүүхийн талаар ярьж байна гэж боддог. Тэгвэл, тийм биш юм.

Учир нь аугаа их цагаан сэнтийн шүүх дээр хэн ч Паулын яриад буй “магтаалыг” Бурханаас сонсохгүй.

Паул *нярвын ажлын* талаар ярьж байгаа бөгөөд бид ч энэ агуулгаа л барьж ярих ёстой. Паул юуны талаар ярьж байгаад эргэлзэх юм алга. Шүүх дээр бэлгээ захиран зарцуулах тал дээр гаргасан бидний “хамгийн аймшигтай нууц”, “аминч сэдэл” бүгд илчлэгдэнэ. Би л лав үүнийг тоохгүй өнгөрч чадахгүй!”

Үүнийг Эзэний номлоорой гэсэн үгийг номлолгүй, дураараа авирласан түүхээ ашиглан, тодорхой тайлбарлая. Тэр цулаанд суусан хүмүүс өнөөдрийг хүртэл намайг Бурханы тааллаар л “шинэ” үгээ номлосон гэж бодож явдаг байх. Гэтэл үгүй байж. Магадгүй, тэд шүүх дээр миний дуулгаваргүй авирын талаар сонсох байх. Учир нь Есүс:

“Тэвч илчлэгдэхгүй байхаар далдлагдсан, мэдэгдэхгүй байхаар нууцлагдсан юм гэж огт үгүй билээ. Иймд харанхуйд хэлсэн [хувийн сэдэл, нууц] чинь гэрэлд сонсогдоно. Дотор өрөөнд чихэнд шивнэсэн чинь дээвэр дээр зарлагдана” гэж хэлсэн. (Лук 12:2-3, дөрвөлжилсөн хэсэг дээрх тодруулгыг зохиолчийн зүгээс нэмэв)

Магадгүй Шүүх сэнтийн өмнө намайг дуудаж гаргаж ирээд, надаас болж тэр орой *Сатаны урхийн* хичээлийг сонсож чадаагүй пастор тэргүүтэй хүмүүсээс уучлал гуйлгуулж ч мэдэх.


ШААРДЛАГА?

Бид нярвын ажлыг ойлгох нь ямар чухал болохыг тогтоолоо. Тэгвэл: Биднээс юу шаардагдах вэ? гэж асуух ёстой. Өөрөөр хэлбэл, Есүс бэлгийг нь хэрхэн захиран зарцуулсныг шалгахдаа, биднээс ямар үр дүн харах вэ? Үүнийг мэдэх боломжтой юу? Мэдээж, боломжтой. Учир нь Есүс: “Хэлсэн үг минь эцсийн өдөрт түүнийг шүүнэ” (Иохан 12:48) гэж хэлсэн.

Бүгдээрээ илчлэл бүхий, энэ хүчтэй яриагаа удаах бүлгээрээ үргэлжлүүлнэ. Номын маань фокус ч үүн дээр л тогтоно.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

1. Энэ бүлгийг уншихаас өмнө та өөрийгөө нярав гэж хардаг байв уу? Тийм бол яагаад, үгүй бол яагаад?
2. Танд өгөгдсөн бэлэг таны төлөө л байгаа бус, харин танаар дамжин бусдад хүрэх ёстой. Өөрөөр хэлбэл, та Бурханы бусдад өгөхийг хүссэн зүйлийг тээж яваа. Үүнийг санангаа, бэлгээ итгэмжтэй захиран зарцуулах нь яагаад чухал болохыг тайлбарлана уу? Няравын ажлаа үл тоох нь ямар эрсдэлтэй вэ?
3. Тухайн цагт Бурханы танд өгсөн бэлгийг та дараах гурван арга замын аль нэгээр нь хэрэглэж болно. Хаанчлалыг байгуулахад хэрэглэж болно. Өөрийнхөө төлөө ашиглаж болно. Эсвэл огт хэрэглэлгүй, үл хэрэгсэж болно. Та бэлгээ хэрхэн хэрэглэж байна? Бурханы танд даалгасан юмсын нярав байх тал дээрээ ямар өөрчлөлт хийх шаардлагатай байна?



*Биднийг Христийн зарц нар ба
Бурханы нууцын нярвууд гэж тооцог.
Үүнээс гадна итгэмжит байхыг
нярвуудаас шаарддаг.*

— 1Коринт 4:1-2

5

ИТГЭМЖТЭЙ

Элч Паул өөрийгөө болоод Аполыг Есүс Христийн зарц нар бөгөөд Түүний хариуцуулсан бэлгийн нярвууд хэмээн тодорхойлжээ. Энэхүү тодорхойлолт нь энэ хоёр аугаа ариунтанд болоод өнөөгийн чуулганы удирдагч нарт төдийгүй мөн итгэгч бүрт хамаатай болохыг бид өмнөх бүлгээр сурсан. Та, бид хоёр ч бас Есүс Христийн зарц нар бөгөөд зарц хүнийхээ үүргийг биелүүлэх гол арга нь сайн нярвууд байж, итгэмжлэн хүлээн авсан бэлгээ сайн нярвууд шиг захиран зарцуулах явдал юм.

Тэгэхээр, нярав хүнд тавигдах шаардлага дээр анхаарлаа хандуулбал, *итгэмжтэй* гэдэг ганц л чанарыг цохон заасан байх юм. Итгэмжтэй чанарын талаар судлахаасаа өмнө эхлээд энэ жагсаалтад хоёрдугаарх, гуравдугаарх гэх мэт олон чанарыг тоочоогүй гэдэг баримтыг анхаарна уу. Уг нь нярав хүн баяр хөөртэй юмуу хүчтэй байх ёстой эсвэл Бичээсийн эрдэмтэд байх ёстой, энэрэнгүй байх ёстой гэх зэргээр аль нэгэн бурханлаг чанарыг жагсааж болох л байсан. Мэдээж эдгээр чанар амин чухал болохыг би няцаахгүй. Тийм боловч энд ганц л чанарыг цохоод, үүнийгээ бүр *шаардлагатай* гэжээ. Тиймээс бид сайн нярав байж, хожим Эзэнтэнээсээ “Сайн байна” гэдэг үгийг сонсохыг хүсч байгаа л бол, энэ чанар дээр л анхаарах ёстой.

ИТГЭМЖТЭЙ ГЭЖ ЯМАР ЧАНАР ВЭ?

Миний бие даян дэлхийн гол төлөв үйлчлэлийн талбарын удирдагч нарт заадаг боловч, нөгөөтэйгүүр корпорац, засгийн газар, бизнес, боловсрол, спорт зэрэг өөр янз бүрийн талбарын хүмүүст заадаг,

аз завшаантай хүн. Тэгж явж байхдаа удирдагч нараас *итгэмжтэй* байдал гэж ямар чанар болохыг олонтаа асууна. Тэд ч удирдагч хүмүүс болохоороо ярих дуртай. Тэгээд уулзалт бүрээс хамгийн түгээмэл сонсдог хариултыг жагсаасан маань энэ:

- Бат
- Тууштай
- Найдаж болох
- Итгэж болох
- Үнэн
- Жинхэнэ
- Найдвартай
- Зориулалттай
- Үнэнч
- Хувирашгүй
- Дуулгавартай

Гэх мэт өөр олон чанар хэлдэг ч, ерөнхийдөө дээрх хэдэн чанарыг хамгаас их дурьдана. Үүнээс гадна эдгээр хариулт нь толь бичгийн тодорхойлолт, ижил утгатай үгстэйгээ таардаг.

Тийм боловч, аль ч цуглаан дээр надад хариулж байгаагүй өөр нэгэн, амин чухал тодорхойлолт байдаг нь “үржил” гэдэг үг билээ.

Та шууд л “*Үржил ээ? Энэ чинь итгэмжтэй байдлын тодорхойлолт биш шүү дээ!*” гэж бодох байх. Магадгүй бүр манай ахлах сургуулийн Англи хэлний багш шиг миний хэл бичгийн ур чадварт ч эргэлзэж байж мэдэх. Тийм боловч, энэ бүлгийн төгсгөлд та миний үржлийн талаарх тодорхойлолттой санал нийлэхээр барахгүй, бүр итгэмжтэй байдлын хамгийн оновчтой тодорхойлолт гэж хардаг болно гэдэгт би итгэл дүүрэн байна.

ТАЛАНТЫН СУРГААЛТ ҮЛГЭР

Үржлийг танилцуулахын тулд талантын талаарх Есүсийн сургаалт үлгэрийг үзье. Хэдийгээр өмнө олонтаа уншиж байсан ч, дахиад анхааралтай уншина уу.

Энэ нь холын аянд гарахдаа зарц нараа дуудаад, эзэмшилээ тэдэнд даатгаж буй нэгэн хүнтэй адил билээ. (Матай 25:14)

Нэгдүгээрт - энэ маань сургаалт үлгэр болохоороо билэгдлийн чанартай гэдгийг ойлгоорой. Үүнчлэн, бид үүнийг Бурханы Үгийн бүрэн зөвлөгөө болох Библийн ойлголтын гэрэл дор хөрвүүлэх хэрэгтэй. Холын аянд гарсан хүн нь Есүсийг төлөөлж байгаа юм. Зарц бүрийг хариуцсан нярав нь та, бид хоёрыг төлөөлнө.

Хоёрдугаарт - холын аян гэдэг ойлголт нь хоёр баримтыг дэмжиж байна. Нэгдүгээрт - Есүс бидэнд амиараа олж тогтоосон хаанчлалыг маань барьж байгуулаарай гэсэн үүрэг өгөөд явснаас хойш хэдийн хоёр мянгаад жил өнгөрчээ. Хоёрдугаарт - мэдээж Есүс одоо хүртэл эргэж ирээгүй байгаа ч, өнөөдрийг хүртэл бас л урт удаан хугацаа өнгөрчээ.

Гуравдугаарт - нярвын ажлыг байнга шалгаад байдаггүйг эндээс мөн харж болно. Хол явсан хүн сар бүр эргэж ирээд, нярвынхаа ажил үүргийг шалгаад байгаагүй. Харин ч бүр мөсөн эргэж иртлээ ажлыг нь нэг ч шалгаагүй.

За, түүхээ цааш нь үзье:

Нэгэнд нь тэр тав, нөгөөд нь хоёр, өөр нэгэнд нь нэг талантыг тусбүрд нь чадварынх нь дагуу өгчээ. Тэгээд аянд гарч гэнэ.
(Матай 25:15)

Энэхүү түүхэнд мөнгө даалгажээ. Библийн дийлэнх орчуулга дээр талант гэдэг үгийг хэрэглэдэг. Грек дээрээ ч *талантон* гэдэг учраас, талант гэдэг үг нь яг таарч байна. Талант гэдэг нь гол төлөв алт, мөнгийг жинлэдэг нэгж юм. Нэг талант нь ойролцоогоор 34 кг болно. Дийлэнх мэргэжилтнүүд нэг талант мөнгө нь ойролцоогоор 18,000 Америк доллар болно гэж тооцоолдог. Гэхдээ Шинэ гэрээ талантаар их хэмжээний мөнгийг төлөөлсөн гэдэгтэй бүх судлаач зөвшилцдөг. 34 кг мөнгө гэдэг задгай мөнгө биш шүү!

Би л хувьдаа, энэ сургаалт үлгэрийн гол санаа нь мөнгөнийхөө хэмжээнд оршиж байгаа гэж бодохгүй байна. Гэхдээ ямар ч байсан, нэг талант нь нилээд том боломжийг төлөөлж байгааг ойлгоод аваарай.

Яахав, зарчим дээр нь хэрэгжүүлж болох боловч, энд Есүс мөнгөний тухай ярьсан гэдэгт би л хувьдаа итгэхгүй. Есүс сургаалт үлгэрээрээ хэлэх гэсэн юмаа шууд түс гас хэлэх нь ховор байв. Есүс улаан буудайгаар бурханлаг хүмүүсийг, хогийн ургамлаар ёрын хүмүүсийг, үрээр үгийг, өргөсөөр амьдралын хэрэг явдлыг, ургацаар дэлхийн төгсгөл дээрх ургацыг, тариачдаар тэнгэрэлч нарыг гэх мэт төлөөлөн ярьсан. Шинэ гэрээний бүрэн зөвлөгөөг үзбэл, эдгээр талант нь *карисма*

бууу даалгагдсан бэлгийг төлөөлж байгаа нь тодорхой болдог.

Энэ түүхээс тэмдэглүүштэй, өөр нэгэн чухал зүйл нь: зарц болгонд ижил хэмжээг даалгаагүй гэдэг баримт юм. Бид энэ баримтыг хожим дэлгэрүүлж үзнэ. Гэхдээ энэ л шалтгаанаар би хүлээж авсан юмсаа “бэлэг” гэж яриад байгааг минь ойлгоно уу. Зарим нь ганган ганцтай, зарим нь хоёртой, зарим нь олонтой.

Тэнцвэргүй хэмжээ нь бэлгийн маань хүч, далайцыг илэрхийлж байж болох. Зарим хүн нөгөөгөөсөө илүү том бэлэгтэй байдгийг шударгаар хүлээн зөвшөөрө. Дуулах бэлэгтэй хүмүүс сонсогч нараа хөгжөөдөг. Тийм боловч дуучид бүгдээрээ Селин Дион, Андреа Бочеллигийн зиндаанд хүрнэ гэж үгүй. Тиймээс хэрэв та надаас тулгаж асуубал, би талант бүр нь тодорхой нэгэн бэлгийг төлөөлөхөөс гадна мөн тухайн бэлгийн хүч, далайцыг төлөөлж байж болох гэж хэлмээр байна. За цаашаа явья:

Таван талант авсан нь тэр даруй явж, түүгээрээ худалдаа хийгээд тавыг нэмж олов. Үүний нэгэн адил хоёртой нь мөн хоёрыг нэмж олжээ. Харин нэгийг авсан нь явж, газар ухаад эзнийхээ мөнгийг нуужээ. (Матай 25:16-18)

Тэгэхээр, би зарц нарыг нэрлэчихбэл, түүх маань бүр тодорхой болж ирэх байх. Эхний зарцыг Цагаанаа, хоёр дахийг нь Бороо, гурав дахийг нь Саарлаа гэж нэрлэе. Цагаанаа анх хүлээж авсан таваа *үржүүлээд*, эцэстээ аравтай болжээ. Бороо хүлээж авсан хоёроо *үржүүлээд*, эцэстээ дөрөвтэй болжээ. Гэтэл Саарлаа хүлээн авсан бэлгээ үржүүлэлгүй, тэр чигээр нь хав дарчихжээ. Үүнийг гаргацтай бичье:

Цагаанаа: $5 \times 2 = 10$

Бороо: $2 \times 2 = 4$

Саарлаа $1 = 1$

Би цаашид бичээсийг тайлбарлахдаа, зарц нарыг дээрх гурван нэрээр нь нэрлээд явна.

ШҮҮХ

Тэгэхээр, энэ сургаалт үлгэр дээр Есүс *урт удаан* гэдэг үгийг цохоод байгааг дахин сануулъя. Түүх маань уртын аянаар эхэлсэн бөгөөд Есүс дахиад л: “Удаан хугацааны дараа өнөөх зарц нарын эзэн ирж, тэдэнтэй *тооцоо* бодож гэнэ” (Матай 25:19) гэжээ. Нярав

бүртэйгээ хийсэн эзний тооцоогоор хүн бүр хүлээн авсан бэлгээ хэрхэн захиран зарцуулснаа тайлагнах шүүхийг төлөөлжээ. Эхлээд Цагаанааг харцгаая:

Таван талант хүлээж авсан *Цагаанаа* хүрч ирэн, нэмэлт таван талантаа өгөөд: “Эзэн, та надад таван талант олгосон. Би таван талант нэмж олсон” гэжээ.

Тэгээд эзэн нь юу хэлснийг үзнэ үү:

Эзэн нь түүнд “Сайн байна, *итгэмжит* сайн зарц минь! Чи цөөн юманд итгэмжтэй байсан тул чамд ихийг хариуцуулья. Эзнийхээ баяр баясгаланд ор” (Матай 25:20-21) гэжээ.

Тэгэхээр, хамгийн түрүүнд Эзэн нь: “Чи итгэмжтэй байсан тул” гэж хэлснийг тэмдэглэх ёстой. Та эзнийх нь хариу үгийг яаж ч тайлбарлаж болох. Гэхдээ *итгэмжтэй байдлыг үржилтэй* шууд холбож байгааг үгүйсгэх аргагүй. Эзнийх нь үгийг дахиад уншаад үзнэ үү. Цагааны үйл хэргийг өөр ямар ч үгээр тодруулаагүй! Эзэн нь Цагааны *итгэмжтэй байдлыг* тууштай, үнэнч, зориулалттай, жинхэнэ гэх зэрэг өөр чанараар тодорхойлоогүй. Миний санааг буруугаар бүү эргүүлээрэй - мэдээж эдгээр нь бүгдээрээ итгэмжтэй байдлыг бүрэлдүүлдэг, үнэ цэнэтэй чанар мөн боловч, гол нь энд энэ бүх чанарыг цохон тэмдэглээгүй байгааг л би хэлээд байна. Түүнчлэн эзэн нь мөн Цагааны нярвын ажлын өөр ямар нэгэн үр дүн, үйлдэл, чанарыг бус, гагцхүү үржүүлснийг нь л цохон тэмдэглэсэн. Тиймээс л эзэн нь *итгэмжтэй байдлыг* шууд *үржилтэй* холбосон байна!

Борын хувьд ч ялгаагүй. Одоо түүний талаар үзье:

Хоёр талант хүлээж авсан *Бор* ирээд: “Эзэн, та надад хоёр талант олгосон. Би хоёр талант нэмж олов” гэхэд...

Борыг эзэн нь ийнхүү шүүжээ:

“Сайн байна, итгэмжит сайн зарц минь! Чи цөөн юманд *итгэмжтэй байсан* тул чамд ихийг хариуцуулья. Эзнийхээ баяр баясгаланд ор!” (Матай 25:22-23)

Есүс дахиад л *итгэмжтэй байдлыг* шууд *үржилтэй* холбож байна. Өөр ямар ч үйлдэл, чанар, үр дүнг - ер нь юуг ч тодруулаагүй! Есүс эзний санааг саармагжуулахыг хүсээгүй. Үүнээс ганц л санаа гарч байна: Бор хүлээн авсан зүйлээ үржүүлсэн бөгөөд энэ үйлс нь итгэмжтэй гэдэг ганц үгээр л үнэлэгджээ.

Түүнчлэн Борд Цагаанаад хэлсэнтэй яг ижил үгийг хэлсэн. Энэ нь шүүх өдөр бидний үржлийн “дүнг” хийсэн хөдөлмөр дээр маань үндэслэн гаргахыг илчилж байна. Хэдэн бэлэгтэй, бэлэг маань хэр хүч, далайцтай байхаас минь үл хамааран, Есүс сэтгэл хангалуун байна. Гол нь бид үржүүлсэн үү гэдэгт л хамаг асуудал оршино.

Жишээлбэл, хүүхдээ асардаг ээж хүн үр нөлөөгөө хэрхэн үржүүлсэн талаар бид үзсэн. Тэр ээж хаанчлалд өгөхийн төлөө бизнесээ үржүүлсэн бизнесмэнтэй яг адилхан магтаал сонсоно.

За, одоо Саарлааг авч үзье:

Мөн нэг талант авсан нь ирж “Эзэн, би таныг тариалаагүй газраасаа хадаж авдаг, цацаагүй газраасаа хураадаг хатуу хүн гэдгийг мэднэ. Би айсан тул явж, таны талантыг газар нуучихсан. Хар, таных энэ байна” гэв. (Матай 25:24-25)

Саарлын шүүх рүү орохоосоо өмнө бүгдээрээ зарим нэг чухал баримтыг үзье. Нэгдүгээрт - Саарлаа үржүүлээгүй, харин хүлээн авсан зүйлээ тэр чигээр нь хадгалчихсан. Түүнчлэн Саарлаа ямар учраас үржүүлээгүй болохыг үзнэ үү: Юуны түрүүнд - тэрбээр эзнийхээ зан аашийг мэдээгүй учраас, эзнээ хатуу харгис эгтээд хэмээн андуу дүгнэсэн. Би дэвэн дэлхийн, янз бүрийн амьдралтай итгэгч хүмүүст үйлчилж явахдаа, тэд Бурханы мөн чанарыг мэдэхгүйгээсээ болоод үр жимстэй амьдарч чадахгүй байгааг ажигласан юм (Энэ талаар хэтгээ дэлгэрэнгүй ярина).

Бурханыг буруугаар үзэх алдаа маань *айдсыг* хөхүүлэн дэмждэг бөгөөд энэ нь биднийг үржүүлэхгүй байх эндэлд хүргэнэ. Саарал айсан! Айх, эмээх, сүрдэх нь бидний амьдралд байгаа Бурханы бэлгийг унтраадаг. Би үүнийг яаж хангалттай сайн анхааруулахаа мэдэхгүй байна. Би өөрөө ч энэ асуудалтай олон жил зөрчилдөж байж, яс махаараа ойлгосон хүн (Энэ талаар ч бас дараа дараагийн бүлгээрээ дэлгэрэнгүй ярина).

Одоо Саарлын шүүхийг үзье:

Эзэн нь түүнийг “Олиггүй муу боол, залхуу чи...”
(Матай 25:26) гэсэн.

Хмм! Бүгдээрээ цаашаа явахасаа өмнө түр зогсоод, энэ мэдэгдлийг нягтлан үзье. Цагаан, Бор, Саарал гурав гурвуулаа гадны хүмүүс биш, *зарц нар* болохыг санаарай. Эзэн нь тэдний ажил хөдөлмөрийг үнэлж дүгнэсэн. Саарлаа “Итгэмжтэй, сайн зарц минь чи, сайн байна!” гэдэг сайшаал сонсолгүй, харин “Залхуу, муу боол!” гэдэг үг сонссон. Үүнийг анзааралгүй, өнгөрөх аргагүй. Есүс авралын талаар яриагүй, харин бэлгээ хэрхэн захиран зарцуулж, нэг бол шагнуулах, нөгөө бол ажил үйлс маань талаар болж, гар хоосон үлдэх шүүхийн талаар ярьж байна.

Бүгдээрээ эзнийх нь хэлсэн хоёр хатуу үгийг нарийвчлан үзье. Гэхдээ арай зөөлнөөс нь эхэлбэ. *Залхууг Грекээр окнерос* гэжээ. “Саатуулах, хойрго, удаан, хөдөлж ядсан, залхуу”⁸ гэсэн утгатай. Өөр нэгэн тайлбар толь дээр “Хэрэгтэй зүйлд оролцохоос хойш суух юмуу татгалзах - магадгүй амбици дутах байдал”⁹ хэмээн тодорхойлсон байна.

Манай Грек хэлний мэргэжилтэн найз Рик Реннер *окнеросыг* “амьдралынхаа төлөө хуруугаа ч хөдөлгөдөггүй, унтаа, хойрго, хайхрамжгүй, царцуу хандлагтай хүнийг дүрсэлсэн үг” гэдэг. Тэгэхээр, дээрх гурван Грек тодорхойлолт нь бидний харааг тэлж, илүү гүн ойлголт өгч байна.

Айж байгаа хүн хийх ёстой эсвэл хийж болох ажил үйлсэд оролцохоос татгалзаж, хойш сууна. Хэрэв та унтаа хандлагатай хүн бол, хийх ёстой зүйлээ хийх хүсэл тэмүүллээр дутна. Та хойрго хүн бол, юм хийе ч гэж бодохоос залхуурна. Энэ бүх нөхцөл байдал нь Грек үгийг нь утгыг дүрслэн харуулж байгаа ч, зарц “Би айсан” гэдгээ хүлээжээ. Тэр зарц залхуурлын ямар ч шинжийг үзүүлсэн байж болох ч, эцсийн дүнд хамгийн гол нь айснаасаа болж л хойш суусан байна.

Танд ч бас ялангуяа залбирч байхад чинь их ойрхон санагдаад байдаг атлаа бас л бүтэхгүй биз гэсэн айдсаараа байнга хойшлуулсаар ирсэн зүйл байдаг уу? Тэгтэл, өөр хүн үүнийг чинь хийчихсэн байдаг? Тэгээд та “Надад ийм санаа байсан шүү дээ, хийчихдэг л байж” гэж бодож байсан уу? Есүс Саарлаагийн тал дээр үүнийг л ойлгуулахыг хүсчээ. Саарлаа нэг удаа эргэлзээд өнгөрөөгүй, харин нярвынхаа ажлыг хүлээж авсан цагаасаа тайлагнах хүртлээ эргэлзсээр дуусжээ. Ганц, хоёр удаагийн эргэлзээ - байх л зүйл. Үүнээс бид сургамж авдаг. Харин эргэлзээтэй удаан түншлээд байвал, энэ маань эцэстээ биднийг зүгээр л зугтдаг, ямар ч үр жимсгүй нярвын амьдралд унагах, амьдралын хэв маяг болж хувирна.

Анх Эзэн надад ном бич гэхэд нь би арваад сар тээнэгэлзсэн. Би бичихээс айсан. Сургуульдаа бүтэлгүйтэхээс өөр юм үзээгүй юм чинь. Коллежийн ангийнхан маань миний бичлэгийг олны өмнө шүүмжилнэ! Бусдынхаа зохион бичлэгийг гэртээ уншиж ирээд, ангид хэлэлцдэг хичээл

дээр ангийнхан маань миний ажлыг профессорын өмнө зад шүүмжилнэ. Ангийнхандаа газар дор орглоо шүүмжлүүлдэг хүн надаас өөр байгаагүй.

Тиймээс айдас маань оргүй зүйл биш байв. ЭсЭйТи, ЭйСиТи шалгалт дээрээ муу дүн авсан, олон багшдаа шүүмжлүүлсэн, дунд сурсан, ангийнхандаа шүүмжлүүлсэн гэх мэт - ер нь намайг өмгөөлөх түүх байсангүй. Энэ бүхэн миний эргэлзээг улам л тордож байв. Ном бичнэ гэдэг чинь маш их цаг авсан ажил. Харин цаг шиг үнэтэй зүйл байхгүй. Үүнээс болж би шинэхэн үйлчлэлээ өсгөж бойжуулах цаггүй болно. Би Бурханы удирдамжийг дагах үүднээс энэ мэт том айдас, зовнилыг хойш тавих ёстой байлаа.

Тэгвэл, хэрэв би хэт удаан эргэлзээд, дуулгавартай дагаагүй бол, яах уу? Тэгсэн бол, мөнөөх хоёр эмэгтэйгээр дамжуулж хэлсэн Бурханы үг биелэх байсан биз. Бурхан талантаа тухайлбал энэ даалгаврыг гүйцэтгэж чадах Улаанаад өгөөд, Улаанаа энэ даалгаврыг хүлээн авах байсан байх. Тэгсэн бол, би өнөөдөр хаана явж байх байсан бол? Шүүх сэнтийн өмнө залхуу хойргоороо л дуудуулах байсан болов уу.

Бичих нь миний хувь заяа байсныг би мэдээгүй! Намайг хорьтой байхад “Жон, Бурхан чамайг бичсэн номоор чинь дамжуулан даян дэлхий рүү илгээнэ” гэсэн бол, би наанаа их л боловсон инээх боловч, цаанаа: “Сайхан залдаг гар байна даа! Би чинь хоёр өгүүлбэр ч холбож чаддаггүй хүн” гэж бодоод, шоглоод өнгөрөх байсан байх. Гэтэл өнөөдөр номууд маань Америкт ч, олон улсад ч бестселлер болж, хэдэн арван сая хувиар борлогдон, зуу давсан хэлээр орчуулагдаад байна. Би дагаагүй бол, яах байсан бол? Хэрэв би айдасдаа чөдөрлөгдсөн бол, яах уу? Ийм том цар хүрээтэй боломжийг алдах байсан гэж бодохоор, дотор арзаймаар!

Одоо эзнийх нь зарцдаа хэлсэн хоёр дахь хагуу үгийг харцгаая. *Ёрын муу* гэдэг үг арай л чангадсан гэмээр боловч, Есүс хэзээ ч дэмий үг ярьдаггүй байсныг санах хэрэгтэй. Ёрын мууг Грекээр *понерос* гэдэг. Энэ нь “Ноцтой алдаа гаргаж, адагтаа үнэ цэнэгүй байх”¹⁰ гэсэн утга бүхий үг.

Энэ үг Саарлаагийн хүлээн авсан зүйлээ захиран зарцуулсан байдлыг яг онож байна. Паул амьдралд нь өгсөн Бурханы бэлэгт итгэмжгүй байсан бол, өчүүхэн би “золгүй” гэж хэлсэнтэй л адил. Саарлаа эзнийхээ зан чанарыг буруугаар таньсан нь айдсыг нь дэвэргэсэн, ноцтой алдаа болжээ. Тэрбээр хүлээж авсан бэлгээ хэрэгжүүлэх тал дээр ямар ч *үүрэггүй* байж. Үнэхээрийн чанга үг боловч, хэрэв та Паулын үгийг бэлгээ хэрэглэлгүй байж байгаад шийтгүүлсэн Саарлаатай зэрэгцүүлэх юм бол, үнэн хангинаж байна.

Энэ бүхэн нь бидний авралтай хамаатай бус, харин хүлээж авсан бэлгээ захиран зарцуулахтай маань хамаатай болохыг би дахин тодруулж хэлье.

*Үржүүлдэг нь сайн бөгөөд итгэмжтэй.
Зүгээр хадгалдаг нь ноцтой алдаж,
үр дүнгүй, залхуу нэгэн болно.*

Бурхан ингэж л үздэг. Тэгвэл, бид итгэмжтэй байдлыг дутуу үзээд байдаг юм биш байгаа? Энэ жишээг бодоод үзнэ үү: Эдийн засаг нь бэхжин, өргөжин тэлж байгаа газар аж төрдөг бизнесмэн байжээ. Ааваасаа өвлөж авсан жижиг дэлгүүр нь ашигтай хэрнээ томордоггүй. Хотын дүүрэг бүрт салбараа нээх боломж гарсан ч, тэрбээр гарааны бизнес хийх бэлгээ хайхралгүй, ганц дэлгүүртэйгээ “болоод байгаадаа” сэтгэл ханана.

Тэгэхээр, одоо дугуйг цааш нь задлая. Сургаалт үлгэрт гардаг Саарлаагийн шүүхээр жишээлэн хоёр чухал асуулт тавья. Тэр бизнесмэн хаанчлалыг тэлэхийн төлөө шинэ зах зээлд нэвтэрч, шинэ, шинэ дэлгүүр нээх ёсгүй юу? Түүний “хангалттай” гэх хүсэл нь итгэмжтэй зарцын “хав дардаг” стратегитэй агаар нэгэн бус уу?

Бид итгэмжтэй байдлыг Есүсийн тогтоосонтой нэг ижил шалгуураар дүгнэж байна уу? Хэдийгээр бизнесмэн сайхан амьдарч байгаа боловч, Тэрбээр бэлгээ үржүүлж байна уу, хадгалж байна уу гэдэг нь хамгийн чухал асуулт бус уу? Даалгавартаа шударга хандацгаая. Бид итгэмжтэй байдлыг гаргаж байгаа үр бүтээгдэхүүнээр нь бус, зөвхөн найдвартай байдлаар нь шүүгээд байгаа юм биш байгаа? Өргөжин тэлэлтээр нь бус, зөвхөн тогтвортой байдлаар нь? Үржлээр нь бус, зөвхөн тууштай байдлаар нь? Бид итгэмжтэй байдлыг бүрэн утгаар нь буюу өгөгдсөн аливаа бэлгээ үржүүлэх гэдэг утгаар нь харахгүй байгаа юм биш байгаа?

Бурхан эр, эм хоёрыг дэлхий дээр суурьшуулахдаа, хүн төрөлхтөнд: “Үр жимстэй байж, үрж” (Эхлэл 1:28) гэдэг тушаал өгсөн. Мэдээж, Бурхан бидэнд үр хүүхэдтэй болж, дэлхийг өнөр өтгөн болгох чиглүүлэг өгсөн. Гэхдээ үүнээс гадна энэ нь *бид амьдралд маань Бурханы өгсөн бүх зүйлийг үржүүлээд, эргүүлээд Түүнд өгөх* гэсэн утгатай. Бид үржлээр дамжин нөхөн үржих ёстой. Есүс Эхлэл дээрх энэхүү анхны тушаалыг талантын сургаалт үлгэртээ зориуд хэрэгжүүлжээ.

ӨӨРИЙНХӨӨ ЧАДВАРААР ХИЙХГҮЙ!

Танд таагүй санагдаж байна уу? Магадгүй ээ. Гэхдээ танд Бурханы нигүүлсэл байхад л хангалттай гэдгийг санаарай. Таныг өөрийнхөө чадвараар хий

гээгүй, харин Бурханы *карисаар* болоод *карисмагаар* хий гэсэн. Энэ үгийг таны урмыг мухарлахын тулд бус, харин Бурханаас өгөгдсөн хүчин чадалд, Бурханы нигүүлсэлд болоод амьдралд чинь өгсөн бэлэгт итгэх итгэлийг чинь сунгахын тулд бичлээ. Тан дээр дааж давшгүй дарамт тавих санаа надад байхгүй. Паул Бурханаас ачаа дарамтыг маань хөнгөлж өгөөч гэж гурван удаа дуу алдан гуйхад, Эзэн юу гэж хариулсныг үзнэ үү:

Тэр надад “Миний нигүүлсэл чамд хангалттай. Учир нь мөхөсдөлд [Миний] хүч бүрэн төгс болдог” гэж айлдсан. Иймд Христийн хүч надад орших тул би ихэд баяртайгаар мөхөсдөлөөрөө илүү *сайрхана*. (2Коринт 12:9-10)

Мөхөс байдлыг Грекээр бас “хязгаарлагдмал байдал” гэдэг. Учраа олохгүй, тэвдэх үе та, бид хоёрт л тохиодог юм биш. Хүн бүр хязгаартай бөгөөд элч Паул ч ялгаагүй. Яг энэ эшлэл дээр Паул онцгойлон хот бүрт өөрт нь нүүрлэх эсэргүүцэл, сөргөлдөөн, тэр бүү хэл биеийн хавчлагын талаар өгүүлсэн боловч (11-ээр бүлэг), энэ үнэн бидэнд тулгардаг хориг, боломжгүй байдал дээр буюу даалгавар маань бүтэхгүй мэт санагдах тохиолдол дээр хэрэгжинэ. Хэдийгээр, амаргүй боловч, энэ бидний Эзэний хүчинд түших шийдвэрийг маань улам гүнзгийлэх ёстой. Тархи толгой дотор чинь чарлалдах хязгаарыг сонсохын оронд Бурханы амлалтыг *тунхагла!* Бид өөртөө хандаж ярих ёстой байтал, өөрийгөө хэтэрхий их сонсоод байна уу?

Паул Бурханы тусламжийг гурван удаа гуйтал Бурхан Паулд тухай бүр *карисыг* сануулжээ. Гурав дахь удаад нь Паул хязгаарлагдмал байдал нь түүний амьдрал дээр орших Бурханы нигүүлсэл, бэлэгт итгэх итгэлийг нь улам бадрааж өгөх ёстойг ухаарсан байна. Тиймээс л Паул “Бурхан минь, надаас зайлуулаач!” гэдэг залбирлаа “Би мөхөс байдалдаа харин ч бүр *баярлана*” гэдэг талархал болгон өөрчилжээ. Паул үнэхээр “баярлана” гэж хэлсэн үү? Тийм ээ! Эдүгээ тэрбээр асуудал боломжгүй байх тусам, *итгэхэд* - Бурханы хүч амьдралынх нь дотор бөгөөд дээр улам хүчтэй харагдана гэдгийг ухаарав!

Тэгэхээр, *Үржүүлэхэд маань хэрэгтэй нигүүлслийг гагцхүү итгэснээр л олж авах нь байна!* Паул “Мөн дотор нь зогсдог энэхүү нигүүлсэл уруу бид Түүгээр дамжин итгэлээр орох боломжтой болсон бөгөөд бид Бурханы алдрын найдварт баярладаг” (Ром 5:2) гэсэн. Ингэж төсөөлье: Итгэл нь үржилд шаардлагатай нигүүлслийг бидний зүрх рүү нэвтрүүлдэг шугам хоолой юм. Энэ үгийг сонсоод,

бидний итгэл буюу шугам хоолой маань нураад унах биш, харин ч бүр томрох ёстой. Гэхдээ энэ бол таны л сонголт.

Учир нь сайнмэдээ бидэнд тунхаглагдсаны адил тэдэнд ч бас тунхаглагдсан. Гэтэл тэдний сонссон үг нь тэдэнд тус болсонгүй. Яагаад гэвэл сонсогчдын дотор үг нь итгэлээр холбогдоогүй ажээ. Түүний ажлууд дэлхийн сууриас дууссан хэдий ч Түүний “Би хилэн дотроо «Миний амралтад тэд эс орно» гэж андгайлсан” гэж айлдсанчлан итгэгч бид тэрхүү амралтад ордог. (Еврей 4:2-3)

Уншиж байгаа үгээ *ашиггүй* гэж харах бус, харин итгэлтэйгээ барьцалдуул. Бурханаас ирсэн нэг л ижил үг Израилийн хүүхдүүдэд хоёр өөр үр дүн авчирсан байдаг. Тэр үг Мосе, Иошуа, Калебт *ашигаа өгсөн*. Тэд үгийг эерэгээр харснаараа бэхэжсэн. Гэх атлаа яг тэр үг сөргөөр харсан Израильчуудад *ашиггүй туссан*. Энэ бол итгэл ба үл итгэлийн ялгаа.

Бурхан таныг чадвараас чинь ч хол явуулахаар боловсруулсан. Бурхан танд Өөрт нь найдахаас өөр хүч, чадлын сонголт өгөөгүй. Үүнийг хийх аваас, та жинхэнэ амралтанд хүрнэ - цаашид үр дүн гаргах гэж өөрийнхөө хүчээр зүтгэхээ болино. *Амралт* гэж юу вэ? Энэ нь даалгавраа биелүүлэхийн төлөө Бурханы чадвартай хамтран ажиллах явдал юм. Та амралтанд орох юм бол, Бурхан таныг үржил рүү дагуулна!

Энэ нь Давидыг “Бурханы зүрхийг мөшгидөг хүн” хэмээг дуудах болсон нэг шалтгаан байх. Давид өөрийнхөө бус, Бурханы хүчээс хамаарсан. Давид “Эзэн - миний амьдралын хүч” (Дуулал 27:1) хэмээн ахин дахин хэлсэн байдаг. Давидын бүтээсэн бүхэн нэг л нийтлэг шийдвэртэй байсан: Тэрбээр өөрийнх нь доторх бөгөөд өөрөөр нь дамжих Бурханы чадварт найддаг байсан. Тиймээс л Паул айдас, айлган сүрдүүлэгтэй зөрчилдөж буй сүнсний хүү - Тимотдоо “хүү минь, Христ Есүст буй *нигүүлслээр зоригтой (хүчтэй) бай*” (2Тимот 2:1) гэжээ.

Тиймээс л би Есүсийн талантын сургаалт үлгэрийг ярихаасаа өмнө номынхоо 2, 3-аар бүлгээр *карис*, *карисма* хоёрын утгыг баттай болгосон юм. Нярвын ажлыг өөрийнхөө хүчээр хийх нь дэндүү хүнд, урамгүй ажил болно.

Дуудлага чинь таны төрөлх чадвараас том болохыг бүү мартаарай. Магад иймээс л бидэнд дараах үгийг захиа байх:

Ах дүү нар аа, та нар дуудлагаа санагтун. Тэгэхэд махбод талаасаа мэргэн хүн олонгүй, хүчирхэг хүмүүс олонгүй,

язгууртнууд ч олонгүй байлаа. Харин Бурхан цэцдийг ичээхийн тулд ертөнцийн мунхгийг сонгож, хүчтэйг ичээхийн тулд ертөнцийн мөхсийг сонгожээ. Байгсдыг хүчингүй болгохын тулд энэ ертөнцийн дордсыг мөн гологдогсдыг буюу юу ч бишийг Бурхан сонгосон ажээ. Ингэх нь Бурханы өмнө ямар ч махбодыг сайрхуулахгүйн тулд болой. (1Коринт 1:26-29)

Яагаад энэ вэ? Яагаад мэргэн, хүчтэн, сурвалжилтан олноороо дуудагдаагүй юм бол? Төрөлхийн чадвартай хүмүүс өөрийнхөө хүчээр “амжилт” олох нь амархан бус уу? Гэтэл тэд мунхаг аж! Тэд өөрсдийгөө бусадтай жишээд, ялдаг. Үүний оронд тэд өөрсдийгөө Бүтээгчийнхээ дуудлагаар нэвтрүүлж харах ёстой юм.

Паулөөрбайсан. Хэдийгээр Паулаврагдахаасаа өмнө үеийнхэнтэйгээ харьцуулашгүй номч, сурвалжтан байсан ч, хожим амьдрал дээрх Христийн хүчинд нэвтрэхийн төлөө энэ бүх төрөлх чадвараа “ялгас” мэт тооцжээ. Хэдийгээр Паул төрөлх цэц ухаанаараа бусдаасаа толгой илүү байсан ч, Бурханы цэц ухааны дэргэд мунхаг болохоо ухаарсан цөөхөн хүний нэг байв (Филиппой 3:4-11).

СОЦИАЛИСТ УУ, КАПИТАЛИСТ УУ?

Есүсийн сургаалт үлгэрийг үргэлжлүүлье. Итгэмээргүй боловч, үлгэр маань улам л чанга, улам л цочирдмоор болж ирж байна!

Түүнээс нэг талантыг авч арван таланттайд нь өгсүгэй.
(Матай 25:28)

Байзаарай! Бид зөв уншчихав уу? Эзэн нь богц мөнгөө (талантаа) Саарлаагаас аваад, Цагаанаад өгчихлөө гэж үү? Үүнийг тодорхой болгоё:

Цагаанаа: $5 \times 2 = 10 + 1$ (Саарлаагаас авсан) = 11

Саарлаа $1 - 1$ (Цагаанаад өгсөн) = 0

Цагаанаа 11-тэй, Саарлаа тэгтэй үлдэв!

Нэгэн өглөөний залбирал дээр зүрхэндээ сонссон үгдээ би итгэж ядаж билээ. Одоо тайлбарлая. Би үнэндээ талантын сургаалт үлгэрийн талаар эргэцүүлээгүй нилээд удсан байлаа. Гэтэл тэр өглөө Бурханы Сүнс надад: “Хүү минь, Би социалист бус, капиталист сэтгэлгээтэй Бурхан” гэж хэлэв.

Юуу?! Бурханы Үг миний нүдийг орой дээр гаргасан ч, би өдий

хүртэл Түүнтэй хамт алхахдаа, шинэ зүйл илчилж байгааг нь таньдаг болчихсон байлаа. Бурханы илчлэл нь хүний төрөлх юмуу шашинлаг сэтгэлгээтэй мөргөлдөх, тэр байтугай шал утгагүй санагдах нь ч олонтаа! Энэ удаагийн Бурханы Үг надад утгагүй санагдав. Би ч Бурханыг социалист сэтгэлгээ, арга барилтай л Бурхан байхаас гарцаагүй гэж үздэг байсан болохоороо, энэ талаар лавлаж асуулаа.

Тэр өглөө Бурхан намайг яг энэ сургаалт үлгэр дээр дагуулж авчраад, Бурхан социалист Бурхан байсан бол, түүх өөрөөр төгсөх байсныг харуулав. Мөнөөх түүх ийм маягаар өрнөх байжээ: Анх бүгдээрээ тэгш тооны талант хүлээж авна. Тухайлбал:

Цагаанаа: 3

Бороо: 3

Саарлаа: 3

Цагаанаа, Бороо хоёр итгэмжтэй байсан (үржүүлсэн) бол, Саарлаа урагшгүй, залхуугаасаа болоод бахь байдгаараа л үлдсэн. Тэгээд ийм үр дүн гарна:

Цагаанаа: $3 \times 2 = 6$

Бороо: $3 \times 2 = 6$

Саарлаа: $3 = 3$

Тэгээд социалист Бурхан маань байдлыг дараах маягаар шийдвэрлэнэ:

Цагаанаа: $6 - 1$ (Сааралд өгнө) $= 5$

Бороо: $6 - 1$ (Сааралд өгнө) $= 5$

Саарлаа: $3 + 1$ (Цагаанаас авна), $+ 1$ (Бороос авна) $= 5$

Тэгээд бүгдээрээ л тэнцүү таван таланттай болно! Гэтэл ийм юм болоогүй. Бурхан Саарлын богц мөнгийг аваад, аравтай хүнд нь өгсөн. Яагаад? Есүс тайлбарлажээ:

Учир нь хэнд байна (*үржүүлсэнд нь*), түүнд илүү ихээр өгөгдөнө.

Тэр нэгэнд *элбэг дэлбэг* байх болно. Харин хэнд байхгүй байна (*хадгалсанд нь*), түүнээс байгаа нь хүртэл авагдана. (Матай 25:19)

Би Бурхан капиталист гэж хэлээгүй шүү. Тийм юм байхгүй! Зүгээр л яг энэ тохиолдол дээр Бурханы сэтгэлгээ социализмтай гэхээсээ илүү капитализмтай дөхүү байна. Америкийн болоод даян дэлхийн залуус Хорин нэгдүгээр зуунд социалист сэтгэлгээнд боловсорч байна. Социализм нь бурханлаг ч биш, ашигтай ч биш, үнэндээ Бурханы цэц ухаантай шууд сөргөлддөг тогтолцоо. Энэ нь нийтийн сайн сайхны

төлөө гэсэн багаар халхавчилж, залхуурлыг өөгшүүлж, хичээнгүй байдал, амжилт, баялгийг ялладаг антихристийн сүнс юм.

Тэгвэл үржүүлж чаддагийг нь илүү ихээр шагнах нь Бурханы арга зам бөгөөд Бурхан элбэг дэлбэг байдалтай зөрчилддөггүй. Есүс: “Тэдэнд элбэг дэлбэг байна” гэсэн. *Бурханы хаанчлалыг байгуулах зүрх сэтгэлтэй байж, элбэг дэлбэг байдлаа бусдын төлөө ашиглах хүсэлтэй байгаа цагт* Бурхан биднийг элбэг дэлбэг байгаасай л гэж хүсдэг.

Бурхан баялгийг эсэргүүцдэггүй, харин биднийг баялагт толгойгоо мэдүүлэхийг л эсэргүүцдэг гэдэг үгийг та сонсож байсан байх. Үнэн үг шүү. Бурханаар дүрэлзсэн зүрхтэй хүмүүс хураасан баялагтаа бус, харин Бурхантай хөл нийлүүлэн алхаж, баялгаа Түүний хаанчлалыг байгуулахын төлөө хэрэглэж байгаадаа сэтгэл ханадаг. Тэд баялгийг бусдыг байгуулах багаж зэмсгээ болгож л хэрэглэнэ. Тэгээд мэдээж ухаантай хүн багаждаа дурладаггүй.

Яг одоо түр зогсоод, нэгэн чухал үнэнийг цохон тэмдэглэе: Бид боломж бололцоо муутай хүмүүсийг буюу хөдөлмөрийн чадваргүй эсвэл эхлэх хөрөнгө шаардлагатай хүмүүсийг тэтгэх ёстой. Паул: “Нэг нэгнийхээ ачаанаас үүрэлц. Тийнхүү Христийн хуулийг хэрэгжүүлэгтүн. Учир нь хэн нэг нь юу ч биш атлаа өөрийгөө эрхэм гэж боддог бол тэр хүн өөрийгөө мэхэлж байна” (Галат 6:2-3) гэсэн.

Анхны чуулганы удирдагч нар уулзалдахдаа, даалгаврынхаа тал дээр, бүр жижиг сажиг санаан дээр хүртэл санал зөрсөн байдаг. Тийм боловч, тэд амьдрах гэж ядаж байгаа хүмүүст туслахыг санал нэгтгэйгээр дэмжсэн. Паул:

“Бидэнд ядуусыг санаж байгаарай гэсэн нь чухамдаа хийхийг эрмэлздэг зүйл минь юм” (Галат 2:10) гэж бичсэн.

Тэгэхээр, үүнийг мэдсэн болохоор одоо тухайн хүн үнэхээр *гачигдсан* хүн үү эсвэл зүгээр л *залхуу* хүн үү гэдгийг тодорхойлох хэрэгтэй. Социалист үзэл нь залхуу хүнд ч, ядуу хүнд ч тэнцүү өг гэдэг. “Залхуучуудад” өгөөд байвал, тэднийг улам л өөрөөсөө хамааралтай болгоно. Бид хүмүүсийг цэцэглүүлж, Бурханы хаанчлалыг бүтээн байгуулах чадалтай болгохын төлөө Бурханаас өгөгдсөн бэлэг рүү нь л чиглүүлэх зорилготой.

АМЬДРАЛ ДЭЭР ХЭРЭГЖИХ НЬ


Ямар ч байсан - бидэнд бэлэг даалгагдсан бөгөөд бид энэ бэлгээ үржүүлэхийн төлөө хэрэглэх ёстой гэдгийг л мэдээрэй. Та Бурханд хайртай бол, Түүний алдрын төлөө бэлгээ улайран хэрэглэнэ. Тэрхүү дотоод хүсэл, хүчин чадлыг чинь сэрээх нь миний гол зорилго. Та зорилгын төлөө зорилготойгоор бүтээгдсэн. Та хүлээн авсан зүйлээ Хааныхаа алдрын төлөө үржүүлэх чадвартай. Энэ бүлгийн маань хамгийн чухал сургамж бол энэ.

Тэгэхээр, бид талантын сургаалт үлгэр, үүний утга учрыг ойлгосон болохоор, хэрэгжүүлэлт дээрээ тулж ирлээ. Үүнийг хэрхэн хэрэгжүүлэх вэ? Энэ бүхэн өдөр тутмын амьдрал дээр хэрхэн буух вэ?

Дараагийнхаа бүлгээр энэ чигтээ үргэлжлүүлэн аялцгаая.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

1. Нярав хүнийг итгэмжтэй эсэхээр нь л үнэлж дүгнэнэ. Тэгвэл та итгэмжтэй байдлыг юу гэж ойлгож байв? Энэ бүлгээс хойш үзэл бодол чинь өөрчлөгдсөн үү?
2. Өнө мөнхийн үржлийг хүний төрөлх хүчээр хийхгүй. Энэ нь Бурханы нигүүлсэлтэй хамтран ажилласны үр дүн юм. Та бэлгээ өөрийнхөө хүчээр үржүүлэх гэж оролдож байна уу? Явал бэлгээ тэмцэлдэж бус, харин амарч үржүүлэх вэ?
3. Бурхан баялгийг эсэргүүцдэггүй, харин биднийг баялагт толгойгоо мэдүүлэхийг л эсэргүүцдэг. Таны хувьд бэлгээ үржүүлэх нь яагаад чухал вэ? Ямар учраас бэлгээ үржүүлсэн хүн Бурханыг илүү хүндэтгэж, хүмүүст илүү нөлөөлж байгаа хэрэг вэ?



*Хэн маш бага юманд итгэмжтэй байна,
тэр нь их юманд ч мөн итгэмжтэй байдаг.
Хэн бага юманд шударга бус байна,
тэр нь их юманд ч мөн шударга бус байдаг.*

— Лук 16:10

Хичээнгүй байдал ба үржил

Есүсийн үгээс үзбэл, хэрэв бид үнэн бөгөөд тууштай, найдвартай, итгэл даасан, үнэнч, хичээнгүй байж, байгаа зүйлээ зүй зохистой захиран зарцуулж чадбал, бидэнд илүү том үүрэг хариуцлага оноогдох аж. Товчхондоо *шударга байж үржүүлэх юм бол, Бурхан бидэнд бүр том үүрэг хариуцлага итгэмжлэх нь байна.* Тэр биднийг тушаал дэвшүүлнэ. Энэ бол хаанчлалын хууль.

Тэгвэл өөрийгөө шалгана уу. Бидэнд үржүүлэх хараа байна уу? Эсвэл зүгээр л хадгалах санаатай байна уу? Та өрөөлөөс буюу тухайлбал аав, ээжээсээ илүү өндөр амжилт гаргаж, илүү сайхан амьдралд хүрчихлээ гэж үзээд, сэтгэл амарчихсан уу?

Даалгавраа шударгаар гүйцэтгээрэй. Хэрэв та өнөөдрийг хүртэл үржүүлээгүй, хадгалсаар ирсэн бол, битгий гутар. Танд дуулгах сайн мэдээ байна: Амьд байгаа цагт өөрчлөгдөж, үржүүлж, эцэстээ илүү том үүрэг хариуцлага хүлээж авах боломж танд байсаар байна!

ХОЁР ӨӨР ҮР ДҮН

Би жаахан хүүхэд байхдаа хоёр талын өвөөгөө бэлэн зэлэн жишээ болгон харж өссөн болохоороо хадгалах, үржүүлэх гэдэг эсрэг, тэсрэг хоёр сэдлийг төвөггүй ялгаж сурсан юм. Нэг өвөө маань жаран таван насандаа тэтгэвэрт гараад, нам тайван амьдрах болов. Түүнийг жилд хоёр долоо хоног манайд зочлоход нь өдөр бүр ажиглаж байхад, өвөө бараг юу ч хийхгүй. Довжоон дээр том царс модны дор гансаа сорсон шигээ тухална. Гэрт нь зочилж очиход ч ялгаагүй л дүр зураг үзэгдэнэ. Тэрбээр амьдралынхаа сүүл хагасыг амьдрахад биш, амьсгаатай өнгөрөөхөд л зориулсан нь харуусмаар.

Гэтэл миний нөгөө өвөө жаран хоёр насандаа тэтгэвэрт гараад, хоёр дахь гэж хэлж болохуй амьдралаа эхлүүлсэн юм. Тэрбээр жаран хоёр насандаа Рүтгерсийн их сургуульд хөдөө аж ахуйн чиглэлээр суралцаж, дүүргэв. Тэгээд дараагийн хэдэн арван жил нь 2 ном бичиж, жигтэйхэн сайхан цэцэрлэг байгуулж, амьтад гэжээж, Флоридагийн далайн эрэг дээр ахмадуудад зориулсан тав тухтай амралтын газар байгуулахад гар бие оролцож, ер нь янз бүрийн хувийн болоод олон нийтийн төсөлд идэвхитэй оролцов. Өвөө гачигдаж дутагдсан хүмүүст байнга гараа сунгана.

Өвөө манайд ирэх эсвэл бид өвөөгийнд очих нь жинхэнэ баяр болно. Өвөө биднийг дагуулан загасчилж, хүүхдийн паркт тоглуулж, Нью Йорк дагуулж явах гэх мэт бөөн, бөөн хөтөлбөр зохионо. Бас бидэнтэй тоглож, биднийг дагуулан айл хэсч, нутгийнхаа бизнесмэнүүдийн дэлгүүр хоршооны ажилд туслаж, орой бүр амттай сайхан хоолоор дайлна. Харин нөгөө өвөө маань хоол ундны ажилд оролцдоггүй байлаа.

Эхний өвөө маань далан таван насандаа өөд болсон бол, нөгөө өвөө маань ерэн нэгэн насандаа өөд болсон юм. Аль өвөө маань урт насласныг таав уу? Тийм ээ, алсын хараатай, үржүүлдэг өвөө маань. Тэгэхээр, нэг сонирхолтой баримт байна: Урт насласан өвөө маань наян есөн нас хүртлээ Есүст итгээгүй юм. Тийм боловч, тэрбээр өмнө нь ч Бурханы зарчмаар - хаанчлалын хуулиар аж төрж, элбэг дэлбэгээр ерөөгдсөн билээ.

Өвөөгөө Есүс дээр авчрах завшаан олдохоос өмнө өвөө миний итгэлийг нилээд хавчив! Уулзах бүрийдээ итгэлийг маань даапална. Түүнд сайн мэдээ ярих гэж удаа дараалан бүтэлгүйтээд, бууж өгдгийн даваан дээр өвөө маань гэнэт л: “Би Есүс Бурханд итгэе!” гэж хэлсэн юм. Ямар сайхан байсан гэж санана!

Түүнийг итгэснээс хойш сарын дараа би өвөөгийндөө зочилж билээ. Тэр үед өвөө манайхаас нэг цагийн зайтай амьдардаг байв. Өвөө Дэйтона эрэг дээрх орон сууцнаасаа Ормонд эрэг дээрх асрамжийн газарт ирээд байлаа. Тэгтэл тэр айлчлалаар өвөө надад: “Жон, чи өвөөгөө ямар даалгавраар газар дээр төрснийг мэдэх үү?” гэж хэлсэн юм.

Би ч дөнгөж аврагдсан, тийм өндөр настай хүн ингэж бодож байгааг нь гайхлаа. Гэхдээ ингэж хэлэхийнхээ оронд би зүгээр л: “Мэдэхгүй ээ өвөө, таны даалгавар юу юм бэ, хэлээч?” гэж хариулсан юм.

Тэгтэл өвөө мишээгээд: “Ариун Сүнс намайг энд байгаа бүх хүнд Есүс Христийн тухай ярихаар энд байгааг хэлсэн” гэв (Тэр цогцолборт хэдэн зуун ахмад настан байлаа).

Хоёр жилийн дараа ээж, ах хоёр маань өвөөг ганц хүүтэй нь ойрхон байлгах гэж Оклахома руу нүүлгэв. Өвөө Оклахомад нүүж ирсэн эхнийхээ долоо хоногийн нэгэн шөнө өөрийг нь хариуцаж авсан сувилагчид туулж өнгөрүүлсэн амьдралаа шөнөжин хуучилж хоноод, нар мандахын өмнөтэй: “Ахынх нь харих цаг боллоо. Миний төлөө үдэшлэг зохиогоорой гэж хүүд минь хэлээрэй” гэж хэлээд, биеэ орхиод, тэнгэрийнхээ гэрт харьсан гэдэг.

Ээж маань өвөөг Флоридагаас Оклахома руу нүүлгэснээс болж л бие нь даалгүй, явчихлаа хэмээн ихэд шаналав. Ээжийг ингэж хэлэхэд нь би ээжийнхээ үгийг эрс няцаагаад: “Ээж ээ, өвөө наян естэй байхдаа надад юу гэж хэлсэн гээч. Бурхан түүнд Ормонд эрэг дээрх даалгавраа биелүүлэхэд нь дахин хоёр жил байгаа гэж хэлсэн гэсэн. Өвөө Оклахомад ирээд л шууд Бурхан руугаа явсан. Тэгэхээр, газрынхаа даалгаврыг дуусгаад л, явах цаг нь болоод л явсан байхгүй юу” гэж хэлсэн юм.

Үүнийг сонсоод, ээж маань ихэд тайтгарч бас биширч билээ.

Өвөө маань аврагдаагүй байхдаа ч, амьдралаараа Бурханы итгэмжтэй, хичээнгүй зарчмыг харуулсан юм. Би ч бас итгээгүй байхдаа хоёр өвөөгийнхөө газар, тэнгэр шиг ялгаатай сонголтыг үзээд, эцсийнхээ амьсгалыг татгалаа үржүүлж, зорилготой амьдарсан өвөөгийнхөө замаар явна хэмээн хатуу шийдэж билээ.

Гэхдээ би үнэнээ л хэлье. Надад амар хялбар амьдрал хөөх өдөөлт олонтаа ирж байсан. “Хадгалагч” амьдралын хэв маяг нь биед амар учраас, ийм амьдралын хэв маягт соруулчихгүйн тулд бодол санаагаа зориуд жолоодож сурах хэрэгтэй байдаг.

Хөдөлж ядсан, эргэлзсэн, хайнга, хойрго сэдлээр үржил өрнөхгүй. Элч Паул бидэнд “Хичээл зүтгэлд бүү хойрго бай. Эзэнд үйлчлэн сүнс дор шат (Хэзээ ч залхууралгүй, хөдөлмөрт шамдан, Эзэнд эрч хүчтэй үйлчил)” (Ром 12:11) гэж хэлсэн.

Юуны түрүүнд энэ бол санал биш, тушаал гэдгийг мэд. “Хөдөлмөрт шамд” гэдэг оргил үгийг үзнэ үү. Энэ бол үржихийн төлөө танд байх ёстой нэн тэргүүний чанар. Та *хөдөлмөрт шамдаад* зогсохгүй, бүр *эрч хүчтэй* ажиллах ёстой ажээ. Намайг буруугаар ойлгох бий! Итгэл, алсын хараа, тэвчээр нь үржлийн амин чухал гурван хүчин зүйл мөнөөс мөн. Гэхдээ нөгөө л хуучны хүнд хүчир, чин хөдөлмөргүйгээр ямар ч хүчин зүйл хэрэгцээгүй болно!

Лиза, бид хоёр бараг л итгэгч болсон өдрөөсөө өнөөг хүртэл хичээнгүй ажиллаж байна. Хөдөлмөрч чанар мах цусанд маань

суусан бөгөөд Бурхан ч үүнийг итгэгч хүн бүрээс хүсдэг. Бидний эрч хүч гадаад нөхцөл байдлаас хамаарахгүй, харин Есүсийг хайрлах, Түүний хүмүүсийг хайрлах гэсэн дотоодын хоёр хүчин зүйлээс ундрэн гардаг цөмийн хүсэл юм. Энэ цөмийн хүсэл маань мэдрэмж дээр биш, харин зүрхний баг шийдвэр дээр үндэслэдэг бөгөөд Бурханы хаанчлалыг байгуулах улайдсан хүслийг маань өрдөж байдаг. Энэ тун чухал. Яагаад гэвэл хүний сэтгэл мэдрэмж цаг үргэлж оргилно гэж байхгүй. Үнэндээ заримдаа таг унтарчих ч улирал бий.

Эрч хүчийг нэрлэдэг нэг Грек үг нь *энтиос* юм. Энэ нь “дотроо Бурханыг тээх”¹¹ гэсэн утгатай. Бидний хичээнгүй чанар сэтгэл мэдрэмжээс юмуу гадаад нөхцөл байдлаас бус, харин Бурханы амьд оршихуйгаас ундрэн гарах ёстой.

БУСДЫН ЮМЫГ ҮРЖҮҮЛ

Лиза, бид хоёр гэрлэснийхээ дараа Техас дахь Далласын нэгэн чуулганд явж эхэлсэн билээ. Тэр нь хэдэн зуун ажилтантай, манай улсын хамгийн алдартай чуулганы нэг байлаа. Бид хоёр ч хэрэгцээ гарсан газар бүрий сайн дураараа үйлчилнэ. Би утгагч хийж, шорон, түр саатуулахад үйлчилж, асрамжийн газраар айлчилж, конференцэд туслаж, чуулганы ажилчдын хүнд хүчир ажилд туслаж, пасторынхаа хүүхдүүдэд теннисний хичээл заана. Би ямар ч үйлчлэлд хэзээ ч “Үгүй” гэж хэлдэггүй байсан бөгөөд энэ бүх үйлчлэлээ Роквел Интернэйшнэлд долоо хоногийн дөчин дөрвөн цаг инженерээр ажиллахынхаа зэрэгцээ амжуулдаг байлаа.

Эцэстээ миний үйлчлэх улайрлыг үзсэн тэргүүн пасторын маань гэргий (Тэрбээр чуулганы маань орлогч захирал байв) намайг чуулганд бүтэн цагаар үйлчлэх хүсэлтэй эсэхийг маань асуув. Тэрбээр ажилд авах албан ярилцлага хийж байхдаа: “Жон, бид чамд хангалттай цалин өгч чадахгүй юм шиг байна” гэж хэлсэн юм.

Тэгэхэд нь би: “Зүгээр ээ, надад өгөх цалин чинь л хангалттай” гэж хариулж билээ. Би цалингийн хэмжээг огт тоогоогүй. Би ямар ч цалингаар ямар ч орон тоон дээр очиход бэлэн байлаа. Ярилцлагын дараа тэрбээр надад гүйцэтгэх багийн туслахын орон тоог санал болгов. Лиза, бид хоёр үүнийг Бурханы хүсэл мөн гэдгийг мэдэж байсан болохоороо, сүйдтэй залбирсангүй. Тэгээд би жилийн 18,000 долларын цалинг нь ч хүлээн зөвшөөрсөн. Энэ мөнгө миний

хуучин ажлын цалингийн дэргэд задгай мөнгө боловч, миний хувьд тушаал дэвшчихсэн мэт санагдаж байлаа. Лиза, бид хоёр ийм шинэ хэмжээний мөнгөөр амьдрахад гайхамшиг хэрэгтэй гэдгийг мэдэж байсан ч, тоогоогүй юм. Бид амьдралын маань дуудлага хэмээн чин зүрхээрээ итгэдэг амьдралынхаа босгоор оров.

Би хоёр пастораа, гэр бүлийг нь, зочид гийчдийг нь халамжлах үүрэгтэй байлаа. Ингэхдээ гурван давамгай сэдлээр ажиллав. Нэгдүгээрт - тэдэнд яг л Есүст үйлчлэх мэт үйлчлэх. Хоёрдугаарт - үргэлж урьтаж харж, хэрэгцээг нь мэдэрч, хэлэхээс нь ч өмнө гүйцэтгэх. Гуравдугаарт - ямар нэгэн хүсэлт хүлээн авсан бол, урдаас нь “боломжгүй” гэж хэлэхгүй байх. Би тэр хүсэлтийг нь залбирал, бүтээлч сэтгэлгээ, хүч хөдөлмөрөөр ямагт биелүүлж өгдөг байв. Бүр бүтэхгүй бол (ийм тохиолдол тун ховор), оронд нь өөр шийдэл олно. Тэр шийдэл маань анхны хүсэлтээс нь ч давж гарсан шийдэл болох нь олонтаа.

Энэ үеэр Лиза, бид хоёр хүүхэдгүй байлаа. Тиймээс долоо хоногийн 6 өдөр дунджаар 50-70 цаг ажиллана. Пасторынхаа ажлыг аль болох хөнгөвчилж өгөх хэрэгтэй гэдэгт Лиза, бид хоёр итгэдэг байлаа. Пасторууд маань чуулганаа л удирдахад анхаараасай гэж хүснэ.

Бид ямар сэдэлтэй байснаа олон жишээгээр дүрслэж болох ч, ганц л жишээ хэлмээр байна. Нэг удаа манай пастор дээр тухайн үед дэлхийд алдартай сайн мэдээ дэлгэрүүлэгч байгаад, эдүгээ өөд болсон нэгэн эрхмийн үйлчлэлийн багийн гишүүн зочилж ирсэн юм. Пастор маань өөд болсон сайн мэдээ дэлгэрүүлэгчийн талаар дэлгэрэнгүй мэдэхийг хүссэн тул зочинтойгоо шөнө орой болтол ярилцжээ. Тэгтэл шөнийн 1 цагт утас хангинав. Пастор намайг гэрт нь хүрч ирээд (манай гэрээс 25 минут жолоодох зайтай) зочныг буудалд нь хүргэж өгөхийг хүсэв.

Би ч шууд л: “Одоо очлоо” гэлээ.

Тэгээд гэрт нь очоод, тэднийг салахыг нь хүлээгээд, зочныг буудалд нь хүргэж өгөөд, гэртээ ирээд, шөнийн 2 цагт орондоо оров.

Пастор намайг маргааш орой нь манай чуулган дээр номлох өөр нэгэн зочныг нисэх буудлаас угтаж авах ёстойг мэдээгүй байлаа. Зочин маань тэр өдөр үүрийн 5:40-д Хавайн шууд нислэгээр ирэх байв. Түүнийг угтахын тулд би 4:30-д босох ёстой. Тэр шөнө би гурав хүрэхгүй цаг унтсанаа пастортаа хэлээгүй. Би Бурханы хүмүүст тулгарсан хэрэгцээ бүрийг биелүүлэхээр шулуудчихсан байсан бөгөөд үйлчлэх нь завшаан болохыг өөртөө байнга сануулдаг байлаа.

Пастор, пасторынхаа гэргий хоёрт дөрвөн жил тусласан хойноо нэг өдөр би тэдэнтэй хамт байхдаа: “Миний оронд ажиллах хүн надаас хоёр дахин сайн ажиллаасай гэж би Бурханаас гуйдаг” гэсэн юм. Би харилцаагаа сайхан дуусгаж, залгамжлагч маань тэр ажлыг бүр ч сайн гүйцэтгээсэй гэж хүсч байлаа.

Гэтэл тэд: “Чи хэтэрхий сайн ажилласан. Чамайг гүйцэх хүн гарахгүй байх аа” гэж хэлж билээ.

Энэ бол үнэхээрийн урам хайрласан баталгаа байлаа. Тэдний үг миний хүч хөдөлмөрийг амархан харагдуулсан ч, би улам сайжруулахыг хүсч байв. Эцэст нь тэд миний оронд хоёр хүнийг тавиад, пастор маань намайг Флоридагийн чуулганы залуусын пастораар үйлчлэхээр явахад ерөөлөө айлдаад явуулж билээ (Энэ тухай 2-аар бүлэгт дурьдсан).

Би Флорида дахь үйлчлэлээ хүлээж авахдаа, илүү олон залууст хүрч чадахгүй байгаадаа гутрав. Тухайн үе буюу 1980-аад оны дундуур телевизээс өөр дэлгэцийн нэвтрүүлэг байсангүй. Компьютер, таблет, ухаалаг утас байхгүй. Лайв шиг шууд дамжуулалт байхгүй. Товчхондоо хүмүүст хүрэх шилдэг арга нь телевизийн нэвтрүүлэг л байлаа.

Нилээд судалгаа хийсний эцэст Флоридагийн хамгийн том телевизийн нэгэн станц Хагас сайны үдэш сул цагтай байгааг олж мэдэв. Оройн хорин хоёр цагаас нэвтрэх гучин минутын хугацааг худалдаж авахад ямар үнэ төлбөртэй болохыг нь лавлалал, чамгүй өндөр дүн гарав.

Би тэргүүн пастортайгаа уулзаад, залуусын сайн мэдээний төлөө тэр цагийг худалдаж авч болох эсэхийг лавлалал, пастор: “Жон, чуулганд тийм төсөв байхгүй” гэж хариуллаа.

Тэгэхээр нь “Тэгвэл тэр хөтөлбөрийг хийхийн тулд сар тутам өсвөрийнхнөөс өргөл авч болох уу?” гэж асуулаа.

Пастор ч: “Өө, цаадуул чинь чадах юм бол, бололгүй яахав” гэж хариулав. Миний бодоход, пастор залуусыг хийж чадна гэдэгт итгээгүй байх.

Тэгээд би залуусын өмнө зогсоод, төөрөгсдөд хүрэх алсын хараагаа хуваалцав. Тэр Хагас сайны оройн нэвтрүүлгийг олон залуус үзсэн байдаг шүү. Хөтөлбөрөөрөө бид эхлээд Бурханы Үгийг номлоод, дараа нь үзэгч хүмүүсийг чуулганд юмуу залуусын бүлэгт явахыг уриална. Би ч бүлгийнхээ залуусыг хармааныхаа мөнгөөс, хичээлээс гадуурх ажлынхаа цалингаас эсвэл өөрсдөө

янз бүрийн бизнес сэдэж өргөхийг уриалж байлаа. Нийт амласан мөнгөн дүнг гаргахад, телевизийн төлбөрийг бүрэн төлчих байсан учраас, манай туслах пастор, бид хоёр гайхав.

Тэргүүн пастор бүр ч их гайхав. Тэгээд зөвшөөрөл өгөөд, бид “Галтай залуус” гэдэг хөтөлбөрөө эхлүүллээ. Бид сар тутмынхаа төсвийг биелүүлж чадсанаас гадна хамгийн гоё нь чуулганд явдаггүй залуус Есүс дээр ирж, залуусын бүлэгт явж эхлэв. 1980-аад оны сүүлээрх “Галтай залуус” нэвтрүүлэг амьдралд нь ямар хүчтэй нөлөө үзүүлж байсныг хориод жилийн хойно ч хүмүүс надад хэлдэг байсан шүү.

Би залуусын цуглааны пасторын ажлаа өгөхдөө, залуусын бүлгээ гурван салбарт хувааж билээ. Ганц удирдагчтай эхэлж байсан бол, эдүгээ гурван удирдагчтай болов. Дахиад л Бурханы нигүүлсэл, дуулгавартай байдал, хүч хөдөлмөр үржлийг бий болгожээ.

Есүс:

“Хэрэв та нар бусдын юманд итгэмжтэй байгаагүй бол хэн та нарт өөрсдийн чинь юмыг өгөх билээ?” (Лук 16:12) гэсэн.

Есүсийн энэ үгийг Талантын сургаалт үлгэрийн дагуу дахин мэдэгдье:

“Хэрэв та нар бусдын юмыг үржүүлээгүй бол, хэн та нарт үржүүлэх юмыг чинь өгөх билээ?”

Яг энэ тэргүүн пастор маань Лиза, бид хоёрыг Мессенжер Интернэйшнэлийг эхлүүлнэ хэмээн мэдэгдсэн билээ. Энэ тухай бид биш, пастор өөрөө эхэлж дуугарсан юм. Залуусын цуглааны үйлчлэлээ эхлүүлж байхдаа, би пасторгаа “Пастор аа, Бурхан биднийг цаашид өөр, өөр замаар явах ёстой гэдгийг та, бид хоёрт хоёуланд нь харуулдаггүй л юм бол, би Есүсийг эргэж иртэл эндээ үйлчилнэ” гэж хэлж байж билээ. Бидний үйлчлэлийн дараагийн байр суурийг Бурхан пасторын маань залбирал дунд ойлгуулаагүй байсан бол, би тэр цуглаанаас тийм эрх чөлөөтэй явахгүй л байсан болов уу. Тиймээс л Бурхан пасторт маань эхэлж харуулсан гэдэгт би өнөөг хүртэл итгэж явдаг.

МЕССЕНЖЕР ИНТЕРНЭЙШНЭЛ МЭНДЭЛСЭН НЬ

Флоридагийн чуулганаас явсныхаа дараа бид Өмнө Каролинагийн Колумбиад үйлчилж байлаа. Намайг өглөө эртлэн, хүнгүй газар залбирч байтал, Бурхан: “Хүү минь, чи өнгөрсөн долоон жил бусдын үйлчлэлд итгэмжтэйгээр тариалсан үрээсээ арвин их ургац авна. Тун удахгүй эхэлж, ирэх он жилүүдийн турш үргэлжилнэ” гэж хэлэв.

Өнөөдөр эргээд харахдаа, би тэр ургацыг үзээд алмайрдаг.

Цуглааныхаа ерөөлөөр Мессенжер Интернэйшнэлийг эхлүүлсний дараа ч биднийг үржилд хүргэсэн амин хүчин зүйл нь мөн л хичээнгүй чанар байлаа. Лиза, бид хоёр олон үдшийг хуурцаг хувилж, хаяглаж, номлолоо ангилж өнгөрөөсөн. Найзууд маань ч байнга ирж, хуурцаг, танилцуулга хаяглах зэрэг олон тал дээр туслана. Лиза, бид хоёр захиа бичиж, чекээ хурааж, санхүүгээ тэмдэглэн хөтөлж, бичиг цаасны ажлаа хийнэ. Компьютер дээр шивж, шуудангийн тэмдэглэгээ, хангамжийн тэмдэглэгээ гэх мэт олон ажил хийнэ. Бид өглөөний залбирлын дараа ажлаа эхлээд, оройны 9 цаг гэхэд л голдуу дуусгана.

Бид үүнийгээ аз завшаан хэмээн үзэж, баяртайгаар хийнэ. Голоос ундрах энэ сэдэл маань үй олон гутрал, хатуу ширүүн улирал дундуур гүрийгээд гарах хат тэнхээ минь болж билээ. Зүрх алдахгүй байх хүч минь өглөө бүрийн залбирлаас ундардаг байсан гэдэгт би итгэдэг.

Бид Хонда Сивикийнхээ арын суудалд нялх хөвгүүдээ хүүхдийн суудалд нь бэхэлчихээд, Зүүн эргийн гол хурдны зам болох Ай-95 замаар дээшээ доошоо аялан, наяс зуун хүнтэй жижиг чуулганд номлоно. Үнэндээ анхны цуглаан маань салах ёс гүйцэтгэх байранд цугладаг жижиг чуулганд болж билээ. Үнэхээрийн цог жавхлантай эхлэл байгаа биз!

Бид хуурцгаа зараад, мөнгөөр нь үйлчлэлээ өргөжүүлнэ. Бид энэ мөнгийг цалин болгож авахгүй байхаар шийдсэн бөгөөд Мессенжерийг үржүүлэх нь илүү чухал байлаа. Яг хэрэгтэй өдрөө яг хэрэгтэй мөнгөн дүн орж ирэх үе олон байв. Манай “аудио хичээлийн борлуулалт” дансанд мөнгө байсан ч, бид үүндээ хүрэхгүй байхаар шийдсэн юм.

Ийнхүү жил хагас хөдөлмөрлөсний дараа Бурхан надад ном бичих даалгавар өгөв. Би ном бичээд, дээрээс нь бусад үүргээ биелүүлэх цаггүй болохоос айж байлаа. Бурханы энэ үгэнд орох эрдэлтэй байсан ч, бид орсоон. Анхныхаа номыг нилээд удаан бичив. Гэтэл миний хамаг цагийг аваад, бичих цаггүй болгох байсан

өдөр тутмын минь ажилд хэдэн залуу сайн дураараа туслахаар болсон нь ёстой гэнэтийн бэлэг байв. Тэд надад яг л би Далласын пастортаа үйлчилсэн шиг үйлчилж билээ. Тэд амьдралын маань хэрэгцээг хараад, өөрсдөө хүрч ирсэн юм.

Жил шахуу хүнд хүчир хөдөлмөрлөж, заримдаа гонсойсны эцэст *Цөл дэхь ялалт* номын маань эх бичвэр бэлэн болов. *Бид амьдралынхаа нигүүлсэл (бэлэг) дотор өсөх ёстой.* Энэ бол миний сурсан маш чухал түлхүүр. Дийлэнх хүн шууд анхнаасаа л “супер” үр дүн үзэхгүй. Петр “Харин бидний Эзэн бөгөөд Аврагч Есүс Христийн нигүүлсэл... дотор өсөгтүн” (2Петр 3:18) гэжээ. Эдүгээ бичих чадвар минь анхны номынхоосоо хавьгүй дээрдсэн.

Лиза, бид хоёр эх бичвэрээ алдартай хянан тохиолдуулагчид өгөв. Гэтэл тэрбээр зад шүүмжлээд, намайг Христийн биед ийм том ярихад жулдана гэж хэлсэн нь намайг цочроов.

Тийнхүү Лиза, бид хоёр нам тавиулсныхаа дараа нь өөр хянан тохиодуулагчийн эрэлд гарлаа. Тэгээд нэг хүн олсон чинь тэрбээр хамаг эх бичвэрийг маань дураараа сэглээд хаядаг байгаа. Лиза, бид хоёр номоо буцааж авахдаа, навсайтлаа хямрав. Тэрбээр номоос маань миний дуу хоолойг арилгаад бас агуулгынх нь хүчтэй нөлөөллийг юу ч үгүй тасдаад хаяжээ. Үүнээс ч аюултай нь ном маань ямар ч утгагүй, товчхондоо сэг болсон байв! Ийнхүү биднийг дахин нэг гай дайрав. Одоо яадаг билээ? Бичих гэж жил болсон шүү дээ.

Бид бууж өгсөнгүй. Гурав дахь хянан тохиолдуулагчаа олтол, тэр эмэгтэй уншиж үзээд, үнэхээр эх бичвэрийг нь сүйтгэснийг хүлээн зөвшөөрлөө. Тэрбээр “Жон, Лиза, нэгэнт сэглэсэн зүйлийг дахин эвлүүлэх нь зөв алхам болдоггүй. Хянан тохиолдуулагчид төлсөн мөнгөө тэр чигээр нь хаяад, шинээр эхэлсэн нь дээр” гэж хэлэв. Тэгээд Лизагаас эх бичвэрийг нь засаад, өөр рүү нь илгээгээрэй гэлээ.

Бид ч хянан тохиолдуулагчийн зөвлөгөөг сонсож, Лиза маань эх бичвэрийг хүн уншихад аятайхан болгох гэж олон цаг засав. Дараа нь Лизагийн бэлэн болгосон ажлыг шинэ хянан тохиолдуулагч маань хүлээн аваад, ажлаа эхлүүлэв. Тэрбээр сайн ажиллаж, бид ч эцсийн эцэст маш сайн эх бичвэртэй болсондоо гялайв.

Дараа нь би номоо хоёр том хэвлэлийн газар руу илгээв. Нэг нь бидэнд хэзээ ч хариулаагүй бол, нөгөө нь хариулав. Тэд миний номыг хэтэрхий “номчирхсон” байна гээд, нэр алдаргүй үйлчлэгчийн номыг хэвлэхгүй гэсэн байлаа. Тэгэхээр нь би дундаж хэвлэлийн газарт хандаж үзсэн ч, хэн ч сонирхсонгүй.

Намайг яаж гутарсныг төсөөлөхгүй байх аа та. Ингээд бүтэн жилийн хөдөлмөр, цаг хугацаа мөхөв гэх шиг л санагдаж байлаа. Өвдөг минь нугараад байсан ч, би бууж өгөхийг хүссэнгүй.

Тухайн үед ном бие дааж хэвлэнэ гэсэн ойлголт байгаагүй юм. Бие дааж хэвлээд амжилтанд хүрсэн түүх үгүй боловч, нэг найз маань үзээд алдахыг зөвлөв. Цөөн хэдэн мянган ном хэвлэхэд 12,000 доллар болно гэсэн бөгөөд үүнд эх бэлтгэл, дизайны хөлс багтаагүй байв. Гэтэл бид хоёр хэдийнээ хоёрын хоёр хянан тохиолдуулагчид мөнгө төлчихсөн байдаг.

Бидний хувьд энэ тоймгүй их мөнгө байлаа. 1990 онд Мессенжер Интернэйшнэлийн бүтэн жилийн орлого 40,000 америк доллар л байв. Бид үйлчлэлийнхээ гурав дахь жил рүү ороод байсан бөгөөд орлого маань эхний жилийнхээсээ давахгүй байлаа. Хоёр дахь жилийнхээ адаг дээр хэдхэн зуун долларын үнэтэй, анхныхаа компьютерийг авах гэж яаж татганаж байснаа санаж байна. Гэтэл 12,000 мянган доллар гэдэг бүтэшгүй хэрэг! Ийм мөнгө олоход бидэнд гайхамшиг л хэрэгтэй.

Бид заалны бус спортын сэдэвтэй ном хэвлэдэг, жижигхээн хэвлэлийн газарт бичээч хийдэг нэгэн хатагтайтай учрав. Тэр намайг ном бичих талаар ярьж байгааг сонсоод, Лизатай уулзаад номыг маань ямар ч үнэ хөлсгүй шивж, эхийг нь бэлтгэж өгнө гэж хэлжээ. Ийнхүү бид энэ ажилд хэдэн мянган доллар төлөхгүй болсондоо баярлав.

Бурхан гайхамшгаа үйлдэн, үлдсэн мөнгийг нь хангаж, бид “Цөл дэхь ялалт” номоо таван мянган хувиар бие даан хэвлүүлэв (Ингэж “Бурхан минь, Тахаана байна?!” номын анхны хувилбарт өрсөн юм). Гэвч төдөлгүй номоо борлуулах сүлжээ харилцаа байхгүйгээ мэдээд, дахиад л гонсойв. Номын дэлгүүр, дистрибюторууд биднийг хэн болохыг ч мэдэхгүй. Тэр үед борлуулалтын компаниуд зөвхөн том, том хэвлэлийн газраас л ном хүлээж авдаг байв. Бие дааж хэвлүүлсэн номыг хэн ч тоохгүй.

Бид номоо үйлчлэхээр очсон газар бүртээ сургалтын материалаа борлуулдаг ширээн дээрээ тавьж зардаг болов. Намайг цөлийн талаар номлох үед л ном маань зарагдана. Ном маань хүмүүст таалагдсан боловч, үүнээс цаашгүй.

Бас нэг удаа залбирч байтал, Бурхан надад өөр нэгэн ном бичихийг сануулсан тул би “Орь дуу хадагчийн дуу” гэдэг хоёр дахь номоо бичих гэж дахиад есөн сар болов. Мөн л ямар ч хэвлэлийн газар сонирхоогүй тул бид 1993 онд энэхүү номоо дахиад л бие даан хэвлүүлэв. Одоо бид сургалтын материал зардаг ширээн дээрээ хоёр ном тавьдаг болсон ч, алийг нь ч номын дэлгүүр авсангүй.

БОЛОМЖ НЭЭГДЭВ

Жилийн дараа нэгэн найз маань намайг өөр нэгэн найзтайгаа уулзуулахаар өдрийн хоолонд урьсан юм.

Би ч зөвшөөрлөө. Гэтэл тэр найз нь хоёр жилийн өмнө миний номыг хэвлэхээс татгалзсан хэвлэлийн газрын шинэ дарга болж таарав. Бид сайхан хооллож, нөгөө дарга: “Та хоёр сүүлийн үед ямар үг номлож байна?” гэж ирээд л Лиза, бид хоёрын ажлыг сонирхлоо.

Би ч зүрхэнд маань дүрэлзэж байгаа шинэхэн сэдвээс хуваалцав. Энэ маань гомдлыг ялж, биднийг гомдоосон хүмүүсийг уучлах нь ямар чухал болох талаар өгүүлсэн үг байв. Дарга ч улам сонирхож, би ч бүр их ярьж өглөө. Арван таван минутын дараа тэрбээр: “Жон, бид жилд 22-24 ном л хэвлэдэг. Гэхдээ дандаа нэрд гарсан зохиолч, үйлчлэгч нарын номыг. Тиймээс таны номыг хэвлэж чадахгүй байх” гэв.

Би түүнийг гайхаад: “Би танайхаар номоо хэвлүүлэх гэж яриагүй л дээ. Та өөрөө намайг сүүлд юу номлож байна гэж асуусан болохоор чинь л...” гэж хариуллаа.

Тэрбээр ойлгосноо, инээд алдаад: “Нээрээ тийм. Дахиад цааш нь ярь л даа” гэв.

Тиймээс би үргэлжлүүлэн ярьлаа. Арван таван минутын дараа тэрбээр дахин намайг зогсоогоод: “Та гурван сарын дотор эх бичвэрийг нь бэлтгэж өгч чадах уу?” гэлээ.

Би дахиад л баахан гайхаад: “Та миний номыг хэвлэхгүй гэсэн биз дээ?” гэв.

Гэтэл тэрбээр: “Би бодлоо өөрчиллөө. Энэ үгийг дэлхий сонсох ёстой” гэж хариулсан юм.

Ийнхүү тэр компани 1994 онд *Сатаны урхийг* хэвлэв. Миний баярласан гэж. Миний онгойлгож дийлээгүй хаалгыг Бурхан Өөрөө нээжээ. Би номоо шууд л алдаршиж, сайн борлуулагдана гэдэгт итгэл дүүрэн байсан ч, эхний 7 сар тун урагшгүй байв. Сарууд өнгөрөх тусам, би хэвлэлийн газраас урам алдмаар борлуулалтын дүн хүлээн авсаар байлаа. Энэ үг олон хүнд - дэлхийн олон үндэстэнд хүрэх ёстой гэдэгт би зүрхэндээ итгээд байдаг. Тиймээс тэр найдвараа алдахаас татгалзсаар байсан ч, бүх хүчин зүйл удаа дараалсан бүтэлгүйтэл рүү зааж байлаа.

Хэдэн сарын дараа нэгэн хэвлэлийн газрын суртчилгааны багийн гишүүн надтай яриад: “Жон, таныг 1995 оны 1-ээр сарын 16-нд олон улсад цацагдах шууд ярилцлагын нэвтрүүлэгт урьж байна. Та

хорь орчим минут гол нь өөрийнхөө болоод гэр бүлийнхээ талаар ярих ёстой. Гэхдээ бас шинэ номын чинь талаар товч дурьдана. Энэ бол боломж шүү. Та оролцох уу?” л гэлээ.

— “Мэдээж оролцоно!”

Намайг очтол, тэр оройн нэвтрүүлгийг маш алдартай нэгэн хос хөтөлж байв. Надтай мэндэлснийхээ дараа гартаа “*Сатаны урхийг*” барьж байсан нөхөр нь шууд л: “Сатаны урхи гэж юу вэ? Энэ юуны тухай ном бэ?” гэж асуулаа.

Хамгийн түрүүнд манай гэр бүлийг биш, номыг маань асуусанд гайхсан боловч, би ч шууд л номынхоо талаар урсгаж гарав. Студи дотор нам гүм. Надад ярилцлагын цаг заасан самбартай хүнийг сайн ажиглаарай, танд хорин минут л байгаа шүү гэж анхааруулсан байсан ч, нөгөө хүн нь ямар ч цаг заасан самбар харуулсангүй. Хөтлөгч нар ч ярианд минь автаад, нэг ч үг хэлж тасалдуулсангүй. Хөтлөгч хос цагийн баримжаагаа алдсан байв. Хожим нь би тасралтгүй дөчин минут ярьснаа мэдэж билээ.

Тэр яриа хөтлөгч эрд хүчтэй нөлөөлсөн болтой. Тэрбээр манай улсын хамгийн том нэгэн чуулганы пастор хүн байлаа. Тэгээд тэрбээр шууд нэвтрүүлэг дээрээ намайг чуулгандаа ирж, энэ талаар номлооч хэмээн урьсан юм.

Хэдэн өдрийн дараа хэвлэлийн газраас яриад, Америк дахь номын дэлгүүрт байсан бүх “*Сатаны урхи*” зарагдаж дуусаад, дээрээс нь хорин мянган хувийн захиалга хүлээн авснаа дуулгалаа. Тэрбээр: “Жон, бид хэзээ ч ийм юм үзээгүй” гэсэн бөгөөд ток шоунаас ч бас “Хэзээ ч үзэгчдээс ийм хүчтэй санал хүсэлт хүлээн авч байгаагүй” гэж хэлсэн юм. Харин би энэ бүхэн нь тэнгэрийн зохицуулалт гэдгийг зүрхэндээ мэдсэн бөгөөд Бурхан Өөрөө үгээ суртчилж байгаагаа батлав.

“*Сатаны урхи*” сүүлдээ олон улсын бестселлер болж, хорин таван жилийн турш бестселлерийн жагсаалтад орж, гарсаар байна. Үүнийг бичиж байхад ном маань цаасан, цахим, сонсдог хэлбэрээрээ хоёр сая хувьд дөхөөд байна. Эргээд харахад, энэ бүхэн яаж өрнөснийг гайхах. Миний анхны номыг тоож хэвлээгүй тэр хэвлэлийн газар “*Сатаны урхийг*” маань үе үеийн шилдэг борлуулалттай ном болгон хэвлэх гэж. Бурхан ч шогч Бурхан юм аа!

Би Бурханы Үгэнд ороогүй, бичээгүй байсан бол, энэ үг ийм олон хүнийг батжуулахгүй байсан. Ном нь номлолоос илүү олон хүнд хүрдэг учраас, ном бичсэн маань Бурханы Үгийг үржүүлжээ.

Үнэндээ, энэ өргөжилт ном бичихээс ч эхлээгүй юм. Үржил маань

бүр өмнөөс буюу биднийг тэр их бүтэлгүйтэл дунд үргэлжлүүлэн урагшилсаар байх цагаас л эхэлжээ. Би анхныхаа пасторын нурууг хөнгөлөх гэж бас залуусын чуулганы пасторынхаа хувьд цуглааныхаа сайн мэдээний далайцыг үржүүлэх гэж хичээнгүйлэн ажилласан. Мессенжер Интернэйшнэл байгуулагдсанаас хойш ч өдөр, шөнө алдалгүй ажиллаж, Бурханы бичиж, хэвлүүл гэсэн дуу хоолойг дуулгавартай дагаж явна.

Би “Сатаны урхи” гэдэг номнолын үржих үйл явц нэгэнт хурдаа авсан бөгөөд номын борлуулалт, дэлхий даяар явж конференц, чуулган дээр илтгэх номлолоор минь дамжин эрчээрээ өснө хэмээн тооцоолсон ч бас л буруу байв. Бурхан надад илүү ихийг даалгахыг хүсчээ.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

1. Танд үржлийг дэмжсэн хараа байна уу? Эсвэл та зүгээр хадгалагчийн сэтгэхүйтэй байна уу? Та тухтай амьдрал, болоод л байгаа нөхцөл байдалдаа ханаж байна уу эсвэл өөрийгөө шинэ, шинэ асуудлаар сорьж байна уу?
2. Залхуу, урсгалаараа хүнээр үржилт явагдахгүй. Бид хүнд хүчир хөдөлмөрлөөд зогсохгүй, бүр эрч хүчтэй хөдөлмөрлөх ёстой. Та өөрийгөө хөдөлмөрч гэж хэлэх үү? Та эрч хүчтэй ажиллаж байна уу? Та өөрийнхөө нүдэнд хангалттай болчихоороо эсвэл бусдаас дээр гарчихаараа тайвшраад, хөвж эхэлж байна уу?
3. Би дөнгөж бичиж эхэлж байхдаа, ой тоймгүй олон удаа гутарч, гологдож, урам хугарч байсан ч, Бурханы хийгээрэй гэснийг дуулгавартай дагасаар байсан учраас, бэрхшээлийг зад татан гарч чадсан. Та амьдрал дээрх нигүүлсэл дотроо хэрхэн өсч байна? Урамгүй байдал, гутралыг зад татаж гарахад чинь миний түүх танд хэрхэн нэмэр болж байна?



Машид олшруулахаар тэднийг бас ерөөдөг.

— Дуулал 107:38

7

Их үржил

Бурхан сэтгэл дундуур байдал, гутралыг бидний үржлийн эхлэлийг тавих юмуу эсвэл дараагийн шатны үржлийн төлөөх итгэлийг маань бадраах өөрчлөгч хүчин зүйл болгон ашигладаг. Жишээ нь Абрам (Абрахам) байна. Абрахамыг далан тавтай байхад нь Бурхан түүнд үзэгдээд, алсын хараа өгчээ:

Үүний дараа ЭЗЭНий үг Абрамд үзэгдлээр ирж Абрам аа, *бүү ай! Бамбай чинь Би тул шагнал чинь агуу их гэжээ.*
(Эхлэл 15:1)

Цөмөөрөө тайзаа засцгаая. Аугаа хүчирхэг Бурхан газар дэлхийг баялгийн сантай нь хамт бүтээсэн бөгөөд өмчилдөг. Бурхан мөнхөд оршин байсан, мөнхөд орших ч болно. Түүний аугаа чанарт дөхөж очих ч амьтан байхгүй. Бурхан амьтай бус, Бурхан Өөрөө амь амьдрал *болой*. Түүн дотор л мөнхийн мэдлэг, цэц ухаан, баялаг, таалал оршино. Түүнээс гадуурх нь үнэ цэнэгүй.

Гэтэл энэхүү гайхамшигт Оршихуй Абрамыг *хамгаалж, аугаа шагнал* өгнө хэмээн мэдэгджээ. Тэгэхээр *хамгаалалт* ба *аугаа шагналыг* тус, тус авч үзье.

Нэгдүгээрт - хамгаалалт. Америкийн ерөнхийлөгч таныг зэвсэгт хүчнээрээ *хамгаалах* гэрээн дээр гарын үсэг зурлаа гээд төсөөл дөө. Генералууд таныг онцгой хамгаалалтанд авч, шаардлагатай бүхий л арга замаар аюулгүй байдлыг чинь хамгаалах тушаалыг доод шатны албан тушаалтнууддаа өгнө. Шаардлагатай бол хамгийн дэвшилтэт зэр зэвсэгтэй цэргүүдээр тал бүрээс чинь хамгаалуулна. Амьдрал дээр ийм юм байхгүй хэдий ч, хэрэв ингэдэг бол, та аюулгүй байдал, бүрэн хамгаалалтыг мэдрэх нь лавтай. Гэхдээ энэ нь Аугаа

хүчирхэг Бурханы “Би чамайг *хамгаална*” гэдэг үгийн дэргэд бас л жул юм.

Тэгвэл *аугаа шагналын* хувьд? Таны хөрш “Би чамайг *том шагнана*” гэвэл, та сайхан сэтгэлийг нь үнэлээд өнгөрөхөөс биш, нэг их юм горьдохгүй байх. Тэгвэл Америкийн хамгийн баян хүн ингэж хэлбэл, та илүү баярлана. Гэхдээ энэ ч бас өчүүхэн хэрэг. Гариг ертөнц дээрх бүхнийг өмчилдөг Бурхан том шагнал амлаж байна! Тэрбээр Абрахамд “Миний чамд өгөх бэлэг “аугаа”” гэжээ. Үнэндээ, энэ амлалтын даац, цар хүрээнд бидний ухаан хүрэхгүй. Гэхдээ бас болоогүй ээ.

Өөр нэгэн алмайрмаар баримт нь - Бүтээгч маань элчээ явуулалгүй, Өөрийн биеэр ирсэн. Аугаа хүчирхэг Бурхан нүүр нүүрээрээ учран байж, төсөөлөшгүй амлалт өгсөн. Хүчийг нь төсөөлж байна уу? Бид байсан бол, юу гэж хариулах бол? Баяр, жаргал, хөөр, бишрэлээ үгээр ч илэрхийлж чадахгүй байх. Гэтэл Абрахам огт тэгээгүй. Тэрбээр баярлах нь бүү хэл, харин ч сэтгэл дундралаа илэрхийлсэн!

Эзэн БУРХАН минь! Та надад юу хайрлахсан бол? Би үр хүүхэдгүй бөгөөд миний голомт сахих хүү бол энэ Дамаскийн Елиезер юм. (Эхлэл 15:2)

Дууных нь өнгөөс л дундуур сэтгэл нь мэдэгдэж байгаа биз? Гайхмаар! Гэхдээ Абрахамын гонсгор байдал нь хэрэг дээрээ сайн ч зүйл байж мэдэх. Абрам: “Вааааав, гайхалтай! Бүгдээрээ тэмдэглэе!” гэж хэлжээ гэж бодъё. Ингэсэн бол, нилээд өөр үр дүн гарах байсан болов уу? Үнэндээ, Абрахам ингэж баярлах байсан бол, Бурхан түүнтэй уулзах байсан болов уу гэж асуух ёстой байх. Би л хувьдаа үгүй байх аа гэж бодож байна. Одоо тайлбарлая.

Энэ бүхнийг тодорхой болгох үүднээс Абрамын түүхээ түр хойш тавья. Хэдэн жилийн дараа Израильчууд цөлөөр бэдэрч явахдаа, тав тухаа алдсандаа гоншигнож, эцэс сүүлдээ тун эмгэнэлтэйгээр хувь тавилангаа алдсан байдаг. Гэтэл элч Паул өөрийнхөө бурханлаг хандлагыг ийнхүү илэрхийлсэн байна:

Би үүнийг дутагдсаны улмаас ярьж байгаа юм биш. Учир нь би байгаадаа сэтгэл хангалуун байж сурсан юм. Би тарчигхан байхыг ч мэднэ, элбэг дэлбэг байхыг ч мэднэ. Ямар ч, аливаа

нөхцөл байдалд цагталан болон өлсгөлөн байх, элбэг байх, дутагдахын аль алины нууцад би суралцсан.
(Филиппой 4:11-12)

Бурхан Паулаас ч, Абрамаас ч бэрхшээлтэй халз мөргөлдөж чаддаг, өөрөөсөө давуулж хардаг хүнийг олж үзжээ. Тэд өөрийгөө бус, бусдыг бодсондоо л сэтгэл дундуур байжээ.

Эрхий мэргэнээ гозойлгох нэгэн сайн дүрэм байдаг: Хүн хувийнхаа гачигдлын улмаас сэтгэл дундуур байх нь Бурханд таалагдахгүй. Нөгөөтэйгүүр, бусдын хэрэгцээний төлөө, Бурханы хаанчлалыг байгуулахын төлөө сэтгэл дундуур явах нь Бурханд таалагдана. Абрам яг ийм гонсгойлттой явсан бөгөөд энэ нь хэрхэн төгссөн? Бурхан тэнгэрийн оддыг, эргийн элсийг үзүүлэн, Абрамын шагнал нь тоолохын аргагүй олон хүнд нөлөөлөхийг амлан, алсын харааг нь тэлжээ. Бурхан бүр сэтгэл хөдөлсөндөө: “Чи бид хоёрын хооронд Би гэрээ байгуулж, Чамайг улам өнөр болгоно” (Эхлэл 17:2) хэмээн тунхагласан билээ.

Абрам өөрийнхөө сайн сайхан амьдралд сэтгэл ханачихсан бол, яах уу? Далан таван насандаа хүүхэдтэй болно гэдэгт итгэх шалтгаан түүнд байх уу даа? *Түүний дундуур сэтгэл нь үржил авчрах, өөрчлөгч хүчин зүйл болжээ.*

Би сэтгэл хангалуун бус байдлыг ойшоохгүй өнгөрөх зүйл бус, харин үр нөлөөг өсгөх дэвхрэг хэмээн үзэх ёстойг сурсан. Лаодикийн чуулганд энэ л дутаж байсан. Есүс тэдний “Би... дутах зүйлгүй” (Илчлэл 3:17) гэдэг хандлагыг нь чангалан зассан. Тэд өөр дээрээ төвлөрч, элбэг хангалуун байдалдаа тухлаад байсан учраас, бусдад нөлөөлөхгүй байгаадаа гонсойгоогүй. Тиймээс үржихийг ч бодоогүй.

Энэ бол Станыг зовоож байсан зөрчил. Би ч бас үүнтэй үе, үе зөрчилддөг бөгөөд ялж гарах ёстой болдог. Үнэндээ бид бүгдээрээ л тэгдэг.

Би Бурханд үйлчлэх тусмаа, жинхэнэ итгэгч хүний жинхэнэ үр жимс нь хаанчлалын төлөө бусдад хүрэх чин сэтгэл болохыг сурсан билээ. Бид аврагдах үедээ тэс өөр хүн болж өөрчлөгддөг. Бид шинээр төрөхдөө үйлчлэх жолоогүй хүсэл тээж төрдөг. Есүс:

*Бэлхүүс чинь бүслээстэй, дэнлүү чинь асаатай байг
(Үйлчлэхэд бүрэн хувцаслаж, дэнлүүгээ асаалттай байлга)
(Лук 12:35) гэсэн.*

Үйлчлэл, үйлчлэх чин хүсэлтэй байх - цэх зогсолтоо хадгалах энэ тушаал нь итгэгч бүрт хамаатай. Үйлчлэл, үйлчлэх чин хүсэл нь бидний шинэ мөн чанарын хэсэг учраас, би *хадгалах* гэж яриад байгаа юм. Аврал нь угтаа үнэ төлбөргүй бэлэг атал хүмүүс бид авралыг “үйлс рүү” хазайлдуулах гээд байдаг талтай. Гэтэл үнэндээ тийм биш. Үйлчлэх нь бидний сүнсэнд төрсөн хүсэл болой. Бид яагаад энэ шинэ амьдралынхаа томоохон хэсгийг хэлэлцэхээс зайлсхийх юмуу үл хайхарна вэ? Христэд итгэх итгэлийг дахин шинээр туурвих хүсэл нь улам л хэрэглээ суурьтай итгэлийн туршлага болоод байна уу? Бид хүн төрөлхтний сүнсний залхууралд улам л автаад байна уу?

Есүс яагаад “үйлчлэхэд бүрэн хувцасла” гэж хэлэв? Яагаад үйлчлэлтэй хувцсыг хамаатуулах болов? Илчлэл ном бидэнд сэжүүр өгчээ:

Баярлан хөөрч, Түүнд алдрыг нь өргөн өргөмжилцгөөе. Учир нь Хурганы хурим болж, сүйт бүсгүй нь өөрийгөө бэлдэв. Тэрээр гялалзсан, цэвэр, нарийн маалингаар хувцаслах болжээ. Учир нь нарийн маалинга нь ариун хүмүүсийн зөвт үйлс юм. (Илчлэл 19:7-8)

Нэгдүгээрт - Бурхан биш, харин сүйт бүсгүй өөрөө өөрийгөө бэлтгэсэн байна. Хоёрдугаарт - сүйт бүсгүйн өөрийгөө бэлтгэсэн арга байдлыг анхаарна уу. Сүйт бүсгүй бүр хуримын даашинзаа сонгох гэж нилээд юм болдог. Хуримлах гэж буй сүйт бүсгүйд бараг үүнээс чухал зүйл байхгүй дээ. Манай Барууны нийгэмд бол сүйт бүсгүйчүүд хуримын даашинзаа олж авахаар *дэлгүүр хэсч, худалдаж авах* гэж овоо хөөрхөн ажил болдог. Бидний хувцас нарийн маалингаар урлагдах бөгөөд Бичээсийн хэлснээр энэ нь хаанчлалын төлөө зүтгэсэн бидний үйлчлэл ажээ. Тиймээс, үйлчлэл нь бидний сүнсний ДНХ-д байдаг байх нь. Есүс “Эцэг Намайг илгээсний адил Би бас та нарыг илгээнэ” (Иохан 20:21) гэсэн. Тэрбээр үйлчлэх зорилгоор л ирсэн (Марк 10:45) бөгөөд бидний үүрэг ч ялгаагүй болой. Есүс мөн үйлчлэхийн цаад “яагаад” гэдэг учрыг ийнхүү хэлжээ: “Миний хоол бол Намайг илгээсэн Түүний хүслийг үйлдэн, ажлыг нь гүйцэлдүүлэх явдал юм” (Иохан 4:34).

Хүний бие хоол тэжээлгүйгээр удаан тэсэхгүй. Үүнтэй адил хаанчлалын бүтээн байгуулалтад үйлчилж байгаа итгэгч хүн хүнс

тэжээлгүйгээр удаан тэсэхгүй, эцэстээ няцна. Энэ талаар Есүс Лук 12 дээр үргэлжлүүлэн дүрсэлсэн байдаг. Энэ шалтгаанаар л нүгэлт дэлхийн хүчирхэг систем биднийг үржлээр өлөн явахын оронд өөртөө бах тавтай, тав тухтай болгож хувиргахын төлөө чадах бүхнээ хийнэ.

Тиймээс хүндэт уншигч минь, үр нөлөөллөө өсгөхийн төлөө өлсөж цангаж байгаа сэтгэл дундралаа бүү үл хайхар! Энэ чинь тэнгэрийн үржилд итгэх итгэлийг чинь сэгсрэн сэрээх Бурханы арга зам болох нь олонтаа.

МИНИЙ СЭТГЭЛ ДУНДРАЛ

Сатаны урхи Америкт төдийгүй, олон улсад тархуут л та намайг сэтгэл ханаад налайчихсан гэж бодож байгаа байх. Үгүй юм. Би илүү гүнзгий төвшний сэтгэл дундралтай тэмцэлдэж эхлэв.

Одоо би хамаагүй том чуулган, конференцэд номлох болсон хэдий ч, нэг цуглаан дээр бүгдийг багтааж номлож чадахгүй байгаадаа гонсойв. Би нэг номыг дунджаар дөрвөн зуун цаг бичдэг бөгөөд тухайн номыг бичиж байхад Ариун Сүнс ч маш ихийг илчилдэг. Тэдгээр нь хайртай хүмүүсээ хүчжүүлж, чөлөөлж, Өөртэйгээ улам ойр дотно болгохын төлөө Бурханы бичүүлсэн үнэн болой.

Тэгвэл дийлэнх чуулган, конференц нэг удаадаа 35-40 минут л номлох хугацаа олгодог. Тиймээс би *Сатаны урхийг* ярихдаа, нэг бүлэг юмуу дээд тал нь бүлэг хагастай л ярьж амждаг байлаа. Тэгэхээр хүмүүс номоо худалдаж авч уншихгүй л бол, номын маань ерэн таван хувь хүмүүст хүрэхгүй. Дээрээс нь цуглаанд оролцсон хүмүүсийн тавны нэг нь л номоо худалдаж авч, уншина.

Тиймээс энэ дундуур сэтгэл маань үр хөвөрсөөр яваад, *Сатаны урхийг* хэвлэгдсэнээс таван жилийн дараа энэ номоороо цогц сургалтын материал гаргах санаа төрсөн юм. Би тус бүр гучин минут үргэлжлэх 12 хэсэг бүхий видео хичээл бичүүлээд, хичээл бүрээрээ тухайн бүлгийн гол үнэнийг базаж заая. Ийнхүү хүмүүс зөвхөн ном унших бус, харин хувиараа юмуу эсвэл бүлгээрээ тухайн үгийг бүрэн эхээр нь сонсож, үзэх боломжтой болов. Ийм маягаар номын маань утга агуулга хүчтэй дэлгэрнэ. Бүлгээрээ болоод хувиараа судлахад нь бэлтгэж өгсөн асуулт маань Ариун Сүнсний ажлыг гүнзгийлж, хүмүүст ч үгийг хэрэгжүүлэхэд нь дөхөмтэй болгов.

Энэ талаар багтайгаа ярилцлаа. Нэг гишүүн маань арван хоёр видеотойгоо хамт оюутны сурах бичиг, удирдагчийн гарын авлага бүтээх боловсрол - хөгжлийн компани олох санал дэвшүүллээ. Энэхүү цогц сургалтын хөтөлбөрийг маань төрөл, төрлийн хүмүүс хэрэглэх ёстой.

Бид Америкийн томоохон корпораци тэргүүтэй дор хаяж 2,500 захиалагчид зориулан ийм ажил гүйцэтгэж өгсөн, шилдэг үйлдвэрлэгчийг оллоо. Бид анхнаасаа л “Захиалагчийн санал хүсэлтэд төгс нийцсэн, чанарын асуудалгүй, дээрээс нь дээд зэргийн шинэлэг байх, хэв загварын талаасаа ч, технологийн талаасаа ч хэзээ ч хоцрогдохооргүй юм хийх” өндөр шаардлага тавьлаа. Дашрамд хэлэхэд, энэ ажлын ачаар надад Америкийн нэгэн ерөнхийлөгчийн багийнхантай Библи судлал хийх завшаан олдсон билээ. Цагаан ордны Баруун жигүүрт нэвтрэхдээ, тэнд төгс эрхэмлэл ноёрхож байгааг өөрийн эрхгүй анзаарч билээ. Тэр өдөр надад “Эд Америкийн ерөнхийлөгчийг төлөөлж байгаа бол, Мессенжерийнхэн бид ертөнцийн Хааныг төлөөлж байгаа” гэсэн бодол сууж билээ. Манайхан анхнаасаа л онцсайныг эрхэмлэн мөрдөж ирсэн хэдий ч, тэр өдрөөс хойш чанарыг хэзээ ч золиослохгүй, аргалахгүй гэдэг итгэл үнэмшил дээрээ бүр хатуу зогсох болсон юм.

Ийнхүү манай цогц материал бэлэн болоход, багийн маань хоёр гишүүн утсаар ярих бүтэн цагийн ажилд томилогдов (2000 онд удирдагч нартай харилцах шилдэг арга энэ л байлаа). Манай хоёр сүүлийн арван жил манайтай хамтран ажилласан чуулган бүртэй холбоо барьж, удирдагчид нь цогц сургалтын материалынхаа талаар мэдээллэнэ. Бид пасторуудтай мөр зэрэгцэн алхалж, хүмүүсээ дагалдуулахад нь туслах замаар нутгийн чуулганыг бэхжүүлэх зүрх сэтгэлтэй л байлаа. Тухайн үед тийм төрлийн сургалтын материал ч хөгжөөгүй, хомс байсан юм.

Гэтэл санаа маань удирдагч нарт хүрч, тэд ч дуртайяа хүлээн авсан нь бас л гэнэтийн явдал байв! Хэсэг хугацааны дараа чуулгануудаас жижиг бүлгийнх нь ч, том цуглааных нь ч ирц огцом өсч буй тайлан мэдээ ирэх боллоо. Бид анх манай материалыг гурван зуугаас доош хүнтэй, жижиг чуулган л хэрэглэнэ гэж бодтол, хэдэн мянган хүнтэй хэд хэдэн чуулган видеог маань Бүтэн сайны үйлчлэлдээ хэрэглэв. Бүр гишүүд нь ирэх долоо хоног баяраар хол явах учраас, эзгүй хойгуур нь дараагийн ангийг үзүүлэлгүй азнаач гэж гуйсныг нь удирдагч нар бидэнд ярьж байлаа. Ирц нь хоёр, гурав дахин нэмэгдсэн тухай мэдээ ч сонсогдоно.

Чуулганд нь эсвэл жижиг бүлэгт нь юу болж байгааг пасторууд хоорондоо хуваалцав. Тэгээд материалын эрэл сурал болсон пасторууд манай руу утасдах болсон юм. Хэдхэн жилийн дотор Америкийн хорь гаруй мянган чуулган, Австралийн мянга гаруй чуулган хэрэглээндээ нэвтрүүлж, манай байгууллагын чуулганы хэлтэс бүтэн цагийн долоон ажилтантай болов. Бид амьдрал, гэр бүл, чуулган өөрчлөгдөж буй гэрчлэлд дарагдлаа.

Ирэх хэдэн жилд нь бид манай байгууллагаас гаргасан томоохон ном бүрийг дагуулж цогц сургалтын материал гаргадаг болов. Арван хоёр жилийн дотор манай арван төрлийн цогц сургалтын материалыг Америк, Австрали даяар хэрэглэсэн байв.

Гэтэл энэ дунд *Сатаны урхийг* хэзээ ч уншаагүй олон арван мянган хүн үгийг сонсож чадах болсон нь бидний урьдчилан хараагүй, хожим ойлгосон үржлийн маань нэгээхэн тал байжээ. Тэд манай материалыг удирдагчаасаа сурсан чуулганы бөгөөд жижиг бүлгийн гишүүд байв.

“ЧИ ИТГЭМЖТЭЙ БАЙЛАА”

Мэдээж бид талархлаар дүүрэв! Борлуулагдсан ном хэдэн саяар, цогц сургалтын материал маань хэдэн зуун мянгаар тоологдож байлаа. Энэ бүхэн нь Христийн биеийн төлөө байсан бөгөөд бид ч асар арвин үр жимс авч байсан ч, цаана нь энэ үнэнийг сонсоогүй итгэгч хүн бүр олон бий.

Тиймээс би Бурханаас борлуулснаасаа олон ном үнэгүй түгээх боломжийг гуйв. Өндөр үнээр ном, материал захиалах, худалдаж авах боломжгүй пастор, удирдагч, итгэгч хүмүүс дэлхийгээр нэг байгааг би мэдэж байлаа. Засгийн газар нь Христийн номуудыг хориглодог улсад нууц чуулганы сая, сая итгэгч бий. Мөн ном импортоор оруулж ирэх чадалгүй улс үндэстэн бүр ч олон бий.

Тэдэнд хэрхэн туслах вэ?

Тэр үлэмж хэрэгцээг мэдэж байсан ч, миний хувьд тэдгээр пастор, удирдагч нартай холбогдоно гэдэг биелэгдэшгүй даалгавар байв. Гэхдээ л бид ямар нэгэн юм хийх ёстой байлаа. Тиймээс тулгарсан бэрхшээл бүрт хариу барьж эхлэв. Тэгээд хөгжиж буй эсвэл хавчлагатай улс орны удирдагч нарт ном, материалын хэрэгцээ гарбал, хүссэн хэмжээгээр нь бэлэглэх юмуу эсвэл эх

оронд нь хэвлүүлэх үнэ өртгийг нь даах маягаар энэ асуудлыг шийдэх даалгаврыг олон улсын захиралдаа даалгалаа.

Тийм боловч, жил тутам арав, хорин мянган номоос хэтрэхгүй байгаа, өчүүхэн ажилдаа улам л бухимдсаар байв. Энэ тоо дагалдагч бэлтгэх материалын их сан дунд ёстой л дусал шиг байсан ч, бид жилээс жилд олдсон боломжоо алдалгүй, юм болгосоор байлаа.

Тэгтэл 2010 оны 5-аар сарын 31 буюу Дурсгалын өдөр тохиов. Лиза Англид эмэгтэйчүүдийн конференц дээр номлож байсан бол, би гольфоо дөнгөж дуусгаад байлаа. Би Библиэ аваад, Даниел номыг унших ятгалгын мэдрэмждээ автан, доод өрөө рүүгээ явлаа. Хоёрдугаар бүлгийг уншиж байтал, гэнэт Бурханы Сүнс манай доод өрөөг дүүргэн, би зүрхэндээ: “Хүү минь, чи Англи хэлтэй хүмүүсийн дунд *итгэмжтэй* үйлчиллээ. Одоо Би чамайг үгээ даян дэлхийн пастор, удирдагч бүрийн гарт хүргээсэй гэж хүсч байна” гэхийг сонслоо.

Ийнхүү Бурханы оршихуй хэдэн минут давалгаалав. Би ч Бурханы оршихуйг дээш өргөгдөх хүртэл нь гайхаж, биширсээр хоцорлоо. Одоо ямар нэгэн өөрчлөлт ирнэ гэдгийг би мэдэв. Цаашид олдсон боломж бүрийг мөлжих шаардлагагүй болсон, эдүгээ бид тэнгэрийн гэрэгэг хүлээн авчээ: Одоо бид үндэстэн бүрийн, хэл бүрийн, санхүүгийн бололцоотой, бололцоогүй пастор, удирдагч нарын эрэлд гарах ёстой.

Ариун Сүнгтэй уулзсан энэ уулзалтаас *итгэмжтэй* гэдэг үг надад тунав. Тэр үед “итгэмжтэй байдлыг” “үржилтэй” холбож мэддэггүй байсан надад энэ явдал илчлэл авчирсан юм. Тухайн үед надаас итгэмжтэй гэдэг Библийн тодорхойлолтыг асуусан бол, би яав ч *уржил* гэж хариулахгүй байсан. Доод өрөөнд хэлсэн Ариун Сүнсний үг энэ ойлголт руу зүрхийг маань анх нээж өгсөн юм. Би Бурханаас сонссоноо мэдэж байсан ч, үйлчлэл маань ийм нүсэр даалгаврыг биелүүлж чадах эсэхээс бас л сүрдэж байлаа.

Тэр үед би маш алдартай нэгэн Сайн мэдээ дэлгэрүүлэгчийн олон улсын үйлчлэлд ажилладаг Роб Биербектэй нөхөрлөөд удаж байсан юм. Роб тус үйлчлэлийн гүйцэтгэх захирлаар ажилладаг байсан бөгөөд энэ дундаа мөнөөх Сайн мэдээ дэлгэрүүлэгчийн номыг хэвлэж, тараах ажлыг хариуцдаг байсан болохоор дэлхийн бараг л бүх улсын пасторын сүлжээ, хэвлэлийн газрынхантай нягт холбоо харилцаатай байв. Гэтэл Сайн мэдээ дэлгэрүүлэгч саяхан тэтгэвэртээ гарч, Роб маань ажилгүй болоод байжээ. Манай

байгууллагын ч олон улсын хэрэг эрхэлдэг захирал дөнгөж ажлаасаа гараад байсан болохоор Лиза, бид хоёр Роб, түүний гэргий Ванесса хоёрыг багтаа урив. Энэ түншлэл ямар нөлөө авчрахыг хэн маань ч төсөөлөөгүй билээ.

Тэгээд 2011 оны 1-ээр сар болж, Роб, Ванесса хоёр манай үйлчлэлийн гол удирдагч нарын хуралд оролцов. Тэр хурал дээр би: “Өнгөрсөн жил бид гадаадын пастор, удирдагч нарт хичнээн ном түгээсэн?” гэж асуулаа.

Манай нэг гишүүн жилийн эцсийн тайланг харснаа: “Гучин гурван мянган ном” гэж хариулав. Тэрбээр намайг баяртай хариу хэлнэ гэж бодсон ч, эндүүрчээ. Би бачууран: “Муу байна!” гэснээ өөрөө ч мэдэлгүй: “Энэ жил бид хөгжиж буй, хавчлагатай улс үндэстэнд 250,000 ном тараана” гээд хэлчихэв.

Өрөө нам болов. Лиза золтой л бөөлжихөөгүй гэдгээ хожим хэлж билээ. (Манай гэргий их өвөрмөц хошигнодог хүн шүү!)

Эцэст нь манай гүйцэтгэх захирал - миний ууган хүү Аддисон: “Аав аа, та ийм олон ном гэдэгт итгэлтэй байна уу?” гэлээ.

Би ч бүх зүрхээрээ: “Итгэлтэй байна” л гэлээ.

Хүү маань дахин хориод минут намайг элдвээр сорив. Бид хоёр таг суугаа бусдынхаа өмнө дайралцсаар байлаа. Хүү маань тун хүндэтгэлтэй байсан ч, миний чиглүүлгийг хэт өндөр хэмээн үзсээр байв. Тэгээд эцэстээ бухимдангуй: “Би зүгээр л багийнхандаа хийсвэр зорилго тулгамааргүй байна!” гэж хэлсэн юм.

Яг тэр үгтэй хамт миний ч тэвчээр шавхагдав. Би нударга зангидан ширээ тулаад: “Энэ жил бид 250,000 ном өгнө гэж би хэлж байна” хэмээн хатуу мэдэгдлээ. Өрөө нам. Уулзалтын дараа уур амьсгал хүнд байлаа.

Маргааш өглөө нь хүү маань аавтайгаа хоёулхнаа байхдаа: “Аав аа, та арай л ширүүлсэн” гэв.

Бид хоёр хоёулаа тайвширсан бөгөөд эвлэрэхийг хүсч байлаа. “Миний хөө, аав нь багийнхаа оролцоонд хайртайг чи мэднэ. Ер нь шийдвэр гаргахаасаа өмнө хүн бүрийн санал бодлыг сонсож, жинлэдэг. Гэхдээ, өчигдрийн асуудал бол өөр. Би та нараас “Бид 250,000 ном өгөх хэрэгтэй юу, үгүй юу?” эсвэл “Дараа жил бид хэдэн ном өгөх хэрэгтэй гэж бодож байна?” гэж асуугаагүй. Аав нь өгнө гэсэн! Гэтэл чи надтай хорин минут маргасан.”

Хүү маань хүлээн зөвшөөрөн, толгой дохиод, эцэст нь: “Аав, та энэ талаараа ядаж 1 хоног залбирчих. Тэгээд дараа нь хийх хэрэгтэй

гэж бодсоор байвал, багаараа зүтгэе” гэж гуйлаа.

“Тэгье, зөвшөөрч байна.”

Гэхдээ яг үнэндээ би нэг их залбирсангүй! Ямар ч байсан амласнаа биелүүлэхийн тулд хагас дутуу залбирсан боловч, шийдвэр маань зөв гэдгийг мөнөөх доод өрөөнд тохиосон уулзалтын цаанаасаа л мэдээд байлаа.

Та намайг айсан болов уу гэж гайхаж байгаа байх. Хэлэх юм биш. Ухаан алдтал айсан! Би тэр их мөнгө хаанаас ирнэ ээ гэж бодохоос зориуд татгалзаж байлаа. Тэгж бодох л юм бол, төдөлгүй хүүтэйгээ санал нийлээд, мөнөөх “боломжгүй” тооноосоо шууд ухрах байв. Саяын дөрөвний нэгтэй тэнцэх зорилго боломжгүй харагдаж байсан ч, би чиглүүлэг дээрээ бат гишгэхээр шийдсэн юм. Нэг бол бүтээлч арга ухаан сэднэ эсвэл гайхамшигтай хангамж ирнэ - ер нь ямар нэг аргаар бүтэх л ёстойг цаанаасаа л мэдээд байлаа. Гэтэл аль нэг нь биш, хоёул хоёулаа ирэхийг нь харин би мэдээгүй юм.

Гурван долоо хоногийн дараа би Флоридагийн нэгэн зочид буудалд шинэ ном дээрээ ажиллаж байлаа. Намайг өглөөгүүр номоо бичиж байхад, залгаж болохгүйг манай багийнхан мэднэ. Энэ үед би хамгийн сайн төвлөрдөг. Гэтэл гар утас маань дуугарлаа. Хартал оффисоос залгаж байна. Би ч ямар нэгэн яаралтай, чухал юм гарчээ хэмээн таамаглаад утсаа авлаа. Утасны нөгөө үзүүрт бөөн баярын чимээ сонсдов. Тэнд гурван долоо хоногийн өмнө хуралд суусан бүх хүн байсан бөгөөд бүгдээрээ л ямар нэгэн баяр тэмдэглэх шиг дуу хөөр болж байлаа.

Аддисон: “Аав, бид 250,000 ном тараах санааныхаа талаар санхүүгийн түншүүддээ албан ёсоор мэдээллээгүй байгаа ч, багийн маань нэгэн гишүүн таньдаг хүндээ хэлж л дээ. Гэтэл нөгөө хүн нь үүнийг сонсоод энэ төсөлд 300,000 доллар өгөхөөр амласан байна!” гэж хэлэв.

Энэ хүртэл манай үйлчлэл нэг хүнээс 50,000-аас дээш долларын бэлэг авч үзээгүй байлаа. Ийнхүү би ч тэр баярт нь нэгдэв! Бөөн, бөөн баяртай, сайхан үгс солилцсоны дараа би хүмүүстээ: “Гурван долоо хоногийн өмнө яагаад намайг тийм хатуу байсныг одоо ойлгов уу?” гэж хэлэв.

Хүү маань инээснээ шууд: “Аав аа, одоо та нэг сая ном өг” гэсэн ч, би бүрэн дагана шүү” гэж хэлсэн бөгөөд бусад нь ч санал нийлсэн юм.

Би тэр өглөөг яагаад ч мартажгүй. Утсаа тавьсны дараа дахиж ном дээрээ төвлөрч чадсангүй. Зүгээр л: “Баярлалаа, баярлалаа,

баярлалаа!” гээд л наашаа цаашаа алхсаар байлаа. Хацраар нулимс бөмбөрөөд л. Зуун зуун пастор, удирдагч хүсэн хүлээсэн дагалдагчийн ном, материалаа хүлээн авахыг нь би зүрхэндээ төсөөлөн харлаа.

Аддисон шударга байж, намайг сорьсонд нь би талархдаг. Тэр санаагаа дотроо нөөцлөлгүй, харин бусдыгаа төлөөлөн ярьсан нь сайн хэрэг. Бусдынхаа гаргаж хэлээгүй ч, мэдэрсэн бодлыг Аддисон төлөөлөн ярьсан бөгөөд тийм бодолтой нүүр тулах хэрэгтэй байдаг. Энэ бүх үйл өрнөлөөр бид дуу чимээгээрээ зүрхийг минь үхүүлэн, замыг маань өөрчилж, арамнаасаа гаралгүй амьдрахад хүргэх зорилготой айлган сүрдүүлэгтэй халз мөргөлдсөн юм. Эс бөгөөс бидний алсын хараа үхэж, бид ч тийм том, том өгөөмөр бэлэг хүлээж авахгүй байсан. Магадгүй тавин мянган ном тараах юмуу эсвэл шийдвэр гаргалгүй явсаар байх байсан биз.

Бид зорилгоо тогтоосон. Үүнийг маань ч Ариун Сүнс үзээд, нөгөө хүнээр ер бусын том бэлэг өгүүлжээ. Бид ч багаараа итгэлийн цоо шинэ төвшин рүү гарсан юм.

Тэр жил бид Бурханы нигүүлслээр 48 орны пастор, удирдагч нарт 271,200 ном өгч билээ. Заримаас нь дурьбал Иран, Сири, Ливан, Узбекистан, Казахстан, Туркменистан, Хорват, Албани, Египет, Вьетнам, Мьямар, Камбож, Монгол, Турк, Хятад, Африкийн хэд хэдэн улс зэрэг болно. Өмнөх жилүүдэд нь хэдэн арваадхан мянган ном өгч байсан бол, одоо саяын дөрөвний нэгт хүрэв. Бидний тэлэх чадал даруй найм дахин өсчээ. Энэ аугаа үржлийн төлөө Бурхандаа л талархах!

ЭНЭ БҮХЭНД Ч ХАНАСАНГҮЙ

Энэ явдал үүгээр дуусаагүй гэж үү?

2011 оны 5-аар сард болсон нөгөө хурлын дараа Роб, бид хоёр Ливаны Бейрутэд Ойрх Дорнодоос зорьж ирсэн пастор, удирдагч нарт үйлчилж байлаа. Цуглааны дундуур Роб надад: “Иракийн Ирбилээс ирсэн нэг пастор чамтай уулзъя гэнэ. Түүнтэй уулзаж болох уу?” гэлээ.

“Уулзалгүй яахав дээ!”

Роб Ирак пастор, бид хоёрыг зочид буудлын хүлээлгийн танхимд

уулзуулав. Пастор маань гучин тав орчим настай залуу хүн байсан бөгөөд нүдэнд нь гал бадарч байлаа. Тэрбээр үнэхээр хаанчлалыг байгуулахаар шийдчихсэн хүн байв. Өөрөөр хэлбэл, үйлчлэлийнхээ төлөө бүрэн хувцасласан бөгөөд дэнлүү нь асаатай хүн байв! Тэрбээр Ирбилээс цуглаан, сургаалаар хүчжих гэж л иржээ. Тэрбээр төөрөгсдийн төлөө санаа тавихын утгыг ойлгосон, санаачилгатай, өсөлттэй удирдагч гэдэг нь шууд харагдаж байлаа.

Уулзалт маань боловсон маягийн, хөнгөн яриагаар эхэлсэн ч, яваандаа нилээд ширүүссээр, сүүлдээ нөгөөх чинь: “Бивэр пастор аа, би таныг сүнсний ааваа гэж үздэг. Би таны ном бүрийг уншдаг (Төрөлх хэл дээр нь цөөхөн ном гарсан ч, тэрбээр англиар уншдаг байж). Тэр бүү хэл, кредит карт ашиглаж Мессенжер Интернэйшнэлийн цахим хуудсаас таны материалыг худалдаж авдаг” гэсэн юм.

Тэрийг сонсоод, дотор харанхуйлаад л явчихлаа. Үнэндээ үүнээс хойш юу ярьснаа ч санадаггүй юм. Толгойд минь *“Өмнө минь дайнд нэрвэгдсэн улсын пастор хүн сууж байна. Гэтэл энэ хүн цахим хуудсаас материалыг маань кредит картаар худалдаж авдаг гэнэ”* гэсэн хашхираа цуурайтаж байлаа. Энэ архаг хэрэгцээний талаар би Эзэнтэй уулзаж ярилцахаар ярав.


Ирак пастораас салсныхаа дараа би шууд өрөөндөө орон, хаалгаа хаагаад, гутарсандаа: “Бурхан минь, Таны бидэнд даалгасан энэ үгийг Таны үгээр гачигдсан пастор, удирдагч нарт хэрхэн хүргэхийг Та Өөрөө харуулах ёстой” гэж хашхирав. Би хажуугийнхаа өрөөний хүмүүсээс зовсонгүй. Би тэр удирдагч нарыг материалаар хангах Бурханы захирамжийг биелүүлэх тэнгэрийн стратегийг олж мэдэх ёстой байлаа.

Энэ хурц залбирлаас хэдхэн хоногийн дараа надад нэгэн санаа орж ирэв: бидний нөлөөг хэд дахин өргөжүүлэх - үнэндээ нэг их нэмэлт ажил, зардалгүйгээр үсрэнгүй нөлөөтэй болгох стратегийн санаа.

Бүр суут санаа ч гэж болох. Энэ үнэхээр Бурханы санаа байв. Маш энгийн санаа. Гэхдээ бид үүнийг шүүрч аваад, хэрэгжүүлсэн. Цаашаа юу болсныг уншаарай!

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

1. Сэтгэл гонсойх, сэтгэл дундрал нь үржлийн төлөө итгэлийг маань бадраах өөрчлөгч хүчин зүйл болох нь олонтаа. Бурхан таны амьдралын аль нэг талыг өсгөхөөр уриалан дуудаж байна уу? Тийм бол, та дуудлагад нь хэрхэн хариулж байна?
2. Хэрэв та хувийнхаа хэрэгцээнээс болж сэтгэл дундуур байгаа бол, Бурхан үүнийг чинь таашаахгүй. Нөгөөтэйгүүр, бусдын хэрэгцээнээс болж, хаанчлалыг байгуулахын төлөө сэтгэл дундуур байгаа бол, үүнийг чинь Бурхан таашаана. Та чухам юунаас болж сэтгэл дундуур байна?
3. 250,000 ном тараасан түүхийг минь бодож үзнэ үү. Бурханы амлалтаас зуурч, үржлийн шинэ төвшинд хүрэхэд яагаад итгэл амин чухал вэ? Хүмүүс санал нийлэхгүй байсан ч, та Бурханыг дагах нь яагаад чухал вэ?



*Харин та нарын хэн нэг нь мэргэн ухаанаар дутвал,
бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч
Бурханаас гүйг. Тэгээд түүнд өгөгдөх болно.*

— Иаков 1:5

Стратегийн санаа

Б и жил өнгөрөх тусам, *хөглөгдсөн стратегийн санаа* гэдэг зүйлийн жинтэй үнэ цэнэд улам л итгэх болсон юм. Бид Бурханы хангамж, оролцоог голдуу ямар ч тактикийн төлөвлөгөөгүй хайдаг. Гэхдээ тийм зүйл байхгүй. Бурханаас төрсөн стратегийн санаа л бүтнэ! Энэ талаар жагсааж болох Библийн дүрслэл олон чиг, санаагаа бодитой болохыг батлах үүднээс хэдхэн жишээ л дурьдъя:

- Сая, сая хүнийг ундаалахын тулд гашуун усанд модны хугархай хаях *стратегийн санаа* (Гэтлэл 15:22-25-ыг үзнэ үү).
- Мөн л сая, сая хүнийг ундаалахын тулд усанд хад хаях өөр нэгэн төрлийн *онгод бүхий санаа* (Гэтлэл 17:5-6).
- Эзлэгдэшгүй хүчирхэг хотын нэвтрэшгүй ханыг зургаан өдрийн турш жагсаалаараа чимээгүй тойрох *стратегийн санаа*. Тэгээд долоо дахь өдөр нь өөр нэгэн стратегийн санаа хэрэгжүүлсэн: жагсаалаараа бүрээ үлээн долоон удаа тойроод, эцэст нь удаан гэгч нь тэнхээ мэдэн орилох. Энэ үйлдэл нь орц гаргаж, хотыг эзлүүлсэн (Иошуа 6-г үзнэ үү).
- Цэргийн гарамгай удирдагчийг тодруулахын тулд хэдэн арван мянган хүнийг булгаас ундаалаад, дараа нь ус руу харж уусан хүмүүсийг нь тулааны талбараас нүдээ салгалгүй уусан хүмүүсээс салгах *стратегийн санаа* (Шүүгч 7:4-6-г үзнэ үү).
- Дайсантай халж тулж байлдалгүй, харин араас нь гэтэн, модон дунд бүслэж аваад, ялам модны орой дээр жагсаалын хөлийн чимээ гарахыг хүлээх (Энэ нь Эзэний “Дайраад!” гэсэн тушаалын дохио байв) *стратегийн санаа* (2Самуел 5:22-25).
- Их өлсгөлөнгийн үеэр хүүтэйгээ амьдардаг бэлбэсэн

- авгайгаас эцсийнхээ хүнсийг өөрсдөө идэлгүй, эш үзүүлэгчийг хооллооч гэж гуйхад нь авгай биелүүлбэл, түүнийг бусад үй олон гэр бүл шиг өлбөрч үхүүлэлгүй, амьд үлдээх *стратегийн санаа* (1Хаад 17:8-15-ыг үзнэ үү).
- Өрөнд ороод, хоёр хүүгээ алдахдаа тулсан бэлбэсэн авгайгаас гэрт нь юу байгааг асуух *стратегийн санаа*. Түүнд айлаас аль болох олон хоосон сав суулга зээлж аваад, гэртээ байгаа өчүүхэн чидуны тосоороо дүүргэн, тосоо зарж өрөө төлөхийг зааж өгсөн (2Хаад 4:1-7).
 - Өвчин туссан цэргийн даргыг Иордан гол дээр аваачин, усанд долоон удаа булхуулж, бүрэн эдгээх *стратегийн санаа* (2Хаад 5:1-19-ийг үзнэ үү).
 - Магтаал, хүндэтгэлийн багийг цэргүүдийнхээ өмнө алхуулсаар, бүрэн ялалтад хүргэх *стратегийн санаа* (2Шастир 20:21-26-г үзнэ үү).
 - Хааны баялаг хоолыг бус, ногоо идсэнээрээ илүү эрүүл, хүчтэй байж, улсынхаа хамгийн сайхан залуус дундаас шалгарах *стратегийн санаа* (Даниел 1:8-16-г үзнэ үү).
 - Гэрт байгаа сав, цэвэр ус хоёроос шилдэг дарс гарган авч, хурим найрыг аврах *стратегийн санаа* (Иохан 2:6-10-ыг үзнэ үү).
 - Өчүүхэн өдрийн хоолыг ерөөж, тарааснаараа мянга, мянган хүнийг хооллох *стратегийн санаа* (Матай 14:13-21).
 - Шороо руу нулиман, зуурмаг болгоод сохор хүний нүдэн дээр наах *стратегийн санаа*. Дараа нь түүнд явж угаагаад, хараатай бол гэсэн (Иохан 9:6-7-г үзнэ үү).
 - Амиа аврахын тулд живж байгаа завиа орхихгүй байх *стратегийн санаа* (Үйлс 27:21-44).

Жишээ болгон дээрх шинэ санаа нь тэнгэрийн оролцоотой байна. Үйл явдал болгоны дундуур нийтлэг нэгэн утас гүйж байгааг олж харав уу? Тэнгэрийн стратеги нь боломжтой эх үүсвэр, байр суурь зэрэг хүлээн авагч хүнд хэдийнээ байгаа зүйлийг нь ашиглаж байна. Үйл явдал бүр дээр тэнгэрийн хангамж төстэй маягаар бууж байна. Өөрөөр хэлбэл, гайхамшигт хүргэж буй амин бүтэц нь гэнэт ер бусаар бий болчихоогүй ажээ.

Бурхан ер бусын үр дүнгийн төлөө *ердийн зүйлийг* ер бусын арга замаар *ашиглах стратегийг олонтаа хэрэглэдэг*. Бидэнд “Мэргэн ухааныг ол Олсон бүхнээсээ Ухааран ойлгохуйг ол Энэ нь мэргэн ухааны эхлэл” (Сургаалт үгс 4:7) гэж заадаг. Тэнгэрийн цэц ухааны

нэгэн хэлбэр нь стратеги бүхий санаа бөгөөд Бурхан цэц ухаанаа харамладаггүй нь тун сайхан мэдээ юм. Ер бусын бэрхшээлтэй тулгарсан бидэнд элч Иаков ингэж зааварлажээ:

Харин та нарын хэн нэг нь мэргэн ухаанаар (стратегийн санаагаар) дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно (Иаков 1:5, хашилтанд хийсэн үгийг зохиолч хийв).

Бурхан үүнийгээ нуудаггүй, харамладаггүй, чөлөөтэй санал болгодог. Тэр ингэж амласан. Тийм боловч, стратегийн санааг хүлээж авахын төлөө биелүүлэх ёстой хоёр нөхцөл байна:

Харин тэр ямар ч *эргэлзээгүйгээр итгэлээрээ* (бат итгэлээр) гуйг. Учир нь эргэлзэгч (шийдвэргүй) нэгэн бол салхиар туугдан давалгаалах тэнгисийн долгио мэт ажээ. Тийм хүн Эзэнээс юм авна гэж бүү санаг. *Хоёр санаатан* (хуваагдмал зүрхтэй, гуйвамтгай) нь бүх үйлдээ *тогтворгүй* байдаг юм. (Иаков 1:6-8)

Бид *бат итгэлээр* гуйх ёстой - бид тактикийн санааг горьдох бус, харин бүрэн эрхээр хүсэн хүлээх ёстой. Түүнчлэн, бид хүсэлтээ дагасан улайралтай байх ёстой буюу *үнэн голоосоо хүсэх* ёстой. Хүсэлт маань “*Хүлээж авбал, сайн л байна. Хүлээж авахгүй бол мөн л зүгээр*” гэсэн боловсон шашинлаг байдлаас төрөхгүй. Үүнийг хүлээж авахад байж ядсан хүсэл, бат шийдмэг чанар хэрэгтэй.

Стратегийн санаа нь Бурханаас өгөгдсөн санаа бөгөөд үүнийг хүлээж авбал, өөр нэгэн үр нөлөө бүхий талбар нээгдэнэ. Энэ нь биднийг үржих хүчтэй болгодог.

ШИНЭЭР ТӨРСӨН, СТРАТЕГИЙН САНАА

Бейрут дэхь зочид буудалд болсон явдлыг дахин сөхөхөд, тэр өдөр би өрөөндөө аядуу тайван залбирч яагаад ч чадаагүй. Би хамаг л арга чарга, санаагаа бараад байсан боловч, нөгөө талаас тэр гачигдаж, цангасан пасторуудыг ном, материалаар хангаж өгөх үүрэгтэй гэдгээ мэдээд байлаа. Уг нь би зочид буудлынхаа өрөөнд орилж хашхичдаг хүн биш боловч, тэр өдөр үнэхээр хүмүүсээс зовсонгүй.

Би үр нөлөөтэй байдлаа үржүүлэх *стратегийн* (цэц ухааны) төлөө аргаа баран бархирсан юм.

Тэгээд хэсэг эрчтэй залбирсны дараа зүрх маань амар тайвнаар дүүрэв. Энэ тайтгарал миний хүсэлт Бурханд хүрсний гэмдэг болсон бөгөөд хариулт айсуйг мэдэв. Хэдийгээр би ямар нэгэн *стратегийн санаа юмуу төлөвлөгөө* хүлээж аваагүй ч, дотоод оршихуй маань талархлаар халгив.

Хэд хоногийн дараа бодлоо: *Бид энэ их номыг тараах гэж маш их цаг, мөнгө, эрч хүч зарж байгаа ч, удирдагч болгон гар дээрээ ганц л ном хүлээн авч байна. Яагаад бид Англи хэл дээр хийж байгаа зүйлээ олон улсад хийж болохгүй гэж? Яагаад бид цогц материалаар нь орчуулан гаргаж болохгүй гэж? Тэгвэл бидний үр нөлөө өсөх бус уу?*

Гэвч энэ бүр том ажил. Бид яаж ийм их материал хэвлэж, тараах билээ? Бид сургалтын материалын үнэ өртгийг нь төлдөг юмаа гэхэд, зорилтот улс үндэстэн маань өөрсдөө тэр их материалыг хариуцаж, тараах ёстой болно. Гэтэл дийлэнх нь хүрч очиход бэрх ширэнгэн ой, уул, цөл, усанд амьдарна. Засмал замгүй газар олон. Үүнээс гадна эрх баригчдын зүгээс эсэргүүцэх, шалгах, материалыг нь хурааж авах ч эрсдэлтэй.

Тийнхүү нилээд залбирч, эргэцүүлсний эцэст бүтэн материалаа DVD-ROM (зөвхөн компьютераар уншдаг DVD) дээр буулгах өөр нэгэн санаа төрөв. Гэтэл энэ санаа ч бас асуудал дагууллаа: Гадаад пасторууд бүгд компьютертай билүү? Байлаа гэхэд, DVD-ROM уншиж чадах болов уу? Нөгөөтэйгүүр, DVD-ROM дээр бүх хичээл багтах уу?

Би энэ бүхнийг мэдмээр байсан тул Робтой уулзлаа. Тэрбээр 160 оронд очиж үзсэн болохоороо, бидний хүрэх гэсэн улсуудын техникийн хүчин чадлыг хамгийн сайн мэдэж байлаа. Би Робоос: “Ядуу улс орнуудын пастор, удирдагч нар компьютер хэрэглэдэг үү?” гэж асуув.

— “Тийм ээ, дийлэнх нь хэрэглэдэг, хэрэглэдэггүй цөөхөн хүн л байгаа байх.”

— “Тэдний компьютер DVD-ROM уншдаг уу? Уншдаг байлаа гэхэд, бид DVD-ROM дээр хэр хэмжээний материал суулгаж чадах уу?”

Робын нүд нь гялалзсанаа: “Уншина. Хоёрдугаарт асуултын хувьд - нилээд их материал суулгана!” гэлээ.

Тэгэхээр нь би ч санаагаа цутгачихлаа. “Бид номынхоо ард DVD-ROM нааж болох уу?”

— “Болно!” хэмээн Роб баяртайгаар батлан хэлэв.

— “Ном бүртэй дагалдуулна гэвэл, хэд болох уу?”

Роб хэдэн өдөр судалгаа хийгээд, надтай холбогдлоо: “Сайн мэдээтэй. Ном хэвлэж, тараах зардал дээр DVD нэмэхэд ердөө таван цент л нэмэгдэх нь байна.”

Би баярласан хэдий ч, датагаа диск дээр хэрхэн буулгахаа мэдэхгүй байсандаа бас л эмээв.

Гэтэл Роб: “Гэхдээ бүр сайн мэдээ нь бид цогц материалаа төдийгүй, дээрээс нь номынхоо аудио хувилбарыг, дээрээс нь өөр 2-3 ном, Шинэ гэрээ, ПиДиЭф файл (нутгийн пастор өөрөө хүсвэл, номоо нэмж хэвлэж болох файл) эдгээрийг багтааж болно!” гэлээ.

Бид хоёрт хичнээн эр бяр амтагдаж, ялалт мэдрэгдэж байсныг ярих юм биш.

Энэ бүхэн маань бас нэгэн *стратегийн санаа* руу хөтлөв. Тэр санаа мөн л үр тариалах улс үндэстний техникийн хүчин чадлаас хамаарах байлаа. Тиймээс би: “Тэр улсуудын дийлэнх нь интернеттэй юу?” гэж асуув.

Роб: “Дийлэх нь холбогдсон!” гэж хариуллаа.

— “Бид тэр бүх орчуулгын эх үүсвэрийг агуулсан цахим хуудас бий болгобол, ямар уу? Христэч цахим хуудас шиг сонсогдохооргүй, библийн сургаалыг эсэргүүцдэг засгийн газар нь хаахааргүй цахим хуудас? Цахим хуудсынхаа нэрийг номынхоо эхний нүүрэн дээр хэвлээд, пастор, удирдагч нарт хүмүүсээ тэр цахим хуудсаас материал татаж авахыг уриалаарай гэж зааварчилбал, чуулган бүхлээрээ ямар ч зардал гаргалгүй, үзэж чадна” гэлээ.

Роб, бид хоёр яг л тоглоомын дэлгүүрт орчихсон хоёр жаал шиг л баяргаа багтаж ядан зогсов. Стратегийг маань бэхжүүлэх санаа ар араасаа ундарсаар байлаа.

Бүхнийг сайтар хэлэлцсэнийхээ дараа бид хоёр нэг удирдагчид очих багцыг дунджаар дөрвөн доллараар хэвлэн тарааж болохыг тогтоов. Манай Мессенжерийн багт цахим хуудас хийдэг мэдлэг, ур чадвартай хүмүүс байлаа.

Тэнгэрээс бусан энэ санаа дан ганц удирдагч хүнээр тогтохгүй, бүхэл бүтэн чуулганаар нь, жижиг бүлгээр нь сургаж, бэлтгэж, бэхжүүлэх хүчин чадалтай болохыг төдөлгүй манайхан ойлгов. Дэлхий дээр олон жижиг тосгон бий. Тэр тосгонд чуулган байдаг бол, ганц л байгаа байх. Тэгвэл бид хэдхэн доллараар тэр тосгоныг бүхлээр нь өөрчилж чадах нь байна. Маш ашигтай хөрөнгө оруулалт! Энэ үнэхээр боломжтой гэж үү?

Бид энэ санаагаа ээлжит Мессенжерийн удирдлагын хурал дээр танилцуулж, алсын хараагаа хуваалцлаа. Төлөвлөгөөний маань

эрч хүч хурдан авалцаж, гишүүн бүр баяр хөөрөөр цалгив. Би ч: “Арван жил, хорин жил - ер нь хэдэн ч жил болсон бай - бид Бурханы даалгасан энэ баялгийн санг даян дэлхийн удирдагч бүрт хүргэхдээ л хүргэнэ” хэмээн баяртайгаар тунхаглалаа.

Сарын дараа нөгөө Техасын бизнесмэн маань манай албан газар руу яриад, Лиза, бид хоёртой арван таван минут уулзах хүсэлт тавив. Тэрбээр гэргийнхээ хамт Колорагод нисч иржээ. Тэрбээр уулзалтынхаа дундуур уйлж гарах нь тэр. Тэгээд хоолой чичирсээр: “Би та нарын ажлыг ойлгож байна! Та нар алс бөглүү газрын пасторуудыг материалаар бэхжүүлж байна. Би үүний чинь нэг хэсэг баймаар байна” гэж хэлэв. Тэгээд ширээн дээгүүр нэг чек дамжуулж өглөө. Би ч тоог нь үзээд, золтой л уначихсангүй. Тэр нь 750,000 долларын чек байлаа.

Дараагийн хэдэн сарын турш бид цахим хуудсаа нээж, “удирдагчийн багцаа” дэлхий даяар ажил хэрэг болгохоор шамдан зүтгэв. Нэг удаагийн төсөлдөө: тухайн хэл рүү ном, сургалтын материалыг орчуулах, хэвлэх, бичүүлэх өртөг, эдгээрийг болоод бусад нэмэлт материалыг багтаасан DVD-ROM-ыг хувилах өртөг зэрэг нийт зардлын дүнг тооцоолон гаргана. Роб гадаадын шилдэг орчуулагч нарыг хөлслөн, багийг нь удирдав. Эхний жилийн зардлыг буюу сая гаруй долларыг хоёр удаагийн өгөөмөр хандив бүрэн даасан юм.

БАГ БАЙГУУЛАХ САНАА

Яг одоо бүгдээрээ 2011 оны 1-ээр сард 250,000 ном тараах шийдвэрийн дараа өрнөсөн үйл явдал руу эргэе. Нөгөө хоёр их хэмжээний хандив хараахан ирээгүй байсан бөгөөд үүнд нь ч би баярладаг. Учир нь хөрөнгө мөнгөний гачигдал маань биднийг өглөө бүр Бурханыг эрэн хайхад хүргэсэн, өөрчлөгч хүчин зүйл болсон билээ. Бидэнд алсын хараагаа түгээх төлөвлөгөө тэгээд хамгийн гол нь өгөх бэлгээрээ энэ нүсэр үйл ажлыг үргэлжлүүлэн амьдруулаад явах эрчүүд, эмэгтэйчүүдийн том багийг байгуулах төлөвлөгөө хэрэгтэй байлаа. Ингэж чадбал, бид газар газрын, хэл хэлний, санхүүгийн боломжтой, боломжгүй пастор, удирдагч нарыг ном, материалаар хангасаар байна.

Хэдэн сар залбирсны дараа Ариун Сүнс зүрхэнд маань: “Хүү минь, чи гольфд хайртайгаараа алдартай. Гольфоороо хүмүүсийг цуглуулаач. Би багт чинь зөв эрчүүд, эмэгтэйчүүдийг татан

нэгдүүлж, даалгаврыг чинь дэмжинэ” гэлээ. Тэр үед манай Колорадо Спрингсд дэлхийн хамгийн сайхан зочид буудлын нэг байдгийг санав. Мэдээж Бродмүүр зочид буудал маань аваргын тэмцээн зохион байгуулдаг хоёрын хоёр талбайтай. Тиймээс би төлөвлөгөөгөө Лиза, Аддисон хоёртой хуваалцлаа.

Тэд сонсож дууссанаа: “Тэгээд хэзээ хийх вэ?” гэж асуув.

Би ч: “Энэ зун хийе” гэж хариуллаа.

Гэхдээ энэ үйл ажиллагаанд бэлтгэх хангалттай цаг байхгүйд зовж байв. Тухайлбал, дэлхийн хамгийн өндөр настай, таван алмазтай зочид буудалд хангалттай өрөө гарах болов уу? Ер нь бол, тэд жилийн өмнөөс л захиалгаа авдаг. Бид ядаж яг оргил үе дээр нь таарчихдаг. Бас нэгэн асуудал нь: зочид маань хэдийн зуныхаа төлөвлөгөөг гаргачихсан байвал, яах уу?

Хүү маань хэд хоног судалгаа хийгээд, тайлагналаа: “Аав, зочид буудал зунжин битүү захиалгатай байна. Гэхдээ ганц долоо хоног л сул байна. Дунджаар зуун өрөө захиалах боломжтой. Дээрээс нь тэр долоо хоногт ээж, та хоёр яг гэртээ байж таарах нь.”

Би ч шууд л: “Захиал!” гэлээ.

Гэтэл хүү маань: “Тэгвэл би гэрээ хийе. Гэхдээ бид бүх өрөөг дүүргэж чадах уу?” хэмээн тулган асуув.

Би ч дахиад л: “Чадна!” гээд л аваад хаялаа. Би энэ талаар нэг их бодол болохыг хүссэнгүй. Энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэхгүй байх шалтаг хаймааргүй байв.

Би үйл ажлыг маань дэмжих чуулган, бизнесийн хүмүүс Америкт зөндөө бийг мэдэж байлаа. Тэгээд санаанд орсон хүн бүртэй ярьтал, бүгдээрээ шахуу оролцох хүсэлтэй байв. Тиймээс хэдхэн сарын дотор өрөөнүүд маань бүгд эзэдтэй болсон байлаа.

Манай баг зүгээр нэг гольфийн тэмцээн зохиолгүй, харин дурсамж дүүрэн, бүрэн хэмжээний хөтөлбөр төлөвлөсөн юм. Гольф тоглодоггүй хүмүүсийг ч уйдаахааргүй, зорилготой бас дээд зэргийн үйл явдал болгохыг хүсэв. Лиза эмэгтэйчүүдтэйгээ тусгай уулзалт зохионо. Зочдыг ирэхэд нь бид хос бүрт амттаны дээжээр бүрдүүлсэн, гоёмсог сагс барина. Үүнээс гадна зөвхөн Бродмүүрийн урладаг тансаг зоог, хосгүй үйл ажиллагаа, удирдлагын хичээл, оролцогч нарт зориулсан үнэтэй бэлэг - энэ бүхэн нь манай багт нэгдэж байгаад талархаж буйгаа илэрхийлэх сэтгэл минь байв.

Ийнхүү бид анхны Мессенжер цомоо 2011 оны 6-аар сард зохион явуулав. Үйл ажиллагаанаасаа өмнө бид мэргэжлийн тамирчид,

алдартай хөгжимчидтэй холбогдон, тэднээс гарын үсэг бүхий эд зүйлсээ хандивлахыг хүссэн юм. Мөн үйл ажиллагаанд маань үнэтэй эд зүйлс юмуу тусламж дэмжлэг үзүүлэх бизнесийн байгууллагатай ч холбогдов. Тэгээд хандивын эд зүйлсээ банкетынхаа үеэр дуудлага худалдаагаар зарсан юм. Анхныхаа цомын тэмцээнээр 340,000 орчим доллар босгосон боловч, нэг л дутуу санагдаад байлаа. Бид алсын хараагаа хуваалцах оновчтой стратегиэ олоогүй л байв.

Тэр намар багийн маань нэг гишүүн өөр нэгэн шинэ санаа олов. Биднийг 2012 оны зуны ээлжит тэмцээнээ төлөвлөж байтал, тэрбээр: “Бид дуудлага худалдаагаар гарын үсэгтэй бэйсбоол, хөл бөмбөгийн дуулга, гитар гэх мэт юмсыг зарсан ч, нэг эд зүйл нэг улсын ч зардлыг дааж чадахгүй. Тиймээс эд бараа биш, харин улсыг “зарбал” яаж байна. Улс үндэстний үнэ цэнэ ч хавьгүй өндөр” гэлээ.

Бидэнд энэ санаа маш таалагдсан ч, санаа маань цаашаа бүр ч төгөлдөршив! Тэрбээр цааш нь: “Үйл ажиллагаанд маш өндөр төвшний өрсөлдөгч нар ирнэ. Тиймээс хяналтын самбар гаргаад, тэдний аль нэг улс үндэстнийг ивээн тэтгэхээр амласан тоог нь бичнэ. Тэгээд аль нэг улсыг хамгийн өндөр ивээн тэтгэсэн хүмүүст бөмбөг, гитар зэрэг үнэт эд зүйлсээ бэлэглэнэ” гэв.

Бүтээлч санаа хөвөрсөөр л байлаа. Тэгтэл гэнэт надад эсэргүүцлээ илэрхийлмээр санагдав: “Би дуудлага худалдааг эцэсгүй сунжрамааргүй байна. Хэдхэн минут чимээгүй байх чинь хэзээ ч дуусашгүй мэт хэцүүтэй. Тиймээс цаг хэрэглээд, цаг дээрээ богинохон хугацаа тогтооё. Тухайлбал гучин таван минут. Тэгээд цаг дуусах юм бол, дуудлага худалдаа ч дуусна гэдгийг анхааруулья. Төсөл нь санхүүжээгүй үндэстэн - хоосон хоцорно. Ингэбэл, хүмүүс яарцгаана.”

Тэгэхээр, төсөл гэж чухам юу яриад байгааг тодорхойлъё. Үүнд - нэгдүгээрт удирдагчийн багцад багтах цаасан, аудио, видео материалыг орчуулах зардал багтана. Нэг улсын зардал дунджаар 17,500 доллар болдог. Хоёрдугаарт - улс үндэстэн бүрт номыг юмуу удирдагчийн багцыг хэвлэж, тараах зардал багтана. Улс бүр дунджаар 500-40,000 удирдагчтай. Нэг улс дунджаар 5,000-10,000 удирдагчтай гэж тооцбол, зардал нь дунджаар 20,000-40,000 доллар болно.

Дараа дараагийн уулзалт дээр манайхан хоёр дахь удаагийн үйл ажиллагааг маань улам баяжуулж, алсын харааг маань дэлгэрүүлэх бүр ч олон санаа дэвшүүлэв.

Хоёр дахь удаагийн дуудлага худалдаагаар бид өнгөрсөн жилийнхээсээ хоёр дахин их санхүүжилт босгосон юм. Цаг

дуусахаас өмнө тавь гаруй төсөл маань уралдан, бүрэн санхүүжсэн байлаа. Эрч чангарсаар, гурав дахь Мессенжер цомоороо бид 1,3 сая доллар босгож, илүү олон төсөл санхүүжүүлж чадсан юм.

Жил ирэх тутам, материалын эрэлт хэрэгцээ ч нэмэгдсээр байлаа. Илүү олон үндэстэн Роб руу төлөөлөгчөө илгээж, хүмүүстээ материал хүсэв. Эцэстээ төслийн маань тоо 100 давж, зургаа дахь удаагийн Мессенжер цом дээр бид 140 төслийг санхүүжүүлэх 2 сая доллар босгосон билээ. 9 дэхь жилдээ бид 200 дөхсөн төслийг санхүүжүүлэх бараг 3 сая доллар босгов!

2020 оны сүүлээр энэ ном шинээр гарах үед Мессенжер цомын баг 100 гаруй үндэстний 120 гаруй хэл дээр 30 гаруй сая материал тараасан байх нь.

Энэ хугацаанд манай баг бүхлээрээ миний баатар болсон Андро Карнеги гэдэг хүнээс үлгэр дуурайл авсаар ирсэн юм. Тэрбээр түүхэн дэхь хамгийн алдартай филантропистуудын нэг байсан бөгөөд хамаг эд хөрөнгөө бусдад өгч амьдарсан билээ. Карнеги сайн үйлсэд өнөөдрийн ханшаар хэдэн тэрбум доллар өгсөн байна! Тэр мөнгөний ихэнхийр нь нийтийн номын сан байгуулсан юм. Үнэндээ 1883-1918 оны хооронд тэрбээр Америкийн дөчин долоон муж даяар 2,500 номын сан байгуулжээ.

Тэгэхээр, би танд нэгэн сонирхолтой асуулт тавья: Америк улс хэдээс хэдэн оны хооронд хамгийн их хүчирхэгжсэн бэ? 1883-1925 онд! Өөрөөр хэлбэл Карнегийн номын сан байгуулсан үед! Мэдлэгийг олон нийтийн болгох Карнегийн үйлс Америкийг дэлхийн тэргүүлэх улс болгоход хувь нэмрээ оруулсан гэдэгт би итгэдэг.

Тэгвэл энэ зарчим сүнсний мэдлэгт ч хамаатай. Бурхан:

“Ард түмэн минь *мэдлэг дутсанаас* болж устгагдсан”
(Хосеа 4:6) гэсэн.

Мөн

“Ард түмэнд минь *мэдлэг дутсанаас* болж тэд цөлөгдөн”
(Исаиа 5:13) гэсэн.

Чуулганы байшин барих нь аймаг, хотоо өөрчлөх хамгийн үр нөлөөтэй арга биш болох нь эдүгээ үйлчлэлд тодорхой болжээ. Энэ арга нутгийн удирдагч нарыг биднээс хамааралтай хэвээр

байлгасаар байна. Үүний оронд нутгийн удирдагч нарт тосгон, хот, нийслэлдээ нөлөөлөх чадалтай болгох сүнсний мэдлэг суулгабал, ажил маань хавьгүй нөлөөтэй болно. Ийм мэдлэг л удирдагчийг өсөхөд нь болоод зайлшгүй тохиолдолд байшин барилга, нөөц бололцоо зэрэг бусад ажлаа хариуцаж авч явахад нь шаардлагатай итгэлийг нь байгуулахад туслана.

Нөөц бололцоог ашиглах стратегийн санаачилгын хувьд - чуулганы байшин нь биднээс хэдэн арван мянган доллар шаардах бол, хэдхэн зуун долларын материал бүхий удирдагчийн багц нь тэр их мөнгөний өчүүхэн хувь болдог нь бас нэг гайхамшигтай зүйл!

Хөгжиж буй чуулганы удирдагч нарт номоо бэлэглэсэн арван жил маань миний дөчин жилийн үйлчлэлийн хамгийн утга учиртай цаг хугацаа байсан нь тодорхой. Үндэстэн болгонд дагалдагч нарыг төрүүлэх алсын хараа, чин хүслээр жигүүрлэсэн эрчүүд, эмэгтэйчүүдийн багийн нэгээхэн хэсэг байх шиг сайхан юм үгүй (Матай 28:19-20). Бид нэгдэн нийлснээрээ ганц ганцаараа хийж чадах байснаасаа хавьгүй ихийг гүйцэлдүүлсэн. Энэ хүчин зүтгэл үнэхээр “таван хүн чинь зууг элдэн хөөх ба зуун хүн чинь арван мянгыг элдэн хөөнө” (Леви 26:8) гэдэг үгийг үлгэрлэсэн юм (Энэ нь үржлийн өөр нэгэн түлхүүр орц болох эв нэгдлийг дүрслэн харуулсан үг бөгөөд энэ талаар хожим ярина).

Бидний энэ бүх уйлаан Есүсийн сургаалт үлгэр дээр л суурилдаг:

Тэр Өөрийг нь урьсан хүнд —Үдийн эсвэл оройн зоог барихдаа анд нөхөд эсвэл ах дүү, садан төрөл, баян хөршүүдээ бүү урь. Тэд хариуд нь чамайг урьж, шан хариу барина. Харин цайллага хийхдээ ядуу эсвэл тахир дутуу, хазгар доголон, сохор хүмүүсийг урь. Тэд *чамд хариу барьж чадахгүй* тул чи ерөөгдөх болно. Зөвт хүмүүсийн амилалд чамд хариу төлөгдөх болно гэв. (Лук 14:12-14)

Бидний хөрөнгө оруулсан удирдагч нар тахир татуу, өвчтэй, сохор хүмүүс биш боловч, тэд *эргүүлэн төлж чадахгүйгээрээ* дээрх сургаалт үлгэрийн хүмүүстэй адил юм. Хэрэв би Америкийн чуулган, конференцэд үйлчилбэл, тэд Мессенжер Интернэйшнэлд мөнгөн өргөл юмуу бэлэг өгч, “талархлаа илэрхийлдэг”. Гэтэл бидний хөрөнгө оруулсан улс орны удирдагч нар ингэж чадахгүй. Хариу нэхэлгүй туслах ер бусын завшаан бидэнд байгааг манай багийн бизнесмэнүүд,

чуулганы удирдагч нар, Мессенжерийн багийнхан - бүгд мэднэ.

Хэдэн жилийн өмнө Лиза, бид хоёр Арменийн Ереван хотод зохион байгуулагдсан, Ойрх Дорнодоос хүрэлцэн ирсэн хэдэн мянган удирдагчийн конференцэд оролцсон юм. Бид тэнд байхдаа Иран, Афганистан, Сири зэрэг улсаас ирсэн пасторуудыг тусад нь цуглуулж уулзсан юм. Тэнд зураг авахыг хориглож, хүмүүсийн нэр усыг нь ч нууцлав. Бурханы оршихуй хүчтэй давалгаалж, би дотроо “Лиза, бид хоёр эдэнд биш, эд бидэнд заах ёстой” гэж бодож байлаа. Тэгээд: “Та нар Лиза, бид хоёрыг баатраа гэж харж байна. Гэвч үгүй юм. Лиза, Жон хоёр биш, харин та нарыг материалаар ерөөх гэж сая, сая доллар өгсөн бизнес эрхлэгч нар, чуулганууд л жинхэнэ баатрууд шүү” гэж хэлж билээ. Тэр үед бид бүгдээрээ асгартал уйлцгааж билээ.

Уулзалтын дараа Ираны нэг пастор: “Тэд хэзээ ч уулзаж үзээгүй хүмүүстээ яаж тийм их мөнгө өгдөг байна аа?” гэж асуусан юм.

Би үүнд нь маш энгийнээр үнэнээ л хэлж билээ: “Зүрхэнд нь Бурханы хайр байгаа учраас л тэр.” Тэгээд дахиад л уйлцгаав.

БҮР Ч ТОМ ҮРЖИЛ

2019 онд бид материал дэлгэрүүлэх цахим хуудас маань хязгаарлагдмал байгааг ухаарав. 2011 онд биднийг эхэлж байхад хэрэглээнд нийцэж байсан бол, өнөөдөр хэрэглэхэд хязгаарлагдмал, болхи болжээ. Жишээ нь, манай хуудсыг ухаалаг утсаар олоход хэцүү. Лиза, бид хоёр бас манай багийнхан ядуу зүдүү олон улс руу аялж байсан. Тэгээд хүмүүс майхан, шавар байшин, дан модон байшинд амьдардаг хэдий ч, их бага хэмжээний ухаалаг утастай байдгийг анзаарсан юм. Үнэндээ 2020 он гэхэд дэлхий дээр таван тэрбум хүн ухаалаг утастай байхыг тооцоолсон байдаг.

Тийнхүү олон удаа аялсны эцэст тун удахгүй дэлхийн хаана ч байгаа хүнтэй онлайнаар харилцах боломжтой болно гэдгийг тодорхой ойлгов. Би ч, бусад маань ч түүхт “Ромын замыг” дахин нэг мэдрэх шиг.

Үүнийг товч тайлбарлая: Бичээс: “Харин цаг нь болоход эмэгтэй хүнээс хуулийн дор төрөх Хүүг Бурхан илгээсэн юм” (Галат 4:4) гэдэг. “Цаг нь” гэдэгт олон зүйл багтана. “Зөв цагийн” нэгэн чухал бүтэц нь Сайн мэдээ хүн төрөлхтөнд танигдсан ертөнцөд бүрэн хүрэх явдал юм. МЭӨ 312 онд Ромчууд зам харилцааг хөгжүүлэн,

танигдсан ертөнцийг замаар холбож эхэлжээ. Есүсийг “бүх дэлхийд хүр” гэж хэлэх үед мөнөөх замууд хэдийнээ хөгжөөд байв. Энэ нь танигдсан ертөнцөд Бурханы Үгийг хурдан түгээх арга зам болжээ.

Есүсийн хоёр дахь удаагийн айлчлалыг тосон засагдах, манай цагийн Ромын зам нь интернэт гэдэгт би итгэдэг. Бид бүх үндэстэнд дагалдагч нарыг бий болгох зорилгоор даян дэлхийд Бурханы Үгийг түгээх чадалтай болсон.

Үүнийг ухаарсан багийнхан маань залбирч, мөрөөдөж, стратеги зохиож эхлэв. Хэдэн сарын судалгааны дараа бид Америкийн хамгийн шилдэг апп, веб боловсруулдаг компанитай хамтарч ажиллахаар тогтсон юм. Бид маш хүчтэй, олон үйлдэлтэй, Айфон, Андроид, таблет, компьютерийн алин дээр ч хэрэглэж болох дагалдагчийн санг байгуулав. Бид өнөөгийн технологийн хүчин чадлыг тулгал ашигласан, хамгийн том сан байгуулахаар шийдсэн. Бид даян дэлхийн удирдагч бүрт - нэн ялангуяа бэрхшээлтэй улсын удирдагч бүрт хамгийн сайныг түгээхийг хүснэ. Хамгийн биширмээр нь өнөөдөр 227 улсын сая, сая хэрэглэгч манай сангаас ном, хичээл, дагалдагч бэлтгэх материал авч хэрэглэж байгааг бид тогтоосон. Цаана нь хүрч амжаагүй хэдхэн л улс байна!

Цаг хугацаа өнгөрөх тусам, бид үржиж болох өөр арга замыг сэтгэсээр байна. Сангийнхаа үр нөлөөг өргөжүүлж, бэхжүүлэхийн тулд бид бас өөрчлөгч хүчтэй, хосгүй үгийг дамжуулдаг багш нарыг сандаа урьж оруулмаар байна. Эдүгээ даян дэлхийн удирдагч нар компьютер, таблет, утсаа хэрэглэн, жижиг бүлгээрээ эсвэл бүр чуулганаараа нүүр нүүрээ харж байгаад уулзаж чаддаг болсон. Энэ нь сангийн маань үр нөлөөг үржүүлээд зогсохгүй, хэвлэмэл номоос ч урт настай байж, олон үе амьдарна.

Лиза, бид хоёр ном бичээгүй байсан бол, яах уу? Эсвэл бид хоёр бестселлер зохиолчид болсондоо ханаад, сургалтын материал боловсруулаагүй бол, яах уу? Баг маань англи хэлтэй хүмүүс, чуулганд л хүрч байгаадаа ханачихсан бол, яах уу? Баг маань Бродмүүр зочид буудалд Америкийн өнцөг булан бүрээс хүмүүсийг нэгэн баг болгон нэгтгэхээр шулуудаагүй бол, яах уу? Төвшин бүр биднийг тэлж, Бурханы нигүүлсэлд найдахаас өөр аргагүйд хүргэсэн, өөрийн гэсэн бэрхшээл дагуулж ирж байсан. Төвшин бүр дээр бусдын төлөө илүү үр нөлөөтэй ажиллах гэж тэмцэхийн оронд, биеэ сул тавиад, урсгалаараа хөвөх нь хавьгүй амар.

Бид Бурханы Сүнсийг сонсохдоо, илүү том үржлийн төлөө алхам, алхмаар нүүдэг. Бурхан эхнээс нь бүх алхмыг харуулах юмуу эсвэл бүр хоёр алхмыг ч урьдчилж харуулахгүй. Би гуч гарч явахдаа л гучин жилийн дараахыг ид шидээр харчихсан бол үгүй мөн сайхан аа. Гэхдээ тэгдэг бол, бид алхам бүрээ тэгтэл

залбирч байж, Бурханы заавраар хичээнгүйлэн хийхгүй. Түүнчлэн дуулгавартай алхам бүрийг дагалдаж ирдэг итгэл, зан чанарын бэхжилт ч шаардлагагүй болно.

Үржүүлэх нь хүний бус, Бурханы санаа. Бурхан Өөрөө хүн төрөлхтөнд хамгийн анх “Та нарт даалгасан бэлэг бүр Хаанчлалыг маань үржүүлэх зорилгын төлөө өгөгдсөн юм шүү” (Эхлэл 1:22, Матай 25:14-29-ийг зохиолч өөрийнхөөрөө утгачлан буулгав) гэж тушаасан. Энэ чухал санаагаа би дахин тэмдэглэе: “Та эрийнхээ сайнд үржүүлдэг юм биш. Учир нь эцсийн эцэст үржил нь Бурханы л бэлэг. Та зүгээр залбирч, сонсож, итгэж, зүрхэнд чинь өгсөн зүйлийг дагахад л болно.”


Дүгнэж хэлэхэд: Бурхан Өөрөө үржил рүү дагуулна.

Та “Сүүлийн гурван бүлэгт бичсэн гэрчлэл чинь зүрхийг маань донслуулж байна. Гэхдээ над шиг залуу ээж, оюутан, мэргэжлийн тамирчин, ажилтан яаж Бурханы хаанчлалыг үржүүлэх болж байна?” гэж бодож байгаа байх.

Тэгвэл, энэ талаар дараагийнхаа бүлгээр ярилцъя.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ:

1. Бидний хүсэн хайсан Бурханы хангамж, оролцоо нь стратегийн санаагаар ирэх нь олонтаа. Бурханаас төрсөн санаагаар дамжин нөхцөл байдал чинь хэрхэн өөрчлөгдөж байхыг та харсан уу?
2. Цэц ухааныг хүлээн авах нь таны хийж чадах хамгийн чухал зүйл. Таны амьдралын ямар хэсэг дээр цэц ухаан хэрэгтэй байна? Та цэц ухааныг Бурханаас хэрхэн хүлээн авах гэж байна?
3. Стратегийн санаа нь тэс өөр төвшний үр нөлөөний талбарыг нээх хүчин чадалтай Бурханы бэлэг бөгөөд бидэнд үржих чадал өгдөг. Нэгэнт санаа төрсөн бол, танаас шаардагдах дараагийн алхам нь юу вэ?



*Бидэнд өгөгдсөн нигүүлслээр бэлгүүд маань ялгаатай.
Эш үзүүлэг нь итгэлийнхээ хэрээр үйлчлэл нь үйлчлэлээр,
сургагч нь сургаалаар, ятгагч нь ятгалгаар, өгөгч нь
өгөөмрөөр, удирдагч нь хичээнгүй зүтгэлээр,
өршөөгч нь баяртайгаар үйлд.*

— Ром 12:6-8

Хөрөнгө оруулах

Элч Паул Бурханы зарц бүртээ өгсөн янз бүрийг бэлгийг цохон тэмдэглэжээ. Миний хувьд, Паулын бичвэрийг бүрэн гүйцэт жагсаалт гэхээсээ илүү тэнгэрийн чадварыг нилээд далайцтай тоймлосон жагсаалт гэж итгэдгээ дахин хэлье. Та санал нийлэхгүй байж болох ч, тайлбарыг минь болгооно уу.

Би элч Паулын жагсаалт дунд дуулах, шүүх хурал дээр хэрэг өмгөөлөх, хорт хавдрыг хагалж авах, уран зураг зурах, хөгжим тоглох зэрэг өдөр тутмын амьдрал дээр байдаг, Бурханаас өгөгддөг чадварыг харахгүй байна. Тиймээс л дээрх нь бүрэн гүйцэт жагсаалт бичиг гэдэгт итгэдэггүй юм. Та одоо ч надтай санал нийлэхгүй байгаа бол, зүгээр ээ, би таны байр суурийг хүндэтгэнэ. Гэхдээ энэ бидний ярих гол сэдэв биш учраас, цааш нуршилгүй, үүгээр төгсгөе.

Бүгдээрээ Паулын үг рүүгээ эргэж орёе. Нью Ливинг Транслэйшн дээр карисмаг “аливаа зүйлийг сайн хийх” чадвар хэмээн тодорхойлсон байдагт би дуртай. Энэ тодорхойлолт номын маань үндсэн фокусыг тодруулж байна. Бид сүүлийн гурван бүлгээрээ *эш үзүүлэх ба заахын* үржлийг гэрчилсэн бол, одоо анхаарлаа өөр бэлэг рүү буюу *өгөх* бэлэг рүү хандуулъя.

ХААНЧЛАЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ

Манай нэг найзыг Майк гэдэг. Тэрбээр 11 настайдаа Есүс Христэд итгэсэн боловч, хаанчлалын ажилд үр дүнгүй шахуу байжээ. Тэгээд мөнхийн нөлөөгүй энэ байдалдаа гутарч явсаар гучин тав

хүрмэгцээ, үүнийгээ цэглэхээр хатуу шийджээ. Ийм байдалд хүрсэн хүмүүс голдуу мэдлэг, цэц ухаан, итгэлгүй, муйхар аргаар өөрчлөлт хийх гэж оролддог. Гэтэл Майк өөрөөр хандсан нь туйлын ухаалаг явдал болов. Тэрбээр мөнхийн нөлөөлөл авчрах эхний алхам нь “саваа дүүргэх” явдал гэж шийдээд, зургаан сарын турш Бичээсээ хоёр мянган эшлэл цээжилжээ.

Харин зургаан сарын дараа Аризона мужийн Финикст болох удирдлагын конференцэд суралцахаар шийдэв. Майк зочид буудлын өрөө ч хөлслөх мөнгөгүй, ядуу байсан болохоороо, хоёрхон унтлагын өрөөтэй байранд өөр арван нэгэн оюутны хамт оржээ.

Конференцийн үеэр онцгой өргөл авч гэнэ. Удирдагч нь төлөөлөгч нараас өргөх мөнгөн дүнгийнхээ талаар залбирахыг хүсэв. Гэтэл Эзэн Майкт: “Би чамайг 200 доллар өргөөсэй гэж хүсч байна” гэх шиг болжээ.

Майк ч: “Бурхан минь, надад байгаа нь л хоёр зуун доллар шүү дээ!” хэмээн эсэргүүцэв.

Гэтэл Эзэн зөөлнөөр: “Би чамаас хоёр зуугаас илүүг хүсээгүй” гэж.

Майк үгэнд нь ороод, байгаа бүх мөнгөө өргөжээ. Дараа нь Бурхан Майкт жилийн турш арван хувь дээрээ нэмж 100 доллар өргөж байхыг зааж өгсөн байна.

Төдөлгүй Бурхан Майкт *стратегийн санаанууд* өгч, шинэ бизнес нь тууштай өсч эхлэв. Дараа жил нь Майкт хаанчлалыг байгуулахын тулд арван хувь дээрээ нэмж 400 доллар өргөх хэрэгтэй мэт санагджээ.

Жилийн дараа сар бүр арван хувь дээрээ нэмж 1,000 доллар өргөдөг болов. Дараа жил нь сар бүр 4,000 доллар нэмж өргөдөг болов. Дараа жил нь сар бүр арван хувь дээрээ нэмж 10,000 доллар өргөдөг болов.

Энэ үед Майк Эзэнээс хаанчлалын төлөө 10 саяыг өргөх чадварыг гуйжээ. Бараг л биелэх боломжгүй, нүсэр хүсэлт шиг харагдаж байсан ч, Майк итгэл, хүсэлт дээрээ бат зогсов. Гэтэл Майкийн зүрхэнд: “Хүү минь, чи яагаад Намайг хайрцаглана вэ?” гэдэг үг орж ирсэн нь түүнийг цочроонд оруулжээ. Тиймээс Майк хязгаараа авч хаяад, бүр ч ихэд итгэжээ. Төдөлгүй, Майкийн өргөл огцом өссөөр, дараа жил нь гэхэд тэрбээр сар бүр арван хувь дээрээ нэмж 17,000 доллар өргөдөг болжээ. Үүний дараа сар тутам 25,000 доллар, дараа нь 40,000 доллар, дараа нь 50,000 доллар

нэмж өргөдөг болов. Эцэстээ Майк хаанчлалыг байгуулахын тулд сар тутам арван хувь дээрээ нэмж 100,000 доллар өргөдөг болов. Түүнтэй сүүлд ярихад, тэрбээр сар тутам арван хувь дээрээ нэмж 150,000 доллар өргөдөг төвшинд хүрсэн гэж билээ.

Гэхдээ Майк өөрөө орлогынхоо 10-15 хувиар тун хангалуун амьдарна. Тийм ээ, та зөв уншлаа. Тэрбээр жилийнхээ орлогын 85-90 хувийг өргөдөг. Тэрбээр Библид суралцаж, залбирахдаа Бурханыг сонсож, өөрөөс нь өндөр төлөвшсөн хүмүүсийг дагасныхаа ачаар л ийм амжилтанд хүрсэн гэдэгтээ итгэдэг.

Үржлийн тал дээр - өгөх гэдэг үгийг хайхралгүй амьдарч болохгүй. Учир нь энэ бол түлхүүр орц. Гэхдээ нэн ялангуяа санхүүгийн талбар дээр олон сайхан сэтгэлт итгэгч нар өргөлд “*Би бусдын төлөө юугаа золиослоход бэлэн байна?*” гэсэн санаагаар ханддаг. Энэ нь бурханлаг бөгөөд хүндэтгэлтэй хандлага мөн боловч, арай дутуу үзэл бодол юм. Одоо тайлбарлая.

Нэгдүгээрт - тийм ээ, үнэхээр Бурхан бидний зүрхэнд Өөрийнх нь хүмүүсийг хайрлах хайрыг суулгасан. Энэ нь амиа бодолгүй *өгч, үйлчлэх* зүрхний хүслийг бүтээдэг. Өгөх хүсэл нь ийм л сэдэлтэй хүслээс үүдэх ёстой. Тийм боловч, ухаалаг өргөгч нь өргөлөө зүгээр нэг хайр, үйлчлэлийн бэлэг гэж үзэхээс гадна мөн *хөрөнгө оруулалт* гэж үздэг. Хөрөнгө оруулах нь өсөлтийн төлөө эх үүсвэрээ барж идэхээс татгалзах явдал юм. Нэн ялангуяа санхүүгийн тал дээр сан хөмрөгөө арвижуулахын тулд өнөөдрийнхөө зарцуулалтаас татгалзах явдал.

Лиза, бид хоёр хэдэн жилийн өмнө хоёр газар худалдаж авсан юм. Дажгүй хямд атлаа ирээдүйд үнэ цэнэ нь өсмөөр газар. Бидэнд хоёуланг нь худалдаад авчих мөнгө байв. Бид хоёр ирээдүйнхээ төлөө мөнгөө өсгөхийн тулд хадгалж байсан бэлэн мөнгөө зарцуулсан юм. Гэтэл хоёр жилийн дотор газар маань санаснаас ч сайн үнэд хүрч, хөрөнгө оруулалт маань хоёр дахин өсөв. Үүний ачаар бид хоёр жилийн дараа хоёр дахин их бэлэн мөнгөтэй болсон юм. Ийнхүү бид хоёр бүр ч том төвшинд хөрөнгө оруулах чадалтай болсон билээ.

Есүс биднийг хаанчлалд хөрөнгө оруулахдаа “энэ үед *өчнөөн дахинаар* хүлээн авна” (Лук 18:29-30) гэсэн. Есүс “*дараагийн амьдралдаа*” гэж хэлээгүй, харин “*энэ амьдралдаа*” гэсэн. Лиза, бид хоёр газраар дамжуулан мөнгөө хоёр дахин өсгөсөндөө баярлаад барахгүй байсан. Гэтэл Есүс ийм өчүүхэн хэргийн талаар

яриагүй юм. *Хоёр дахин, олон дахины* хооронд том ялгаа бий. *Олон дахин* үржих хөрөнгө оруулалтын хүчин чадал юу вэ? Энэ үнэнийг Майкийн амьдрал гэрчилнэ.

Элч Паул бидний өглөгийг үр тарихтай адилтгасан. Нэг хувин буудайг идэлгүй, хөрсөнд тарих юм бол, нөхцөл байдлаасаа шалтгаалаад дунджаар зуун хувин буудай өгнө. Үүнийг “олон дахин” гэдэг ангилалд багтаахаас өөр яахав. Тиймээс л бидэнд “Харамгүйгээр тараах хүн арвижих. Хэт гамнах хэрнээ ядуу тарчиг болох” (Сургаалт үгс 11:24) гэдэг. Итгэгч нар өсөлт, үржлийн талаар бодох ёсгүй байсан юм бол, Соломон, Есүс, Паул тэргүүтэн юу гэж л энэ үнэнийг цохож ярих билээ.

Майкийн 10-15 хувиараа аж төрдөг байдлыг ихэнх хүмүүс цэвэр хайрын золиос гэж үзэх байх. Энэ үнэн боловч, арай дутуу байна. Майк илүү өргөн тоймоор харжээ. Тэрбээр Библийн хоёр мянган эшлэлээр сэтгэлээ чигжихдээ, Бурханы цэц ухаанаар дүүрсэн учраас, үүнийгээ дан хайрын үйлс гэдэг талаас нь бус мөн хөрөнгө оруулалтын талаас нь ч харжээ.

Лиза, бид хоёр мөнөөх хоёр газрыг харсантай л адил. Майк яг л амжилттай зоогийн газрын бизнес эрхлэгч - гэр бүл шиг ханджээ. Тэд бүх орлогоо идэж уугаад барахын оронд илүү олон байшин худалдаж авах, илүү олон хүн ажилд авах, илүү их хүнс авах гэх мэт бизнесээ цэцэглүүлэхэд шаардлагатай бүхнийг хийжээ. Хэрэв сайн хийж чадах юм бол, тэд эцэстээ тав дахин өссөн хөрөнгө бүхий таван зоогийн газартай болно. Үүнийхээ үр дүнд тэд ганц зоогийн газартай байсан үеийнхээсээ ч олон хүнийг ерөөх чадалтай болно.

Майк үүнийг хөрөнгө оруулалт гэж үзээгүй байсан бол, өгөхийн гүн гүнзгий утга учрыг ойлготлоо өгсөхгүй байсан юм. Талантын сургаалт үлгэр ч энэ тухай л өгүүлнэ. Есүсийн: “Таван талант авсан нь тэр даруй явж, түүгээрээ худалдаа хийгээд (хөрөнгө оруулаад) тавыг нэмж олов” (Матай 25:16) гэдэг үгийг л хараарай. Есүс зарцын үржүүлсэн аргыг зориуд хөрөнгө оруулах гэдэг үгээр дүрсэлжээ.

ҮРЖЛИЙН ТУХАЙ ӨӨР НЭГЭН СУРГААЛТ ҮЛГЭР

Тэд энэ бүхнийг сонсох зуурт Тэрээр үргэлжлүүлэн нэгэн сургаалт зүйрлэл айлдав. Ингэсэн нь Тэрээр Иерусалимаас холгүй байсан болон Бурханы хаанчлал тэр даруй бий болох юм хэмээн нөгөөдүүл нь бодсон тул ажээ. (Лук 19:11)

Есүсийн энэхүү сургаалт үлгэрээ гаргаж ирж ярьж байгаа маягт нь би их дуртай. Хүмүүс Есүсийг хаанчлалаа тогтоогоод, ард түмнээ Ромын захиргаа, дарлалаас чөлөөлнө гэж харж байсан. Гэтэл Есүс Өөрийг нь явсны дараа биднээр дамжуулж хаанчлалаа байгуулах хүслээ илэрхийлсэн нь хүмүүсийн үзэл бодлыг зүгшрүүлж, сэтгэлгээг нь тохируулах нүдээ олсон арга болжээ. Гэвч үүнийг хэрхэн хийх вэ? *Хөрөнгө оруулалтаар*. Одоо түүхээ сонсоно уу:

Тэрээр —Нэгэн сурвалжит хүн хаанчлалыг хүлээн аваад буцаж ирэхээр алс холын орныг зорьжээ. Тэр арван боолоо дуудаж, тэдэнд арван маанэ өгөөд “Намайг буцаж иртэл эдгээрийг эргэлдүүл” гэжээ. (Лук 19:12-13)

Матайн түүхэнд гардаг шиг язгууртан бидэнд “хөрөнгө оруулах” заавар өгчээ. Бид дааж авсан зүйл дээрээ залхуу хойрог бус, харин *ухаалаг* бөгөөд *шамдан* ажиллах ёстой.

Энэ хоёр сургаалт үлгэр адилхан мэт харагдаж байгаа ч, үнэндээ ялгаатай юм. Тэднийг юу ялгаж байгааг харцгаая. Нэгдүгээрт - Матай гурван зарцын талаар ярьсан бол, Лук арван зарцын талаар өгүүлсэн. Хоёрдугаарт - Матайн түүх дээр зарц бүрт өөр, өөр дүн өгөгдсөн бол, энд яг тэнцүү буюу нэг, нэг маанэ өгчээ. Гуравдугаарт - Матайн түүх дээр нэг, нэг маанэ биш, харин 34 орчим кг ууттай мөнгөний тухай ярьсан. Энэ хоёр түүхийг харьцуулбал, Матайн түүх нь харилцан адилгүй өгөгддөг бэлгийн талаар өгүүлсэн бол, Лукийн түүх нь итгэл, Бурханы хайр, Бурханы Үг, ерөөлийн гэрээ гэх мэт Бурханаас итгэгч бүрт эн тэгш хайрладаг үндсэн юмсын талаар өгүүлдэг гэж би итгэдэг. За, цаашаа явъя:

Мөнөөх хүн хаанчлалаа хүлээн авсны дараа буцаж ирэв. Тэгээд мөнгө өгсөн боолууд нь хэр эргүүлснийг мэдэхээр тэднийг дуудуулж гэнэ. Эхнийх нь ирж “Эзэн, таны нэг маанэ (маанэг *эргэлдүүлээд*) *арван маанэ* болсон” гэхэд тэр түүнд “Сайн байна, сайн зарц минь. Чи маш бага юманд *итгэмжтэй* байсан тул *арван хот* захирах эрх мэдэлтэй боллоо” гэжээ. (Лук 19:15-17)

Энд тэмдэглэх хэрэгтэй хэд хэдэн санаа байна. Нэгдүгээрт - зарц нь хүлээж авсан зүйлээрээ л хөрөнгө оруулсан. Хоёрдугаарт -

тэрбээр ухаалаг бөгөөд хичээнгүй ажилласныхаа хүчээр арав дахин үржүүлсэн. Ухаалаг ажиллах гэдэг нь Бурханы цэц ухаантай гар нийлэхийг хэлэх бөгөөд үүнийг гагцхүү манай Майк шиг Бурханы зөвлөгөөг сонссоноор л хийж чадна. Гуравдугаарт - итгэмжтэй байдлыг мөн л гагцхүү үржлээр дүгнэж байна. Өөр ямар ч үйлдэл, чанарыг дурьдаагүй. Учир нь Бурханы нүдэнд итгэмжтэй байна гэдэг нь үржүүлэх юм. Эцэст нь зарц үржүүлсэн хэмжээгээрээ л мөнхийн шагналаа хүлээн авсан. Эхний энэ зарц арван хотыг засаглахаар болжээ.

Тэгвэл хоёр дахь зарцыг харцгаая:

Хоёр дахь нь ирж, “Эзэн, таны нэг маанэ таван маанэ болсон” гэхэд тэр түүнд мөн “Чи таван хот захирах эрхтэй” гэлээ. (Лук 19:18-19)

Энэ зарц арав дахин бус, харин тав дахин үржүүлжээ. Тэгээд хөрөнгө оруулсан хэмжээгээрээ буюу арван хотыг бус, таван хотыг захирах мөнхийн шагнал авсан. Тэр яагаад эхний зарц шиг арав дахин үржүүлсэнгүй вэ? Бурханы цэц ухааныг сайн сонссонгүй юу? Боломжийг алдсан уу? Нэгдүгээр бүлэгт гарсан Станы төлөвлөж байсан шиг амьдарлынхаа сүүл хагасыг зүгээр сайхан налайж өнгөрөөсөн үү? Тэтгэврийн хөгшин гэдэг сэтгэхүйтэй байсан уу?

Хэдэн жилийн өмнө би удирдлагын конференц дээр номлов. Номлолын дараа надтай хаанчлалд сая, саяар нь өргөдөг, Калифорнийн үл хөдлөх хөрөнгийн арилжаа, хөгжлөөр дагнасан том бизнесмэн уулзав. Тэрбээр нэг талаараа цочирдсон, нөгөө талаараа гэгээрсэн янзтай байлаа. Тэгээд: “Жон, би амжилтдаа автаад, амралтын сэтгэлгээ суужээ. Өөрөө ч мэдэлгүй ийм болчихож. Гэхдээ би алдаагаа олж харлаа. Цаашдаа би Бурханы надад даалгасан зүйл дээр улам л төвлөрч, улам л хичээнгүй үржүүлнэ” гэж хэлсэн юм. Үнэн гэмшил нь түүнийг тав дахин үржүүлэгчээс арав дахин үржүүлэгч болгох зам дээр гаргаж чадах.

Тэгвэл гурав дахь зарц хэрхэв?

Өөр нэг нь ирж, “Эзэн, үзэгтүн, би таны нэг маанээг алчууртаа боогоод хав дарчихсан. Та тавиагүй хэрнээ авдаг, тариалаагүй хэрнээ хураадаг чанга хүн тул би танаас айсан юм” гэсэнд тэр “Өөдгүй боол чамайг үгээр чинь Би шүүнэ дээ. Чи намайг

тавиагүй хэрнээ авдаг, тариалаагүй хэрнээ хураадаг чанга хүн гэдгийг мэддэг байх нь уу? Тэгвэл чи мөнгийг минь юунд мөнгө хүүлэгчид өгсөнгүй вэ? Тэгсэн бол би буцаж ирээд, хүүтэй нь авах байсан юм” гээд... (Лук 19:20-23)

Матайн түүх дээр гарсан шиг энэ зарц ч бас хоёр том алдаа гаргажээ. Нэгдүгээрт - тэр айсан. Хоёрдугаарт - эзнийхээ зан чанарыг мэдэхгүй байсан. Бурханы бидэнд өгснийг тэг чигээр нь хав дарах нь *итгэмжтэй байдал* бус, харин *муу ёрын байдал* гэдгийг энэ түүх дахин давтаж байна. Хаан нь *архирсныг* тэмдэглэнэ үү! Захирагч залхуу хандлагад хилэгнэж байгаагаа нуугаагүй! Эндээс нэгийг бодоорой доо.

Дараа дараагийн үйл явдал нь Матайн түүхээс хийсэн дүгнэлтийг л бататгаж байна:

“...дэргэдээ байгсдад “Түүнээс нэг маанээг авч, арван маанэтай хүнд өгсүгэй” гэв. Тэд “Эзэн, түүнд арван маанэ байгаа шүү дээ” гэхэд “Би та нарт хэлье. Хэнд байна, түүнд илүү ихээр өгөгдөнө. Харин хэнд байхгүй байна, түүнд байгаа нь хүртэл түүнээс хураагдана. (Лук 19:24-26)

Дахиад л Бурхан социалист Бүтээгч бус, харин “капиталист” маягийн сэтгэлгээтэй болох нь харагдаж байна. Хөндлөнгийн хүмүүс эхний зарц хэдийнээ арван маанэтэй шүү дээ хэмээн эсэргүүцлээ илэрхийлэхэд, эзэн нь: “Хэн зөв хөрөнгө оруулна, түүнд илүү ихээр өгөгдөнө, хэн *хадгална*, түүнээс байгаа нь хүртэл хураагдана” гэдэг мэдэгдлээрээ тэдний нэхээд байгаа “шударга ёсыг” нь нам даржээ.

Бид Майк шиг Бурханд, Түүний Үгд хангалттай их цаг зориулахгүй л юм бол, даруй амьдралын аахар шаахар юмсаар Бурханыхаа зан чанарыг шүүн тунгаадаг болно. Эдгээр нь нийгмийн шүүлтүүр, Холливүүдийн шүүлтүүр, Инстаграммын шүүлтүүр, хэвлэл мэдээний шүүлтүүр, хатуу харгис аавын шүүлтүүр, шашны шүүлтүүр гэх мэт бидний дуртай, дургүй амьдралын аливаа үйл явдал юмуу нийгмийн сэтгэлгээ байж болох. Бурханыг, Түүний Үгийг мэддэг хүн эдгээр доголдолтой шүүлтүүрийг шууд танина.

БҮГД ӨГӨХӨӨР ДУУДАГДСАН

Майк *өгөх бэлгээ* онцсайн хэрэглэсэн. Гэхдээ бид бүгдээрээ *өгдөг* байх ёстой.

Үүнийг тодруулах үүднээс Есүсийн “Бүх ертөнцөөр явж, сайнмэдээг хамаг бүтээлд тунхаглагтун” (Марк 16:15-16) гэдэг захирамжтай харьцуулъя. Энэ үүрэг хүн бүрт хамаатай. Бид бүгдээрээ элчин сайд болж, төөрөгсдөд Сайн мэдээг түгээх ёстой. Үүнийг Паул ч бүх итгэгч нарт хэлсэн: “Харин чи бүгдэд саруул ухаантай бай, хэцүүг тэвч, сайнмэдээг дэлгэрүүлэгчийн ажлыг хий, үйлчлэлээ гүйцэтгэ” (2Тимот 4:5).

Гэхдээ байна шүү - *сайн мэдээ дэлгэрүүлэгч* гэдэг нэртэй, тусгайлсан бэлэгтэй, онцгой албан тушаал бас бий. Паул: “Тэр... заримыг нь сайнмэдээ тунхаглагч...болгосон” (Ефес 4:11) гэсэн. Тэгэхээр, уг албан тушаалыг бүгд биш, тодорхой хүмүүс л гүйцэтгэхээр дуудагдсан байх нь. Энэ бэлэг сүнсний ургац авчрах чадлаараа онцгойрдог. Үйлс ном дээр бүх итгэгчийг биш, харин Филиппийг л сайн мэдээ дэлгэрүүлэгч гэж нэрлэдэг (Үйлс 21:8). Билли Грахам, Ти. Эл. Осборн, Рейнхард Боннке нар бүгд бэлэгтэй сайн мэдээ дэлгэрүүлэгч нар байсан. Тэд тус бүрнээ багаараа хэдэн арван сая хүнийг сүнсний авралд хүргэсэн. Тэд Майк тэргүүтэй миний өмнө ярьсан хүмүүстэй л адил Бурханаас хүлээж авсан бэлгээ үржүүлжээ.

Тэгтэл яг үүнтэй адил итгэгч хүн бүр *өгөхөөр* дуудагдсан хэдий ч, зарим нь *өгөх* онцгой *карисматай* байдаг. Сайн мэдээ дэлгэрүүлэгч хүн сүнснийг аврахдаа гоцолдог шиг, *өгөх* карисматай хүн санхүүгийн өглөг дээрээ гоцолно. Ном маань Бурханаас өгөгдсөн бэлгээ үржүүлэх талаар төвлөрч өгүүлдэг ном хэдий ч, санхүүгийн өглөг нь үржлийн амин чухал тал учраас, би энэ бүлгээ дуусан дуустал итгэгч хүн бүрийн хийхээр дуудагдсан санхүүгийн өглөгийн тал дээр хэрхэн үржүүлэх талаар голлон ярьмаар байна.

Миний бие дөчөөд жил үйлчлэхдээ, санхүү ба өглөгийн тал дээр хоёр туйлшрал байдгийг гэрчлэн харсан билээ. Энэ хоёр туйлшралд чуулганы хүмүүс бөөн бөөнөөрөө автдаг бөгөөд миний хувьд энэ байдал өөрчлөгдөөсэй хэмээн үнэн голоосоо хүсч явдаг. Нэгдүгээрт - гагцхүү авахын тулд өгдөг хүмүүс байна - тэд амин хувьдаа л илүү ихийг хүсдэг. Энэ сэдэлд бодитой хандаж, зохих нэрээр нь нэрлэх юм бол, *сүвдаг зан* гэхээс өөр замгүй.

Харамсалтай нь, энэ буруу сэтгэлгээ нь нөгөө янзын туйлшралыг төрүүлэхэд түлхэц болжээ. Майк шиг Бурханы Үгийн бүрэн зөвлөгөөнд бүрэн суралцдаггүй хүмүүс л голдуу ийшээ хадуурна. Тэд хүмүүст итгэлээрээ өргөхийг заасан сургаал бүрийг жигшинэ. Тэр бүү хэл, бүх төрлийн өглөг, өргөлийг эсэргүүцэж туйлшрах ч явдал гарна. Үнэндээ энэ хандлагыг сахигч нар нь өөрийнхөө ч, аялдан дагалдагч нарынхаа ч үр нөлөөтэй байдалд саад хийж, үүгээрээ Сайн мэдээний ерөнхий ажлыг гацаадаг.

Лиза, бид хоёр Есүст итгэснийхээ дараа өргөлийн талаар өргөн дэлгэр заадаг чуулганд явдаг байлаа. Тухайн 1980-аад онд хүмүүс үйлчлэл гэхээсээ өөр дээрээ их анхаардаг байв. Чуулганы маань сургаал номнол дийлэнхдээ зөв байсан ч, зан чанарынхаа доголдлоос болоод хүмүүс илүү том байшин, илүү тансаг машин, илүү үнэтэй амралт зэрэг амин хувийнхаа “дурыг” биелүүлэх гэж өргөдөг байлаа. Тэд Бичээсийн томъёог л барьж үйлддэг болохоос, фокус нь итгэдэггүй хүмүүсийн дур хүсэлтэй яг адил. Лиза, бид хоёр энэ байдлыг нэг л тэнцвэргүй байгааг мэдрээд байсан хэрнээ, яг юу нь болохгүй байгааг онож хэлж мэдэхгүй байлаа.

Үнэндээ бид тийм уур амьсгалд хэсэг байсныхаа ачаар л их бага хэмжээгээр цэвэршин, төлөвшиж, өргөлийг эрүүл саруулаар хардаг болсон юм. Сүүлдээ чуулганы маань удирдагч өдөөлтөнд унаж, бүх зүйлээ алдсан. Үүнийг үзсэн бид юу юугүй нөгөө туйл руу хадуурах дөхсөн боловч, амьдрал дээр болсон явдлаас илүү Бурханыхаа Үгд үнэнч үлдэхээр шийдсэн юм.

Үүнээс хэдэн жилийн дараа тэр чуулган биднийг (Мессенжер) үйлчлэлд маань албан ёсоор үдэж гаргаж өгсний дараа нүд тайлсан нэгэн үйл явдал болов. Намайг цуглаан дээр номлохдоо бэлтгэж байтал, Ариун Сүнс: “Хүү минь, чи *шашны сүнс* гэж юу болохыг мэдэх үү?” гэж асуух нь тэр.

Миний бие энэ талаар хүмүүсийн яриаг уншиж, сонсож, өөрөө ярьж, тэр бүү хэл шашинлаг сэтгэлгээний талаар бичиж байсан ч, Ариун Сүнсийг асуух үед, шууд л би энэ талаар огт мэдэхгүйгээ ойлгов. Тэгээд: “Би мэдэхгүй. Мэдэхгүй учраас л Та асууж байгаа. Юу юм бэ?” гэж хариуллаа.

Гэтэл Ариун Сүнс: “Шашны сүнс нь өөрийнхөө хүслийг гүйцэтгэхийн тулд Миний Үгийг ашигладаг нэгэн. Тэр хүн Миний зааврыг, Миний хүслийг дээдлэн тээдэггүй. Тэр хүн өөрийнхөө ашгийн төлөө л Үгийг маань хэрэглэдэг” гэж хариулав.

Энэ үг намайг хүрээлэн байх хорт уур амьсгалаас гарахад шаардлагатай тохиргоог зүрхэнд минь хийх өөрчлөгч хүчин зүйл болсон юм. Бид буруу санаагаар өгсөн ч, үр ашгийг нь хурааж авах боломжтойг Ариун Сүнсний үг бидэнд илчлэв. Сэдэл нь буруу байсан ч, Бурханы хууль тусаа өгөхдөө л өгнө.

Элч Паул өгөх тал дээр газар тариалангийн дүрслэл ашигласан болохоор, би ч бас даган дуурайлаа. Тариачин хүн нэг л зорилгын төлөө үр тарьдаг: ургац авахын тулд. Тэрбээр илүү гарсан хүнсээ томуу агуулахдаа нөөцлөөд дотроо: “Амь гол минь, чамд олон жилийн турш хэрэглэх хөрөнгө байна. Өөрийгөө амраа, ид, уу, зугаац” (Лук 12:19) гэж хэлнэ.

Гэтэл Бурхан түүнийг: “Мунхаг!” (20-аар эшлэл) гэж дууджээ. Тариачны хувьд тарих ба хураах зарчим ажилласан уу? Ажилласан. Гэтэл Есүс түүнийг сувдаг хэмээн дууджээ.

Нөгөөтэйгүүр, өөр нэгэн тариачин хүмүүсийг тэжээж, туслах хүсэлтэй байж болох. Тэрбээр эхний тариачин шиг л ургац авсан ч, үүндээ өөрөөр ханджээ. Тэгээд дотроо: “Пөөх, би өөрөө идээд зогсохгүй, хамт олноо эрүүл, хүчтэй болгох чадалтай боллоо. Би өгөөмрөөр өгч чадах нь!” гэж боджээ.

Хоёр тариачны хэн хэнийх нь хувьд тарих ба хураах хууль ажилласан. Эхний хүн шунхайрлаар тарьж, хураасан нь эмгэнэлтэй. Гэтэл олон хүн хаанчлалд яг ингэж өгдөг.

Паулын үгийг цааш нь лавшруулан үзье. Тэрбээр:

“Тиймд та нарын хэдийнээ амласан өгөөмөр сэтгэлийн бэлгийг урьдаас цэгцлүүлэхийн тулд ах дүүсийг түрүүлж явуулахаар ятгах шаардлагатай хэмээн би үзлээ. Ингэснээр албадлагын бус, харин өгөөмөр өглөг байхаар бэлтгэгдэх юм” (2Коринт 9:5) гэжээ.

Паул санхүүгийн бэлэг, өргөлийн талаар ярьж байгаад эргэлзэх юм алга. Өргөдөг хүний төлөө Бурхан юу үйлдэхийг Паул мөн л газар тариалангийн зарчмаар үргэлжлүүлэн дүрсэлжээ:

Тэгэхлээр ийм байна. Харам таригч нь харам хураана. Өгөөмөр таригч нь өгөөмөр хураана. (2Коринт 9:6)

Хүн бусдад зүгээр л туслах цорын ганц сэдлээр өгөх ёстой юм

бол, Паул яагаад өргөлийнхөө үр дүнд хурааж авах ургацын талаар ярина вэ? Өгөхдөө, давхар үржүүлэх хүсэлтэй байх буруу юу - ялангуяа энэ нь хаанчлалын төлөө хүмүүсийн амьдралыг босгон байгуулах амин хүслийг маань өрдөж, өсгөж байгаа нөхцөлд? Есүс талантын сургаалт үлгэрээр зааж өгсөн шиг, Паул ч бас Коринтын чуулганы шинэ итгэгчдийг үр нөлөөгөө үржүүлэх ухаанд сургаж байгаа биш үү? Паул тэднийг чин хайраар үйлдэхдээ, давхар илүү том ерөөлийн төлөө хөрөнгө оруулахыг ятгаад байгаа юм биш үү? Паул яг л ингэж хүссэн гэдэгт би итгэдэг. Учир нь түүний дараа дараагийн үгийг үзнэ үү:

Хүн бүр дурамжханаар бус, албадлагаар бус зүрхэндээ байгаачлан өгөгтүн. Учир нь уриалгахнаар өгөгчийг Бурхан хайрладаг. Та нарыг Бурхан бүхий л ерөөлөөр бялхаах чадалтай. Харин та нар бүх зүйлд, бүхий л талаар, үргэлж сэтгэл хангалуун байж, алив сайн үйлээр дүүрэн байгаарай (Тэр цагт та нарт *үргэлж хэрэгтэй бүхэн чинь байж, цаана нь бусадтай хуваалцах юмсаар ч хангалттай байна*). (2Коринт 9:7-8)

Энд хоёр зүйл гүйцэлдэж байгааг тэмдэглэнэ үү. Хувийн хэрэгцээ хангагдана. Мөн цаана нь *бусадтайгаа хуваалцах юмс ч хангалттай* байхыг Паул хэлжээ. Бид үр тарьсан буюу хөрөнгө оруулсан учраас л өгөөмөр байх хүчин чадал маань үрждэг. Энэ сэдлийг цааш нь бүр ч хурцалж өгчээ:

Тариачинд үр, идэх талхыг ханган өгдөг Тэрээр *тарих үрийг чинь* хангаж, *үржүүлэх* бөгөөд зөвт байдлын (*өгөөмөр байдлын*) чинь ургацыг нэмэгдүүлнэ. Та нар их өгөөмөр байдлын төлөө юм бүхэнд баяжих болно. Энэ нь биднээр Бурханд өргөх талархлыг бий болгодог (Тийм ээ, та нар *үргэлж өгөөмөр байхын* тулд тал бүрээрээ баяжина). (2Коринт 9:10-11)

Өгснөөр чинь Бурхан *та нарын баялгийг үржүүлнэ* гэдгийг Паул онцгойлон мэдэгджээ. Энэ нь та нарт *үргэлж өгөөмөр байх* чадварыг өгнө. Энэ үнэн дан ганц өгөх бэлэгтэй хүмүүст хамаатай бус, итгэгч хүн бүрт хамаатай. Энэ бол Бурханы эртээ урьдын цагт тогтоосон, сүнсний хууль болой.

Лиза, бид хоёр үйлчлэлээ эхлүүлж байхдаа жилийн 18,000 долларын л орлоготой байлаа. Дөнгөн данган төлбөр тооцоогоо л хийх мөнгө. Үйлчлэлийнхээ анхны Христмас баярыг санадаг юм. Илүүчилсэн хэдхэн доллартаа багтаан, хүмүүст зориулж голдуу гэртээ гараар урласан бүтээл бүхий бяцхан сагстай бэлгээ бэлдэж байсан сан. Бидэнд олигтой юм авах мөнгө үнэндээ байгаагүй.

Хэдэн жилийн дараа пастор маань нэг удаа онцгой өргөл авахад, Лиза, бид хоёр түүнд нь оролцохыг хүсэв. Бурхан бидэнд: “1,000 доллар өргө” гэлээ.

Энэ явдлаас хоёр жилийн өмнө бид жижиг байшингийн урьдчилгаа хийх гэж хадгалсаар, хадгалсаар 1,800 доллар л хураасан маань манай хамаг хөрөнгө байлаа. Бидэнд тэтгэвэр, хөрөнгө оруулалт зэрэг өөр ямар ч хадгаламж байсангүй. Хэрэв 1,000-ыг нь өгчих юм бол, цаана нь 800 доллар л үлдэнэ. Энэ өргөлийг өгчих юм бол, бидний бүтэн хоёр жилийн хадгаламж юу ч үгүй улайна. Байрны урьдчилгаа хийгэл даанч хол байна даа гэмээр санагдав. Тийм боловч, бид бусдад нөлөөлөхийг хүссэндээ, өгөөмөр байхыг хүссэндээ өргөлөө өргөсөн юм. Хүчин чадлаа өсгөх цорын ганц зам нь өөрт байгаа өчүүхэнээ өгөх явдал гэдгийг бид Бичээсээс мэдэж байв.

Он жил өнгөрөхийн хэрээр бид бяцхан сагснаас бас 1,000 доллараас ихийг өгч чаддаг болов. Зөвхөн энэ жилд л гэхэд, бид анхныхаа тэр том өргөлөөс тавь дахин ихийг өргөсөн. Бид боломжтой бүх аргаар улам олон хүний амьдралд нөлөөлмөөр байна. Бурхан бидний чадварыг үржүүлж, өгөөмөр байх чадалтай болгосон. Энэ үнэнийг Пэйшн Транслэйшн маш сайхнаар хэлдэг:

Хоолонд маань талх болдог үрээр тариачныг элбэг дэлбэг хангаж өгдөг энэ өгөөмөр Бурхан та нарын төлөө бүр ч гараа гаргадаг. Тэрбээр эхлээд хэрэгцээ бүрийг чинь бас бус зүйлстэй чинь хангана. Дараа нь тариалах үед чинь *өгөөмөр байдлын ургацыг чинь ургуулахын тулд* үрийг чинь *үржүүлнэ*. Та нар боломж болгоныг угтан өгөөмрөөр өгөхдөө, тал бүрээрээ өгөөмрөөр баяжина. (2Коринт 9:10-11)

Бурхан бидний төлөө бүр ч гараа гаргана гэснийг тэмдэглэнэ үү. Тэрбээр хаанчлалыг байгуулахын төлөө бидний хийж байгаа хөрөнгө оруулалтыг зорилготой үржүүлдэг бөгөөд тийнхүү бидний өгөөмөр байдал өсдөг. Бид цагаан эрвээхэй, зэвэнд идүүлэхгүй,

хулгайч ороод, тоноод явчихгүй тэнгэрийн дансаа байгуулж байгаа бөгөөд тэр данснаасаа энэ амьдралдаа ч зарлагадаж болох ажээ. Тийм ээ, мөнхийн шагнал гэж байдаг ч, энэ амьдралдаа ч бас өгөөмрөөр өргөхийн төлөө нээж, ашигладаг данс мөн бий. Үүнийг Паул Филиппойн итгэгч нарт маш тодорхой бичсэн:

Би [та нарын] бэлгийг нь эрж байгаа юм биш, харин та нарын үнэлгээнд нэмэгдэж буй үр ашгийг [та нарын дансанд арвижиж буй ерөөлийн ургацыг] эрж байна. (Филиппой 4:17)

Зарим хүн хадгаламжийн, хувьцааны, хөрөнгө оруулалтын данстай байдаг шиг итгэгч - бидэнд тэнгэрийн данс бий. Энэ данс биднийг илүү үр нөлөөтэйгээр газар дээр Бурханы хаанчлалыг байгуулахад түлхэц болдог хөдөлгүүр болох учиртай. Итгэгч хүн бүр сүнсний хуулийг мэддэг, ойлгодог, итгэдэг бол, яах бол? Бид Сайн мэдээг дэлхийд мөн ч хурдан хүргэнэ дээ! Хаанчлалын дайсан яагаад итгэгч - биднийг санхүүгийн үр тарихаас зүйл бүрээр хорьдгийг одоо ойлгож байна уу?

Лиза, бид хоёрт Фил, Дана гэдэг гэр бүлийн найзууд бий л дээ. Тэд дэндсэн гэмээр өгөөмөр хүмүүс. Тэд орлогынхоо бараг тавин хувийг өргөдөг. Саяхан л гэхэд нэгэн байгуулагын илгээлтийн ажилд 100,000 долларын бэлэг өгсөн. Хоёр өдрийн дараа өөр нэгэн илгээлтийн ажилд бас л 100,000 доллар өгсөн. Хоёр дахь байгууллага нь манай Мессенжер Интернэйшнэл байсан учраас, би энэ бүгдийг мэдэж байгаа хэрэг.

Фил бизнесээ олон жилийн өмнө эхэлсэн бөгөөд цулайх ч үгүй, улайх ч үгүй алтан дунджаа бариад л явдаг байж. Тэгтэл хорин жилийн өмнө Фил, Дана хоёр ирэх гурван жилийн хугацаанд хаанчлалын ажилд 250,000 доллар өргөхөө Бурханд амлажээ. Энэ бүтэхгүй зорилго шиг харагдаж байсан ч, тэд Бурханд дураараа ажиллах орон зай гаргаж өгсөн байна.

Филийн бизнес цэцэглэсэн боловч, тэрбээр ажил хэрэг нь тэгтлээ сайн явааг мэдээгүй ажээ. Гурван сарын дараа Фил дансанд нь илүү 250,000 доллар байгааг олж мэдэж. Тиймээс гэргийтэйгээ ярилцаад, заавал гурван жил гэж сунжруулалгүй, шууд өргөхөөр шийдсэн байна. Фил надад: “Өргөл гэхээр л гуяа алгадаж гүйдэг явдал маань ингэж л эхэлсэн шүү дээ” гэж билээ.

Фил, Дана хоёр Майктай адил няцахаас татгалзжээ. Ухрах

амархан байсан ч, тэд давшсаар байсан бөгөөд эцэстээ тэдний тэнгэрийн данс нь төсөөлшгүйгээр тэнтийжээ. Та, бид хоёрт ийм зүйл тохиолдож болохгүй гэж үү? Паул:

“Эдүгээ, дотор маань ажилладаг хүчний дагуу гуйх буюу бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай Түүнд (Та нарын дотор ажиллаж, энэ бүхнийг гүйцэлдүүлдэг Бурханы аугаа хүчинд хэзээ ч бүү эргэлз. Тэрбээр та нарын хамгийн өндөр хүсэлт, хамгийн боломжгүй зүүднээс чинь хол давсан зүйлийг бий болгож, хамгийн галзуу төсөөллөөс чинь ч хол сунайна! Энэ бүхнийг чинь Тэр хол хаяна. Учир нь Түүний гайхамшигт хүч та нарыг тасралтгүй эрчилсээр байдаг)” (Ефес 3:20) хэмээн чангаар мэдэгдсэн.

ЗАД ТАТАЖ ГАРАХ

Өдий олон жил үйлчлэхдээ би карисма ч, санхүүгийн өглөг ч шалгагддагийг сурсан юм. Номыг чинь хүн байтугай амьтан ч тоож хэвлэхгүй улирал - үнэндээ ганц бус, олон улирал ирнэ. Нойр хоолгүй зүтгээд л байхад, номын чинь ажил урагшлах ч царайгүй, дээрдэх ч янзгүй. Тийм боловч, та дуулгавартайгаар урагшилсаар. Тэгж чадбал, нэг л өдөр гэнэт л нөхцөл байдал чинь *зад үсрэн нурна*.

Эсвэл та өгөөд л байдаг, өгөөд л байдаг. Гэтэл ургац байтугай, ургамлын толгой ч цухуйхгүй. Цаашдаа юм хийх мөнгө чинь л дуусч байдаг. Гэтэл гэнэт Бурхан Майктай ярьсан шигээ тантай ярьж, та ч Бурханы итгэхийн аргагүй үгийг дуулгавартай дагана. Тэгээд саадыг *зад татаж гараад*, өргөлийн тэс өөр төвшинд нэвтэрнэ.

Зад татах гэж юуг хэлнэ вэ? Толь бичиг дээр “хориг буюу саадыг зайлуулах юмуу гэтэлж гарах үйлдэл, жишээ”¹² гэжээ. Ингэж төсөөлье: Усны урсгалыг ханаар битүүлжээ. Усны төвшин нэмэгдсээр байвч, хана саад хийсээр л. Гэнэт чимээ гарч, хананд цуурхай үүссээр, хэсэг хугацааны дараа ус ханыг зад татан, сад тавина. Одоо урьдын саад байхгүй учраас, ус чөлөөтэй урсана. Үүнийг л зад татах гэнэ.

Давид хаан “*Миний гараар* Бурхан, дайснуудыг минь үерийн ус мэт зад татлаа” (1Шастир 14:11) хэмээн тунхагласан. Өндөрсөх ус нь үнэнд үнэнч үлдэх дуулгавартай үйлдэл минь бол, шувтаргын дараа чөлөөтэй урсах ус нь үр жимстэй, элбэг дэлбэг байдлыг төлөөлнө.

Фил, Дана хоёрын эхний 100,000 долларын өргөлөө өргөсөн тэр долоо хоногт бизнес нь рекорд эвдэж, тухайн долоон хоногтоо л 100,000 доллараа эргүүлээд олсныг Фил надад хэлж билээ. Бэрхшээлийг зад татан гарах гэдэг ийм л байдаг. Тэд анхнаасаа ингэж эхлээгүй. Өгсөөр, өгсөөр байсан ч, олигтой ургацгүй үе тэдэнд байсан. Тийм боловч, бууж өгөлгүй, жил бүр итгэмжтэй тарьсны үр дүнд тэд саадыг зад татаж гараад, бараг л тарьсан даруйдаа шууд ургацаа хураадаг болжээ.

Энэ бол эш үзүүлэгч Амосын үгийн биелэл болой: “Эзэн тунхаглаж байна: “үр тариа, усан үзэм нь хурааж амжихаас хурдан ургах өдрүүд айсуй” (Амос 9:13). Энэ үнэнийг Нью Кинг Жэймс Вержн дээр тун уран яруугаар зураглан хэлдэг:

“Үзэгтүн, айсуй” хэмээн Эзэн айлдруун:

“Газар хагалагч нь ургац хураагчаа гүйцэх.

Усан үзэм тариалагч нь усан үзмийн худалдаачнаа гүйцэх.

Амтат дарс уулсаар нэг дусалж,

Нуруудаар нэг даган урсах.”

Ургац хураагч нь ургацаа хурааж дийлэхгүй байсаар, үр тариалагчдаа гүйцэгдэнэ.

Усан үзмийн худалдаачин нь өмнөх улирлынхаа ургацыг борлуулж дуусаагүй байхад л, тариалагч нь дараа жилийнхээ ажлыг хэдийнээ эхлүүлэх! Гэхдээ үр дүн нь бүр ч биширмээр. Газар хагалагч, ургац хураагч, усан үзэм бяцлагч нар нь бүгдээрээ дарс бүтээх гэсэн ганц л хүсэлтэй. Тэгвэл үр дүнг нь сонс доо: “Дарс хэзээ ч татрахгүй, урсан урссаар байх бөгөөд үр жимсгүй цаг дахиж хэзээ ч байхгүй” (зохиолчийн дүрслэл).

Бидний *карисма*, *санхүүгийн өглөг* дээр яг л ийм зүйл болно. Майк, Фил, Дана нарт ийм зүйл тохиолдсон. Мессенжер Интернэйшнэлийн хувьд - энэ олон жил тариалсан ном материалаар маань амьдрал нь өөрчлөгдсөн тухай үй түмэн гэрчлэл бидэнд бий. Үнэхээр ч нэг усан үзмээ хурааж амжаагүй байхад л дараа дараагийнх нь багсайн гарсаар байна!

Олон хүн яг зад татдагийнхаа даваан дээр буугаад өгдөг. Тэд бэрхшээлд сөхөрч, хүссэн үр дүнгээ үздэггүй. Лиза, бид хоёр ч Бурханы Сүнсийг үл ойшоон, шалтаг тоочих юмуу учир зүйн гаргалгаа руу эргэж болох л байсан. Бидэнд шаардлагатай

байшингаа авахад дор хаяж 5,000 долларын урьдчилгаа хэрэгтэй байв. Манай хотын гоё, гоё байшингууд жаахан хүүхэдтэй хүмүүсийг оруулдаггүй, зөвхөн томчуудад л нээлттэй байлаа. Бид “Эхлээд байшиндаа орчихёе. Тэгээд ирээдүйд мянган доллар цуглуулаад өргөчихье” гэсэн шийдэлд хүрч болох л байсан. Тэгсэн бол, бид хоёр хаанчлалд хөрөнгө оруулж, эх үүсвэрээ өсгөх хамгийн том боломжоо алдах байжээ.


Гэхдээ түүхийн маань хамгийн гоё хэсэг хараахан болоогүй байна. Зургаан сарын дараа бид Бурханы гайхамшгаар 5,000 доллартай болов. Тэр мөнгийг бид Лизагийн аавын нээсэн данснаас хүлээж авсан юм. Бид тэр дансыг нь огт мэддэгүй байв. Дээрээс нь бидний хэрэгцээг мэдэхгүй, танихгүй хоёр хүн бидэнд 2,000 доллар нэмж өгч билээ. Ийнхүү жил хүрэхгүй хугацааны дотор бид шинэ байшиндаа нүүж орсон юм. Ямар ч боломжгүй гэмээр энэ үед Бурханы жинхэнэ гайхамшигтай хангамжийг үзэх нь бидний итгэл, тэвчээрт тустай байв. Хэрэв бид Ариун Сүнсний өгөөрэй гэсэн 1,000 долларыг өгөлгүй, атгаад үлдсэн бол, ийм түүх өрнөх байсан гэдэгт би лав итгэхгүй.

Яг одоо энэ сэдэвтэй уялдуулан нэг анхааруулга өгмөөр байна: Бид дураараа үйлдэж болохгүй. Юу гэсэн үг үү? Бид Тэргүүн Хамтрагч - Ариун Сүнсний зөвлөгөөг хайх ёстой. Тэр бидэнд “Чамд тустайг сурган Чамайг явах замаар чинь удирддаг “Бурхан ЭЗЭН чинь *Би байна*” (Исаиа 48:17) гэдэг. Мэдрэг ухаанаа тээж (Ариун Сүнсний гэрэл гаргаж буй газар), айлдсан үгэнд нь орох нь амин чухал. Учир нь хаанчлалын хөрөнгө оруулалтын ажил дундуур Ариун Сүнс л биднийг удирдан чиглүүлнэ. Ариун Сүнс зүрхэнд маань хүслээ шивнээгүй бол, бид 1,000 доллараа өгөхгүй байх байсан.

Зарим хүн Ариун Сүнсний зөвлөгөөг хайдаггүй. Зарим нь байнга “үгүй” гэж хэлдэг учраас, ухаан нь хатуурч, Ариун Сүнсний зөвлөгөөнд таг дүлий болсон байдаг. Та ийм байдалд байгаа бол, гэмшээд, дуу хоолойг нь хаасандаа Ариун Сүнснээс уучлал гуй. Ариун Сүнс таныг шууд уучилж, ухаан чинь ч даруй эргэж ирнэ! Гэхдээ дараа нь өөрийнхөө учир шалтгааны дуу хоолойд авталгүй, Ариун Сүнсний шивнээнд байнга чих тавьж амьдраарай.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

1. Бурхан таны зүрхэнд Түүний хүмүүсийг хайрлаж явах хайрыг суулгасан учраас, та тэдэнд *өгч, үйлчилдэг*. Яг одоо та бусдад хэрхэн өгч, үйлчилж байна? Өгч, үйлчлэх талаа өсгөх ямар, ямар бүтээлч арга зам байж болох вэ?
2. Ухаалгаар өргөдөг хүний өргөл нь зүгээр л хайр, үйлчлэлийн бэлэг биш юм. Энэ нь давхар *хөрөнгө оруулалт* байдаг. Та өргөл, үйлчлэлийн хөрөнгө оруулалтаасаа ямар төрлийн ашиг хүлээж байна? Үйлчлэх, өгөхийг хөрөнгө оруулах явдал гэхээр хандлага чинь хэрхэн өөрчлөгдөж байна?
3. Таны *каризма ч, санхүүгийн өглөг ч* шалгуулна. Шалгалт өгч байгаа хүний хүч хөдөлмөр ч үр дүнгүй шахуу, хураах ургац ч гэх юмгүй байдаг. Ийм үед бууж өгдөг дээрээ тулбал, та яах ёстой вэ? Яаж өөрийгөө тэнхрүүлэх вэ?



*Хүн бүр хүлээн авсан бэлгээрээ
бие биендээ Бурханы олон төрлийн
нигүүлслийн сайн нярвууд шиг үйлчил.*

— 1 Петр 4:10

Өөрчлөгч хүчин зүйл

Энэ чухал бүлгээрээ би *үр нөлөөтэй өсөлтөд* хүргэдэг *өөрчлөгч хүчин зүйлийн* талаар хуваалцмаар байна. *Үр нөлөөтэй* гэдэг үгийг хэрэглэхдээ, би мөнхөд тогтох үржлийн талаар ярьж байгаа билээ.

Өөрчлөгч хүчин зүйл нь тухайн үйл явдлыг юмуу өөрчлөлтийг бий болгодог гол түлхүүр удиртгал буюу өгсүүр бүтэц байх нь (Энэ тодорхойлолтыг олон толь бичиг үзсэнийхээ дүнд би өөрөө гаргаж ирсэн болно). Бидэнд бэлэг өгөгдсөн хэдий ч, түүнийг тогтмол хүчин чадалтай байлгаж өгдөг зүйлийг Петр олж хэлжээ: “бэлгээрээ бие биедээ *үйлчил*.” Үйлчлэх нь *өөрчлөгч хүчин зүйл* мөн боловч, жинхэнэ үйлчлэлийн өдөөгч нь хэзээд хайр байдаг. Элч Паул:

“бидний Бурхан бөгөөд Эцэгийн өмнө та нарын итгэлийн үйл, хайрын хөдөлмөр (*хэрхэн хайр чинь бусдад үйлчлэхэд өдөөдгийг*) хийгээд Эзэн Есүс Христ дэх найдварын чинь тууштайг байнга санадаг” (1Тесалоник 1:3) гэсэн.

Жинхэнэ үйлчлэл хайраар бадарсан зүрхнээс л төрдөг. Энэ нь дайсагнал, бэрхшээл зэрэг аливаа таагүй нөхцөл дор хувирдаггүй дотоод горим юм. Энэ нь заримдаа үгээр илрэх боловч, дийлэнхдээ үйлдлээр илэрдэг.

ХАТАГТАЙ ЦАЦАГТ ХЯРУУЛ

Үйлчлэл гэж юу байдгийг би нэгэн түүхээр дүрсэлье. Миний өгүүлэх хос маань бидний маш дотны нөхөд бөгөөд нэр усаа

дэлгэхгүй байхыг хүссэн юм. Тиймээс би тэдний нэрийг нууцлаад, зохиомол нэр өгье. Райли, Дэйв хоёр Америкийн хамгийн том нэгэн хотын захад аж төрнө. Манай хоёр хар багаасаа л зэргэлдээ байшинд амьдардаг байсан болохоор, заяаны хос байж.

Гэрлэснийхээ дараа Райли ихэнх чуулган, орон гэргүй хүмүүсийн хорогдох байр зэрэг буяны байгууллага Христмас баяраар хоол, бэлгээр дайлдаг мөртлөө яагаад Талархлын баяраар юм хийдэггүй юм бол хэмээн гайхдаг байжээ. Талархлын баяр нь гэр бүл, идээ будаа дээр төвлөрдөг учраас, маш чухал баяр гэдэгт Райли итгэдэг байв. Талархлын баяраар өрх толгойлсон ээж, тахир татуу, орон гэргүй хүмүүс идээ будаагаар элбэг байх хэцүү. Үнэгүй хоол зорилгоо биелүүлдэг ч, ширээ дүүрэн зоог өрөөд, гэр бүлээрээ баярлах боломж талаасаа дутмаг.

Райли: “Хүн бүрт тодорхой нөлөө авчрах хүчин чадал байдаг ч, бултаараа нийлбэл бүр ч томыг гүйцэлдүүлнэ” гэдэг сэн. Тэрбээр Бичээсийг сайн мэддэг бөгөөд нэгэн санаагаар гар нийлэн ажиллах нь ганцаараа ажилласнаас арав дахин ихийг гүйцэлдүүлнэ (Дэд хууль 32:20) гэдгийг мэднэ. Түүнчлэн аль болох олон итгэгч нийлэх тусам, үр дүн нь улам л өссөөр байдгийг ч мэднэ. Үүнээс гадна жинхэнэ зарц хүн өөрийнх нь нэр мандах, мандахгүйг үл тоон, багийн нэгээхэн хэсэг байгаадаа баяртайгаар үйлчилдэг гэдэгт Райли үнэн голоосоо итгэнэ. Райлигийн хандлага үржлийн төлөөх эдгээр чухал орцын амьд жишээ болдог юм.

Райли анхныхаа Талархлын баярын боломжоор найз нөхөд, гэр бүлээсээ мөнгө цуглуулаад, цацагт хяруул худалдаж авчээ. Үржүүлэх сэтгэлгээтэй Райли, Дэйв хоёр маань хүлээж авсан доллар тутамдаа өөрсдөөсөө нэг доллар гаргахаар шийджээ. Тэр жил Райли арван нэгэн цацагт хяруул худалдаж аваад, түүнийгээ нэр усаа илчлэлгүйгээр, шууд л машиныхаа ачаан дээрээс тараажээ. Хоёр дахь жилдээ гучин нэгэн цацагт хяруул болов.

Гурав дахь жилдээ Райли нийтэд нэр усаа зарлалгүйгээр, энэ алсын харааг түмэнд түгээхийг гэр бүл, найз нөхдөөсөө хүсчээ. Нөгөөдүүл нь ч хүссэнээр нь хийж, хүчин зүтгэл нь хурдтай үржив гэнэ. Тав дахь жилдээ тэд таван зуун гэр бүлд цацагт хяруул, дээрээс нь нэг айлд хоёр лааз ногоо өгөх чадалтай болжээ.

Энэ үед л тэрбээр Авралын арми гэдэг байгууллагатай албан ёсоор нууц тараалтын гэрээ байгуулсан байна. Авралын арми гэдэг буяны байгууллага нь нийгмийн төлөө үйлчилдэг байгууллагуудтай хамтран ажилладаг учраас, үнэхээрийн гачигдалтай байгаа хүмүүсийг олж тогтоох, бүртгэх ажлыг гүйцэтгэх боломжтой

байжээ. Тэд (хүнсний талон, засгийн газрын хөтөлбөр зэрэг) ямар нэгэн халамжид хамрагдах боломжгүй хүмүүсийг онилж сонгосон байна. Райлигийн баг Авралын армийг баазаа болгон, унаагаар болоод явганаар хүргэх ажиллагаа зохион байгуулжээ.

Мөн гачигдсан хүмүүс ч хэрэгтэй хүнсээ хүлээж авахын тулд өөдөөс нь хөдөлж, эрвийж дэрвийхээрээ хамтран ажиллав. Тэд тэрэг түрж, дугуй унаж, сагс зөөж, хөршүүдээсээ унааг нь гуйх юмуу эсвэл зүгээр л алслагдсан дүүрэгт байдаг контэйнер байшин, орон сууц, цэцэрлэгт хүрээлэн зэрэг газраасаа явганаар хүрч ирээд, цацагт хяруул, ногоогоо аваад явдаг болжээ. Орон гэргүй нэгэн хүн бусад орон гэргүй нөхөдтэйгээ хогоос олсон, хийгээр ажилладаг шарагчаа ашиглан цацагт хяруулаа гадаа шараад сурчихсан байж.

Энэ тараалт сүүлдээ бүр газар авч, тэр олон хүнийг зохион байгуулж, зохицуулах өөр газар хэрэгтэй болжээ. Хажуугийн УайЭмСиЭй томуу байртай байсан ч, Авралтын арми тэр хоёр харилцааны асуудалтай байв. Тиймээс Райлигийн баг тэр хоёр байгууллагыг ялгаатай талаа харилцан хүлээн зөвшөөрөхөд ятган уриалах хэрэгтэй болжээ. Хоёр байгууллага ч гар барин, түүнээс хойш Райлигийн төсөл дээр ч, нийгэмд хандсан бусад ажил дээрээ ч түншлэн ажиллах болсон байна.

Жил бүр Райли, Дэйл хоёр түрүү жилийнхээ рекордыг эвдэх зорилго тавина. Тэд Талархлын баяраар ширээ дүүрэн гэрийн зооггүй нэг ч айл байлгахгүй гэсэн зорилт тавьжээ. Тоо өсөх тусам, үнийн өсөлт, үйл ажиллагаа юмуу хүмүүсийн нүүдэл суудлаас болж тараалтын үйл явц улам л ээдрээ, бэрхшээлтэй болов. Манай хоёр санхүүгийн хувьд хүчтэй байсандаа ийм нөхцөлд үйл явцыг зогсоохыг хүсэлгүй, хандивын нэг доллар тутамд өөрсдөөсөө хоёр доллар гаргахаар шийджээ (Тэр зургаан жилд тэдний санхүүгийн хүчин чадал ч өссөнд гайхалтгүй. Бурхан тэднийг улам үр нөлөөтэй байлгахын тулд өглөгийг нь үржүүлжээ).

Райли: “Бурхан ямар нэг аргаар, янз бүрийн эх үүсвэрээс заавал мөнгөөр хангаж, нийт дүнг улам л дээшээ болгодог сон” гэж билээ. Хамгийн гайхалтай нь манай хоёр анхнаасаа л засгийн газрын аль нэгэн хөтөлбөр, бизнесийн байгууллагаас ширхэг ч зоос авахгүй гээд шийдчихсэн байжээ. Бүх мөнгө гэр бүл, найз нөхөд, найзын найзаас л орж ирэх ёстой.

Тоо өсөх тусам шинэ, шинэ бэрхшээл тулгарав. Хүлээж авах хүмүүсийн тоо олширсон тул хүнсээ нэг өдрийн дотор тараах боломжгүй болжээ. Райли, Дэйл хоёр тараах өдрийг нэмэгдүүлж, хоёр өдөр болготол, энэ нь ч бас том бэрхшээл дагуулав: Эхний өдрөө

тарааж амжаагүй тэр их махаа хаана хадгалах билээ? Райли уйгагүй шийдэл хайж байлаа. Цацагт хяруул худалдаж авсан хүнсний том сүлжээ дэлгүүр нь шөнийн цагаар хөргүүртэй машинуудаа үнэ төлбөргүй хэрэглүүлэхээр болсон тул одоо тэд мөнгөө агуулахад биш, хүнсэнд зориулж чадахаар болжээ.

Үүнээс гадна тоочиж барамгүй, шийдвэрлэх ёстой өч төчнөөн том, жижиг саад тулгарч байжээ. Энэ хосын итгэл, шийдэл үнэхээрийн ган бат байв. Тэд бэрхшээлийн өмнө тасралтгүй залбирсаар, Бурхан руу хашхирсаар, стратегийн санаа хүлээн авсаар, тус болж чадах хүмүүсийн тааллыг олсоор байв.

Эдүгээ тэд үйлчлэлийнхээ хорин зургаа дахь жилтэй золгосон бөгөөд энэ мөрийг бичиж буй энэ жилд л гэхэд манай хоёр 10,500 гэр бүлийг тэжээжээ (Нэг бүл дунджаар дөрвөн хүнтэй гэж тооцох юм бол, нийт 42,000 хүн болно). Тэд дүүргийнхээ төдийгүй, хөрш дүүргийнхээ гачигдалтай олон хүнийг хоол хүнсээр хангажээ (Тэр газарт Америкийн хамгийн том нэгэн хот багтдагийг санаарай). Ингэхдээ тэд тус бүр 15 орчим метрийн урт чиргүүлтэй таван тракторыг цацагт хяруулаар, гурван тракторыг ногоо болоод бусад хүнсээр дүүргэнэ. Энэ ажилд 200 гаруй сайн дурынхан хэдэн өдөр эцэж цуцалгүй, зохион байгуулалттай оролцоно. Тэдэн дундаас олон хүн Райлигаар бүр анхнаасаа л хамт байжээ. Гэхдээ хамгийн гайхамшигтай нь юу гээч? Тэр хүмүүсийн ихэнх нь “Хатагтай цацагт хяруул” гэж хэн болохыг одоо хүртэл мэдэхгүй!

Тэдний үржүүлгээр өрнөсөн, амьдрал өөрчилсөн гайхамшиг, түүх, гэрчлэлийг тоочих боломжгүй. Үй олон хүн Есүс дээр ирсний дунд Райлигийн нөхөр Дэйв байв. Гэр бүлүүд эвлэрч, засгийн газрын ажилтнууд, хүнсний дэлгүүрийн ажилчид, Авралын арми, УайЭмСиЭй-ийн ажилтнууд, сайн дурынхан бөгөөд нийгэм бүхлээрээ их бага хэмжээгээр үлгэр жишээ авчээ.

Хэд хэдэн богино түүх хуваалцъя. Райлигийн нэг найз хотынхоо мотоциклын дэлгүүрт нярав хийдэг ажээ. Тэгээд жил бүр дэлгүүрийн ажилчдаа уриалан, Хатагтай цацагт хяруулд зориулж хандив цуглуулдаг гэнэ. Тэгээд хэн нь хамгийн их өгөхөөрөө өрсөлддөг ажээ. Байкерууд өнгөрсөн жилийн Талархлын баярын дараа ирэх жилийн Талархлын баярт зориулж 3,000 доллар цуглуулснаа Райлид мессежээр мэдэгджээ.

Нэг удаа Хатагтай цацагт хяруул үлдэгдэл мөнгөө нутгийн чуулганд хандивласанд, тэд Райлигаас үлгэр жишээ аван, Талархлын баяраар болоод жилийн бусад үеэр ядуу зүдүү хүмүүст туслах өөрийн гэсэн хөтөлбөр эхлүүлжээ.

Авралын армийн багийн гишүүд өөр муж руу илгээгдэхдээ, Райлигийн үлгэр жишээгээр зүйл бүрийн хөтөлбөр хэрэгжүүлэх хүсэл тэмүүлэлээр дүүрэн явдаг ажээ. Түүнчлэн Райлигийн амьдардаг хотод шинээр суурьшсан гишүүд ч Авралын армийн цолтнуудын ярианаас Хатагтай цацагт хяруулын тухай хэдийнээ мэдчихсэн ирдэг болохоороо, тэр үйлчлэлтэй танилцах гэж яарна.

Райли чуулганд ч ажилладаггүй, пастор ч биш, бизнес эрхчлэгч ч биш. Тэр зүгээр чуулгандаа итгэмжтэй явдаг үнэнч итгэгч, гэргий, ээж. Тэрбээр өөрийнх нь үйлчилдэг Аугаа хүчирхэг Бурхан үржилд дуртайг сайн мэднэ. Миний хувьд, энэ хостой нөхөрлөх нь нэр төрийн хэрэг мөн.

МӨНХИЙН ҮРЖҮҮЛГИЙН ТЭРГҮҮН ЖИШЭЭ

Хайраар өдөөгдсөн үйлчлэл нь үржүүлгийн амин хүчин зүйл болой. Бичээс дээр байдаг хамгийн мундаг үржлийн түүхээс үзье л дээ. Мэдээж, хамгийн түрүүнд Есүс орно. Тэрбээр:

“Харин та нарын дунд бүү ийм байг. Хэн чинь та нарын дунд агуу болохыг хүснэ, тэр нь та нарын зарц болог. Мөн та нарын дунд хэн чинь тэргүүнд байхыг хүснэ, тэр нь бүгдийн боол болог. Учир нь Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд мөн олны төлөө амиа золиос болгон өгөхийн тулд ирсэн билээ” (Марк 10:43-45) гэсэн.

Есүс жинхэнэ аугаа амьдралд хүргэдэг зам нь үйлчлүүлэхийг бус, үйлчлэхийг эрэлхийлэх явдал гэжээ. Тэрбээр үйлчлэлийнхээ оргил үйлдлийг дараах маягаар тодорхойлсон нь ч гайхах зүйл биш: “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Буудайн үр газар эс унан, эс үхвээс тэр ганцаараа үлдэнэ. Харин тэр үхвээс олон үр гаргана” (Иохан 12:24). Дахиад л *тарих* (буюу *хөрөнгө оруулах*) ба *хураах* талаар яригдаж байна. Буудайн үрээр *хөрөнгө оруулсан* нь олон, олон буудайн үр авдаг шиг, Есүсийн дуулгавартай үйлчлэл нь Бурханы үй олон хөвгүүд, охидыг төрүүлжээ. Гайхмаар! Есүс бидэнд хэрхэн үр нөлөөтэй үржүүлэхийг биеэр үзүүлэх зам тавьж, жишиг тогтоожээ. Есүс:

“Та нар Намайг Багш, Эзэн гэж дууддаг. Тэр нь Би мөн тул та нарын зөв. Тэгвэл Би, Эзэн бөгөөд Багш атлаа та нарын хөлийг угаасан юм чинь та нар ч мөн нэг нэгнийхээ хөлийг угаах учиртай. Миний та нарт үйлдсэн лугаа адил та нарыг үйлд хэмээн Би ийм дуурайл өгөв” (Иохан 13:13-15) гэжээ.

Удирдагч, харилцагч хүнийхээ хувьд би “эцэст нь хэлэхэд” гэдэг үг ямар чухал болохыг мэднэ. Энэ нь уншигч, сонсогч, оюутан, багийн гишүүн, ажилтан, хүүхэд зэрэг хүмүүст хамгийн сүүлд үлдээгээд явах мэдэгдэл, үг юм. Энэ нь та сонсогч нараа цаашид тээж амьдраасай гэсэн, таны хамгийн чухал бодол юм.

Есүс газраас явахдаа хамгийн сүүлд юу хэмээн айлдлаа? Хамгийн сонирхолтой нь энэ нь Түүний цовдлогдохоосоо өмнө дагалдагч нарынхаа хөлийг угаахдаа хэлсэн дүрслэл бүхий номлол байдаг.

Би танд үнэнээ л хэлье. Би шинэхэн итгэгч байхдаа жижиг бүлэг дотор маань “Бие биеийнхээ хөлийг угаая” гэхээр жигтэйхэн дургүйлхдэг байж билээ. Нэг хар юмыг хөлөндөө хүргэнэ гэхээс дотор муухайрч, ямар нэг арга сүвэгчлээд зугтчихна!

Олон жилийн дараа хөл угаах нь илүүтэй найзуудын маань сахидаг уламжлал байсныг мэдээд дотор онгойж билээ. Үүнтэй зэрэгцээ нэгэн жишээ нь: Мосе шураг дээр могой байрлуулахад (Тооллого 21:8-9) үүнийг нь харсан хүн бүхэн могойн хазуураас эдгэрсэн байдаг. Үнэхээрийн гайхамшигтай, хүчирхэг явдал. Тийм боловч хэдэн үеийн дараа Израиль мөнөөх могойгоо шүтсэн байдаг (2Хаад 18:4). Тэд олон жилийн өмнөх эх үйлдэл нь Эзэний зааврыг дуулгавартай дагах явдал байсныг ойлголгүй, эд дээр нь анхаарчээ.

1980-аад онд манай Библи судлалын бүлэг яг ийм зүйл хийсэн юм. Бид “хөл угаахыг” үндсээс нь ховхлоод, утга агуулга дээр нь бус, үйлдэл дээр нь анхаарах болсон байв. Нэгдүгээр зуунд засмал зам байхгүй, мал адгуусаас өөр тээврийн хэрэгсэл байхгүй, Адидас, Найкийн гутал байхгүй, голдуу нүцгэн хөлөөрөө шахуу явган явдаг байсан. Тиймээс хүмүүсийн хөл хар шороо, шавар шавхай, мал амьтны баас зэрэг бохиртой хутгалдана. Тийм нөхцөл дэхь шивэртэй, хар хөл л бидний өнөөгийн Барууны ертөнцөд анх хүрч байсан гэхэд буруудахгүй.

Тэр үед баян хүний зарц боол нь гэртээ морилж буй эзнийхээ бас гэр бүлийнх нь гишүүдийн мөн зочдынх нь хөлийг цэвэрлэх шаардлагатай байв. Язгууртны гэрт олон янзын үүрэг хариуцлага бий: зүчээ хариуцах, хоол хүнс бэлтгэх, гэр орон цэвэрлэх зэрэг. Хөл угаах

ажлыг хамгийн дорд боол гүйцэтгэнэ. Зарим хүрээнд бүр ч дор. Энэ бохир ажлыг хамгийн дорд эм боолоор л хийлгэнэ. Учир нь тэднийг ийм заваан ажил хийж байхдаа л таарсан боолын боол, босгоны шороо гэж үздэг байж.

Сүүлчийн зоог дээр Есүсийн багийнхан бүгдээрээ нэг том өрөөнд багтах боломжтой, чинээлэг айлд сууж байжээ. Магадгүй тэр хотын хамгийн нэр нөлөө бүхий хүний гэр байх. Хэдэн цагийн өмнө арван хоёр эр бүгд тэр айлын хамгийн дор зарцаар хөлөө угаалгажээ. Гэтэл Есүс тэр орой түмпэн, ус бариад зогсохгүй, Багшийнхаа билэгдэл болсон орхимжоо тайлаад, дагалдагч нарынхаа хөлийг угаасан байдаг. Тэд юу болоод байгааг, энэ нь ямар учиртай болохыг сайн мэдэж байсан. Тэгвэл би коллежид байхдаа, Библи судлалдаа ирэхээсээ өмнө усанд орчихсон, цэвэрхэн хөлтэй байдаг байсан учраас, хөл угаалд эргэлзэж, тэр бүү хэл цэрвэж, татгалздаг байлаа. *“Яахаараа энэ таних ч үгүй хүн миний хөлийг угаах гээд байдаг билээ?”*

Та хэрэв Есүсийн үгийг дахин унших юм бол, илүү утга төгөлдөр болж ирнэ. Есүс хэзээ ч мартахааргүй сэтгэгдэл хоногшуулж байжээ: Хэдэн дагалдагчдаа насан турш тээж явах *эцсийн үгээ* үлдээж байна.

Хоёр үгээр хэлбэл, аугаа болохын тулд бид сайн дураараа хамгийн дорд зарцын байрыг эзлэх ёстой. Магадгүй тиймээс л Есүс “Би дөлгөөн, зүрхэндээ даруу” (Матай 11:29) хэмээн айлдаа юм болов уу?

Би үүнийг нилээд юм үзэж байж ухаарсан. Шинэхэн итгэгч байхад, олон хүн үйлчлэлийг яг эсрэгээр нь үзээд байх шиг санагддаг байлаа. Итгэгч хүмүүсийн дотор *“Номлох эвсэл олныг дагуулахаас нааш чухал хүн биш”* гэдэг чимээгүй итгэл амьдарна. Үйлчлэх нь чуулганы хамгийн доод байр суурийн хүмүүсийн хийдэг зүйл гэх. Хангалттай хөдөлмөрлөж байж л, эцэстээ чухал хүн болно гэх. Даанч завхарсан үзэлтэй байж дээ!

Тэвчээр алдалгүй, уйгагүй төлөвшүүлдэг Ариун Сүнснийхээ тэсвэртэй чанарт л талархах минь! Тэр л миний сэтгэлгээг өөрчилсөн. Гэхдээ цаг хугацаа орсон. Би эхний дөрвөн жил пасторынхаа хувийн амьдралд туслах үйлчлэлтэй байснаа өмнө ярьсан.

Нэг өдөр ойр зуурын ажил амжуулж явтал, Бурханы Сүнс надад: “Хүү минь, Би чамайг дэвшүүлэх цагт чи *үйлчлэлийн илүү өндөр байр сууринд* очно. Чи өнөөдөр алдаа гаргалаа гэхэд, хими цэвэрлэгээнд цамцаа цэвэрлүүлэхтэй адил залруулж болно. Харин олон нийтийн үйлчлэл нь цамц солихтой адилгүй. Тэнд эрэмдэг зэрэмдэг ч гэсэн Миний хайртай хүмүүсийн амь амьдралын асуудал

тавигдана” гэж хэлсэн юм. Ариун Сүнсний энэ үг намайг гавлчих шиг л болов. Өндөр байр суурь нь үйлчлэлийн илүү өндөр үүрэг хариуцлагаас гадна жижиг зүйлд ч гэсэн хэзээд итгэмжтэй байх явдал болой. Миний үйлчлэлийн төвшин жинхэнэ баялаг болох хүмүүсийг дагаж хувьсахгүй.

Ребека

Бусдын төлөөх үйлчлэлээс төрсөн өөр нэгэн жинтэй жишээ нь Хуучин гэрээний Ребекагийн түүх юм. Товч сэргээхүй.

Абрахам Исаак хүүдээ гэргий авч өгөхөөр зарцаа нутаг явуулжээ. Зарц нь тэр даруй арван тэмээ дагуулан, уртын аянд гарав.

Зорьсон газраа хүрээд Абрахамын зарц яг өдийд бүсгүйчүүд худаг дээр ирж, ус авдгийг санажээ. Тэгээд залбирав: “Чи ваараа тонгойлгож, уснаасаа надад уулгана уу?” гэж намайг асуухад “Уу, уу! Би бас таны тэмээг ч усалж өгье” гэж хариулагч эмэгтэй нь Таны зарц Исаакт Танаас заяасан хүн байг! Та миний эзэнд хайр энэрэл үзүүлснийг тань үүгээр би мэднэ” (Эхлэл 24:14).

Түүнийг залбирч дуусав уу үгүй юу, Ребека усны саваа барьж хүрч ирсэнд, зарц түүнээс ус гуйв. Тэгтэл тун сонирхолтой явдал болсон:

Эзэн минь, уу! гээд ваараа *яаран* гар дээрээ буулгаж уулгав. Тэр түүнд ус уулгаж дуусаад —Би бас ус утгаж, таны тэмээнүүдийг ч ханатал нь усалъя гэж хэлэв. Тэрээр ваартай усаа онгоцонд яаран юүлээд, дахин ус авахаар худаг уруу гүйж, бүх тэмээнд нь ус утгажээ. (Эхлэл 24:18-20)

Охин арван тэмээг услаж дуустал, зарц түүнийг сэм ажиглав. Энэ хэдэн эшлэлээс Ребекагийн үйлчлэлийн олон гоц чанарыг олж үзэж болно. Түүнийг нэг бүрчлэн жагсаая:

- *Уриалгахан.* Ребека хөдөлж ядаагүй. Хурдан шаламгай хөдөлж, наашаа цаашаа жирийлгэсэн. Ярвагнасан, удаан үйлчлэл нь жинхэнэ үйлчлэл биш. “Ямар ядаргаатай юм бэ” гэсэн хандлагаар, албатай мэт үйлчилж байгаа хүмүүсийг харсан биз дээ? Тэгвэл Ребека ч тэгээгүй, жинхэнэ зарц хүн ч тэгдэггүй. Жинхэнэ зарц хүн хүсэл тэмүүллээр дүүрэн, эрч хүчтэй хандлагатай байдаг бөгөөд үүнийг нь үйлдэл нь хэлээд өгдөг.
- *Давуулан гүйцэтгэх.* Онцсайн үйлчилгээ гэж бий. Ребека

зарцын хүсэлтийг давуулан биелүүлжээ. Бидний дийлэнх маань хувьдаа тэмээгүй бас Ойрх Дорнодод аж төрж үзээгүй учраас, Ребекагийн үйлчлэлийг биширмээр болгож байгаа хүчин зүйлийг сайн ойлгохгүй байгаа байх. Урт аяллын дараа тэмээ дунджаар гучаас тавин галлон (115-190 литр) ус ууна. Абрахамын зарц арван тэмээтэй байсан! Тоо бодъё: Хэрэв нэг тэмээ гучин галлон (115 литр) ус уусан гэвэл, Ребека худгаас гурван зуун галлон (1,150 литр) ус зөөжээ дээ. Нэг вааранд тавин галлон (20 литр ус) багтдаг гэвэл, тэрбээр бараг 60 удаа худаг тэмээ хоёрын хооронд гүйжээ.

Гэхдээ энэ юу ч биш! Дээр үед хоёр төрлийн худаг байж. Нэг нь оосортой хувингаа худаг дээрээс доош шидээд, усаа дүүргэн татаж гаргадаг худаг. Нөгөө нь гучаас дөчин шат уруудаж байж, усандаа хүрдэг худаг. Ребека ямар худаг ашигласныг мэдэж чадна гэж үү? Чадна аа - хоёр дахийг нь. Яагаад гэвэл хожим Абрахамын зарц Ребекагийн үйлсийн талаар гэр бүлд нь ярихдаа: “Ребека мөрөн дээрээ ваараа тавин, худаг уруу бууж ирээд (тэрбээр булаг руу *уруудаж буугаад*), ус татав” (45-аар эшлэл) хэмээн өгүүлсэн байдаг. Ребека зүгээр нэг тавин галлон (20 литр) усыг мөрөн дээрээ тавиад, 60 шахуу удаа наашаа, цаашаа зөөлгүй бас шагаар найган өгсөж, урууджээ. Хамгийн гол нь Ребека гуйлгаж хийгээгүй, сайн дураараа хийснийг бүү мартаарай. Үүнээс дараагийн чанар төрнө.

- *Хэрэгцээнд мэдрэг.* Хэрэгцээ тодорхой болчихоод байхад жинхэнэ зарц гуйлгаж, үглүүлэлгүй, өөрөө шууд хөдөлдөг. Миний бие энэ олон жил үйлчлэхдээ, нэг юмыг тодорхой харсан билээ: Байнга хэлүүлж, гуйлгуулж байж л хөдөлдөг хүмүүс үржүүлдэггүй бол, ямагт түрүүлж хөдөлдөг хүмүүс өсгөж үржүүлдэг.
- *Зориулалттай.* Даалгавар хэцүү байсан ч, Ребека хичээнгүй үйлчилсэн. Миний үйлчлэх хугацаандаа ажигласан өөр нэгэн загвар нь даалгавар хүнд байх тусам, үйлчлэх баяр хөөр хурдан татардаг. Хүний чанар ийм л байдаг. Тийм боловч, бидэнд Есүс Христийн мөн чанар бий. Тэр нэг ч шантраагүй. Ухаан санаанд багтамгүй эсэргүүцэл, зовлонг туулахдаа ч, шантраагүй. Ребекаг үлгэрлэн дуурайгаад, Есүс Христийн мөн чанараар амьдар!
- *Дуусгадаг.* Ребека ажлаа дуусан дуустал хийсэн. Хаяагүй. Ерэн есөн хувийн гүйцэтгэл нь даалгавраа дуусгасан хэрэг биш. Саул

хаан Амалекуудтай байлдахдаа яалаа? Хэдэн арван мянгаар нь хядчихаад, нэгийг нь амьд үлдээснээс болж, Бурхан хүчин зүтгэлийг нь шагнаагүй (1Самуел 15-ыг үзнэ үү). Ребека ажлаа шагналтай гэж мэдэлгүй, зүгээр л хийсэн. Шан харамж горилж бус, харин үйлчлэх боломжоо шагнал мэт үзэн үйлчлэх нь жинхэнэ зарц хүний чанар болой. Тэд үйлчлэлээсээ баяр хөөр, биелэл, ханамж авдаг. Ажил нь шагналтай бол, зарц хүн үүнийг сэдлээ болголгүй, ердөө л нэмэгдэл ерөөл гэж үзнэ. Ребека ер бусын шагнал хүртсэн. Тэрбээр арван тэмээн дээр өөрт нь зориулсан бэлэг сэлт ачсаныг ч, тэрбээр бурханлаг хүнтэй гэрлэхээ ч мэдээгүй. Гэхдээ бас болоогүй ээ. Хамгийн чухал бэлэг нь Ребека Абрахамын ерөөлд нэвтрэх эрхийг хүртсэн. Энэ бол түүний хүлээн авсан мөнхийн бэлэг байв. Ребека олон үндэстний ээж болно. Түүгээр дамжин бүх үндэстэн ерөөгдөнө. Ребека тулгал үржүүлжээ.

БУСАД ЖИШЭЭ

Үйлчлэх зүрхээрээ мөнхийн үржилд хүрсэн Бичээсийн жишээ олон бий. Дараах хэдэн жишээг та өөрөө хувьчлан дэлгэрүүлж судлана биз ээ:

Рүүт

Хадам эх Наоми нь Моаб бэр Рүүтээ гэртээ харь хэмээн гурвантаа ятгажээ. Гэсэн ч Рүүт:

“Таныг орхиж, таныг дагахаас буцаж эргэхийг надад бүү ятгаач. Учир нь таны явах газар уруу би явна. Таны суух газарт би ч сууна. Таны ард түмэн миний ард түмэн, таны Бурхан миний Бурхан” (Рут 1:16) хэмээн татгалзсан байна.

Нөхцөл байдал хэцүүдсэн ч, Рүүт ч бас Ребекатай адил илүү явж, илүү ажиллаж, илүү зориулагдахаас буцаагүй. Рүүтийн зам Ребекагийн замаас ч хүнд байсан байх. Тэр Моаб хүн учраас, нутгийнхан дунд яс үндсээрээ гадуурхагдсан л байх. Тийм боловч, тэрбээр хадам эхдээ үйлчлэхийн тулд ямар ч бэрхшээлийг тэсэн гарсан.

Тэгээд ямар үр дүнд хүрсэн? Тэрбээр алдарт Давид, Соломон тэргүүтэй Иудагийн хаадын алтан ургийн хэлхээг бөхөлсөн юм. Гэхдээ

хамгийн чухал нь тэрбээр Есүсийн ургийн бичигт багтсан болой. Ребека ч бас Абрахамд амласан мөнхийн үржлийн гэрээнд багтжээ.

Елиша

Елиа Елишаг өөрийг нь орхиж явахыг гурвантаа ятгасан ч, Елиша Елиагийн дэргэд үлдэж, түүнд үйлчлэхээр шийджээ. Бусад эш үзүүлэгч нар түүнийг Елиад үйлчилж, цагаа гарзадлаа хэмээн нэг бус удаа басамжлан доромжилсон ч, Елиша шийдвэр дээрээ л үлдсэн. Бусад эш үзүүлэгч нарын үг ч буруугүй л мэт харагдаж байв. Тэд чинь хэргэм зэрэг, амьдралтай бүтэн цагийн эш үзүүлэгч нар болцгооно. Тэгтэл Елиа авагдбал, Елиша юутай хоцрох вэ? Тэрбээр өөрийн гэсэн үйлчлэлгүй, олон жил Елиад хоосон үйлчилсэн биш үү? Бусад эш үзүүлэгч нар ийм тооцоо гаргаж ирсэн ч, Елиша тэднийг сонсоогүй. Үүний оронд Елиша тухай бүр тэдний амыг хаасан! (2Хаад 2) Елиша үйлчилж, даалгавраа дуусгахаас буцахгүй.

Елишагийн авир, үйлдэл Ребека, Рүүт хоёрынхтой төстэй байв. Тэгээд яасан? Тэрбээр Елиагаас хоёр дахин олон гайхамшиг үйлдэж, Елиагийн хийж чадаагүй зүйлийг хийн - Иезебелийн эзэрхлийг төгсгөсөн байдаг. Тэр үржүүлж чадсан!

Гехазид

Гехазид Елишагийн ажлыг үржүүлэх боломж байсан ч, харамсалтай нь зарцын зүрх сэтгэл байгаагүй. Тэрбээр амиа бодсон, сувдаг хүн байсан болохоороо үр дүнтэй үржүүлээгүй (2Хаад 5).

Х

Шинэ гэрээнд бэлбэсэн эмэгтэйчүүдийг хооллодог эрчүүд гардаг. Тэд ажилдаа тун нухацтай хандсан. Энэ ажлыг сайн гүйцэтгээсэй гэсэндээ тэдэн дээр бүр гар тавьсан байдаг. Үүнээс алмайрмаар үр дүн гарсныг Үйлс номд ийнхүү тэмдэглэжээ:

Бурханы үг түгэн тархсаар Иерусалим дахь дагалдагчдын тоо үлэмж ихээр нэмэгдсээр (*үржсээр*) байлаа... (Үйлс 6:7)

Юу нь гайхмаар гэж? “*Үлэмж үржсэн*” гэж чангаар хэлнэ үү. Бодоод үз! Пентекост өдөр хэлсэн Петрийн сонгодог номнолын дараа

гурван мянган хүн Есүст итгэх үед ч энэ үгийг хэрэглээгүй. *Нэмэгдсэн* л гэж хэлсэн (Үйлс 2:41-ийг үзнэ үү). Түүнчлэн өдөр тутам итгэсэн хүмүүсийн талаар ч мөн л *нэмэгдсэн* гэдэг (Үйлс 2:47). Хожим нь таван мянган хүн Есүст амьдралаа өгөхөд ч ялгаагүй (Үйлс 4:4).

Үйлс 6-аар бүлэг дээр чуулган бүхлээрээ хаанчлалыг байгуулахад идэвхитэй оролцож эхлэх хүртэл *үржсэн* гэдэг үгийг хэрэглээгүй.

Стан, Майк, Фил, Райли, Дэйв шиг хүмүүс үйлчлэх ёстой байраа эзэлж, бэлгээ хэрэглэх үед л үржил өрнөдөг. Энэ үед л бид *аугаа үржлийн* талаар сонсдог.

ШИЙДВЭРЛЭХ БҮТЭЦ

Үр нөлөөтэй үржлийн шийдвэрлэх бүтцийг та юу гэж ойлгож байна? Райли, Дэйв хоёрыг Бичээсээс сурсан зүйлээрээ дахин нэг нэвтрүүлээд хар даа. Үлгэр жишээ бүхий стратегийг ажил хэрэг болгон, онцсайн үйлчилсэн тэр ганцхан хос хэдийн хэдэн арван мянган хүнд нөлөөлжээ. Есүсийн үгээс үзбэл, тэд аугаа болжээ. Стан, Майк, Фил, Данагийн хувьд ч ялгаагүй. Тэд бүгд жинхэнэ зарцын чанартай хүмүүс болой.

Гэхдээ бинэг чухал үг хэлье: *Хүн амин хувийнхаа төлөө үржүүлж* болох ч, үр нөлөө нь мөнхийн байж чадахгүй. Замбараагүй үржүүлж байгаа хэдий ч, амин хувийнхаа ашиг хонжоогоор хөдөлдөг учраас, хожмын өдөр хамаг ажил хөдөлмөр нь шатах хүмүүс байна. Үүнийг Есүс нүсэр том зоорь барьсан хүнээр үлгэрлэн сургасан. Мань хүн: “Би зорилгодоо хүрээд, хэдэн үеэрээ ч идээд барахгүй хөрөнгөтэй болсон тул амарч, идэж, ууж, баясья” гэсэн. Гэхдээ энэ түүх сайнаар төгсөлгүй, ололт амжилт нь сүйрсэн.

Энэ ном танд өөртөө хөрөнгө хураахын төлөө үржих итгэлийг заахгүй. Энэ ном танд бусдын төлөө үйлчлэхэд амьдралаа зориулахыг л заана. Үүнийг хийхэд, үл итгэдэг хүмүүсийн хөлөө хугалах шахам хөөцөлддөг юмс бидэнд зүгээр л нэмэлтээр өгөгдөнө (Матай 6:33) гэж Есүс мэдэгдсэн. Биеэр гэрчилсэн хүнийхээ хувьд л би үүнийг баттай хэлээд байна.

Лиза, бид хоёрын анхны чуулганы талаар дахин нэг дурьдъя. Зургаан жил хортой уур амьсгалд байсныхаа үр дагавраар би үржлийн талаар эрүүл бус хандлага бойжуулсан байв. Тэндээс явсныхаа дараах нь нэгэн өглөө давхиж явтал минь Ариун Сүнс

надтай уулзсан нь намайг өөрчилж, чөлөөлсөн олон учрааны нэг болов. Ариун Сүнс: “Хүү минь, ерөөлийн төлөө Намайг бүү хай. Би түүнийг чинь чамд зүгээр л өгнө” хэмээв.

Би ч шууд л Матай 6:33-ыг бодлоо: “Гагцхүү эхлээд Бурханы хаанчлал ба зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно.” Сүнсний үг надад зөв үзэл бодлыг авчирч, аминч хандлагын шавхрууг шувтарч туслав.


Би Түүнд хичнээн талархдаг гээч. Би аминч, сувдаг байхыг мэднэ - аз жаргалгүй, бөөн дарамттай, Бурханы оршихуйгаас алслагдмал байдаг. Нэн түрүүнд хаанчлалыг байгуулах Бурханы зам, зүрхийг сурсан явдал маань өдөр бүр баяр баясал, амар тайван, Бурханы оршихуйг авчирдаг болсон!

Х

Одоо бид нэгэн асуултанд тулж очлоо: Ажлаа өөрөө удирддаггүй, хүний удирдлага дор ажиллаж байгаа хүн яаж үржүүлэх болж байна аа? Энэ асуултанд дараагийн бүлгээрээ хариулъя. Тэгвээс бид илүү том ач тусыг үзнэ.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

1. Үйлчлэх нь жинхэнэ аугаа байдалд хүргэх зам болохыг Есүс зааж өгсөн. Есүс үйлчлэхийг хэрхэн үлгэрлэн харуулсан бэ? Түүний үйлчлэлийн үр дүн юу байв? Аугаа байдалд хүрэх Бурханы зам дэлхийн замаас юугаараа өөр байна?
2. Ребекагийн түүхийг сана. Түүний ямар, ямар онцгой чанар үйлчлэлээр нь илэрсэн бэ?
3. Та өөрийнхөө төлөө үржүүлж чадах ч, мөнхийн үр нөлөө авчрахгүй. *Авахын* төлөө үйлчлэх, *өгөхийн* төлөө үйлчлэхийн ялгаа юув? Амиа бодолгүй үйлчлэх нь яагаад чухал вэ?



*Тиймээс та нараас гуйя.
Намайг дуурайгсад бай.*

— 1Коринт 4:16-17

Намайг дуурай

Үржилд саад болдог юмсыг үзэж эхлэхээсээ өмнө авч үзэх хэрэгтэй өөр нэгэн чухал талбар бий. Өөр хүний төлөө ажиллаж байгаа эсвэл зүтгэж байгаа бол, хэрхэн үржүүлэх вэ? Дийлэнх хүмүүс ингэж л амьдардаг учраас, энэ бол түгээмэл асуудал.

Энэ талаар ярилцахдаа, би үйлчлэлийн талбар дээр тогтож ярих боловч, зарчим нь бизнесийн ертөнц, зах зээл, боловсрол, эрүүлийг хамгаалах, засгийн газар, хэвлэл мэдээлэл, биеийн тамир спорт, урлаг уран сайхан зэрэг нийгмийн бүх талбар дээр хэрэгжинэ.

Паул “Мөн итгэмжит байхыг нярвуудаас шаарддаг” (1Коринт 4:2) гэсэн. Итгэмжтэй байдлын нэгэн тэргүүний чанар нь үржих гэдгийг бид Бичээсээс үзсэн. Хэдэн эшлэлийн дараа Паул замбараагүй үржлийн түлхүүр орцыг зааж хэлжээ:

Учир нь та нар Христ дор тоо томшгүй сургагчидтай байлаа ч эцэг болох нь олонгүй. Учир нь би Христ Есүс дор сайнмэдээгээр та нарыг төрүүлсэн. (1Коринт 4:15)

Паул өөрөө Коринтын чуулганы *эцэг* нь байсан. Дээрх эшлэлийн дагуу, *эцэг* гэдэг нь өөр нэгнийг итгэл рүү дагуулдаг хүн байх нь. Тийм боловч, аав гэдгийг бас өөр олон замаар тодорхойлж болно. Бичээс дээр итгэдэггүй хүнийг “эцэг” хэмээн нэрлэх нь олонтаа.

Яг тэр л Паул Галатын чуулганд: “Би *өвөг дээдсийнхээ* ёс заншилд дэндүү зүтгэгч байж, нутаг нэгт нас чацуутан олныхоо дунд иудеизмд илүүтэй товойж байсан юм” (Галат 1:14) хэмээн мэдэгдсэн. Паул *өвөг дээдэс* буюу *эцгүүд* хэмээн олон тоон дээр ярьсан учраас, нэг хүний талаар яриагүй нь тодорхой байна. Энэ нь

мөн түүний “эцэг болох нь *олонгүй*” гэдэг үгийг баталж байна. Олон гэдэг үг нь Грекээр “их тоо” гэсэн утгатай. Энэ нь бид амьдралдаа нэгээс олон “эцэг”-тэй байж болохыг хэлж байна.

Паул Тимотыг байнга “хүү” гэдэг байсан. Тийм боловч, Паул Тимотыг аврал руу дагуулаагүй. Учир нь Паул “Үзэгтүн, тэнд нэгэн итгэгч иудей эмэгтэйн хүү Тимот гэгч дагалдагч байсан бөгөөд эцэг нь грек аж. Лустр болон Икониумын ах дүүс ам сайтай байв” (Үйлс 16:1-2) гэдэг. Паулыг Тимоттой анх уулзахад, тэрбээр хэдийнээ хөлөө олсон итгэгч байсан нь тодорхой байна.

Хуучин гэрээг үзэх юм бол, Давид өөрийнхөө хатуу ширүүн удирдагчийг “эцэг” гэсэн (1Самуел 24:11) бөгөөд мөн Елиша удирдагчаа “эцэг” (2Хаад 2:12) гэсэн. Елиа өөрийгөө “эцэг өвгөсөө” дээрдэх юмгүй хүн гэсэн (1Хаад 19:4-ийг үзнэ үү). Гэх мэтчилэн тоочоод л байвал, тоочоод л байна.

Ном маань эцэг хүн гэж хэн болохыг тодорхойлох бус, *эцэг хүн хэнийг төлөөлдгийг* харуулах зорилготой. Эцэг бол хүнд ч, байгууллагад ч удирдлага, тордолгоо, соёлыг авчрах чадалтай хүн юм. Учир нь бидний хэлэлцүүлэг таныг ажиллуулж байгаа бизнес эрхлэгч, танай хэлтсийн удирдагч, танай пастор, танай жижиг бүлгийн удирдагч, танай хөдөлгөөнийг хариуцагч, танай багш, танай дасгалжуулагч, таны тусладаг эмч гэх мэт янз бүрийн байр суурь дээр өрнөж болох. Мэдээж, энэ тохиолдолд эмэгтэй хүн ч “эцгийн” байр суурийг эзэлж болохыг та ойлгож байгаа байх. Тиймээс, миний ярих агуулгад “эцгийн байр сууринд зогсож буй” эмэгтэйчүүд ч бас багтана.

ТӨРӨЛ БҮРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Коринтын чуулганы эцгийнхээ хувьд Паул тэдэнд: “Тиймээс та нараас гуйя. Намайг дуурайгсад бай” (1Коринт 4:16) хэмээн зааварлажээ.

Паул “Би Христийг дуурайдаг шиг, намайг дуурай” гэж хэлээгүй байна (Тэрбээр хожим 11-ээр эшлэл дээр л ингэж хэлсэн). Тэрбээр энд ердөө “Намайг дуурай” л гэжээ. Энэ нь ч учиртай бөгөөд энэ учраа дараагийнхаа мэдэгдэлд илчилжээ:

Үүний улмаас би Эзэн доторх миний хайрт, *итгэлт* хүү болох Тимотыг та нарт илгээв. Хаа сайгүй чуулган бүрд би хэрхэн сургадгийн адил *Христ [Есүс] доторх замуудыг минь* тэр та нарт сануулах болно.

Түүний “үүний улмаас” гэдэг эхлэл үг тун чухал юм. Паул дөнгөж сая уншигч нартаа өөрийгөө дуурай гэсэн. Тийнхүү тэднийгээ алсын хараа, арга барил, соёл, үнэмшилдээ барьц алдуулахгүйн тулд *итгэлт* хүүгээ илгээжээ. Итгэлт хүү ямар байдаг вэ? *Итгэлт хүү, охин нь аавынхаа арга замыг үржүүлдэг!* Би энэ талаар удахгүй дэлгэрүүлж ярина. Харин эхлээд нэг зүйлийг авч үзье: Паул Коринтын чуулганд “Тимот та нарт Христ доторх Петрийн замыг сануулна” гэж хэлээгүйг бодоорой. Петр чуулганы жинхэнэ удирдагч байсан уу? Мэдээж байсан. Тэр бурханлаг бөгөөд тослогдсон удирдагч байсан уу? Мэдээж. Петр Библийн хоёр номыг бичсэн! Петр Паулаас ч эртний элч байсан.

Түүнчлэн Паул “Тимот та нарт Христ доторх Иаковын замыг сануулна” гэж ч хэлээгүй. Петрийн нэгэн адил Иаков ч бас Паулаас ч эрт элч болсон, чуулганы жинхэнэ эцэг, итгэлт удирдагч байсан. Тэр ч бас Библид өөрийн гэсэн номтой бөгөөд Иерусалим дахь чуулганы тэргүүн хариуцлагатан байв.

Петр, Иаков хоёр Паулаас өөрөөр ажилладаг байсан уу? Тийм ээ. Тиймээс Паулын бичээс, арга зам нь Петр, Иаков хоёрын аргыг хүчингүй болгож байна уу? Яалаа гэж! Тийм боловч тэр хоёрын зам Паулын сүнсний хүүхдүүд болох Коринтын чуулганд таарахгүй ажээ.

Паул Коринтын чуулганд соёлоо тогтоох үйл явц дундаа явж байна. Түүний арга барил бусад “эцгийнхээс” өөр боловч, тэд бүгдээрээ л Христийн суурь итгэл, сургаалд үнэнч байсан. Тийм боловч, бүгдээрээ бүх үндэстнийг дагалдуулах даалгавраа биелүүлэхдээ өөр, өөрийн гэсэн арга барил, зам, үнэмшил барьж ажилладаг байжээ.

Энэ нь олон итгэгчийн мэдэхгүй явдаг, сэрэмж дутсанаасаа болоод Христийн бие дотор маш их хагарал авчирдаг нэгэн үнэнийг тодруулж байна: Чуулган олон янзын *үйл ажиллагаатай*. Өөрөөр хэлбэл, хаанчлалыг урагшлуулах ганц л зорилгыг гүйцэлдүүлэх өөр, өөр зам бий.

Паул Коринтын чуулганд:

“Үйлдлүүд нь ялгаатай ч бүгдийн дотор бүхнийг үйлдэгч нь мөнөөх л Бурхан юм” (1Коринт 12:6) хэмээн зааварласан.

Миний бие гучаад жил бүтэн цагаар аялан үйлчлэхдээ, даян дэлхийн олон янзын чуулган, тэдгээрийн ялгаатай соёл, арга барил, итгэл үнэмшлийг өөрийн биеэр мэдэрсэн билээ. Гэхдээ л тэр дунд Есүсийн оршихуй байж л байдаг.

Паул чуулганд заавар өгөхдөө, цэргийн нэр томъёо олонтаа хэрэглэдэг. Энэ чинь зүгээр нэг төсөөлөл биш, бид үнэхээр газар дээрх Бурханы их цэрэг мөн. Би ч бас үйлчлэлийн ялгаатай үйл ажиллагааг Паулын арга маягаар дүрслэн ярьж. Манай Америкийн зэвсэгт хүчин олон салбартай: арми, усан цэрэг, нисэх хүчин, далайн цэрэг, эргийн хамгаалалт, сансрын хүчин. Эдгээр нь тус бүр зорилго, үүргээ өөр, өөр үйл явц, арга барилаар гүйцэтгэнэ. Тийм боловч улс, эх орноо хамгаалах тал дээрээ бүгдээрээ л нэг талынхан.

Нисэх хүчний цэрэг хүн Америкийн нисэх хүчинд зүтгэхэд л тусгайлан сургагдана. Салбарынх нь үйлчлэл гол төлөв тэнгэрт л өрнөдөг учраас, голчлон агаарын тактикийн үйл ажиллагаан дээр төвлөрсөн зааварчилгаанд суралцана. Энэ цэрэг Усан цэрэгт элсэхээр шийдбэл, шинээр сургагдах шаардлагатай болно. Мэдээж аль, аль салбарынх нь ерөнхий суурь техник адилхан боловч, усан цэрэг чинь гол төлөв усанд ажилладаг учраас, нисэх хүчний хуучин цэрэг маань байлдааны олон янзын шинэ сургуулилт, стратеги заалгана.

Тэгвэл Бурханы хаанчлалд ч ялгаагүй. Жишээлбэл, нэгэн хийсвэр жишээ хэлье. Танай пасторуудыг чинь Жой Андерсон, Терри Андерсон гэдэг. Тэд удирдлагын багтайгаа нийлэн Бурханы нигүүлслээр чуулганаа мянга найман зуун хүнтэй болтол нь өсгөх явцдаа гагцхүү тэдний л удирдлагын хэв маягт таарсан арга барил, соёлыг чуулгандаа бүрэлдүүлэн бий болгожээ. Чуулган чинь өөрийн гэсэн онцгой арга барилаараа л нийгэмдээ нөлөөлж, үр жимс хураана. Энэ тухай танай хотынхон мэддэг боловч, бусад хүмүүс сайн мэдэхгүй.

Тэгтэл өөр нэгэн газар дэлхийд нэрд гарсан, хэдэн арван мянган хүнтэй, хүчирхэг чуулган байх ажээ. Тэдний хоёр пасторыг Кевин Смит, Марисса Смит гэнэ. Тэд шинэ чиг бий болгон, үйлчлэлийн цоо шинэ тактикаар танай пасторуудаас ч илүү олон хүнд нөлөөлдөг ажээ. Тэгвэл та хэнийг нь дагах вэ? Смитийн гэр бүлийг дагах уу эсвэл өөрийнхөө пасторуудыг дагах уу?

Та алдартай пасторуудыг дагахад өдөөгдөн, удирдагч нараа хаяад, нөгөө пасторуудын арга барилд нэвтрэх гэж оролдож болох л юм. Та энэ өдөөлтөд бууж өгөх юм бол, би таныг Есүс Христийн итгэмжтэй зарц гэж нэрлэж чадахгүй. Та зүгээр л хагарал, хуваагдал, тэр бүү хэл салалт хагацлыг тарааж байна. Та Коринтчууд шиг эв нэгдлийн төлөө удирдагч нарынхаа арга зам, соёлыг танин мэдэж, дагахыг эрэлхийлэх ёстой. Үнэндээ Смитүүд биш, Андерсоныхон таны гэр бүл билээ.

Энэ суурь үнэнийг мэдэхгүйгээс болоод Христийн бие дотор байнга шахуу тохиодог эмгэнэлт явдлыг миний бие бөмбөрцгөөр тойрон

аялж, Христийн биеийг нэвт шувт ажиглаж явахдаа гэрчлэн харсан юм. Удирдлагын болоод Библийн сургуульд сурахаар явсан хүмүүс чуулганд өссөн хүмүүсээс өөр соёлтой байдгийг би ажигласан. Тэдгээр сургууль нь голдуу тэр сургуулийн ерөнхий соёлыг тогтоож өгдөг, өөр том чуулгантай холбоотой байдаг. Тухайн чуулганы ажиллагааг оюутнууд нь сургуульдаа ч, долоо хоногийн сүүлээрх хүндэтгэлийн цуглаан дээр ч мэдэрнэ.

Төгсөлтийнхөө дараа оюутнууд нь хүсэл тэмүүлэл өвөрлөсөөр хариад, чуулганыхаа соёл, арга барилыг өөрчлөхийг оролдож эхэлнэ. Магадгүй тэдний сурсан арга барил илүү ач холбогдолтой, үр нөлөөтэй гэдэг нь үнэн байж болох ч, хэрэв тэд тэр чигээрээ гэжөөд байвал, нутгийнхаа чуулганы ерөнхий үүрэг даалгаврын эв нэгдэлд амархан саад тотгор учруулна.

Хэрэв байгууллага нь тэр оюутны санал болгосон арга барилыг зөвшөөрөхгүй бол, тэрбээр өөр чуулган руу явах эсэх талаараа Бурханаас залбиран асуух юмуу эсвэл чуулганыхаа соёл, удирдагчийнхаа арга барилд хоёргүй сэтгэлээр зүтгэх эсэхээ шийдэх нь аль, аль талдаа хэрэгтэй.

Оюутан явлаа гэхэд, өөрийнхөө чуулганыг шархлуулалгүй, эрүүл арга замаар явах хэрэгтэй. Үнэндээ тэрбээр тухайн газраасаа хол нүүх нь хамгийн зөв байдаг. Энэ тохиолдолд хүмүүс танил талаа даган эх чуулганаа орхиж явах үзэгдэл гарахгүй бөгөөд Бурхан тэр газарт цоо шинэ эхлэлийг тавих шинэ удирдагчийг авчирна.

ИТГЭЛТ ХҮҮ

Харин одоо элч Паул Тимотыг “итгэлт хүү” гэж дуудсан баримтыг авч үзье. Эцгийнхээ арга замыг үржүүлэхийг эрэлхийлдэг хүүг итгэлт хүү гэдгийг хэдийн хэлсэн. Ер нь бол удирдагчид чинь байдаггүй бэлэг танд байж л байгаа. Хамгийн гол нь: Та эцэгтэйгээ адилхан зүрх сэтгэлээр бэлгээ үржүүлж байна уу? Таны үржлийн суурь сэдэл эцгийнхээ итгэл үнэмшил, соёлтой авцалдаж байна уу эсвэл та эцгийнхээ зүрхтэй харшилдсан, тэс эсрэг үр дүнтэй, хувийнхаа арга замыг байгуулах гэж тэмцэлдэж байна уу?

Энэ бүхнийг амьдрал дээр хэрхэн хэрэгжүүлэх вэ? Хоёр арга замаар хэрэгжүүлнэ: Нэгдүгээрт - удирдагч чинь таны оронд байсан бол, таны онцгой бэлгээр бүтээх байсан тэр үр дүнг дуурайж бэлгээ хэрэглэх. Энэ нь та удирдагчийнхаа клон (хуулбар) болж, өөрийнхөө онцгой даалгаврыг үл хайхарна гэсэн үг биш. Энэ нь дараах утгатай болно: Тухайлбал, та залуусын пастор байжээ. Та

пасторынхаа Бүтэн сайн өдрийн үйлчлэлийг хуулбарласнаараа нийгмийнхээ залууст хүрэхгүй.

Цуглаанаа залууст хүртээлтэй арга замаар хийх нь ухаалаг хэрэг мөн. Гэхдээ хамгийн гол нь үүнийгээ эцгийн зүрх сэтгэлээр хийх ёстой. Харин үүнийг гагцхүү эцгээ мэддэг хүн л хийж чадна. Стратеги, арга барилаа эцэгтэйгээ нээлттэй ярилцаж бай. Эцэгтэйгээ харилцаж байхдаа, хариу үгийг нь сонсож, түүний зүрх, таны зүрх хоёр параметрээрээ хэр таарч байгааг анхаараарай.

Ийм амьд үйлдэлд нээлттэй, шударга харилцан яриа шаардлагатай. Хэрэв таны дотор “миний санааг удирдагч маань битгий л олж мэдээсэй” гэсэн далд бодлого яваа бол, та хэдийнээ уруудах замдаа оржээ. Эргэлзээ байгаа бол, удирдагчдаа ил тод гаргаж хэлээд, зовнилоо тодорхой мэдүүл. Цуглаандаа урьж суулгах нь ухаалаг шийдэл байж мэдэх. Удирдагч чинь таны арга барилыг ойлгохгүй байвал, цаад “учрыг” нь тайлбарлаж хэл. Тэгээд ч таагүй байвал, тэр даруй санал зөвшилцөх төлөвлөгөө хай.

Хоёр дахь зам нь өөрийгөө “нөхөн үржүүлэх”. Тухайлбал, та хотынхоо хамгийн том залуусын бүлгийг удирддаг байжээ гэж бодъё. Энэ чинь тун сайн хэрэг. Бурхан таны арга барилыг ерөөж, таны амьдрал дээрх Бурханы бэлэг хүмүүсийг соронздоно. Тийм боловч та өөртэйгээ адилхан бэлэгтэй хүмүүсийг олж, тэдэнд өөрийнхөө сурсан цэц ухаан, арга замыг дамжуулж байна уу? Та хүчин чадалтай пасторуудыг босгон байгуулж байна уу? Ингэснээрээ “эцэг” чинь хотын өөр дүүрэгт шинэ бүлэг эхлүүлэх болсноо зарлах үед танд илгээгдэхэд бэлэн, хэдийнээ бэлтгэгдсэн хүмүүс байх болно. Тэргүүн пасторын дор байгаа хүмүүс нөхөн үрждэггүй учраас л олон чуулган хотынхаа өөр, өөр дүүрэгт шинэ бүлэг юмуу чуулган тариалж чаддаггүй юм.

Та хамгийн шилдэг дууны инженер, видео хянагч, хүүхдийн пастор, магтаалын удирдагч, гитарчин, харилцагч, угтагч юмуу өөр нэгэн ажилтан байж болох ч, энэ чинь дангаараа хаанчлалын амжилтыг шийдэхгүй. Жинхэнэ ач холбогдол нь нөхөн үржилд оршино. Өөрөөсөө: *“Би өөртэйгээ төстэй бэлэгтэй хүмүүсийн төлөө залбирч, хайж байна уу?”* гэж асуу. Олчихсон бол, тэдэнд аав хүний зүрхийг суулгангаа, бэлгийг нь илрүүлж, зааж, сургаж байна уу?

Өрөөлийн алсын харааны төлөө зүтгэж байхдаа, итгэмжтэй байх хоёр арга зам бий. Есүс “Хэрэв та нар бусдын юманд итгэмжтэй байгаагүй бол хэн та нарт өөрсдийн чинь юмыг өгөх билээ?” хэмээн түс тас хэлсэн.

Есүсийн энэ үгийг Өөрийнх нь хэлсэн итгэмжтэй гэдэг тодорхойлолтоор орлуулан давгъя: “Хэрэв та нар бусдын юмыг үржүүлэхгүй бол, хэн та нарт

өөрсдийн чинь юмыг өгөх билээ?” Эсвэл “Хэрэв та нар удирдагчийнхаа арга зам, соёл, хүч, алсын хараа, эх үүсвэр - за тэгээд хамгийн гол нь зүрх сэтгэлийг нь үржүүлэхгүй бол, хэн тан нарт өөрсдийн чинь юмыг өгөх билээ?” Ингэж хэлэхээр нэгийг бодогдуулж байгаа биз?

Миний уулзаж байсан амжилттай хүмүүс бүгдээрээ л анх бусдын юмд итгэмжтэй хандсан хүмүүс байдаг шүү. Би тэднээс анх хэрхэн эхэлж байсныг нь ямагт асуудаг. Эцгийнхээ юмуу эцгүүдийнхээ юмд итгэмжгүй байсан атлаа эдүгээ өөрийнхөө юмд амжилттай яваа нэг ч хүн байдаггүй юм.

МИНИЙ ХАМГИЙН ТОМ ЗӨРЧИЛ

Би дөнгөж үйлчлэлд гараад байхдаа, дотроо алдартай, чухал хүн болох гэсэн нууц сул талтайгаа ихэд зөрчилддөг байлаа. Би өөрийгөө бусдад болоод хамгийн гол нь өөртөө юм юмны анхдагч, жинхэнэ удирдагч хүн гэдгээ батлах ёстой байв. Гэтэл хүчин чадалтай үй олон удирдагч нарт ийм сул талтайгаа зөрчилдөх үе байдаг бөгөөд хэрэвзээ зүрхэнд байх үе дээр нь дарж авахгүй бол, хожим өөрсдийг нь сүйрэлд хүргэдгийг сүүлд мэдэж билээ.

Би улсынхаа нэгэн том хотын, хамгийн хурдан өсч яваа чуулганы залуусын пастор байхдаа, багийнхантайгаа хотынхоо ахлах сургуулийн хүүхэд бүрт сайн мэдээ хүргэх арга замыг олсон гэх үү. Тэр маань ч хосгүй бөгөөд онцсайн төлөвлөгөө байлаа. Манай залуусын бүлгийн ирээдүй тэр чигээрээ энэхүү санаачилгыг маань тойроглох учиртай байв. Учир нь манай туслах, бид хоёр энэ стратегийг бий болгох гэж найман сар ажилласан сан. Би алсын хараагаа залуусын бүлэгтэйгээ хуваалцахад, тэд ч дуртайяа хүлээн авав.

Тэгтэл төлөвлөгөө яг хэрэгждэгийн даваан дээр энэ маань манай пасторын зүрхэнд нийцэхгүй байгааг мэдэв. Пастор намайг хөтөлбөрөө зогсоо гэлээ. Би пастортайгаа хориод минут маргалдсан ч, пастор няцсангүй. Би хэлэх үггүй болсондоо дуугаа хураасан ч, дотроо бол асч байлаа. Найман сарын ажил угаадас шиг цацагдаж, аугаа төлөвлөгөө маань нурав. Хамгийн аймаар нь бид хамаг алсын хараагаа энэ хөтөлбөрийг тойруулж байгуулсан байлаа. Тиймээс дахиад л бүхнийг тэгээс эхлэх болов. Хорин дөрвөн удирдагчдаа, тэдний дорх залуусын бүлэгтээ яаж дуулгана аа? Тэд хичнээн их зүтгэлээ.

Бачуурсан сэтгэлээ засах гэж Лиза дээр очлоо. Гэтэл хэрэг

явдлыг сонссон Лиза маань: “Жон, Бурхан чамд ямар нэгэн юм зааж өгөх гэж байгаа болтой” хэмээн уриалгахнаар тулгав. Ийнхүү би пастортаа уурлаж байсан бол, одоо нэмээд Лизад дургүй хүрэв!

Би Лизаг нөхрийгөө дэмжсэнгүй гэж үзээд, бушуухан зайгаа авлаа. Миний төлөвлөгөө чинь наддаа бол, ахлах сургуулийн өчнөөн хүүхдэд сайн мэдээ түгээх хамгийн аугаа төлөвлөгөө байсан юм шүү дээ. Минийхээр бол, Пастор, Лиза хоёр таг сохор амьтад! Би ганцаардаж, гонсойгоод, тайтгарахыг үл хүсэв. Бүр “Энэ бол хар дарсан зүүд, удалгүй сэрээд дахиад бүх юм хэвийн үргэлжилнэ” ч гэж бодож үзлээ. *Үнэхээр ийм юм болчихлоо гэж үү дээ?*

Тэр үед Бурхан миний зүрхэнд: “Хүү минь, би чиний залуусын пастор байсан үеийг чинь шүүхдээ, хэд хичнээн залуусыг Над руу авчирснаар чинь шүүхгүй, харин чиний дээр тавьсан Миний зарцад хэр итгэмжтэй үйлчилснээр чинь шүүнэ” хэмээн пал хийтэл хэлэв.

Энэ үг намайг дав хийтэл сэргээсэн боловч, удаах үг нь бүр ч алмайруулав: “Чи хотынхоо ахлах сургуулийн бүх сурагчийг Над дээр авчирсан байлаа ч, пастортаа *итгэмжгүй байсныхаа* төлөө хамаг ажил хөдөлмөрийнхөө шагналыг алдана.”

Намайг шууд ариун айдас нөмрөөд авав. Би газар дээрээ гэмшин, уучлал гуйгаад, дараа нь пастор руугаа яриад бас л гэмшиж, уучлал гуйв. Утсаа тавиад, хүлээж авсан ухаарлаа эргэцүүлж байтал, гэнэт эзэн надад үзэгдэл үзүүлэв. Би хорин дөрвөн удирдагчтайгаа хийх хурал дээрээ зэвхий царайлсаар орох юм. Тэгээд машид гунигтай, хүнд царай, зэвүүрсэн дуугаар: “Манайхаан, та нар үүн дээр олон сар ажилласан. Энэ манай залуусын бүлгийн алсын хараа байсан. Гэтэл тэргүүн пастор дөнгөж сая хөтөлбөрийг маань таслан зогсоолоо. Бидний хамаг хүчин зүтгэл өнгөрлөө” гэж мэдэгдэв.

Зарим нь жигшсэн байдалтай толгойгоо унжуултал, зарим нь итгэж ядсандаа нүд нь орой дээрээ гарч, ам нь ангайлаа. Бүгдээрээ цочирдож, гонсойжээ. Тэд тэргүүн пасторт уурлаж, өөрсдийгөө тэр хүний бүтээлч бус, мухар сэтгэлгээний золиос хэмээн үзэхийг тэр үзэгдлээс би мэдэв.

Бурхан намайг ингэх санаатай байна уу гэж асуулаа. Би ч: “Эзэнтэн минь, үгүй, үгүй, үгүй!” гэж хариуллаа. Бурхан миний зүрхний хандлагыг харуулсныг би ойлгов. Бурханы үзүүлсэн тэр үзэгдэл намайг бас л аавын зүрх сэтгэлтэй болоогүйг харуулсан юм. Би бүр ч гэмшив.

Хэд хоногийн дараа удирдлагын хуралдаа явж байхад, зүрхэнд маань ариун айдас давалгаалж, нүдэнд маань цог асч, хоолойд маань оч жингэнэж, хөл маань хөнгөрч, гүйхээрээ явж байлаа. Би тэдэнд: “Манайхаан, сайхан

мэдээтэй! Манай тэргүүн пастор биднийг Ишмаелшиг шатахаас хамгааллаа. Пастор бидний ажлыг манай чуулганы чиглэл биш гэж мэдэгдсэн учраас, бид хөтөлбөрөө зогсоолоо!” гэж ирээд л өөдрөгөөр зарлалаа.

Тэд ч шууд л өөдрөгөөр хүлээн авав. Зарим нь инээмсэглэж, алгаа цохилцож, бусад нь зөвшөөрснөө илтгэн уухайллаа. Би эцсийн эцэст пасторынхаа зүрхийг өвлөсөн учраас, тэд ч бас миний зүрхийг өвлөжээ.

Жилийн дараа би дахиад л хэдэн сарын турш ажилласан, чухал төсөл дээрээ шалгуулав. Энэ удаа пастор таа сайтар мэдүүлж, ажлынхаа чиглэл дээр санал нийлээд явж байтал, гурван сарын дараа пастор санаагаа өөрчилсөн юм. Ажлын чиглэлд огцом өөрчлөлт гарсанд пастор уучлал эрэв. Харин би энэ явдалд урьдынхаасаа тэс өөрөөр хандсан юм. Би эргэж буцалгүй, хэрэлдэж маргалгүй, эсэргүүцэл үзүүлэлгүй, шууд л ажлаа цуцлав. Ямар ялгаа мэдрэгдсэнийг одоо ч санаж байна: боломж нь байгаад, өөрийнхөө санааг гүйцэлдүүлэхийн оронд санал нийлэх шиг ханамж авчирдаг зүйл үгүй юм билээ.

Дахиад л удирдагч нартаа төсөл цуцлагдсаныг мэдэгдлээ - яг л би өөрөө цуцалж байгаа мэт. Бурхан манай залуусын бүлгийг ерөөж, миний ажилласан хоёр жилийн хугацаанд бүлэг маань гурав дахин өсөв.

Хэрэв би тэдгээр шалгалтдаа унасан бол, өнөөдрийн Жон болж чадахгүй байсан гэдэгтэй би итгэдэг. Юу болох байсныг ч мэдэж байна. Учир нь Ариун Сүнс надад харуулсан. Би сонголтгүй болсон учраас, хөтөлбөрөө цуцална. Гэхдээ үйлдсэн хандлага маань тархаж, удирдагчдыг хордуулах байв. Тэгээд би эцэстээ чуулганаасаа яваад, амьдралдаа байгаа бэлгээрээ цөөн тооны хүмүүст нөлөөлөх л байсан байх. Гэхдээ би хэзээ ч өнөөдрийнх шигээ даян дэлхийн сая, сая хүнд хүрдэг, үйлчлэлтэй болохгүй байсан. Яагаад? Яагаад гэвэл би хүний юмд итгэмжгүй байсан болохоор, Бурхан ч надад даалгавраа итгэмжлэхгүй байсан.

Үүнийг сурах амархан байгаагүй. Би А төрлийн хувь чанартай удирдагч хүн учраас, өөрийнхөө зөв гэж үзсэн зүйлийн төлөө үзэлцчих гээд байдаг талтай. Гэхдээ Бурхан үр дүнгээс илүү зан чанарт маань анхаардгийг би сурсан. Бурхан Лиза, бид хоёрт өөрийн гэсэн даалгаврыг маань өгөхөөсөө өмнө хөдлөшгүй, бат бэх суурь цутгахыг хүсчээ.

Хүндэт найз минь, та ч бас удирдагч. Бид Бурханы замаар явбал, Бурхан маань бүх хүүхэддээ удирдлагын боломжийг амласан байдаг. Биднийг “сүүл биш, толгой болно”, биднийг “доор биш дээр байна” гэсэн (Дэд хууль 28:13-ыг үзнэ үү). Над шиг жадат шилбүүр өөд бүү өшиглө. Надаас суралцаад, хаанчлалынхаа үүрэг хариуцлагаа ахиул.

ЭВ НЭГДЛИЙН АМЬ

Үржихийн тулд байгууллага нэгдмэл байх ёстой. Эхлэл ном дээр нүд нээсэн Бичээсийн хэсэг олон бий. Бурханлаг бус хэсэг бүлэг хүмүүс тухайн үедээ бараг л боломжгүй гэмээр нэгэн үйл хэрэг бүтээхээр зорьж, тэнгэр баганадсан, өндөр цамхаг барихаар шийджээ. Гэтэл Бурхан үүнийг нь юу гэснийг үзнэ үү:

Хараач, эд нар *нэг* үндэстэн, цөм *нэг* хэлтэй агаад энэ бол тэдний хийх юмсын эхлэл нь юм. Хойшид *тэдний хийхээр зорьсон бүхэнд боломжгүй зүйл гэж үгүй болно.* (Эхлэл 11:6)

Энд хэн үйлдэж, өгүүлж байгааг санаарай: Бурхан Өөрөө шүү. Гэтэл Түүний үгийг сонсоно уу: “тэдний хийхээр зорьсон бүхэнд боломжгүй зүйл гэж үгүй болно.” Бурхан яагаад ингэж хэлэхэд хүрэв? Яагаад гэвэл тэд “нэг” хэлтэй, нэгдмэл “нэг” байсан. Тэд эвлэн нэгдсэн байжээ. Тэд зөвшилцлөөр амьдарсан.

Аврагдаагүй хүмүүсийн талаар Бурхан Өөрөө ийн айлдсан бол, гэрээтэй хүмүүстээ бүр юу гэх бол? Түүний хүмүүс нэгдэх үед Эзэн “тэнд ерөөлийг тушаасан” (Дуулал 133:3) гэсэн. *Тушаасан* гэдэг нь “тушаах, удирдах, томилох”¹³ гэсэн утгатай. Ойлгож ядах зүйл алга - нэгдэл нь ерөөлийг дууддаг бөгөөд үүнд үржил ч багтана.

Энэ нь Шинэ гэрээний хүүхдүүдэд бүр ч хамаатай! Тиймээс ч дараах үгийг байн байн давтдаг буй за:

адил сэтгэж, адил хайртай байж, нэгдэн, *нэгэн бодолтой байж*, баярыг минь гүйцээ. (Филиппой 2:2)

Эцэст нь, ах дүү нар аа, баярлагтун. Цэгцэрцгээ. Ятгалгыг ав. *Санаа нэгтэй байж*, амар тайван амьдрагтун. Хайр ба амар тайвны Бурхан та нартай хамт байх болно. (2Коринт 13:11)

Христийн сайнмэдээнд л зохистой амьдар. Тэгвэл би ирээд, та нарыг харлаа ч эсвэл байхгүй байлаа ч та нарыг сайнмэдээний итгэлийн төлөө *нэг сэтгэлээр* хамтдаа зүтгэж, *нэг сүнс* дотор бат зогсоцгоож. (Филиппой 1:27)

Бид чуулганы *эцгүүдийн* хүсэлт гуйлтыг сонсож байна. Паул “нэгэн бодолтой бай”, “нэг санаатай бай”, “нэг сүнтэй бай” гэсэн үгс хэрэглэжээ. Тэрбээр чуулган Бурханы тушаалын төгсгөл дээрх ерөөлийг хүлээн аваасай гэж хүсчээ. Тэр цагт л тэд жинхэнэ бүх талаараа үржинэ.

Нэгдмэл хүмүүст хадгалагдсан ерөөлийн онцсайн үлгэр жишээг харж болно: Дээд өрөөнд байгаарай гэсэн Есүсийн тушаалыг итгэмжтэй дагалдагч нар дагасан (Үйлс 1:4). Есүсийг амилснаас хойшхи дөч хоногийн турш Есүс дор хаяж 500 эрчүүд, эмэгтэйчүүдэд үзэгдсэн (1Коринт 15:6) ч, зөвхөн 120 нь л Түүнийг дээш одсоноос хойш арван өдрийн хугацаанд Иерусалимд үлджээ. Бусад нь хаачив? Миний ойлгож байгаагаар тэдний 75 хувь нь Есүсийн үгийг ойшоогоогүй болтой. Тэдний хаачсаныг мэдэхгүй ч, тэд Есүсийн хүслийг хамгаас чухалчлаагүй нь тодорхой байна.

Дээд өрөөнд байсан эрчүүд, эмэгтэйчүүд Бурханы Үгийн эрх мэдэл дор нэгдсэн байв. Тэгэхээр, тэд Есүсийн чуулганыхаа эцгээр томилсон, төлөөний эрх мэдэлтэнд хэрхэн хандсан нь сонин байна.

Сайн мэдээнээс үзбэл, Петр ихэвчлэн Бурханы хүсэлтэй долгион таардаггүй, огцом зантай хүн. Петр Есүсийг амьд Бурханы Хүү - Христ хэмээн мэдэгдэхэд, Есүс Петр дээр ерөөл айлдсан. Гэх атлаа хэдхэн эгшний дараа: “Миний араас зайл, Сатан аа! Чи Надад бүдрүүлэл болж байна. Учир нь чи Бурханы юмсыг бус, харин хүмүүний юмсыг л бодож байна” (Матай 16:23) гэсэн.

Өөр нэгэн удаа Петр усан дээгүүр явж, бусдыгаа ангайлгасан байдаг. Бас л бусдыгаа тэргүүлж байна. Гэтэл хэдхэн агшны дараа живж эхэлсэн. Үүнд нь Есүс: “Өчүүхэн итгэлтэн минь ээ, чи юунд эргэлзэв?” (Матай 14:31) хэмээн халагласан.

Өөр нэгэн тохиолдол дээр Петр, Иаков, Иохан гурав Есүсийг дагаж яваад, уулан дээр хувирахыг нь үзсэн. Есүсийн царай нар луга адил цацарч, хувцас нь хүртэл хувирахыг үзсэн. Мосе, Елиа хоёр гарч ирэн, Есүстэй ярьсан. Юутай хүндэтгэл вэ! Тийм боловч, Есүсийг гурван дагалдагчтайгаа уулнаас буухаас өмнө Петр Елиа, Мосе, Есүс гуравт зориулж цацар барьж өгье гэсэн (Матай 17-г үзнэ үү). Бас л Бурханы төлөвлөгөө, зорилгоос хадуурав.

Үүнийг санангаа, Петрийн чуулганы албан ёсны удирдагчийнхаа зүгээс гаргасан, анхных нь шийдвэрийг үзье. Гэхдээ үүнээс өмнө өөр нэгэн чухал баримтыг санах ёстой: Энэ бүхэн Петр Есүсийг танихгүй хэмээн мэлзсэнээс хэдхэн өдрийн дараа л өрнөж байгаа явдал шүү. Тиймээс нэн ялангуяа Петрийн шийдвэр, чиглэлтэй

санал нийлэхгүй байгаа эрчүүд, эмэгтэйчүүдийн хувьд түүний удирдах чадварт эргэлзэх нь үндэслэлтэй л зүйл байв.

Тиймээс тайзаа засъя. Есүс дээшээ одоод хэдхэн хонож байсан бөгөөд Петр Дуулал номоос Иудагийн Есүсээс урвахтай шууд холбоотой эш үзүүлийг олжээ. Тэгээд дээд өрөөнд байсан цөөн хүмүүст: “Харгалзах үүргийг нь өөр нэгэн аваг” хэмээн уншиж өгөв (Үйлс 1:20). Петр дахиад л бусдын хараагүйг харсан боловч, зөв зүйтэй шийдвэрлэж чадах болов уу?

Одоо таны унших зүйл үндэслэлгүй санагдаж болох ч, би хэлсэн санаагаа хангалттай олон бичээсээр батална. Миний бодлоор, Петр Иудасын оронд Бурхан хэнийг сонгосныг үзэхийн тулд тэдэнтэй анхнаасаа хамт байсан бүх эрчүүдийг цуглуулаад “сугалаа явуулъя” гэдэг санал дэвшүүлэхдээ, дахиад л Бурханаас зөрүү шийдвэр гаргажээ.

Шинэ гэрээнд Бурхан элчээ сугалааны системээр сонгож байхыг үзэхгүй! Есүс элчийг яаж сонгодгийг Өөрийн биеэр үлгэрлэн харуулсан байдаг: Есүс анхны арван хоёр элчээ сонгохдоо, шөнөжин залбирч, Бурханаас үг сонссон (Лук 6:12-13). Петр ч удаах элчийг Есүстэй адил аргаар сонгосон бол, дээр байх байж.

Хэдэн жилийн дараа Антиохын чуулганы эш үзүүлэгч, багш нар Есүсийн үлгэр жишээг дагаж үйлдсэнийг санана уу. Тэд Барнаб, Саул хоёрыг элчээр тусгаарлан томилохдоо мацаг барин, залбирсан (Үйлс 13:1-4). Энэ нь Петрийн бушуу шийдвэр бас л алдаатай байсныг баталж байна.

Дээд өрөөнд байсан 120 хүн Матиас, Юүтүс гэдэг хоёр хүнийг нэр дэвшүүлээд, Матиас нь сугалаанд хожин, элч нарын тоонд багтсан ч (Үйлс 1:23-26-г үзнэ үү), түүний нэр дахиж Шинэ гэрээнд гардаггүй. Яагаад? Яагаад гэвэл Иудасын оронд Бурханы сонгосон хүн нь Матиас биш, Паул байсныг Бичээс хэлдэг юм. Тиймээс л Паул:

Тэр дараа нь Иаковт, тэгээд бүх элч нарт үзэгдсэн. Бүгдийн эцэст дутуу төрсөн мэт надад ч Тэр бас үзэгдсэн билээ. Учир нь би элч нараас хамгийн өчүүхэн нь бөгөөд Бурханы чуулганыг хавчиж байсан тул элч гэж нэрлэгдэх зохисгүй хүн юм (1Коринт 15:7-9) гэж бичжээ.

Паул өөрийнхөө талаар буруу цагт төрсөн хүн мэтээр бичжээ. Өөрөөр хэлбэл, тэрбээр анхны арван хоёр дунд багтахад хэтэрхий залуудаж. Паулын төрсөн огнооны талаар хэд хэдэн хувилбар байдгийг би судлаж мэдсэн юм. Тэдгээрийн тооцоолол нь бараг

арван дөрвөн жилийн наана цаанатай гардаг. Гэхдээ тодорхой зүйл нь Паулын төрсөн огноог хэн ч мэдэхгүй. Тиймээс түүний насыг барагцаалахын тулд Шинэ гэрээний цаглабарыг харцгаая.

Ихэвчлэн Есүсийг амилснаас дөрвөн жилийн дараа Степан итгэлээсээ болж алуулсан гэж тооцдог болохоор, Есүс анхны арван хоёр дагалдагчаа долоон жилийн өмнө сонгосон болж таарч байна. Степаныг чулуугаар нүүлгэж алах үеэр Бичээс Саул (хожмын Паул) гэдэг “залуугийн” тухай дурьддаг (Үйлс 7:58). Грек - Англи үгийн толь бичгээс үзбэл, “залуу” гэдэг үг нь дөнгөж бэлгийн бойжил нь явагдаж эхэлсэн хүнийг нэрлэдэг үг аж. Тэгэхээр дээрх долоон жилийг хасбал, Паул анхны арван хоёрт багтахад дэндүү балчирдаж байсныг баттай хэлэхээр байна.

Бурхан үнэхээр Паулыг сонгоод байсан гэдэгт би бүрэн итгэдэг. Тэрбээр Матиасаас илүү элч хүний үр жимс, эрх мэдлийг эзэмшсэн хүн байсан нь тодорхой. Хамгийн гол нь - Петр удирдлагын тал дээрээ Бурханы төлөвлөгөөтэй авцалдаагүй, огцом шийдвэр гаргасан гэж би итгэдэг. Хэрэв Петр өнөөдөр ийм шийдвэр гаргасан бол, чуулган маань: “элчийн сонгуулын сугалааг эсэргүүцэгч нарын бүлэг”, “шинэ элч сонгохыг эсэргүүцэгч нарын бүлэг”, “элчийн сугалааг дэмжигч нарын бүлэг” (энэ бүлэг нь үлдэх байсан байх) гэж гурав хуваагдах байсан байх. Тийм боловч энэ явдлын дараа юу болсныг Бичээс ингэж хэлжээ:

Пентэкостын өдөр болоход *тэд цөмөөрөө (сэтгэл нэгтэйгээр)* нэг газар цугласан байлаа. (Үйлс 2:1)

Сэтгэл нэгтэйгээр гэдэг нь *хомотумадон* гэдэг Грек үг юм. Үүнийг “нэгэн санаагаар, санал нэгтэйгээр, сэтгэл нэгтэйгээр, булаараа”¹⁴ хэмээн тодорхойлно. Энэ тодорхойлолтоос үзбэл, тэнд оюун санааны ч, зан авирын ч хагарал байгаагүй байна. Тэд нэг л зорилго, санаа, зүрх, сүнсээр нэгдсэн байжээ. Үр дүн нь? Тэр өдөр Эзэн дээр гурван мянган хүн *нэмэгдсэн!* Энэ тоог 120-иор хуваах юм бол, хорин тав нугалсан *үржил* гарна.

Ганцхан цуглаан хийгээд л чуулган нь хорин тав дахин өссөн гээд бод доо. Бурхан тэдний нэгдэл дээр ерөөлөө тушаав! Энэ бол сүнсний хууль.

Мэдээж дээд өрөөнд Петрээс өөрөөр ажиллах байсан итгэгч нар байсан л байгаа. Мэдээж шийдвэр гаргахаасаа өмнө Есүсийн үлгэр загвараар Бурханыг эрэн хайх нь дээр байсан.

Энэ асуудлыг шийдвэрлэх сайн арга олон байсан ч, үүнээс чухал

нь удирдагчийнхаа стратегийг дагаж, *нэгдмэл* байх ёстой гэдгийг дээд өрөөнд байсан хүмүүс харжээ. Тэгээд бүгдээрээ яг өөрийн санаа мэт гүйцэтгэжээ. Гэтэл бид ялихгүй, хөгийн арга барилын ялгаанаасаа болж хичнээн хагаралддаг билээ? (Удирдагчийн чинь шийдвэр Бичээсийн “нүгэл” гэдэг ангилалд багтаж байгаа тохиолдолд л бид удирдагчаа дагах ёсгүй. Арга барилын бусад алдаа нь *нүгэл* биш болохыг би танд хэлье.)

СӨРӨГ УРСГАЛ

Тийм боловч, санал зөрөх нь дан ганц үг, үйлдлээр хязгаарлагдалгүй, оюун санаа, зүрх, сүнс рүү хүртэл гүн явдгийг бид санах ёстой. Үүний санамж болгон өмнөх гурван Бичээсийг дахин харъя. Гаднаа нэгдмэл мэт атлаа сэдэл, санаагаараа хуваагдмал байж болно.

Манай ээж Флоридагийн Веро эрэг дээр аж төрдөг. Ээжийн байшингаас хойш хорь гаруй километрийн зайтай Себастьяны булан гэдэг газар бий. Нутгийнхан тэр газрыг маш хүчтэй сөрөг урсгалаар нь сайн мэднэ. Сөрөг урсгал гэдэг нь нүдэнд ил харагддаггүй байгалийн үзэгдэл. Далайн мандлын бүх ус нэг чигтээ буюу эрэг рүү давалгаалаад байгаа мэт харагдах атал мандал доорх ус нь эсрэг чигтээ хуйларч байдаг. Энэ сөрөг урсгал замдаа таарсан бүгдийг задгай далай руу хамаад явах бөгөөд заримдаа үхэлд ч хүргэнэ.

Чуулган, бизнес, сургууль, засгийн газар, спорт баг, клубт үржлийг нь үгүй хийдэг сөрөг урсгал байна уу? Яриангүй бий. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл, бид Бурханы хаанчлалыг хаанчлалын сэтгэхүйгээр бус, ардчилсан үзлээр байгуулах гэж оролддог. Бид бодитой хаанчлалын иргэд бөгөөд Хааныхаа томилсон төлөөний эрх мэдлийг үл ойшоож болохгүй. Бид удирдагч нартаа зүрхээрээ зориулагдсан цагт л Бурханы ерөөл харагддаг.

Бид өөрөөсөө *“Миний зөв байх нь чухал уу, бид нэгдмэл байх нь чухал уу?”* гэж асуух ёстой. Таны 100 хувийн зөв чинь 100 хувь буруу байж болно. Петрийн сонгосон сугалааны системийг (Бичээсийн дагуу) мацаг, залбирлаар сольё хэмээн эсэргүүцсэн бол, тэр хүмүүс 100 хувь зөв л байх байсан. Гэхдээ эв нэгдэлгүй байдлаас нь болж, Бурханы ерөөлийн цутгал татрах байсан.


Та санаж байгаа бол, чуулганы эцгүүд үйл ажиллагааны чиглэл өгсний дараа л Бичээс дээрх хамгийн анхны ер бусын үржил

тохиосон байдаг. Тэр тухайд “энэ саналыг хамаг олон дэмжсэн” (Үйлс 6:5) гэдэг. Тэгээд ямар үр дүн гарсан? “дагалдагчдын тоо үлэмж ихээр нэмэгдсээр байсан (үлэмж үржсэн) (Үйлс 6:7). Тэр саналыг байгууллагын хүн бүр яг л өөрийн санал мэт өмчилжээ. Мэдээж хүмүүс эсэргүүцэж болох байсан ч, тэд зөв байхаас ерөөгдсөн байх нь дээр гэдгийг ойлгосон байв. Тиймээс тэд тэр арга барилыг яг л өөрийн санаа мэт хүлээн авчээ.

Одоо бүгдээрээ хамгийн хэцүү асуултыг асууя: Шүүх сэнтийн өмнө хэд маань илчлэгдсэн зүйлийг үзээд цочирдож, ангайх бол? Бидний сөрөг урсгал Бурханы тушаасан ерөөлд тушаа болсныг Есүс мэлмэрэн байж харуулах болов уу? Бид хүмүүст мөнхөд нөлөөлж чадах байснаа үзээд, үржүүлэх боломжоо алдсанаа ухаараад, Түүнтэй хамт уйлах болов уу? Үй олон хүн эргэж буцаад, зөв байхын оронд нэгдмэл байхыг хүсэх л байх. Харамсалтай нь оройтжээ.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

1. Эцэг гэдэг нь хувь хүнд юмуу байгууллагад удирдлага, бойжил, соёл авчирдаг хүн бөгөөд тэрбээр захирал, пастор, жижиг бүлгийн удирдагч, хэлтсийн удирдагч, дарга, багш, дасгалжуулагч гэх мэт олон янзын байр суурьтай байна. Таны амьдралын “эцэг” хэн бэ? Ямар учраас тэр хүн таны хувьд эцэг бэ?
2. Итгэлт хүү, охин нь эцгийнхээ арга замыг үржүүлдэг. Удирдагч нарынхаа арга замыг даган дуурайх нь яагаад чухал вэ? Энэ нь алсын хараа, арга барил, барил, соёл нь хоорондоо саланги бус, холбоотой болохыг хэрхэн баталж байна?
3. Хүний юмыг үржүүлэхийн тулд өөрийгөө нөхөн үржүүлэх шаардлагатай. Та өөртэйгээ төстэй бэлэгтэй хүмүүсийг олж, сурсан цэц ухаан, арга замаа дамжуулж байна уу? Та залгамж халаагаа босгож байна уу? Хэрэв үгүй бол, үүнийг хэрхэн хийж эхлэв вэ?



*Мөн нэг талант авсан нь ирж
“Эзэн, би таныг тариалаагүй газраасаа хадаж авдаг,
цацаагүй газраасаа хураадаг хатуу хүн гэдгийг мэднэ.
Би айсан тул явж, таны талантыг газар нуучихсан.
Хар, таных энэ байна” гэв.*

— Матай 25:24-25

Үржлийн саад (I хэсэг)

Одоо Есүсийн сургаалт үлгэр дээрх залхуу нярвын сэдэл, бодлыг үзье. Яагаад нөгөө хоёр зарц нь үржүүлээд байхад, тэр ганцаараа хадгалав? Яагаад 1,2-аар зарц “итгэмжтэй, сайнаараа” сайшаалгасан байхад, тэр ганцаараа “залхуу, муугаараа” дуудуулав?

Үргэлжлүүлэхээсээ өмнө энэ үнэн дээр тогтож, тодруулъя: *Хүн Есүсийн оршихуйд зогсохдоо, худлаа хэлж чаддаггүй.* Яагаад ингэж хэлэв гэж үү? Үүнийг нэгэн хөгжилтэй жишээгээр дүрсэлье. Та мөрдөн байцаалтын үеэр тагнуулд “үнэний шидэт ус” уулгаж байж, нууцыг нь илрүүлдэг кино үзэж байсан уу? Тагнуул эсвэл давхар - тагнуул маань хэзээ ч задлахгүй хэмээн андгайлсан зүйлээ илчилж, үнэн ил болдог.

Тэгэхээр, бодит амьдрал руугаа эргэж орёе. Би гэрлээд удаагүй байхдаа, төлөвшөөгүй, өөртөө итгэлгүй хүн байв. Лиза надтай нүүрэлдэх хүртэл би тухайн үед байх л ёстой мэт санадаг юмсаа хийж л орхидог байлаа. Тэгээд ярилцах үед би өөрийнхөө үйлдэл, сэдлийг цээжээрээ хамгаална. Түүнчлэн хэлж байгаа үгийнхээ үнэнийг ч хатуу хамгаална! Хожим нь би Бурханы оршихуй дор залбирч байхдаа, Лиза миний талаар чухам үнэнийг хэлснийг ухаарч, Лиза дээр даруухнаар явж очоод, алдаагаа хүлээн зөвшөөрнө.

Гол санаа нь: Заль мэх, шударга бус явдал, хууран мэхлэл, хоёр нүүр зэрэг иймэрхүү зан авир нь Бурханы эрхмийн дээд оршихуйд зэрэгцэн оршиж чадахгүй. Есүс ч хэлсэн:

Гэвч илчлэгдэхгүй байхаар далдлагдсан, мэдэгдэхгүй байхаар нууцлагдсан юм гэж огт үгүй билээ. Иймд харанхуйд хэлсэн чинь гэрэлд сонсогдоно. Дотор өрөөнд чихэнд шивнэсэн чинь дээвэр дээр зарлагдана. (Лук 12:2-3)

Есүс онцгойлон худлаа хэлэх, залилан мэхлэх ямар ч боломжгүй шүүхийн талаар ярьжээ. Учир нь үнэн уур амьсгалыг эрхшээж, ямар ч худал юмуу зальтай үг гарах боломжгүй болно. Няrvын сургаалт үлгэр нь шүүхийг төлөөлж байгаа нь залхуу зарцын өөрийнх нь үгээр баглагдаж байна. Тэрбээр үгээрээ өөрийгөө яллаж байгаа хэдий ч, үнэнээ илчилжээ.

Тэрбээр мөнхийн үржлийг бий болгож чадаагүй нь цаанаа хоёр гол хүчин зүйлтэй:

- Тэр Эзэнийхээ зан чанарыг таниагүй.
- Тэр айсан.

Ийм дараалсан хоёр шалтгаан байна. Дандаа биш боловч, ихэвчлэн хоёр дахь шалтгаан нь эхнийхээ шалтгааныг дагалддаг. Өөрөөр хэлбэл Бурханы зан чанарыг танин мэдээгүй нь айдас төрүүлэх шалтгаан болдог. Хоёр алдааг хоёуланг нь судлах явцад энэ бүхэн илүү тодорхой болно оо.

“БИ ИНГЭЖ ИТГЭДЭГ”

Эхний алдааг нарийн судлах үүднээс нэгэн түүх хэлье. Би дөнгөж сая Хавайд конференц хийхээр найман цаг нисээд ирлээ. Зочид буудлынхаа өрөөнд орохоор аяныхаа хувцас, ачаатай хүлээж байх хойгуураа усан сангийн сүүдрэвчийн дор аятайхан суудал олж тухлав. Гэтэл манай конференцэд оролцохоор ирсэн, өөр нэгэн бизнес эрхлэгч эмэгтэй бас хүлээж байж таарчээ. Бид хоёр яриа дэлгэж, тэрбээр намайг Христэч зохиолч, үйлчлэгч гэдгийг маань мэдмэгцээ, Бурхантай тогтоосон харилцааныхаа талаар хүүрнэж гарав.

Эмэгтэйтэй ганц, хоёр үг солиход л, тэрбээр Бурханыг мэддэггүй нь мэдэгдсэн юм. Юм л бол өөрийнхөө итгэдэг зүйлийг ярих бөгөөд тэр нь Бичээсийн илчлэлтэй тун жаахан авцалдаж байв. Түүнийг өөрийнхөө итгэлийг хүүрнэх хооронд нь би Ариун Сүнсээс цэц ухаан асуутал, Ариун Сүнс надад юу хэлэхийг маань харуулав.

Эмэгтэйг үгээ дуусгамагц нь би: “Та усан сангийн цаана сууж байгаа залууг харж байна уу?” гэлээ.

Эмэгтэй: “Харж байна. Юу гэж?” гэв.

Би: “Би танд тэр хүний талаар ярьж өгье. Тэр хүн ногоон хоолтон. Амьтны гаралтай юм, тэр бүү хэл зөгийн бал ч идэхгүй. Тэрбээр Олимпод оролцох Америкийн усанд сэлэлтийн багт шалгарахыг мөрөөддөг. Тэр өдөр бүр гурван цаг бэлтгэл хийдэг. Тэр агаарын теннис, ширээний теннис, скайдайвинг, зураг зурах хоббитой. Тэрбээр тээр тэр халуун онгоцонд амарч байгаа, өөрөөсөө арваар дүү бүсгүйтэй гэрлэсэн” гэж ярилаа.

Эмэгтэй биширсэн боловч, намайг гэнэт л энэ тухай яриад унасанд яльгүй гайхсан янзтай байлаа. Тэрбээр дөнгөж сая надтай Бурханы талаарх гүн бодлоо хуваалцтал, хариуд нь би усан сангийн цаана байгаа хүний талаар яриад унажээ. Сониуч зандаа хөтлөгдсөн эмэгтэй: “Тэр залуу тантай хамт конференцэд оролцохоор ирсэн хүн юм уу?” хэмээн лавлалаа.

— “Үгүй ээ, хатагтай.”

— “Тэгвэл таны танил юм уу?” хэмээн бүр ч сонирхов.

— “Анх удаа л харж байна.”

Эмэгтэй айх, гайхах зэрэгцэн, тэр залуугийн талаар яаж ийм сайн мэдэж байгааг минь асуулаа. Яг тэгж бодсон эсэхийг мэдэхгүй ч, царайнаас нь үзбэл, эмэгтэй намайг Тагнуулын төв газар, Холбооны мөрдөх товчооны тагнуул, мөрдөгч, тэр бүү хэл - хүн шиншлэгч - гаж донтон гэж бодсон байж мэдэх ч, сониуч зандаа дийлджээ.

Би хэсэг чимээгүй болсноо эмэгтэйд: “Зүгээр л би тэр залуугийн талаар ингэж *итгэж* байна” гэж хэлэв.

Эмэгтэй нам болчихов.

Тэгэхээр нь би: “Та дөнгөж сая Бурханыг хэн болох талаар өөрийнхөө итгэлийг аягүй итгэл дүүрэн ярьсан. Гэвч Бурханы талаар хэлсэн бараг бүх зүйл чинь худлаа. Би Бурханыг мэддэг учраас хэлж байна” гэж хэллээ.

Тэгээд түүн рүү эргэн, нүд рүү нь эгц харж байгаад: “Бурханы талаар ярьж байгаа тань сая миний огт танихгүй залуугийн талаар ярьсантай яг адилхан байна. Усан сангийн цаана байгаа хүний талаарх *итгэл* маань нилээд үнэмшилтэй сонсогдож байгаа биз дээ? Гэхдээ л ихэнх нь худлаа болж таарна. Яагаад гэвэл би тэр хүнтэй танилцаж мэдэлцэх цаг гаргаагүй.”

Эмэгтэй намайг сонсож байхдаа царай нь минчийж, бие нь чичирхийлж харагдав.

“Бурхан бидэнд Үгээ өгсөн. Библийн хуудас дээр бичээстэй байгаа тэр Үг нь бидэнд Бурханыг хэн болохыг илчилдэг” хэмээн би тайвнаар ярьлаа. “Тэр бас Есүсийг илчлэхээр Ариун Сүнсээ илгээсэн бөгөөд Есүс Өөрөө махан бие дотор илчлэгдсэн Бурхан учраас, эргээд бидэнд аугаа хүчирхэг Бурханыг илчилдэг.”

Би хэсэг чимээгүй байгаад: “Та үнэндээ бодит бус, төсөөллийнхөө Бурханыг дотроо бүтээчихсэн юм шиг санагдахгүй байна уу?” хэмээн зөөлнөөр асуулаа.

Харамсалтай нь тэр эмэгтэй ч бас Бурханыг мэдэхгүйгээ хүлээн зөвшөөрөхөд бэлэн бус эсвэл Бурхантай нүүр нүүрээрээ уулзахаас айж байв. Бид хоёр дахин хэдэн минут ярилцаад, зам салсан юм.

Та энэ түүхийг уншаад “*Би Бурханыг мэднэ ээ. Би чуулганд явдаг, Библиэ уншдаг*” хэмээн инээвхийлж байгаа байх. Тийм боловч, бодолдоо тайвшрахаасаа өмнө бүгдээрээ Фарисайчуудын байдлыг санацгаая. Тэд цуглаанаа нэг ч тасалдаггүй, залбирдаг, тогтмол мацаг барьдаг, Библийн эхний таван номыг хаанаас нь л бол хаанаас нь эшлэж чаддаг байсан. (Би ч ингэж чадахгүй!) Гэтэл тэд яг өмнө нь зогсох, махан биеэр ирээд буй Бурханаа - Есүсийг таниагүй.

БУРХАНЫГ МЭДЭХ

Бурханыг мэдэх завшаан хэнд байна? Бүгдэд. Гэхдээ тогтоосон хүрээ хязгаар гэж бий. Үнэн голоосоо Бурханд амь амьдралаа өгөх шийдвэр гаргасан хүн бүрт жинхэнэ харилцааны үүд ямагт нээлттэй. Зүгээр дүр эсгэдэг бус, зохих үйлдэл хийдэг хүнд. Есүс “Хэн амиа аврахыг хүснэ, тэр түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө амиа алдана, тэр түүнийгээ олно” (Матай 16:25) гэсэн. “Аварна” гэдэг нь юу гэсэн үг юм бол? Тун энгийн: Жинхэнэ амьдрал нь *Есүсийг танин мэдэхүй* дотор л оршино.

Бид чуулганд явж, Христэд итгэдэг хүмүүсээр хүрээлүүлж, ном уншиж, магтаал сонсож, “авралын” залбирлыг давтаж, тэр бүү хэл сайн үйлс хийснээрээ Бурханыг танин мэдэхгүй. Бичээс Есүсийг Сүйт хархүү, биднийг Сүйт бүсгүй хэмээн байнга хэлдэг. Сүйт хархүү, бүсгүй хоёр нэгдэхэд, хоёр нь нэг болно. Паул “Энэ нууц нь агуу юм. Гэвч би Христ ба чуулганы тухайд ярьж байна Энэ нь Христ, чуулган хоёр нэг болохын *зураглал* юм” (Ефес 5:32) гэдэг. Түүнийг танин мэдэх гэж юу болохыг харуулахын тулд Бурхан бидэнд хүн төрөлхтний сайн мэдэх зурган номлолыг өгчээ. Түүнтэй тогтоох харилцааг *ариун гэрлэлт* хэмээх хүний амьдралын танил нэгэн үйл явдлаар төлөөлүүлжээ.

Эмэгтэй хүн цагаан дашинзтайгаа чуулганы жигүүрээр урагш алхахдаа маш чанга мэдэгдэл хийж байгаа юм. Тэрбээр дэлхийн багцаагаар 3,930,000 эр хүнд баяртай гэж буй хэрэг! Тэрбээр зүрх, сэтгэл, бие, амьдралаа тэр чигээр нь танхимын урд, тахилын ширээний өмнө

хүлээж буй залууд өгч байгаа билээ. Сонирхолтой нь түүний шийдвэр жинхэнэ "гэмшлийг" төлөөлж байгаа юм. Тэрбээр дэлхий дээрх бусад бүх эртэй гэрлэлтийн гэрээ байгуулах боломжоос зугтан, сонгосон эртэйгээ гэрээнд орж байгаа юм. Тэр эрэгтэй бүхлээрээ эмэгтэйнх бол, эмэгтэй нь бүхлээрээ эрэгтэйнх. Тэр хоёр цаашид хэн хэнээс илүү бие биеэ танин мэдэж, улам гүнзгийрэх адал явдалд гарч байгаа билээ.

Одоо миний хэлэх зүйл танд эргэлзээ төрүүлж болох ч, намайг сонс! Бурханыг *танин мэдэхэд* хүний бүтээн бий болгосон нэгэн том саад нь "нүгэлтний залбиралтай" танилцах явдал гэдэгт би л хувьдаа итгэдэг. Бид нэг иймэрхүү дүр төрх бүхий уламжлалтай: Бид Бурхантай тогтоох харилцааг яг л хэрэглэгч нарт эд бараа зарах мэт арилждаг. Итгэлийн номлолын дараа бид: "Та нар Бурханыг мэдмээр байна уу? Та нар Бүтээгчтэйгээ харилцаа тогтоомоор байна уу? Тэгвэл энэ залбирлыг хэл: Есүс, миний амьдралд ирээч. Би нүглээ гэмшиж байна. Би Таныг Аврагчаа болгож байна. Намайг уучилж, Бурханы хүүхэд болгосонд баярлалаа" л гэдэг.

Дараа нь бид тэнд байгаа хүмүүст баярт мэдээ дуулгаж, шинээр итгэсэн хүмүүсийг ийнхүү Бурхантай хамт мөнхөд байхаа баталгаажууллаа хэмээн тэмдэглэж, нөхөрлөлдөө урина. Тийм боловч, бид гэмшлийн талаар юу ч хэлэхгүй - хүмүүсийг амиа бодсон амьдралаа бүр мөсөн хаяж, Есүсийн төлөө амьдралаа бүрэн зориулах хэрэгцээний талаар дурьдах ч үгүй. Тийм боловч, Есүсийн бүрэн мэдэгдлийг сонсоно уу:

Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа авч Намайг дага. Хэн амиа аврахыг хүснэ, тэр түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө амиа алдана, тэр түүнийгээ олно. (Матай 16:24-25)

Бид Бурхантай жинхэнэ, амьд харилцаа тогтоосон цагтаа л Бурханыг жинхэнээсээ мэднэ. Үүнийг л дээрх эшлэлд Есүс хураангуйлан хэлжээ. Бурханыг танин мэдэх нь ганц удаагийн явдал бус, харин өөрийнхөө зөв зүйтэй гэж үзсэн зүйлээсээ дээгүүр Бурханы замд захирагдах хатуу шийдвэр. Энэ бол өдөр бүр, агшин бүр гаргах шийдвэр юм. Бурханы Үг тодорхой хэлсэн байхад, дагахгүй байх арга чарга хайж, найрч, маргах ёсгүй. Есүсийг дагана гэдэг нь Түүнийг гомдоох зүйлсээс зайлж, Түүнд насан турш үйлчлэх зүрхний шийдвэр болой.

Элч Иаков “Гэхдээ өөрсдийгөө хуурдаг зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид байг” (Иаков 1:22) хэмээн бичжээ. Бурханы Үгийг сонсдог ч, бодол, үг, үйлдлээрээ хариу үйлддэггүй хүн өөрийгөө л хуурч буй хэрэг аж. Пэйшн Транслэйшн дээр “өөрийгөө мэхлэх” гэдэг бөгөөд энэ үг нь гурав дахь зарц, Фарисай, Хавайн усан сангийн дэргэд уулзсан эмэгтэй зэрэг чуулганд явдаг, Бичээсээс эшлэж мэддэг, өөрийгөө Бурхантай харилцаатай гэдэг ч, Бурханы Үгээс зөрж ярьдаг, зөрж амьдардаг олон хүнийг онож дүрсэлж байна. Тэд тун буруу явна. Энэ нь өөрийгөө мэхлэх явдал юм.

Би маш чухал нэгэн санаа хэлье. Лиза гэрлэлтийнхээ амьдралд хар мянган алдаа гаргаснаа ярьдаг ч, хэзээ ч амин хувийнхаа төлөө гэрлэлтээ золиосолж байгаагүй юм шүү (Би бүр ч олон алдсан. Гэхдээ энд сүйт бүсгүйн талаар ярьж байгааг минь ойлгоорой). Лизагийн зан авир мэдээж төгс байгаагүй ч, зүрх нь хэзээ ч урваж шарвалгүй, үнэнч байсан.

Үүнтэй адил бид Бурханд үе үе дуулгаваргүй авирладаг ч, Бурхан биднийг уучилдаг. Энэ нь нөхөр, эхнэр хоёр алдаа гаргахдаа, гэрлэлтийн гэрээгээ зөрчдөггүйтэй л адил юм. Бүтээгчтэйгээ тогтоосон харилцаа маань зохих, ёсны жинхэнэ үйлдэлгүй, ам дагуулсан үйлчлэл бус, зүрхэн дэхь цэвэр үнэнч байдал болой.

Есүс хамгийн содон мэдэгдэл хийсэн байдаг: “Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсвэл тэрээр... мэднэ” (Иохан 7:17). Энэ нь бид худлаа сонсоод өнгөрөх бус, харин үйлдэж амьдрахыг үнэн голоосоо хүсэх үед бидний гүний гүнээс эхэлнэ. Бид Түүний айлдсан *бүхнийг* үйлдэх юм бол, *мэдэх* л *болно*. Бид Бурханыг болоод Түүний үгийг таньж, *мэддэг* болно. Пэйшн Транслэйшн дээр Иохан 7:17-г маш сайхнаар хэлдэг: Эхлээд Бурханы хүслийг үйлдэхийг улайран хүсбэл, тэр цагт та нар сургаал маань Бурханы зүрхнээс гарсан эсхийг ялгаж таних чадвартай болно.”

Талантын сургаалт үлгэр дээр гурван нярав гурвуулаа эзнийгээ явахаас өмнө яг адилхан заавар хүлээн авдаг. Хоёр нь эзнийхээ зааврыг ёсчлон гүйцэтгэсэн бол, нэг нь хөдлөөгүй. Гурав дахь нярав нь эзнээ үнэнээсээ мэдэхгүй байсан нь санаандгүй давхцал биш бөгөөд иймээс ч тэрбээр зааварт нь хөнгөн хуумгай ханджээ. Тэр нярав өөрийгөө мэхэлжээ.

АРИУН ЭМЭЭХҮЙ

Үүнийг Библи *Эзэнээс эмээхүй* гэдэг. Нэн ялангуяа өнөөдөр шиг ийм

их айдас хүйдэстэй энэ цаг үед бид энэ мэдэгдлээс дөлдөг. Тийм боловч эсрэг тэсрэг *хоёр төрлийн айдас* байдгийг мэдээрэй. Нэг нь “айдсын сүнс” бол, нөгөө нь “Эзэнээс эмээхүйн сүнс”. Бичээс энэ хоёрыг ялгаж үздэг. Мосе Бурханы оршихуйгаас ухарсан Бурханы хүмүүст:

Мосе ард түмэнд —*Бүү ай*. Учир нь Бурхан та нарыг зөвхөн шалгахын тулд ирсэн. Мөн Түүнээс эмээхүй нь та нарт байж та нарыг нүгэл бүү үйлдээсэй гэсэндээ ирсэн юм гэв. Бурханы байгаа түнэр харанхуйд Мосег *ойртон очих үед* ард түмэн *хол зогсож* байв. (Гэтлэл 20:20-21)

Анх харахад, Мосе өөрөө өөрийнхөө үгийг няцаах мэт. Тиймээс би түүний үгийг тодорхой тайлбарлаж өгье: “*Бүү ай*. Учир нь Бурхан... Түүнээс эмээхүй нь та нарт байгаа эсэхийг шалгахын тулд ирсэн.” Энэ мэдэгдэл нь няцаалт гэхээсээ илүү “Бурханаас айх”, “Эзэнээс эмээхийг” ялгасан явдал юм. Энэ хоёр нь ялгаатай. Нуух юмтай хүн л Бурханаас айдаг. Адам Бурханы эсрэг нүгэл үйлдчихээд, Эзэний оршихуйгаас нуугдаж байсныг санаж байна уу? (Эхлэл 3:8) Нөгөөтэйгүүр, Бурханаас эмээдэг хүнд нуух юм байхгүй. Тэрбээр үнэндээ Бурханаас холдохоос айдаг.

Тиймээс гол санаагаа шууд л хэлье: *Эзэнээс эмээхүй нь Бурханаас айх явдал биш юм*. Бид айдаг хүнтэйгээ яаж дотносох билээ? Жинхэнэ айдас нь Бурханаас холдохоос ухаан алдталаа айх явдал гэдгийг өмнө хэлсэн. Та Түүний оршихуй, халамж, хайраас өөр хаа ч байхыг хүсэхгүй. Нөхцөл байдлаас үл хамааран, юмс хэцүүдэж байсан ч, Бурханы дэргэдээс илүү дээр газар үгүйг та баттай мэднэ. Үүнийг Бурханд дуулгавартай байх байдал чинь гэрчилнэ.

Бурханаас эмээхүй нь өөр хэнээс ч, юунаас ч илүү Бурханыг дээдэлж, хүндэтгэж, эрхэмлэж, өргөмжлөх явдал юм. Түүнийг хамгаас өндөр өргөж, зүрхнийх нь хүслийг өөрийнхөө хүслээс дээгүүр үнэлж, эрхэмлэн өвлөж авах явдал юм. Бид Түүний хайрладгийг хайрлаж, үзэн яддагийг нь үзэн ядна. Түүнд чухал нь бидэнд чухал болж, Түүнд чухал биш нь бидэнд чухал биш байна.

Энэ хандлага биднийг Түүний ойрын хүрээнд нэвтрүүлнэ. Израилийн хүүхдүүдийг үзэх юм бол, тэд Бурханаа болзолтойгоор хайрлаж байжээ. Таатай нөхцөлд Бурханаа хайрлаж, дагаж, хүндэтгэсэн. Таагүй нөхцөлд гомдоллон гонгинолдсон. Тэд Бурхандаа ямар ч татлаа түтлээгүй, бүрэн итгэхийн оронд харан

байж итгэсэн. Тэд Есүсийн “амиа аврахын төлөө үйлдээрэй” гэсэн үгийг нь эсэргүүцэж, Бурхантайгаа тогтоох жинхэнэ харилцааны алдрыг нь уландаа гишгэсэн. Мосе Бурханаас эмээсэн бол, тэд эмээгээгүй.

Дор бүрнээ сэдлийнхээ дагуу л үйлдсэн - хүмүүс *холхон зогссон* бол, Мосе Бурханы оршихуй руу *ойртсон*. Тэд юу нь дээр болохыг харах нүдгүй байсан. Гэтэл Мосе тодорхой харсан. Мосе Бурханыг - Түүний үгийг, замыг, цэц ухааныг мэдсэн. Гэтэл хүмүүс Бурханыг залбиралд нь хариулдаг Бурхан гэдгээр нь л мэддэг байв.

Бид утгагүй санагдаж байсан ч, ашиггүй санагдаж байсан ч, тэр бүү хэл бидэнд хор хохиролтой санагдаж байсан ч, Эзэнийг үг дуугүй дагахдаа, Эзэнээс эмээхүйг биелүүлдэг. Бид Бурханыхаа зан чанарыг мэддэг учраас, итгэл төгс байдаг. Зарим зүйл гаднаасаа хор хөнөөлтэй харагдаж байсан ч, Бурханыг дагаж байхад хэзээ ч хор хөнөөл тохиохгүй.

Эзэнээс эмээхүй дотор алхаж байгаа хүн Түүнийг эцэс хүртэл дагадаг. Бурхан Абрахамаас хорин таван жил хүлээн байж төрүүлсэн, хэнээс ч, юунаас ч нандин, ганц хүү Исаакаа Өөрт нь өргө гэхэд, Абрахам зүгээр л биелүүлсэн. Тэрбээр Бурханы тушаалыг биелүүлэхийн тулд өглөө эртлэн гараад, гурав хоногийн газар аялсан. Бурхан Абрахамд “учрыг” нь хэлээгүй бөгөөд энэ тахил Абрахамын амьдралд зүгээр л цэг тавих мэт харагдаж байв. Өөрөөр хэлбэл, хор хөнөөлтэй харагдаж байв. Гэвч Абрахам зүгээр л Бурханы *зан чанарт* итгэсэн (Абрахам залхуу нярваас эсрэгээр үйлджээ).

Абрахам хутгаа далайгаад, Исаакийг дүрэх гэтэл, Эзэний тэнгэрэлч түүнийг хориод: “Хөвгүүний эсрэг гар бүү далай! Түүнд юу ч бүү хий! Учир нь чи хүүгээ, цорын ганц хүүгээ Надаас харамлаагүй тул чамайг *Бурханаас эмээдгийг* чинь одоо Би мэдлээ” (Эхлэл 22:12) хэмээн мэдэгджээ. Эзэнээс үнэхээрийн эмээдэг хүний зүрх ийм л хайр, итгэлцэл, итгэлтэй байдаг.

Бидэнд “ЭЗЭНээс эмээхүй нь мэдлэгийн эхэн юм. Мэргэн ухаан хийгээд сургамжийг Мунхгууд л үл тоомсорлодог ажээ” (Сургаалт үгс 1:7) гэсэн. Ямар мэдлэг? Хариултыг нь удахгүй хэлнэ. Гэхдээ эхлээд энэ хариултад хүргэсэн хүчин зүйлийг шалгая - Абрахамтай адил Бурханы Үгийг бүхнээс дээгүүр өргөх:

Хүү минь, үгсийг минь хүлээн авч,
Тушаалуудыг минь дотроо нандигнаваас,

Мэргэн ухаанд чих тавьж,
 Ухаан бодролд зүрхээ зүглүүлвээс,
 Ухаарлыг чи чангаар дуудаж,
 Ухаарал ойлголтын төлөө дуугаа өндөрсгөвөөс,
 Цалин цагаан мөнгө мэт үүнийг эрж,
 Нууц эрдэнэ мэт түүнийг хайваас
 ЭЗЭНээс эмээхүйг чи ойлгоно
Бурханы мэдлэгийг олж авна.
 (Сургаалт үгс 2:1-5)

Хариулт нь тун тодорхой байна: Эзэнээс эмээхүй нь *Бурханы мэдлэгийн эхлэл*. Өнөөдөр үүнийг жаахан өөрөөр хэлэх байх. “Та нар Эзэнээс эмээхүйг ойлгож, Бурханыг дотно танин мэдэж эхэлнэ” гэх байх. Эдүгээ бид залхуу нярвын үндсэн алдааг ойлголоо. Тэрбээр ариун эмээхүйгээр дугааж байсан нь түүний үйлдэлгүй байдал, эцсийн мэдэгдлээс харагдана. Израиль үе үе Бурханыг дарангуйлагч гэж үзэж байсан шиг мөнөөх нярав ч эзнийгээ үүнчлэн үзсэн. Тэрбээр эзнийхээ зан чанарыг харах нүдгүй байжээ.

Ариун эмээхүй нь Эзэнийг танин мэдэх гарааны цэг ажээ. Магтаалч үүнийг “ЭЗЭНий андлал Өөрөөс нь эмээгчидтэй хамт байдаг. Тэр тэдэнд гэрээгээ мэдүүлнэ” (Дуулал 25:14) гэдэг мэдэгдлээр баталдаг. Нөхөд нь *дотно* мэддэг хүмүүс юм. Есүс “Та нар тушаасныг минь үйлдвээс Миний (*дотно*) нөхөд мөн” (Иохан 15:14) хэмээн зог тустал хэлсэн байдаг.

Олон хүн Есүст алдартай кино жүжигчин, тамирчин, олны танил хүнд хайртай дуртай гэж хэлж байгаа юм шиг л “хайртай” гэдэг. 2020 оны эхээр Кобе Браинт, охин Жианнатайгаа нисдэг тэргийн ослоор амь үрэгдэхэд, улс даяараа гашуудан уйлсан. Кобегийн сагсан бөмбөг тоглодог байсан Лос Анжелес дэхь Стэйплес Төвийн гадаа хүмүүс бөөн бөөн бөмбөлөг, ил захидал, цэцэг өргөсөн. Би ч бас энэ эмгэнэлд гашуудаж, ихийг эргэцүүлэн бодсон.

Гэхдээ бидний дийлэнх маань Кобег түүний гэргий, гэр бүл, дотно нөхөд шиг мэдэхгүй. Кобе бидэнтэй гудманд таарсан бол, хэн гэдгийг маань мэдэх ч үгүй. Би лав түүнтэй цаг өнгөрөөж үзээгүй. Гэхдээ л таньдаг мэддэг хүн шигээ л хойноос нь гашуудсан. Кобе амьд ахуйдаа намайг таньдаггүй байсан шиг чуулганд явдаг, Есүсийн тухай олон нийтийн сүлжээгээр ярьдаг, Түүний тухай хөгжим сонсдог, Түүний нэрээр үйлс бүтээдэг, тэр бүү хэл Түүнийг Эзэнээ хэмээн мэдэгддэг болохоороо Есүсийг танина мэднэ гэж

мэдэгдэх үй олон эрчүүд, эмэгтэйчүүд байх болно. Гэхдээ Есүс тэдэнд “Би та нарыг танихгүй” гэж хэлнэ. Яагаад гэвэл:

Намайг “Эзэн минь, Эзэн минь” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Эцэгийн минь хүслийг үйлдэгч нь л орно. Тэр өдөр Надад олноороо “Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшгийг үйлдэж байсан бус уу?” гэх болно. Тэгэхэд нь Би тэдэнд “Би та нарыг танихгүй. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” гэж хэлнэ. (Матай 7:21-23)

Бид Эзэнээсээ ийм үг сонсохыг ёстой хүсэхгүй. Та энэ Бичээсийн хэсгийг нарийн үзэх юм бол, дээрх хүмүүс Есүстэй тогтоосон харилцаандаа итгэлтэй - тэр бүү хэл сэтгэл зүрхээ өгсөн байжээ. Кобе надад: “Та хаанахын хэн бэ?” гэж хэлэх байсан. Яг үүнтэй адилхан Есүс Өөрийг нь таньдаг мэддэг гэх тэр олон хүнд “Би та нарыг хаанахын хэн болохыг чинь мэдэхгүй” (Лук 13:25) гэнэ.

ТҮҮНТЭЙ ЦАГ ГАРГАН НӨХӨРЛӨ

Эзэнээс эмээхүй нь Түүнийг дотно танин мэдэхүйн эхлэл цэг боловч, заавал эхлэл цэг дээрээ л буудаллаад байх хэрэг байна уу? Эзэн таныг өөр рүүгээ ойртохыг дуудаж байгаа учраас, Түүн рүү улам ойрт. Бидэнд “Бурханд ойртогун. Тэгвэл Тэр та нарт ойртоно” (Иаков 4:8) гэж хэлсэн. Түүнтэй ямар төвшний харилцаа тогтоохыг Есүс бус, бид мэддэг нь гайхмаар бус уу?

Яагаад өөрийгөө итгэгч гэдэг үй олон хүн миний Хавайд усан сангийн дэргэд таарсан эмэгтэйгээс ялгаагүй байдаг нь гайхмаар. Тэд “Бурханы мэдлэгээ” олон нийтийн сүлжээ, хүндэтгэлийн хөгжим, блог, найз нөхдийн харилцан яриа, долоо хоногт ганц удаа Түүний талаар ярих пасторын номлолоос олж авна. Гэхдээ Түүнтэй хувьчлан уулздаггүй.

Арван таваас хорин таван насны хүмүүс долоо хоногт дунджаар 53.7 цаг ухаалаг утас, таблет, компьютер, зурагын дэлгэц дээрээ өнгөрөөдөг гэсэн сүүлийн үеийн судалгаа бий.¹⁵ Тэгвэл бид Бурханы Үг дээр хэдэн цагийг өнгөөдөг бол? Энэ асуулт дан ганц залуу хүмүүст хамаатай биш шүү!

Би Библиэ дөчөөд жил уншиж байгаа ч, хийх хамгийн дуртай

зүйл маань хэвээрээ л байна. Уншихаасаа өмнө би ямагт Ариун Сүнснээс надад Есүсийг цоо шинээр илчиж өгөхийг гуйдаг. Би олон жил өглөө эрт сэрээд, доод өрөөндөө эсвэл эзгүй газар эсвэл зочид буудлынхаа өрөөнд зүгээр л уншиж, залбирч, сонсож байна. Эзэнээс авсан авьяас бэлгийнхээ хүчээр дэлхийгээр нэг сайн мэдээ номлочихоод, Эзэнийг Өөрийг нь танихгүй явахыг би хүсэхгүй.


Бурхан тантай дотно нөхөрлөхийг хүснэ. Түүний төгс хайр эмээхүйг төрүүлдэг. Гэтэл бид эзнийхээ сайн сайхан зан чанарыг харах нүдгүй байсан нярав шиг авирлах маань олонтаа. Тиймээс л би таныг ариун эмээхүйгээрээ дүүргэж өгөхийг Бурханаас гуйхыг ятгаж байна. Дараа нь Түүнтэй хувьчлан нөхөрлөх цаг гаргаж, Түүнийг үнэндээ хэн болохыг нь танин мэд. Бурхан бол Хайр.

Бид Бурханыг мэдээ ч үгүй байхад, Бурхан биднийг олж авсан, хайрласан, бидний төлөө үхсэн. Энэ ер бусын харилцааг Бурхан л эхлүүлсэн. Тэр таны төлөө. Тэр таныг дотно таньж мэдэхийг хүсдэг. Гэхдээ дэндүү хайртай учраас, албадлагаар нөхөрлөхийг хүсдэггүй.

Тиймээс одоо сонго! Амийг сонго! Түүнийг дотно мэдэхийг сонго.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

1. Айдас нь Бурханы зан чанарыг мэдэхгүй байхаас үүдэлтэй. Бурханы мөн чанарын талаарх буруу үзэл бодол чинь таны бэлэг, дуудлагаа захиран зарцуулах арга замд нөлөөлсөн үү?
2. Та өөрийгөө Бурханд бүрэн өргөж, Үгэнд нь орж амьдрах үед Бурхантай жинхэнэ харилцаа тогтоох боломжтой болно. Бурхантай тогтоох харилцаанд чинь саад болж байгаа үзэл бодол, зан үйлдэл танд бий юу?
3. *Бурханаас айх, Эзэнээс эмээхүй* хоёр нь том ялгаатай. Тэр ялгаа нь юу вэ? Бурханыг дотно мэдэхэд яагаад Эзэнээс эмээхүй амин чухал вэ?



*“Эзэн, би таныг тариалаагүй газраасаа хадаж авдаг,
цацаагүй газраасаа хураадаг хатуу хүн гэдгийг мэднэ.
Би айсан тул явж, таны талантыг газар нуучихсан.
Хар, таных энэ байна.”*

— Матай 25:24-25

Үржлийн саад (II хэсэг)

Одоо бүгдээрээ залхуу зарцын хоёр дахь үгийг буюу “Би айсан” гэдэг үгийг судлая. Түүнийг айдас хөшөөжээ. Гурав дахь зарцын үгийг Мессеж Библи их гоё орчуулсан байдаг: “Би таны өндөр жишгийг мэднэ... Та шилдгийг шаардаж, алдаа гаргахыг зөвшөөрдөггүй.”

Энэ үг надад нэг түүхийг санагдуулж байна. Би хоёр дасгалжуулагчийн дор сагсан бөмбөг тоглодог байлаа. Гурван онооны шидэлт нь миний спортын цөөхөн чадварын нэг байсан болохоор би аль, аль багтаа довтлон хамгаалагчаар тоглодог байв.

Эхний дасгалжуулагч маань урамшуулал, заавраараа ур чадварыг маань тултал гаргадаг хүн байв. Тэр хүн миний эсрэг бус, миний төлөө гэдгийг би мэддэг байлаа. Тэгээд заалны хаанаас л бол хаанаас шиднэ. Дасгалжуулагчийн маань надад итгэх итгэл намайг өөртөө итгэх итгэлээр цэнэглэдэг байв.

Гэтэл удаах дасгалжуулагч маань тэс өөр хүн байлаа. Тэрбээр өөрийнх нь хэлдгээр “өндөр жишигтэй бөгөөд алдаа гаргахыг үл зөвшөөрөгч” хүн байв. Шидээд, алдах юм бол, дараагийн завсарлагаар хатуу донгодоод, ер нь бол төдөлгүй сэлгээний сандалд суулгана. Тэр дасгалжуулагчийн дор би олигтой шидэж чадахгүй. Түүнийг эзгүй хойгуур би бие дааж бэлтгэл хийж байхдаа, хаанаас л бол хаанаас харвана. Би нөгөө л авьяастай, нөгөө л тоглогч хэвээрээ байсан ч, дасгалжуулагчийнхаа дэргэд ерөөсөө шидэж чадахгүй.

Бичээс дээрх зарцын үгийг үзбэл, тэрбээр эзнийхээ талаар яг л дасгалжуулагчийнхаа талаарх миний бодолтой адил бодолтой

байна. Гэхдээ нэг том ялгаа бий: *Бодит байдал* дээр зарцын эзэн нь миний хоёр дахь дасгалжуулагчаас тэнгэр, газар шиг ялгаатай.

Тиймээс л Бурханыг таньж мэдэх нь амин чухал болохыг дахин дахин хэлье. Бурхан залхуу зарцын *бодсонтой* огт адилгүй. Бурхан бидний төлөө байдаг, бидэнд итгэдэг бөгөөд бидэнд итгэл дүүрэн байдаг. Бурханыг ингэж харахгүй бол, амархан айдаст олзлуулж, бэлэг маань ч булшлагдана.

Үүнийг хэлсэн болохоор, одоо бүгдээрээ үр жимсгүй байдалд хүргэдэг тэс өөр үндэс рүү эргэе. Өмнөх бүлэгт хэлсэнчлэн, Бурханыг мэддэг боловч, айдастай тэмцэлддэг, тэр бүү хэл олзлуулдаг хүмүүс байна аа. Үүний шалтгааныг Бичээс хэлсэн бөгөөд бүгдээрээ бүлгээ дуусан дуустал энэ талаар л ярья. Гэхдээ эхлэхээсээ өмнө айдастай холбоотой, хэдэн мэргэн үгийг үзье:

Хүн айдсаас биш, амьдарч эхлэхгүй байхаас айж явах ёстой.

— Маркус Аурелиус

Шинэ зүйл оролдож үзэхээсээ хэзээ ч бүү ай. Сайн дурынхан хөвдөг авдар барьсан бол, мэргэжлийнхэн *Титаникийг* барьсныг бүү март.

— Нэргүй

Хүний гаргадаг хамгийн том алдаа нь алдаа гаргахаас байнга айж амьдрах явдал юм.

— Жон Си. Максвел

Хүний хамгийн том нээлт, хамгийн том гайхамшиг нь хийж чадахгүй хэмээн айж явсан зүйлээ хийгээд чадчих явдал юм.

— Хенри Форд

Тэгэхээр, яриагаа хөдлөшгүй үнэний мэдэгдлээр эхэлье: *Эрүүл бус айдсын эсрэг зүйл нь Бурханы хайр болой.* Бид Бурханыг болоод хүмүүсийг болзолгүй хайрлахад айдас устдаг. Элч Иоханы хэлсэн шиг “Хайр дор айдас үгүй (Төгс хайр бүх айдсыг хөөдөг)” (1Иохан 4:18).

Энэ үнэний тал дээр - би Сан Диегод байхдаа Ариун Сүнстэй хийсэн, нүд нээсэн учралаа хэзээ ч мартахгүй. Би дөнгөж цуглаанаа дуусгачихаад, өрөөндөө ганцаараа байж байтал, гэнэт хөвгүүдийнхээ талаар айж эхэлсэн юм. Би Бурханд үйлчилдэг

олон хүний хүүхдүүд цахилгаанд цохиулах, машины осолд орох, хар тамхинд хордох, усанд осолдох гэх зэрэг золгүй тохиолдлоор амиа алдсан тухай сонсож явсан бөгөөд саяхан бас нэгэн эмгэнэлт явдлыг сонсоод, хамаг биеийг маань шиншлэх айдсыг үргээх гэж тэмцэлдэж байв. Гэтэл гэнэт зүрхэндээ: “Хүү минь, айдас бол заалтууртай л адил. Айдас чиний Надад даатгаагүй, өөрөө эзэн сууж байгаа амьдралын чинь талыг заадаг” гэж сонсов.

Энэ үг намайг ухаан оруулав. Би өөрөө аваад явж чадахгүй зүйлээ шийдэх гэж оролдож байгаагаа ухаарлаа. Энэ гэгээрлийн дараа би өрөөндөө: “Аав аа, энэ хөвгүүд минийх биш. Би зүгээр л Таны өмчийн л нярав. Тиймээс тэдний амьдралд Таны хүсч буй бүхнийг би ч бас хөвгүүдийнхээ амьдралд хүсч байна. Та тэднийг дэлхийн нөгөө өнцөг рүү бас цаг нь болохоор тэнгэр рүү авч явахыг хүсбэл, тааллаараа үйлдэх болтугай. Харин тэд энэ дэлхий дээр бүтээхээр ирсэн зорилгоо бүрэн биелүүлээд явахыг би Танаас хатуу гуйж байна” хэмээн чангаар хашхирсан юм.

Тэгээд дараа нь бүр ч чангаар: “Гэхдээ диавол чи, Есүсийн нэрээр миний хөвгүүдэд гар хүрэхгүй! Тэд бол Бурханых гэдгийг би тунхаглаж байна. Бурханы өмчийг чи алахгүй, хулгайлахгүй, устгахгүй!” гэж хашхирлаа.

Үүний дараа зүрх минь амар тайвнаар хальж, тэр цагаас хойш би хөвгүүдийнхээ талаар дахиж хэзээ ч зовниогүй билээ. Зовнил дахин гулсаж орж ирэх гэвэл, би: “Би Сан Диегод байхдаа хөвгүүдээ Бурханд даатгасан. Тиймээс буцааж авахгүй” гэж хатуу хэлдэг. Тэгэх бүрий айдас тэр даруй дальдчин үргэж, амар тайван эргэж ирдэг.

Айдас бол маш муу эзэн. Сэм гэтэн, лавширсаар, нэгэнт тогтоод авбал, даагдахаа болино. Нэг мөр шийдвэрлэхгүй л бол, хувь тавиланг чинь эргүүлнэ. Гэхдээ хамгийн сайхан нь: Айдсыг ялж болно. Гэхдээ гагцхүү зөв зүйтэй аргаар.

БЭЛЭГТЭЭ АНХААР

Паул “сүнсний хүү” Тимотдоо хоёр захидал бичжээ. Аль, аль дээр нь Тимотыг бэлгээ (карисмагаа) ажиллагаагүй, сул байлгаж байгаа талаар өгүүлдэг. Гэхдээ эхлээд нэг зүйлийг хэлье: Тимот бурханлаг эр хүн байсан. Паул захидлынхаа турш Тимотын зан чанар, жинхэнэ итгэлийн баталгааг сайшаасан байдаг. Тимот Бурханыг мэдэхгүй айдасдаа хүлэгддэг хүмүүсийн нэг яав ч биш. Паул эхнийхээ захидалд “чамд соёрхогдсон бэлгийг бүү үл хайхар” (1Тимот 4:14) гэсэн.

Үл хайхрахыг Грекээр *амелео* гэдэг. Нэг тодорхойлолт нь “үл тоох юмуу хөнгөн хандах”¹⁶ гэсэн утгатай. Өөр нэг эх бичиг дээр энэ үгийг “тухай бодохгүй байх - тиймээс зохистой хариу үйлдэхгүй байх - “анхаарлаа хандуулахгүй байх”¹⁷ хэмээн тодорхойлдог.

Тимот юмуу бид яагаад Бурханы өгсөн бэлэгт анхааралгүй, үл тоож, тэр бүү хэл тэр талаар боддог ч үгүй вэ? Нэгэн шалтгаан нь магадгүй:

*Бидний санаснаар ажиллахгүй юмуу
үр дүн гаргахгүй байгаа учраас тэр байх.*

Тэгээд “би хичээсэн боловч, юу ч бүтээгүй” гэдэг. Би 20-30 насандаа ийм бодолд их өдөөгддөг байлаа. Нэг удаа миний номлолын үеэр Лиза, найзтайгаа нам унтчихсан тухай би бичсэн. Тэр үед: *Дотны хүмүүс маань л сэрүүн байж дийлэхгүй байхад, өөр хүмүүс юу гэж намайг сонсох билээ?* гэсэн бодол байнга орж ирнэ.

Яг тэр үеэр манай нэг найз, бид хоёр Хүүхдийн цуглаанд номлосон нь миний бүтэлгүйтэх айдас дээр тос нэмэв. Найзын маань ангид хоёр зуун хүн зогсоогоороо сонсдог байсан бол, яг нэгэн зэрэг миний ангид дунджаар хориод л хүн оролцдог байлаа. Нэг удаа бүр ганцхан хүнтэй ч зааж байв!

Надад бэлэгтээ эргэлзэх үй түмэн тохиолдол байсан. Хэрэв би биелээгүй хүсэн хүлээлэг, хараажийн бүтэлгүйтэлдээ буугаад өгсөн бол, үйлчлэхээ больж, тэс өөр зам хөөсөөр, эцэстээ амьдралынхаа дуудлагыг хаясан учраас, золгүйгээр төгсөх байсныг эдүгээ би ойлгодог юм.

Бурханы өгсөн бэлгийг анхаарахгүй, үл тооход хүргэдэг өөр нэгэн шалтгаан нь:

Бусдын шүүмжлэл.

Миний анхны номын эх бичмэлийг хянан тохиолдуулсан эхний хүн, эхний хэвлэлийн газар номыг маань үл хэрэгсэж, шүүмжилж, няцаахад, би сэтгэлээр навс унаж, бүхнийг хаямаар санагдсан нь тодорхой. Номоо бие дааж хэвлүүлсэн хойно ч нэг нөхөр маань миний бичих хэв маягийг хуга мялаав. Тэр үгийн дараа орой нь би том өрөөнийхөө шалан дээр хорь, гучин минут тааз гөлрөн хэвтэхдээ, хэнд ч хэрэггүй мэт санагдаж билээ. Би амьдралынхаа бүтэн нэг жилийг бас баахан мөнгө дэмий үрчихэв үү?! Эхлээд хянан тохиолдуулагч, хэвлэлийн газар, одоо найзууд маань - бүгд шүүмжиллээ. *Жон минь, сэрж үз! Ном чинь ч муу, чи өөрөө ч бүтэлгүйтсэн гэдгээ хүлээн зөвшөөр!* гэж л бодогдоно.

Би эдгээр бодол, үгсд ялагдсан бол мөн л дампуурсан мэт харагдаж байсан, хоёр дахь номоо бичихгүй байсан. Номоо хуучин Библийн сургуулийнхаа багшид явуултал, тэр хатагтай хурцаар шүүмжилсэн нь намайг бүр ч зовоов! Эдүгээ хоёр жил хагас өнгөрч, аль ч ном маань өчүүхэн ч дэмжлэг авсангүй.

Хэрэв би бусдын шүүмжлэлийг, өөрийнхөө гутруу бодолтой сонссон бол, шууд л больчих байсан. Тэгээд мэдээж “*Сатаны урхи*” гэдэг гурав дахь номоо бичихгүй байх байсан юм.

Бурханы өгсөн бэлгийг анхаарахгүй, ойшоохгүй байх гуравдугаар шалтгаан нь:

Бүтэлгүйтэхээс айх явдал.

Энэ айдсын даажигналтай чанар нь: Бид эхлэхээсээ өмнө бүтэлгүйтлээ хүлээдэг учраас, өөрийгөө хамгаалж байна гэсэндээ оролдож үздэг ч үгүй! *Бүтэлгүй юмыг оролдож үзээд ч яалаа?* л гэж бодно. Бүтэлгүйтэх айдсаас болж, хичнээн мөрөөдөл, алсын хараа үйрсэн бол? Бурханы өгсөн бэлэг нь мөнөөх залхуу зарцын гарг үрэгдсэн шигээ л үрэгдэнэ.

Бүтэлгүйтэхээс айх айдас юу бүтээдгийг манай найз Майлс Манро “*Хүчин чадлаа төгөлдөршүүл*” гэдэг номдоо бичжээ:

Оршуулгын газар бол дэлхий дээрх хамгийн баян газар. Тэндээс л хэзээ ч биелээгүй мөрөөдөл, хэзээ ч тэрлээгүй ном зохиол, хэзээ ч эгшиглээгүй дуу хөгжим, хэзээ ч хүртээл болоогүй шинэ санаа, хэзээ ч нээгээгүй эмчилгээг олно. Учир нь эзэн нь *анхныхаа алхмыг хийхээс* дэндүү айжээ.¹⁸

Бурханы өгсөн бэлгийг энэ амьдралдаа илэрхийлэл болгохоос бүү хойш суугаарай гэж би танд Майлстай санаа нэгтэйгээр хатуу анхааруулъя.

Бид бүгдээрээ Тимотыг өндрөөр үнэлдэг учраас, одоо миний хэлэх зүйл таныг гайхшруулж магадгүй. Гэхдээ Паулын захидлаас үзбэл, Тимот залхуу нярвын замаар л замнах гэж байна! Түүний Бурханаас өгөгдсөн бэлэг идэвхигүй болж, тэрбээр үүндээ анхаараагүй байна. Золоор Тимот өөрийг нь бахь байдгаар нь үлдээхгүй, итгэлийн сайн эцэгтэй хүн юм.

Хоёр дахь захидалдаа Паул “хүүдээ” “Энэ шалтгааны улмаас, миний гар тавигдсанаар чамд буй Бурханы бэлгийг *сэргээхийг* чамд сануулъя” (2Тимот 1:6) гэж бичжээ. Сэргээхийг Грекээр *аназонурео* гэдэг бөгөөд “гал асаах”¹⁹ гэсэн утгатай болно. Тийм боловч Грек-Англи толь бичиг дээр утгыг нь бүр илүү бүрэн тайлбарласан

байдаг. “Ямарваа нэгэн зүйлийг дахин асахад хүргэх - “дахин идэвхижүүлэх”²⁰ гэж тодорхойлжээ. Тимот доторх Бурханы бэлэг идэвхигүй байсан бөгөөд дахин цохилж эхлэх хэрэгтэй байжээ. Тэгэхээр, идэвхигүй байдал нь хэрхэн эхлэв? Шалтгааныг нь Паул яг дараагийн эшлэл дээр нь тайлбарлажээ:

Учир нь Бурхан бидэнд айдсын бус, харин хүч, хайр ба биеэ захирах сүнсийг өгсөн. (2Тимот 1:7)

Айдсыг Грекээр *дейлиа* гэдэг ба “зүрх үхэх” гэж орчуулбал онох байх. Паул Тимотод “Тимоот, чиний зүрхгүй байдлаас болж Бурханаас хүлээж авсан бэлэг чинь идэвхигүй болж байна” - бүр энгийнээр хэлбэл “Тимоот, *айлган сүрдүүлгийн* сүнснээс болж Бурханаас өгөгдсөн бэлэг чинь ажиллагаагүй байна” гэжээ.

Энэ уг амархан ойлгогдохоор. Айлган сүрдүүлэг гэдэг нь “айснаасаа болж үйлдэл хийхээс ухрах” гэсэн утгатай. Гэхдээ үүнээс чухал нь айлган сүрдүүлгийн эх үүсвэр нь *сунс* юм. Энэ нь сүнсний хүч бөгөөд бид айдсыг сүнсний төвшинд авч үзэхгүй бол, үндэс нь бүрэн тасрахгүй.

АЙЛГАН СҮРДҮҮЛЭГТЭЙ ТЭМЦСЭН МИНЬ

Би энэ сүнстэй олон жил дайтсан учраас, энэ бүхнийг мэдэж байгаа билээ. Би үүнийг миний зан чанарын тасархай л гэж боддог байлаа. Гэтэл тас буруу бодож явснаа 1990 оны эхээр болсон нэгэн цуглаан дээр олж мэдсэн юм. Тэр жижиг хотын цуглаан дөрвөн өдөр л үргэлжлэх товтой байсан ч, эцэстээ гурван долоо хоногийн Бурханы их хөдөлгөөн болж хувирсан билээ. Үдэш бүр байшин пиг дүүрч, олон хүн аврагдаж, эдгэрч, чөлөөлөгдөв. Миний амьдрал дахь Бурханы үгийг номлох бэлэг оргилдоо тулав. Үнэхээр мартагдашгүй. Хүмүүс оройн цуглаанд оролцохын тулд 150 километр газрыг туулсаар ирж байв. Өдөр нь хоосон танхимд явж ороход Бурханы оршихуй тэр байшинд суурьшсан мэт санагддаг байлаа.

Гэтэл сүүлийн долоо хоногийн нэгэн орой энэ бүхэн өөрчлөгдсөн юм. Өмнөх орой нь зарим магтаалын удирдагч нар миний үйлчлэлийг шүүмжилсэн байлаа. Тэдний хэлсэн үгийг цуглаан эхлэхийн өмнө надад нэгэн удирдагч дуулгасан юм. Тэр хүмүүсийн үг гэмгүй санал шиг л сонсогдож байв. Гэхдээ би тэдний үгийг гөвж чадсангүй. Фокус

маань удахгүй эхлэх цуглаанаасаа шилжээд, өмнөх оройн цуглааны шүүмж үг дээр буцаж тогтоод байв. Пастор тэдний үгийг үл тоогоод, урьд нь олон удаа хийсэн шигээ залбираад, танхим руу явж орлоо.

Гэтэл тэр орой бүх юм хув хуурай байв. Би өмнөх хоёр долоо хоног шигээ үйлчлэх гэж оролдсон ч, нэг л тогтож өгөхгүй, уймраад, тайзнаас буучихмаар санагдаад байлаа. Тайзны арын хаалгаар гараад гүйчихмээр! Би үе тэнгийнхээ хүүхдүүдийн өмнө үгээ эвлүүлж хэлж чадахгүй, эв хавгүй түгдчих жаалхүү шиг л байлаа. Над дээр Бурханы ширхэг ч тосолгоо, оршихуй алга. Аймшигтай муухай. Тэгээд би цуглаанаа эртхэн дуусгаад, байрлаж байсан газартаа ирлээ.

Би Бурханд бухимдав. *Тэр яагаад надад тусласангүйв? Цуглаан яагаад ийм өөр байв? Намайг яагаад хаячихав? Номлож, үйлчлэх гэж ёстой хөгөө чирлээ. Маргааш орой хэн ч ирэхгүй. Би өөрөө ч очмооргүй байна.*

Маргааш юмс өөрчлөгдөнө гэсэн найдлагаар би хажууллаа.

Гэтэл маргааш өглөө нь мөн л бөөн дарамттай, урамгүй сэрэв. Залбирах гэж оролдсон ч, нэмэр алга. Юун буруудав гэсэн зовнил томорсоор. Үдээс хойш нь гурван цаг залбирлаа. Энэ хоорондоо бүтэлгүйтлийн бодолтой тасралтгүй тэмцэлдсээр. Би дарамтыг сөрөн, оройн цуглаандаа биеэ бэлтгэн, цэгцрэхээр өөрийгөө өөд нь татаж байв.

Тэр оройн танхимд магтаал хүндэтгэл яг л урьд оройнх шиг хуурай байсан бөгөөд надад хүмүүст өгөх юу ч байсангүй. Дахиад л хойд хаалгаар гараад зугтмаар байв. Намайг танилцуулсны дараа би босоод хэсэг тээнэгэлзлээ. Толгойд юу ч тогтохгүй байв. Гэтэл толгойд: “Чи яах гэж тэгж хэлсэн юм? Чи наад үгээрээ юунд хүрэх юм? Чи үнэхээр хөгийн байна!” гэсэн дуу сонсогдов.

Тэр үед л би “Гүйцээ!” гэв. Тэгээд зургаан зуун хүний өмнө гэнэт л “Би учрыг нь мэдэхгүй байна. Гэхдээ сүүлийн хоёр орой нэг л биш байна. Та бүхэн босоод, надтай хамт залбирахгүй юу?” гээд хэлээд тавьчихлаа.

Биднийг залбиртал, Бурхан надтай ярив - сүүлийн хорин дөрвөн цагийн хугацаанд анх удаагаа ярив. Бурхан надад Паулын Тимотод бичсэн 2Тимот 1:7-г сануулаад: “Хүү минь, чи чиний хойно тайзан дээр зогсож байгаа магтаалын багаас айн сүрдсэн. Айлган сүрдүүлгийн сүнсийг таслаад, Миний өгсөн үгийг хэл” хэмээв.

Би ч Бурханы үгийг дагаж үйлдтэл, тэр даруй Бичээсийн хүчирхэг үг зүгээр л урсав. Тэр цуглаан хорин нэгэн цуглаанаас хамгийн хүчтэй нь болсон юм. Хүмүүсийн далан таван хувь нь мөн ялгаагүй айлган сүрдүүлэгтэй тэмцэлдсэнээ хүлээн зөвшөөрч, урагшаа гарав. Чөлөөлөлтийн

төлөө залбируулах гэсэн хүмүүс цуглааны жигүүрээр пиг дүүрсэн байлаа.

Пастор нь хэдэн долоо хоногийн дараа надтай уулзаад, тэр цуглаан ямар нөлөө авчирсныг тайлагнасан юм. Намайг шүүмжилсэн удирдагч нар өөрсдөө завхайрал, садар самуун, архи дан согтуурал зэрэг эрээ цээргүй нүглээр амьдарч байжээ. Энэ бүхэн нь хэдхэн долоо хоногийн дотор ил болж, нэгээс бусад нь чуулганаасаа явжээ. Түүнээс хойш чуулганых нь магтаалын баг урьд хожид байгаагүйгээрээ эв нэгдэлтэй, үр нөлөөтэй болсон байна. Тэр явдал амьдрал, үйлчлэл өөрчилсөн үйл явдал байжээ.

Миний хувьд, энэ явдал олон жилийн сэтгэл санааны өвчний зовиурыг бас заримдаа Бурханы бэлгийг хэрэглэлгүй, өөрийнхөө хүчээр үйлчилчих гээд байдаг оролдлогыг маань эцэс болгосон билээ.

Гэвч хамгийн чухал нь Есүс цөлд соригдохдоо шууд Сатанд хандаж Бурханы үгийг хэлсэн шиг, бид ч шууд айлган сүрдүүлгийн сүнсэнд хандаж тушаах ёстойг сурсан явдал байлаа. Есүс Бурханаас нэмэлт хүчээ илгээн, дайсныг дарж өгөөч гэж гуйлгүй, харин Өөрөө шууд Бурханы үгээр диаволыг дарсан.

ЕЛИАГИЙН ОРНЫ ХҮН

Би таныг 1Хаад 17-19-ийг уншихыг ятгаж байна. Тэндээс та Елиа яг над шиг Израилийн хатан Иезебелээс айж сүрдсэн түүхийг үзнэ.

Энэ аугаа эш үзүүлэгч Кармел уулан дээр Израиль үндэстэнтэй, 850 хуурамч эш үзүүлэгч, Ахаб хаан, сурвалжитнуудтай мөргөлдсөн. Бүх ард түмний нүдэн дээр Бурхан Елиагийн залбиралд хүчит галаар хариулсан. Тэр байтугай Елиа хуурамч эш үзүүлэгч нарыг алж хаяхыг хүмүүст зааварласан. Елиа бэлгээ хүчтэй хэрэглэсэн! Дараа нь түүнийг залбирахад, гурван жил хагасын ган гачиг төгссөн. Тэр бүү хэл, Елиа хааны сүйх тэргээс ч хурдан гүйсэн! Энэ бүхэн нэг л өдрийн дотор өрнөсөн! Ямар мундаг үйлчлэл вэ!

Гэхдээ нар жаргахаас өмнө энэ бүхэн Иезебелийн сонорт хүрэх үед жинхэнэ тулаан эхэлжээ:

Тэгэхэд Иезебел, Елиад хүн илгээн —Хэрэв би маргааш өдийд чиний амийг тэдгээр эш үзүүлэгчдийн амь шиг болгохгүй бол бурхад намайг шийтгэг, бүр илүү үйлдэг! гэж хэлүүлжээ.
(1Хаад 19:2)

Иезебелийн заналхийллийн талаар ярихаасаа өмнө сүнснүүд серферүүдтэй (далайн давалгаагаар гулгагч нар) адилхан байдгийг хэлье. Серферүүдэд гулгах давалгаа хэрэгтэй байдаг шиг, сүнснүүдэд ч гулгах үг хэрэгтэй. Бидэнд “Чиний эсрэг бүтээгдсэн нэг ч зэвсэг амжилт олохгүй. Шүүх дээр чиний эсрэг боссон хэл бүрийг чи яллана. ЭЗЭНий зарц нарын өв нь энэ бөгөөд Тэдэнд Надаас зөвтгөл ирнэ” (Исаиа 54:17) гэсэн. Биднийг сөрсөн үг бүрийг бид нам дарах ёстой. Энэ бол Бурханы бус, бидний ажил. Есүс цөлд Сатаныг дарж өгөөч гэж Бурханаас гуйгаагүй. Тэгвэл бид ч цохилтод орохдоо, тэгж гуйх ёсгүй.

Мэдээж Иезебелийн үг айлган сүрдүүлгийн булиа сүнснийг тээж байсан. Түүний үг Елиад хүрмэгц, тэрбээр хэрхэн хариу үйлдсэнийг үзнэ үү: “Елиа айн босож, амиа аврахаар зугтан Иудад харьяалагддаг Беершебад ирэв” (1Хаад 19:3).

Үндэстэнтэй, хуурамч эш үзүүлэгч нартай, хаантай халз тулахаас буцаагүй энэ эр одоо нэг хүүхнээс амиа авран, зугтаж явна. Тэрбээр улсаа хөндлөн гулд туулаад, өдөржин цөлөөр явсаар модон дор суугаад, *үхье хэмээн залбирчээ*.

Пөөх нөгөө Елиа мөн үү? Яах нь энэ вэ? Елиа мэдээж эргэлзэж, хямарч, найдвараа алдан, алсын хараагүй болоод байсан. Эдгээр нь айлган сүрдүүлэгч сүнсний шинж тэмдэг. Хамгийн харамсалтай нь олон хүн цаана нь байгаа сүнснийг шийдвэрлэхийн оронд шинж тэмдэгтэй нь л үзэлцээд байдаг.

Тэр орой Бурхан мөнөөх сүнсний зальжин арга замыг илчилж өгөхөөс өмнө би ч бас мэдэхгүйгээсээ болоод олон жил шинж тэмдэгтэй нь тэмцэлдсэн билээ. Би бэлгээ ч олигтой хэрэглэж чадахгүй байсан бөгөөд үүнийхээ учрыг ч олохгүй байв.

Елиа буугаад өгсөн учраас, Бурхан самуурсан эш үзүүлэгчээ холын замд гаргажээ. Тэнгэрэлч гарч ирээд, түүнийг Синай уул руу хийх дөчин өдрийн урт замд нь хооллосон. Елиаг зорьсон газраа хүрсэн хойно Бурхан хамгийн түрүүнд түүнээс: “Елиа, чи энд юу хийж явна?” (1Хаад 19:9) гэж асуужээ.

Юу? Байз! Бурхан Өөрөө тэнгэрэлчдээ Елиаг аян замд нь хооллоорой гэсэн учраас л Елиа зорьсон газраа хүрсэн. Гэтэл ирсэн хойно нь яагаад “юу хийж явна” гэж асууж байх. Бурхан орон гаран уу?

Үгүй юм аа. Бид нэг зүйлийг ойлгох хэрэгтэй. Биднийг айлган сүрдүүлэгт ялагдах үед Бурхан бидэнд хайртай болохоороо, биднийг тэнхрүүлэхээр аюулгүйн бүс рүү илгээдэг. Би тэр цуглаан

дээр юу болоод байгааг мэдээгүй бол, Елиагийн хувьд - бүгдийг мэдэж байсан гэдэгт би итгэж байна. Елиа ямар ч эсэргүүцэлтэй эрэмгий зоригтой нүүр тулдаг байсан ч, хатнаас айжээ.

Тэгэхээр, “Бурханы асуултын цаад утга юу байв?” гэдгийг л олох ёстой. Хамаг л муу ёр хатнаас гарч байсан болохоор, Бурхан Елиагаас яагаад хатантай халз тулаагүйг нь л асуужээ. Елиа хатныг зогсоох ёстой байсан ч, зугтсан.

Елиа асуултын цаад асуултад хариулахын оронд сэдвээ өөрчлөөд, өөрийгөө Бурханд үнэнч цорын ганц хүн хэмээн гомдолложээ. Гоморхлын сонгодог түүх байна:

Тэрээр —Би түг түмдийн Бурхан ЭЗЭНд маш их зүтгэсээр ирсэн. Израилийн хөвгүүд Таны гэрээг умартаж, Таны тахилын ширээнүүдийг нураан Таны эш үзүүлэгчдийг илдээр цавчин алсан билээ. Одоо ганцхан би л үлдээд байна. Тэд миний амийг авахын тулд намайг хайж байна гэж өчив. (1Хаад 19:10)

Бурхан энэ хариултыг ойшоолгүй: “Елиа, чи энд юу хийж явна?” (1Хаад 19:13) хэмээн дахин асуужээ. Тэгтэл Елиа дахиад л нөгөө гоморхлын түүхээ хүүрнэсэн (14-ээр эшлэлийг үзнэ үү). Тэрбээр ёрын муугийн цаад ёрын мууг шийдвэрлэхийг хүсэлгүй, бууж өгчээ.

Бурхан мөн л Елиагийн “золгүй амьтны” түүхийг огт ойшоолгүй, нүд орой дээр гаргамаар тушаал буулгав:

Яв, Дамаскийн цөл уруу явах замаараа буц. Чи Хазаелыг Арамын хаанаар томилон тослох болно. Мөн Нимшийн хүү Иехүг Израилийн хаанаар томилон тосолж бас Абел-мехолагийн Шафатын хүү Елишаг *өөрийнхөө оронд эш үзүүлэгчээр томилон тослох болно.* (1Хаад 19:15-16)

“Өөрийнхөө оронд эш үзүүлэгчээр томилон тослоно” гэдэг сүүлчийн үг нь тусч байна уу? Елиа айлган сүрдүүлэгт бууж өгөөд, ялагдсан болохоор Бурхан түүнийг өөр хүнээр орлож байна. 2Хаад номыг уншбал, Елиа дараагийнхаа дөрвөн жил гол төлөв орны хүнээ сургасан байдаг. Түүнчлэн үүнээс ч гайхшруулмаар мэдээ нь Елиа Хазаелыг ч, Иехүг ч томилоогүй. Энэ ажлыг Елиагийн орны хүн Елиша гүйцэтгэсэн.

Елиша огтхон ч айж сүрдээгүй. Тэрбээр зоригтой байж, ямар ч муугаас дальтраагүй. Бурхан түүний тухайд “Иехүгийн илднээс зугтсан хүн Елишагийн гарт орж үхэх болно” (1Хаад 19:17) гэсэн. Иехү, Елишагийн хооронд Ахаб, Иезебел хоёрын муу ёрын улс нурсан түүхтэй. Уг нь үүнийг анх Елиа хийх ёстой байсан ч, айлган сүрдүүлгээс болж хувь тавиланд өөрчлөлт гарчээ.


Елиа залхуу зарц шиг Бурханыг мэддэггүй нэгэн байгаагүй. Тийм атал Елиагийн тэмцэл бидэнд айлган сүрдүүлэг нь бэлэг, дуудлагыг явал ч яадгийг тодорхой харуулж байна.

Айдас, айлган сүрдүүлгийн нүүрэн дээр ухрахгүй хэмээн хатуу шийдэх нь амин чухал. Биднийг энэ хүчний өөдөөс гүйхэд, Бурхан бидний бат ар тал болно. Айлган сүрдүүлгийг ялж болно. Гэхдээ үүнийг Бурханы Үг, амлалтаар л тархидах хэрэгтэй.

Дахин хэлье: Бурхан таны төлөө байна. Тэр танд итгэдэг. Таны амьдралд өгсөн бэлэг нь хөгжин цэцэглэхийг Бурхан харахыг хүсдэг. Бүү ухар. Даалгавар, хувь тавиланд чинь саад хийхийг хэнд ч, юунд ч бүү зөвшөөр.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

1. Айдас олон мөрөөдлийг хулгайлсаар ирсэн. Айдас зальжин бөгөөд хяналтаа тогтоохыг эрэлхийлдэг. Зүй ёсоор нь шийдэхгүй бол, айдас хувь тавиланг чинь өөрчилнө. Айдас хэрхэн хувь тавиланг чинь өөрчлөхийг санаархдаг вэ?
2. Тимот бэлгээ анхаарах тал дээр анхааруулга авсан. Бэлгээ ойшоохгүй байх нь ямар аюултай вэ? Бэлгээ үл ойшооход хүргэдэг жишээнээс аль нь танд хамгийн ойр таарч байна? Яагаад?
3. Айлган сүрдүүлэг бол сүнс. Та энэ сүнстэй хэрхэн тулгарч байв? Энэ сүнсийг хэрхэн ялан дийлэх вэ?



*Харин хүн бүр үйл хэргээ шалга. Тэгвэл уг хүн өөрийгөө
бусадтай харьцуулалгүй, өөрийнхөөрөө сайрхах болно.
Учир нь хүн бүр ачаагаа үүрнэ.*

— Галат 6:4-5

Бэлгээ нээж олоод, хөгжүүл

Одоо бүгдээрээ Бурханы өгсөн бэлгийг нээж олоод, хөгжүүлэх талаар ярья. Би энэхүү ном дээрээ төрөлх авьяас, чадвараа хөгжүүлэх талаар ярихгүй гэдгийг өмнө хэлсэн. Хангалттай дадлага сургуулиар бараг хүн бүр юун дээр ч чадваржиж чадна.

Миний энэ үгийг гэрийнхэн маань сонсбол, зарим нэг хүн хичнээн дадлага хийлээ гээд дуулж ёстой сурахгүй хэмээн маргаж мэдэх. Тухайлбал, тэр зарим нэг хүн нь би байна л даа. Тэдний ч зөв байх. Тиймээс би бодитой жишээ татъя: Би өдөрт арван цаг хөгжмийн бэлтгэл хийгээд байвал, хөгжмийн талаар анхны ч мэдэгдэхүүнгүй хүнээс хөгжмийн дөртэй хүн л болох байх. Би тийм олон цаг хүчин зүтгэлээ ч, төгөлдөр юмуу гитар тоглох дуртай л болж мэдэхээс биш, хөгжмийн чадвар маань Бурханы хаанчлалыг байгуулах дуудлагыг маань бэхжүүлэх *карисмагийн* төвшинд очтолоо хөгжихгүй л болов уу.

БУРХАНЫ ОРОЛЦОО

Бүлгийнхээ эхэн хэсгээр бид Паулын “Харин хүн бүр үйл хэргээ шалга (Өөрийгөө болоод даалгагдсан ажлаа нарийвчлан судла)” гэсэн үг дээр төвлөрнө. Дуудлага, дуудлагатай хамаатай бэлгийг олж мэдэх томъёо гэж байдаггүй юм. Хэдийгээр, танд чадвартай талаа олж мэдэхэд чинь туслах олон янзын эх үүсвэр байдаг ч, Бүтээгчийн тус дэмгүйгээр мөнхийн нөлөөтэй *дуудлага, карисмагаа* олж илрүүлэх боломжгүй.

Бэлэг авьяасаа илрүүлэх тал дээр зарим тохиолдолд Бурханы шууд оролцоог амархан ойлгодог. Тухайлбал, миний ном бичиж эхэлсэн түүх байна. 1991 оны зуны тэр нэгэн өглөө залбирч байхдаа үг хүлээж аваагүй байсан бол, би хэзээ ч бичих гэж оролдохгүй байсан. Надад ном, сургалтын материал бичих санаа ч төрөхгүй, за төрсөн байлаа ч, би тоож үзэхгүй байх байсан. Өөр жишээ хэлэхэд, Давид хонин сүргээ арслан, баавгайгаас хамгаалаагүй байсан бол, хэзээ ч бидний мэддэг дайчин болохгүй байх байсан. Үүний дараа Израилийг Филистинчүүдээс аврах баатар хэрэгтэй болсон. Давидын хувьд арслан, баавгай зэрэг араатан нь Голиатыг ялан дийлэх гишгүүр болжээ. Гэтэл энэ хооронд Израиль нуугдаж байв. Бурхан Давидад амьдралд нь үүссэн амин хэрэгцээн дээр үндэслэн бэлэг чадварыг нь таниулжээ.

Тэгвэл Гидеоны хувьд надтай төстэй байдаг. Бурхан хэд хэдэн тохиолдлоор дамжуулан Гидеонд өөрт нь дайчных нь дуудлагыг үнэмшүүлэх хэрэгтэй байв.

Нэгдүгээрт - *карисмаг* илрүүлэхэд Бурханы тусламжийг хайж, Түүнд итгэх нь хамгаас чухал. Бурхан Өөрийг нь итгэлээр хичээнгүй эрж хайдаг хүмүүсийг шагнадаг тухай Бичээс хэлдэг. Бурхан Өөрийг нь эргэлзэж, гайхширсаар хайсан болдог хүмүүсийг шагнадаг (Еврей 11:6-г зохиолч өөрийнхөөрөө өөрчлөн эшлэв) гэж хэлээгүй. Есүс ч энэ тухай айлдсан:

Гуй, тэгвэл та нарт өгөгдөнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ. Гуйдаг бүр авна, эрж хайдаг нь олно, тогшдогт нээгдэнэ. (Матай 7:7-8)

Бид *карисмагаа* мэдэхийн төлөө улайрах ёстой. Энэ ном таны хайгуул, бэлгээ хэрэглэх хүсэл дээр чинь тос нэмнэ гэдэгт найдаж байна. Улайрал чинь таныг хайх, эрэлхийлэх, тогшихдоо хайнга хандалгүй, харин Есүсийн дээр айлдсан шиг тууштайгаар үйлдэхэд чинь тусална. Бурхан таныг хааж, хориод байгаа юм биш. Таны гуйгаад байгаа зүйлийг Бурхан таны дотор хөгжүүлэхийг танаас ч илүү улайран хүсдэг.

Би ахлах сургуульд байхдаа, одон орон судлалд дурлаж, шөнийн тэнгэрийг танин мэдэхийг хүссэндээ, өндөр хүчин чадалтай дуран авайтай болохын мөрөөсөл болов. Сайнд нь миний бэл бэнчин хүрэхгүй болохоор, би одон орон судлалын ном сэтгүүл их уншина. Номын сангаас нэг удаадаа дөрөв, таван ширхэг ном сэтгүүл аваад, чөлөө заваараа уншина. Заримдаа давтан уншаад, дараа нь эргүүлж өгөөд, оронд нь өөр олныг авна. Уншлага маань миний дуран авай авах хүслийг улам л бадраасаар байлаа.

Улайрлынхаа хүчээр эцэстээ дуран авайгаа авахад шаардлагатай мөнгийг олох ер бусын санаа сэдэж билээ. Би усан сэлэлт, теннисний клубт теннис заадаг байсан бөгөөд зөвхөн зуны амралтаараа л ажилладаг байлаа. Тэгээд би клубдээ тэдний урьд өмнө хэзээ ч хийж байгаагүй зүйлийг санаачилж, клубынхаа зөвлөлийн зөвшөөрлөөр, намар хичээлийн дараа ганцаарчилсан сургалт явуулах санал дэвшүүлэв. Төлөвлөгөө бүтэх юм бол, би дуран авай авах хангалттай мөнгөтэй болох байлаа. Төлөвлөгөө ч бүтэв! Гэхдээ хамаг учир нь дуран авайдаа бус, улайрсан хүсэл тэмүүлэлдээ л байсан юм. Намайг тэгтэл улайраагүй байхад, хүн надад дурай авайг маань бэлэглэсэн бол, би хэсэгтэй хөөрч байгаад, сонингоо буухаар хаячих байсан биз.

Бурхан чих хатуутай биш. Бурхан барьж хорьдоггүй. Гэхдээ хүмүүсийн амьдралыг барьж байгуулуулахаар өгсөн бэлэгт нь хэв нэг хандахыг тэвчихгүй. Улайрал чинь мөрөөдөлдөө хүрэх замд чинь тулгарах дайсагналаас хүчтэй байх ёстой. Тиймээс, хүсэл чинь өсөг. Тэгвэл улайрал чинь таныг карисма, бэлгээ олж мэдэхийн төлөө халуунаараа байхад тусална.

Удаагаар нь - Бурханы хариулт яг нэг янзаар бус, хүн бүрт харилцан адилгүй загвараар ирдгийг бид ойлгох ёстой. Бид Есүстэй “хувийн харилцаатай” байх талаар байнга ярьдаг атлаа тухайлбал *карисма* бэлгээ ойлгох тал дээр Бурханыг сонсох ёстой гэхээр, томъёо нэхээд байдагт би гайхдаг. Бурхан үүнийг хувийн хэмжээнд л байлгах хүсэлтэй. Бурхан үүнийг та хоёрын дунд л хадгалахыг хүсдэг. Бурхан хайртай хүүхэд бүртээ нэг хэвэнд цугтгасан хариулт өгөхийг хүсдэггүй. Тиймээс л Есүс бидэнд гуйсаар байх, хайсаар байх, тогтсоор байхыг зааварлажээ. Түүний хүслийн араас явах “эрэл хайгуул” нь үнэндээ бидэнд туйлын тустай.

Эрэл хайгуулынхаа дунд бид өөртөө болоод бусдад асуулт тавих ёстой. Энэ нь эрлийн нэгээхэн хэсэг юм. Бид хүний цэц ухааныг хайгаагүй, харин ярилцаж байгаа хүмүүсийнхээ дуу хоолой дундаас Бурханы дуу хоолойг чих тавин хайдаг.

Хэнтэй ярилцах маань чухал. Урамшуулдаг атлаа үнэнийг хэлэхээс айдаггүй хүмүүсийг олох хэрэгтэй. Ийм хүчирхэг хүмүүс байх нь байдаг ч, тун ховор. Очоод ярилцахаар, хүссэн зүйлийг маань л хэлдэг танилууд надад олон бий. Түүнчлэн бүхий л зүйл дээр гутруу, шүүмжтэй, сөрөг ханддаг, алсын хараагаар дутмаг хүмүүс ч байна. Аль, алиас нь дөлж яв. Бурханд итгэдэг, төлөвшсөн, ухаалаг хүнийг ол. Итгэлийн аав, ээжийг юмуу танаас урт аялсан, алдаа гаргаж, түүнээсээ суралцсан хүнийг ол.

Итгэж найдаж байгаа эрхэм тань тас унтарчихаагүй бас хүн төрөлхтөнд гомдож, итгэл алдарчихаагүй, хүн байх нь чухал. Учир нь гомдол тээж явдаг хүний дотор бусдыг нүд үзүүрлэсэн, хар сэртэй ийм хандлага амархан үрждэг. Амархан уучилдаг, шашинлаг сэтгэлгээгүй, харин цаг хугацаатай болоод Бурханы Сүнсний сэргэг хөдөлгөөнтэй хөл нийлүүлэн өсч дэвшдэг хүнийг хай. Хамгийн чухал нь юмсыг өнө мөнхийн хараагаар хардаг хүнийг хай. Ийм хүнийг олбол, тэр харилцаагаа хадгалж, нандигнаж явахын төлөө бүхнийг хийгээрэй.

Цэцэн цэлмэг олон хүн өнө мөнхийн үзэлгүй байдаг. Тэдний зөвлөгөөнд хэмжээ хязгаартай л найдаж болно. Тэдний зөвлөгөөг ямагт Бурханы Үг, залбирлын шүүлтүүрээрээ шүүх байгаарай.

Эцэг эх, хань ижил, пасторууд чинь бүгдээрээ таны л төлөө гэсэн сэтгэл тээж, ихэвчлэн ухаалаг зөвлөгөө өгдөг ч, тусгай тохиолдол гэж байна аа. Би залуу байхдаа, Бурханд үйлчлэх мөрөөдлөө аавдаа дэлгэсэн юм. Түүний үеийнхэн “баталгаатай” тоглохыг л заалгаж өсчээ (Гэтэл энэ нь итгэлийн амьдралд хүч нөлөөгүй зүйл билээ). Тэгээд аав маань: “Хүү минь, наад зам чинь баталгаагүй” гэж хэлсэн юм. Өөрөө дөчин жил инженерээр амьдарсан аав маань намайг тоо, шинжлэх ухааны хичээлдээ сайн байсан учраас, инженер болохыг санал болгов. Инженер бол баталгаатай мэргэжил. Тэгэхэд би бүтэн зургаан жил коллежид үйлээ үзэх юманд зөвшөөрч байгаагаа яаж мэдэх билээ. Хэдийгээр би эдгээр хичээлд авьяастай байсан ч, амьдралд маань зориулсан Бурханы дуудлага байгаагүй тул ёстой л үйлээ үзсэн дээ.

Би анх АйБиЭм-д (IBM) инженерээр ажилд оров. Нэг өдөр дарга намайг өрөөндөө дуудаад: “Бивэр, чи яах гэж инженер хийнэ? Чи хүмүүстэй ажиллаж байх ёстой хүн. Хүмүүстэй харилцдаг талбар дээр л байх хэрэгтэй” гэж хэлсэн юм. Алдар нэртэй үйлчлэгч хүмүүс ч надад: “Хүү минь, чиний дээр сайн мэдээ номлох Бурханы дуудлага байгааг би харж байна” хэмээн аминчлан хэлдэг байлаа.

Хэдийгээр надад үйлчлэх санаа байгаагүй ч, ганцаараа залбирч байхад минь Бурхан миний зүрхийг үйлчлэлд урвуулсаар байлаа. Гэтэл миний хүүхэд байхдаа харж байсан үйлчлэгч хүмүүс дандаа хачин жигтэй хүмүүс байдаг байв. Гэвч зүрхний минь сонгогч Бүтээгч рүүгээ л тэмүүлээд байлаа. Би аврагдахаасаа өмнө долоо хоног яг л санваартан болохоор бэлтгэгдэх мэт Католикийн семинарт хамрагдаж байв. Гэхдээ Католикийн тахилч хүн гэрлэж болохгүй гэдгээс нь айгаад зугтсан юм.

Тийм боловч дээрээс ахин дахин ирэх баталгаа минь надад аавынхаа зөвлөгөөг хойш тавихад туслав. Аавыгаа үнэн голоосоос хүндэтгэж

байсан минь Бурханд таалагдсан ч, инженерээр суралцаж, ажиллахад нэг л биш, шал буруу байгаа нь мэдэгдээд байлаа. Би Бурханаас ахин дахин асууж, чиглэл хүсч байсан болохоор Бурхан намайг яагаад ч буруу чиглүүлэлгүй, өөрийнхөө хүслийг юу юунаас тодорхой хэлнэ (Бурхан намайг ганц хүүгээ гэсэн аавын маань сайхан сэтгэлийн зөвлөгөөнд ч төөрөлдөхийг зөвшөөрөхгүй байх байсан).

Бүтэн жил хагас эрэл хайгуул хийж, нэгэнт шийдсэн хойно зүрх минь улайсч байлаа. Түүнчлэн инженерийн зэргээ хамгаалахад ганц жил дутуу байв. Би сургуулиа дүүргээд, нэгэнт тодорхой болсон үйлчлэлээ хөөв. Сургуулиа дүүргэсэн маань ч зөв шийдвэр болов. Учир нь инженерийн сургууль надад Библийн сургуулиас хэзээ ч сурахгүй стратегийг зааж өгсөн юм. *Бурхан биднийг сургахдаа бүх туршлагыг хэрэглэдэг!*

Бэлгээ олж мэдэхэд шаардагдах бас нэг чухал орц нь нутгийн эрүүл чуулганд суулгагдахуй юм. Бичээс “ЭЗЭНий өргөөнд тэд суулгагдаж Бурханы маань хүрээнүүдэд тэд цэцэглэнэ” (Сургаалт үгс 92:3) гэдэг. Та хөвөнгийн үр тарьбал, хөрснөөс хулуу ургахгүй. Хөрс нь нутгийн эрүүл чуулган бөгөөд таныг тэр чуулгандаа үнэнчээр зүтгэх үед Бурханаас өгөгдсөн бэлэг чинь ил болно. Та зах зээл, боловсрол, засгийн газар, биеийн тамир - спорт зэрэг дуудагдсан газартаа цэцэглэнэ. Энэ бол Бурханы загвар.

ӨӨРӨӨСӨӨ БОЛООД БУСДААС АСУУХ АСУУЛТ

Одоо өөрөөсөө бөгөөд ухаалаг нөхдөөсөө асуух асуулт руу орцгооё. Зөв хүмүүсээс асуусан зөв асуулт таны бэлгийг илрүүлэхэд тусалж юуны магад. Хэдэн жишээ хэлье:

Таны төрөлх авьяас юу вэ?

Энэ тун сайн эхлэл асуулт шүү. Магадгүй та тоо бодох, хүнд бүтэцтэй өгүүлбэр ойлгох, барьж байгуулах, видео түүх бүтээх, хувцас урлах, үйл ажиллагаа зохион байгуулах чадвартай байж болно. Та төрөлхийн спортын авьяастай, үнэртэх онцгой чадвартай, ажигч гярхай байж болно. Юу ч байсан - өөрийнхөө давуу талыг тодорхойл.

Танд дуулах чадвар, хүмүүсийг Бурханы оршихуй руу дагуулах хүсэл байгаа бол, магтан хүндэтгэхээр эсвэл өөр ямар нэгэн хөгжмийн үйлчлэлд гар бие оролцохоор дуудагдсан байх өндөр

магадлалтай. Мөн хүний бие организм сонирхдог, анагаах ухаанд дурладаг бол, эрүүл мэндийн салбарт дуудагдсан эсэхээ Бурханаас заавал лавлах хэрэгтэй. Гэх мэтээр үргэлжлүүлээд байж болох.

Тийм боловч эдгээр сэжүүр нь эцсийн дүгнэлт хараахан биш ээ. Жишээлбэл, би теннисдээ маш сайн байлаа. Сургуульдаа Үндэсний их сургуулиудын тамирчдын холбооны I зиндааны багаас эхлэн Америкийн теннисний холбооны тэмцээн, Дэйвис цомын өсвөрийн ангилалд тоглож явлаа. Гурван жил мэргэжлийн теннис зааж, Вержиниа мужийн ахлах сургуулийн теннисний тэмцээнд ялж явснаа өмнө ярьсан. Гэхдээ залбирч байхдаа, мэргэжлийн теннисчин болохоор дуудагдаагүйгээ мэдээд байлаа.

Гэтэл манай найз Аарон Баддели гэж Мэргэжлийн гольфийн холбооны тэмцээний тамирчин, хосгүй гольфчин хүн бий. Аарон 2004 онд буюу тэмцээнийхээ хоёр дахь жилд нилээд тэвдэж билээ (Тэрбээр 124-т жагссан учраас, арай чүү л 2005 онд тоглох эрхээ олж авч байлаа). Энэ хүндхэн жилийн адгаар Аарон манай гэрт байрлан, тэмцээнд оролцох үеэрээ тун харамсалтайгаар хасагдсан юм. Бид хоёр онгоцонд суугаад, Лас Вегас явав. Би тэнд конференц дээр заах ёстой байлаа. Тэр цуглаан дээр Бурхан түүний зүрхэнд дөрвөн удаа “Би чамайг үйлчлэлд дуудаагүй, гольфд дуудсан” хэмээн айлджээ.

Аарон гольфд бүрэн зориулагдахаас хойш сууж байв. Учир нь тэр өмнө нь хийж байсан зүйлээ л хийхийг хүсч байжээ. Аарон хагас цагаар нь аялж, конференц, чуулганууд дээр номлоод, хагас цагаар нь гольф тоглохыг хүсч байж. Гэтэл тэр орой Аарон дуудлага, бэлэгтээ зуун хувь зориулагдахаар зүрхэндээ хагуу шийдсэн байна. Хэдхэн жилийн дотор Аарон гольфийн зиндааны 16 дугаарт бичигдэж, эцэстээ Мэргэжлийн гольфийн холбооны тэмцээн, Австралийн Мастерст дөрвөн удаа түрүүлсэн юм. Тэрбээр одоо арван дөрөв дэхь жилдээ тоглож байгаа бөгөөд эрч хүч саараагүй л явна. Аароны нөлөө өссөөр, тэрбээр чуулганы хаалгыг хэзээ ч татахгүй маш олон хүнд үйлчилж, сайн мэдээ түгээсээр явна.

Надад Ааль гэдэг нэгэн найз бий. Олон жилийн өмнө Аалийн чуулганд Библи заах дуртай, заахдаа ч сүрхий нэгэн хүн байжээ. Тэрбээр багш - пастор болохыг хүсдэг байж. Гэтэл бас машин засах содон бэлэгтэй байжээ. Тэгж байтал хотынх нь өөр дүүрэгт байршдаг том чуулган түүнийг багш - пастораар авч ажиллуулахаар амласан байна. Мань хүн энэ тухай Аальд хэлэхээр өдрийн хоолонд дагуулж оржээ. Гэтэл манай Ааль хурц ухаантай хүн болохоороо: “Чиний төлөө залбирч байхад, чи бүтэн цагийн Библийн багш болохгүй юм шиг санагдсан. Чи машин засах онцгой авъяастай” гэж хэлжээ.

Мэдээж нөгөө хүн пасторынхаа зөвлөгөөг сонголгүй, өөр чуулган руугаа яваад өгч гэнэ.

Жилийн дараа нөгөө хүн тун хэцүү байдалд оржээ. Тэрбээр багшийнхаа ажилд ч албан ёсоор ороогүй, гэр бүл нь ч санхүүгийн асуудалтай, гэрлэлт нь ч сүйрэх дээрээ тулжээ. Гэтэл Бүтэн сайны цуглаан дээр Эзэн түүнд: “Би чамайг хэзээ ч пастораар дуудаагүй, харин нутгийнхаа чуулганд Библи заадаг механикаар дуудсан” гэж хэлсэн байна.

Нөгөө хүн Ааль пастор дээрээ эргэж очоод, зөвлөгөөг нь сонсоогүйдээ гэмшээд, нутгийнхаа чуулганд эргэж ирсэн байна. Тэрбээр машин засах ажил дээрээ төвлөрчээ.

Нэг шөнө Бурхан түүнд машины моторын асуудлыг оношлохын тулд компьютерт залгаж буй зүүд зүүдлүүлжээ. Нөгөө хүн компьютер мэддэг найз дээрээ очоод, тэр хоёр компьютержсэн оношлуур бүтээжээ. Тэр оношлуур нь машины асуудлыг жирийн аргаар оношлохоос 1/4 дахин хурдан оношилдог болж таарав. Нөгөө хүн шууд л Хойд Каролина даяар засварын газраа нээн, шинэ төхөөрөмжөө ашиглах болжээ. Хожим тэрбээр Ааль пастортайгаа уулзахдаа, мишээгээд: “Би машин засахаар дуудагдсан!” гэж хэлсэн гэдэг.

Таныг юу цэнэглэж байна?

Нэг удаа манай туслах надаас долоо хоног тутмынхаа “эрч хүчийн төвшинг” тэмдэглээд, дараах маягаар үнэлээрэй гэв: “Хамаг тамир тэнхээг минь сордог ажил даалгаврыг -2, бага зэрэг тамирдуулдаг юмсыг -1, бага зэрэг эрч хүч өгдөг юмсыг +1, хамгийн их эрч хүч хайрладаг юмсыг +2 гэсэн оноогоор тэмдэглэх.

Салбарын хурал, аялал, бичиг цаасны ажил, аяллын бэлтгэл гэх мэт зүйлс нь -2, -1 гэсэн тэмдэглэгээ авав. +1 оноо авсан хэдхэн л зүйл байсан бол, хоёрхон зүйл л баттай +2 гэсэн оноо авсан нь номлох, бичих ажил байв. Энэ дүн намайг ёстой гайхшруулав.

Би энэ нээлтийг эргэцүүлэхдээ, нээрээ л бичиж байхдаа цаг хугацаанаас тасардгаа ухаарч билээ. Заримдаа өглөө эхлээд, үд өнгөрснийг ч анзаарахгүй. Ийм их бичсэний дараа нэг талаараа - оюун санаагаар тамирддаг боловч, нөгөө талаараа улам эрч хүчтэй болдог.

Номлоход ч ингэдэг. Дээх нь үед цагийн хязгаар тавьдаггүй байхад, би хоёр цагаас илүү номлодог байлаа. Надад гучин минут шиг л өнгөрдөг байсан ч, сонсогч нарт ямар байсныг мэдэхгүй!

Миний бүтээлч хүү Алек шинэ төсөл дээр ажиллахаараа цаг хугацаагаа алддаг. Хүү маань манай уран бүтээлийн хэлтэст онцсайн

ажилладаг. Лиза эмэгтэйчүүдийн цуглааны дараа найзуудтайгаа уулзахаараа цаг хугацаагаа алддаг. Охидын яриа Лизаг маань цэнэглэдэг.

Альберт Эйнштейн нэг ажиллахаараа хэзээ ч зогсдоггүй байж. Ядраад ирэхээрээ төмөр хавтан аваад, өвдгөн дээрээ бариад сууна. Тэгээд зүүрмэглэхээр нь төмөр хавтан гараас нь гулгаад, шалан дээр унана. Төмрийн тар няр хийсэн чимээ Эйнштейнийг сэрээж, тэрбээр ажилдаа эргэж ордог байжээ.

Тэгэхээр, дуудлагаа тодорхойлох тун амархан нэгэн арга нь: Та жинхэнэ бэлгээ хэрэглэж байгаа бол, их ажлаас болж бие, оюун чинь тамирдсан хэрнээ давхар эрч хүчтэй болдог жамтай. Жинхэнэ бэлгээрээ ажиллаж байхад, олон цагийн бэлтгэл, өрсөлдөөн, ажил нь хэдхэн минут шиг л санагдана. Тиймээс: “Юу намайг цаг хугацаагаа алдахад хүргэж байна? Юу намайг цэнэглэж байна?” гэж өөрөөсөө асуу.

Таны бэлэг хаана байгааг хариулт чинь сайтар тодорхойлно.

Та юунд татагдаж байна?

Таны сонирхлыг юу татаж байна? Юу амьд болгож байна? Дуулахад зүрх чинь хайлдаг уу? Хэн ч дуулахгүй байхад, та ганцаараа дуулдаг уу? Би л лав дуулахаараа дорхноо цуцдаг. Дуулах нь миний бэлэг биш. Би өрөөндөө суугаад, бусадтай нийлж дуу хөгжим зохиож чадахгүй. Надад үүнийг хийх сонирхол байхгүй ч, ийм сонирхолтой хүмүүсийг би мэднэ.

Таныг ямар сэтгүүл татаж байна? Ямар Юүтүбийн видео баясгаж байна? Пинтерест дээр ямар зураг нүдийг чинь олзолж байна? Хамгийн дуртай хичээл чинь юув? Номын дэлгүүрт орохоороо ямар төрлийн ном руу чиглэж байна?

Тэгэхээр, нэг чухал асуулт байна: Та цалин мөнгө авахгүй байсан ч, юунд татагдаж байна? Ихэнх мэргэжлийн тамирчид цалин хөлс авахгүй байсан ч, спортодоо тоглоход бэлэн байдаг. Аав маань Хагас сайны өглөө намайг суулгаж байгаад, ямар ч хамаагүй цахилгаан хэрэгсэл асаалгуулдаг байж билээ. Нэг Хагас сайны өглөө бойлуур хэрхэн ажилладгийг цаг гаруй зурж, тайлбарласан юм даг. Гэтэл энэ нь намайг уйлуулах шахдаг байв. Тэгэхэд л инженер бол миний хийх ажил биш гэдгийг ойлгочих ёстой байж! Би аавдаа үнэн голоосоо хайртай байсандаа, тэр хичээлд нь дургүйгээ хэлж зүрхлээгүй юм. Санхүүгийн баталгаа хайсандаа, инженерийн мэргэжил хөөсөн маань миний хамгийн том алдаа байв. Та л над шиг бүү алдаарай.

Хичнээн хүн цалингийн төлөө гэдэг ганцхан шалтгаанаар үзэн яддаг ажлаа хийдэг бол?

Олон жилийн өмнө пасторын маань гэргий надад “Бид чамд хангалттай цалин өгч чадахгүй юм шиг байна” гэхэд нь би: “Зүгээр ээ, надад өгөх цалин чинь л хангалттай!” гэж хариулж байлаа. Би үйлчлэлд дурласандаа, өчүүхэн мөнгөөр ч хамаагүй ажиллахад бэлэн байв. Долоо хоногт далан цаг пастортаа болоод зочдод үйлчлэх нь надад юу ч биш санагдана. Тэр байтугай, тэд надад биш, харин үйлчлэх завшаан олгосных нь төлөө би тэдэнд төлөх ёстой гэж Лизадаа хэлдэг байлаа.

Уг нь би энэ талаар бичмээргүй байв ч, намайг оодорч байна гэж бодох бий гэсэндээ бас сэдэл маань танд тус болоосой гэсэндээ хэлмээр байна. Үйлчлэлээ эхэлж байхдаа Лиза, бид хоёр номынхоо роялтиг (нөөц ашигласны төлбөр) Мессенжер Интернэйшнэлд өгөхөөр шийдсэн юм. Эдүгээ би хорь гаруй ном бичсэн бөгөөд нэг номыг бичиж, засварлахад дунджаар 400-450 цаг зарцуулна. Энэ нь би бичихэд бараг есөн мянган цагийн хөрөнгө оруулалт хийжээ гэсэн үг. Энэ нь бүтэн гурван жил амралтгүй, өдөр бүр найман цаг бичих хугацаа. Тэгэхээр, үндсэндээ би энэ гурван жилийнхээ ажлын төлөө цалин аваагүй гэсэн үг. Яагаад гэвэл бэлэг маань миний дуудлагыг тэтгэдэг.

Би энэ ажил эсвэл жилийн 200,000 долларын цалинтай инженерийнхээ ажлын аль нэгийг сонгох ёстой болбол, ямар ч эргэлзээгүй, дахиад л энэ ажлаа хийнэ. Тиймээс л элч Паул:

“Би үүнийг хүслээрээ хийвэл шагнал хүртэнэ. Хүслийн минь эсрэг байлаа ч нярвын үүрэг нь надад даалгагдсан юм. Тэгвэл миний шагнал юу вэ? Сайнмэдээг би төлбөргүйгээр тунхаглаж, ингэснээрээ сайнмэдээн дотор эрхээ бүрэн ашиглахгүй байх явдал юм” (1Коринт 9:17-18) гэж хэлжээ.

Та хэнд татагдаж байна?

Хэнд татагдаж байгаага олж мэдэх нь таны дуудлага, бэлгийн талаар ихийг илчилж өгнө. Зарим хүн таны дотоод бэлгийг сэрээж, тайлдаг. Адилхан бэлэг, дуудлагатай - овог нэгтнээ ол. Тэр хүмүүс таныг хэн болохыг, ямар бэлэгтэй болохыг тайлахад чинь чухал үүрэг гүйцэтгэнэ. Танай овгийнхон таныг хүлээн авч, ойлгодог хүмүүс байх ёстой.

Би үйлчлэгч нартай суугаад, үйлчлэлийн адал явдал, бэрхшээлийн талаар тэгээд мэдээж Бурханы Үгийн талаар ярилцах дуртай. Түүнчлэн энтрепренер, бизнесмэнүүдтэй суух дуртай. Тэд - миний амьдралын тал бүрийн хүч болой.

Үйлчлэлийн багийг авч явах нь олон талаараа зах зээл дээр бизнес эрхлэхтэй адилхан. Лиза, бид хоёр энтрепренер болохоос өөр аргагүй болсон. Биднийг залуу байхад, бидний хүсч байгаа шиг үйлчлэл дэлгэрээгүй байлаа. Бидэнд дуурайгаад хийчих үлгэр жишээ байгаагүй учраас, өөрсдөө л жим гаргах хэрэгтэй болсон. Иймээс л бизнесийн ертөнцийн энтрепренерүүд надад дуудлагаа биелүүлэх санаа, сэхээрэл хайрладаг юм.

Та интерьер дизайн дуртай бол, дизайнеруудтай байх дуртай байна. Та эмч бол, бусад эмч нартайгаа ярихаараа цэнэглэгдэнэ. Та хөгжимчин бол, бусад хөгжимчид танд бэлгээ бадраахад чинь тусална гэх мэт тоочоод л байвал, тоочоод л байна. Овгийнхоо олох нь бэлгээ тодорхойлох, тэр бүү хэл илрүүлэхэд чинь тустай.

Гэхдээ байна шүү - дээрх хэдэн асуултын аль ч хариулт нь Бурханаас дуудлагаа хувьчлан хайх цагийг чинь давах ёсгүй. Би хэрэв үйлчлэлээ эхэлж байхад минь хэлж ярьсан ихэнх үйлчлэгч нарын үгээр явсан бол, аль нэг хотод чуулган эхлүүлэх байсан биз. Тэр олон хүнээс тоотой хэд нь л Лиза, бид хоёрын содон дуудлага, бэлгийг харсан билээ. Нөгөөтэйгүүр, тэр цөөн хэдэн мэргэн хүн л биднийг зүрхийг маань даллах зөв чиг рүү зүглүүлж тусалсан юм.

БЭЛГЭЭ ХӨГЖҮҮЛ

Одоо эхлэл эшлэлийн хоёрдугаар хэсэгт анхаарлаа хандуулъя: “Учир нь хүн бүр ачаагаа үүрнэ (Та нар бүгдээрээ амьдралаа тулгал нь урлан хөгжүүлэх үүргээ хүлээх ёстой)” (Галат 6:5). Бурхан бүгдэд маань амьдралаа бүтээн байгуулах хүчин чадал хайрласан. Амьдралаа бүтээн байгуулах нь Бурханы хаанчлалд нэмэртэй. Гэхдээ зүгээр л нэг их овойсон хүчин чадал яваад байх нь хангалтгүйг эрт орой хэзээ нэгэн цагт бид бүгдээрээ ойлгоно.

Та, бид хоёр амьдралынхаа төгсгөлд тулж очоод, үй олон хайран боломж, бололцоог хийсгэсэндээ харуусбал, үүн шиг зовлон үгүй. Шүүх сэнтийн өмнө зогсохдоо, бид Бурханы даалгасан юмсыг хайхраагүй, хөгжүүлээгүй учраас, өөрчилж чадаагүй юмс, хүмүүсийн амьдралыг үзээд, даагдашгүй харуусалд автана.

Тиймээс үхэх үедээ юу ч хураагаагүй, өөрийгөө юу ч үгүй хоосолсон байна гэж одоо шийд. Хов хоосон болтлоо шавхсан байгаарай. Бурханаас танд заяасан бэлэг чинь дэлхийд хэрэгтэй шүү.

Бурханы өгсөн бэлэг ямар увидастай эд болохыг Сургаалт үгс 18:16 дээр маш сонирхолтой хэлсэн:

Хүнд өгсөн бэлэг сэлт хаалгуудыг нээх.
Хүндэт нэгэнтэй ч хүртэл учруулах
(Хүний бэлэг түүнд өрөө гаргаж өгөх.
Томчуудын өмнө түүнийг авчрах).

Таны бэлэг танд “өрөө гаргаж өгөөд” “аугаа хүмүүсийн өмнө” авчрах нь байна. “Өрөө гаргаж өгөх” гэдэг нь “орон зай бий болгоно” гэсэн үг. “Орон зай” нь хоёр утгатай. Нэгдүгээрт - бэлэг чинь танд хүчин чадлаа биелүүлэх өрөө гаргаж өгөөд, *таны байгаа газар* болоод таны *хурч болох газрын* хооронд гүүр болж өгнө. Хоёрдугаарт - таны бэлэг танд хувь тавилангийн шинэ төвшин рүү дэвших өрөө гаргаж өгдөг. Дэвшил бүрийг дагаж илүү өндөр төвшний ур чадвар шаардагддаг болохыг санаж яваарай. Соломон бичихдээ:

“Ажилдаа чадмаг хүнийг чи харсан уу? Тэрээр хаадын өмнө зогсоно Дорд хүмүүст эс үйлчилнэ” (Сургаалт үгс 22:29) гэжээ.

Давидыг аваад үз. 1Самуел 16 дээр Бурханы Сүнс орхиж явсан учраас, муу сүнсэнд тамлуулж буй Саул хаан гардаг. Саул тайвшрахын тулд чадварлаг хөгжимчин олж авчрахыг зарц нартаа тушаажээ.

Гэтэл нэг зарц нь: “Харагтун, би Бетлехемийн Иессийн хөвгүүнийг харсан. Тэрээр *чадварлаг* хөгжимчин, эрэлхэг хүчит дайчин, үгэнд цэцэн сайхан эр билээ. ЭЗЭН түүнтэй хамт байдаг” (1Самуел 16:18) гэдэг. Давид зүгээр нэг *бэлэгтэй* бус, харин *чадварлаг* хөгжимчин байсан. Юу түүнийг тийм *чадварлаг* болгов? Давид бэлгээ хөгжүүлсэн учраас, дуудлагадаа дэвших өрөө гарчээ.

Олон хүн бэлгээ хөгжүүлэхгүй учраас, дуудлагадаа дэвшихгүй байна уу? Бид бэлэг авьяасаа хөгжүүлсэн хэм хэмжээгээрээ л дэвшдэг байж болох уу?

Бүгдээрээ өмнөх бүлэгт эш татсан, Тимотод бичсэн Паулын үгийг дахин харцгаая. Гэхдээ энэ удаа сүнснийхээ хүүд санал болгосон Паулын эмчилгээг үзье:

Ахлагчид гар тавихад эш үзүүллэгээр дамжин чамд соёрхогдсон бэлгийг бүү үл хайхар. Ахиц дэвшил чинь бүгдэд илэрхий байхын тулд эдгээрт санаа тавьж өөрийгөө зориул (Чамд шууд дамжуулагдсан, доторх бэлгээ (дотор чинь байгаа онцгой соёрхлыг) бүү үл хайхар. ... Эдгээр ажлаа хэрэгжүүлэн, боловсруулж, тунгаан бод. Ахиц чинь хүн бүрт ил байхын тулд үүнд өөрийгөө бүрэн зориул (үйлчлэлээ болго). (1Тимот 4:14-15)

Суу ухаанаар дүүрэн энэ үгээс сурах юм их байна. Талбар дээрээ манлайлагч эрчүүд, эмэгтэйчүүд олон. Заримдаа тэдний амжилтыг “Тэд чинь онцгой бэлэгтэй төрсөн” гэдэг үгээр зөвтгөж болох. Энэ нь ч үнэн. Гэхдээ та ч бас онцгой бэлэгтэй төрсөн. Гол нь тэд хөгжүүлсэндээ л бий. Өөрөөр хэлбэл, бид л гэрчлэн хараагүйгээс биш, тэд цаанаа бэлэг авьяасаа хөгжүүлэхийн төлөө хүнд хүчир хөдөлмөрлөсөөр яваа.

Паул Тимотод хандсан үгээ Бурханы бэлгийг хайхрахгүй явж болохгүй гэдэг анхааруулгаар эхэлсэн байсныг бид өмнөх бүлгээрээ үзсэн. Бид бэлгээ юмын чинээ боддоггүй. Паул Тимотод бэлэгтээ хөрөнгө оруулбал, ахиц дэвшил чинь үзэгдэнэ гэж заасан. Үүнийгээ дадлага, боловсруулалт, тунгаалтаар хий гэсэн. Тэгвэл, эдгээрийг тухай бүр товч авч үзье:

Дадлага

Мириам - Вебстерийн толь бичгээс үзбэл, хэрэгжүүлэх нь “ашиг тусаа өгтөл нь давтаж ажиллах юмуу гүйцэтгэх” үйлдэл ажээ. Хувиараа хэр давтана - тэр хэмжээгээрээ л олон нийтийн дунд үйлдэнэ. Өөрөөр хэлбэл, давталтын төвшнөөрөө л гүйцэтгэнэ. Бид олны өмнөх гүйцэтгэлийг биширдэг атлаа тэр төвшинд хүргэсэн олон долоо хоног, сар, жилийн бэлтгэл сургууль, хүч хөдөлмөрийг нь мэддэггүй.

Ойролцоогоор арван мянган цаг дадлага хийж байж, тодорхой ур чадварын эзэн юмуу мэргэжилтэн болох боломжтойг хүний зан авир, гүйцэтгэлийн шинжлэх ухааны мэргэжилтнүүд тогтоожээ. Тийм боловч, Флорида мужийн их сургуулийн профессор Кэй. Андерс Эриксон “дадлага төгс болгоно” гэдэг уламжлалт итгэл үнэмшилд асуулга тавьжээ. Профессор маань цааш нь нэг алхам лавшруулаад, сайжрах санаа зорилгогүй, дан үйл хөдлөл давтаад байвал, арван мянган цаг ч нэмэргүйг илчилжээ. Тэрбээр үүнийгээ “зорилготой хэрэгжүүлэлт” гэсэн байна. Тэгээд ингэж бичжээ:

Тэгэхээр, бидэнд хоёр үгээр хэлбэл зорилготой хэрэгжүүлэлт

байна: Тав тухын бүсээсээ гараад, тодорхой зорилготой, тэр зорилгодоо хүрэх төлөвлөгөөтэй, ахиц дэвшлээ хянах замаар, фокустай үйлд.²¹

Бид өөрийгөө тав тух, ур чадварын төвшнөөсөө түрж гаргахаас нааш, хэзээ ч өсөхгүй. Бид “зорилготой” байхгүй бол, “дажгүй” гэдэг төвшинд хүрмэгцээ, шууд өөртөө ханана. Тэгмэгц удалгүй хэрэгжүүлэлт маань саарч эхлэх бөгөөд энэ нь бидний гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж, цаашдын үржилд саад хийнэ.

Хүчтэй талаа хөгжүүлэх нь хязгаарладаг бус, харин ч эрх чөлөө авчирдаг зүйл. Хүчтэй талаа хөгжүүлэх тусам, үржих хүчин чадал чинь өснө. Энэ нь сул талаа хөгжүүлэх хэрэггүй, шинэ ур чадвар олох хэрэггүй гэсэн үг бус, харин хүчин чадалд маань хамгийн том ашиг авчрах илүү том талбар дээр төвлөрч, хөрөнгө оруулна гэсэн үг.

Би таныг шинэ ур чадварт суралцахыг дэмжинэ. Гэхдээ дуудлагаа золионд гаргаж болохгүй.

Товчхондоо: Өсөлт автоматаар явагдахгүй. Өсөлтөд санаатай зориулалт шаардлагатай. Бид бэлгээ “чадваржуулахын” тулд тасралтгүй хэрэгжүүлэхээс нааш, бүрэн хүчин чадлаа хэзээ ч олж мэдэхгүй. Тиймээс л хувийнхаа өсөлтөд ямагт анхаарах ёстой. Олон хүн аугаа амьдрахыг хүсдэг ч, цөөхөн хүн л аугаа хүн болоход шаардагдах ажлыг хийх хүсэлтэй байдаг. Дадлага нь аугаа шагналд хүрэхийн төлөө төлөх ёстой үнэ төлөөс билээ.

Боловсруулах

Дадлага нь хэрэгжүүлэлт бол, боловсруулах нь боловсрол, гэгээрэлтэй холбоотой. “Боловсруулах” гэдэг нь “мэдлэг боловсрол, сургалтаар хөгжүүлэх, сайжруулах, өсөлт, хөгжлийг нь дэмжин тэтгэх”²² гэсэн үг.

Боловсруулах гэдэг үгийг бодохоороо “дасгалжуулалтыг” сана. Дасгалжуулалт нь хүнийг өөрөө өөртөө бий болгож чадахгүй бүтээлч шүүмжлэл, удирдамжаар хангаж өгдөг учраас, хувь хүний өсөлт, хөгжилд амин чухал юм. Амьдралдаа бусдын дасгалжуулалт, чиглүүлэг дор сургагдсан хүн л бэлэгтээ гаршдаг. Хүний хүчин чадлыг олж хараад, хатуу, зөөлөн - ямар ч аргаар хамаагүй, тултал нь шүүж гаргах нь дасгалжуулагч хүний гайхамшигт чанар!

Дасгалжуулалт нь ментор - менти (зөвлөгч - зөвлүүлэгч), аав - хүү, ээж - үр хүүхэд, багш - оюутан, дасгалжуулалтын харилцаа,

дагалдуулалт, дадлагажуулалт эсвэл шууд хаа сайгүй байгаа ном, дамжаа, эх үүсвэр гэх мэт замаар өрнөж болно.

Бэлгээ боловсруулах өөр нэгэн арга зам нь төстэй бэлэгтэй хүмүүсийг нэгтгэх юм. Энэ талаар би өмнө “овгийнхноо ол” гэдэг хэсгээрээ өгүүлсэн. Ижил төстэй бэлэг, хүсэл тэмүүлэлтэй хүмүүсийн дунд байх нь хамтдаа гар нийлэн ажиллах, шинийг сэдэх боломжоор хангадаг.

1930-1940 онд Инклингчүүд нэрээрээ алдаршсан хэсэг бүтээлч зохиолч нар Оксфордын их сургуулийн ойролцоох уушийн газрын тусгай өрөөнд уулзалддаг байжээ. Тэдгээр утга зохиолд дурлагсдын дунд Си. Эс. Люис, Жэй. Ар. Ар. Толкиен нар байв. Тэр уулзалт нь гишүүдийнхээ дуусгаагүй бүтээлийг уншиж, шүүмж дүгнэлт өгөх зорилготой байж. Үүнээс л Толкиений *Бөгжний эзэн*, Люисийн *Нарниагийн домог* мэндэлсэн. Овог гэдэг ийм л аугаа!

Тунгаан бодох

“Тунгаан бодох” нь “тунгаах, эргэцүүлэх” гэсэн утгатай. Заримдаа түр зогсоод, тунгааж эргэцүүлсний үр дүнд өсөлт явагддаг. Бид өсөлтөө шударгаар хянаж, ахиц дэвшил, гүйцэтгэлээ шударгаар үнэлж цэгнэх үедээ л анхаарах хэрэгтэй, сайжрах хэрэгтэй, онцгой талаа ухаарч мэдэх байр сууринд хүрдэг.

Манай найз Жон Максвел сонсогч, уншигч нартаа “туршлага өөрөө сайн багш болдог бус, *турилагаа үнэлж дүгнэх* нь сайн багш болдгийг” сануулдаг. Ахиц дэвшлээ эргэцүүлэн тунгаахдаа, дасгалжуулагч, нөхдөөсөө сонссон хариултаа зүрхэндээ шингээхийн зэрэгцээ бэлгээ сайжруулах, хэрэгжүүлэх шинэлэг арга замыг санаачил. Өөрөөсөө болоод Бурханаас зөв асуулт асуу: Би юуг өөрчлөх хэрэгтэй байна? Миний хамгийн том өсөлт юу вэ? Би аль талдаа илүү анхаарах хэрэгтэй байна? Шинэ төвшин рүү үсрэхэд, надаас юу шаардагдаж байна?

ЮУГАА Ч БҮҮ ХАДГАЛ

Эцэст нь Тимотод хандсан Паулын үгийг дахиад нэг үзье:

Ахиц дэвшил чинь бүгдэд илэрхий байхын тулд эдгээрт санаа тавьж өөрийгөө зориул. (1Тимот 4:15)


Ярьсан үзсэн бүхэн маань бидэнд өгсөн Бурханы бэлэг, дуудлагад хэр үнэнч байхаас л бүрэн шалтгаална. Дуудлага танаас бүрэн зориулалт шаардана. Бурханы бидэнд даалгасан зүйлд бүрэн зориулагдах үед ахиц маань бүгдэд илэрхий болж, бид хүчин чадлаа үржүүлнэ.

Хүн бүр бэлгээ захиран зарцуулж, аль болох бүтээлчээр амьдрах үүрэгтэй. Бэлэг авьяасын хөгжил маань дуудлагын талбартаа ахиц дэвшилтэй байх, үр нөлөөгөө үржүүлэх шийдвэрлэх хүчин зүйл болдгийг бид мэдлээ.

Энэ амьдралдаа байгаа бүхнээ өгөх боломж хүн бүрт бий. Юу ч хадгалалгүй, эргүүлэн Бурханд бэлэглэж, хоосорцгооё. Энэ бол жинхэнэ амьдрал. Энэ үед л бид жинхэнээсээ амьд байж, жинхэнээсээ амьдарна.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

1. Дуудлага илрүүлэх томъёо байхгүй. Таны давуу талыг илрүүлж туслах олон эх үүсвэр байдаг ч, Бурханы тусламжгүйгээр дуудлага, бэлгээ олох боломжгүй. Та дуудлага, бэлгийнхээ талаар Бурханаас асуусан уу? Бурхан танд юу харуулав?
2. Дуудлагынхаа араас явахдаа, бид өөртөө болоод бусдад асуулт тавих хэрэгтэй. Энэ нь үйл явцсын нэгээхэн хэсэг юм. Итгэж болох хүмүүсийг олоод, таны дээр, таны дотроос юу харж байгааг нь асуу.
3. Зүгээр хүчин чадал тээх нь дангаараа хангалтгүй. Хүчин чадлаа хэрэгжүүлэх хэрэгтэй. Бэлгээ хөгжүүлэх нь яагаад чухал вэ? Бэлгээ санаачлагатайгаар өсгөж, хөгжүүлэх үед юу болдог вэ?



*Христ дотор биднийг та нартай хамт
бататгаж тосолсон нь Бурхан мөн.*

— 2Коринт 1:21

Тослогдсон

Өнгөрсөн Талархлын баяраар манай гэрийнхэн том өрөөндөө ширээгээ тойроод сууж байлаа. Лиза үнэхээрийн сайхан найрын ширээ засч, бид бүгдээрээ л сайхан хоолны дараа гэдсээ илцгээж, хоорондоо хөгжилдөж байлаа. Тэр үед би аав хүнийхээ зүгээс гэр бүлдээ болоод бидэнтэй хамт баяр тэмдэглэж байсан багийнхандаа хэдэн жинтэй үг хэлэх хэрэгтэй юм шиг санагдав.

Чимээгүй дотроо залбирсны дараа зүрхнээсээ: “Залуус аа, би одоо жаран настай. Тэгээд олон талаараа аав хүнийхээ хувьд бяцхан цэц ухаан хуваалцах үүрэгтэй гэж бодож байна. Өнгөрсөн дөчин жилийн хугацаанд Лиза, бид хоёрыг Бурхантай хамт алхахдаа хийсэн хамгийн чухал зүйл маань юу вэ гэж асуубал, би *тууштай байсан* л гэж хариулна.

Энэ хугацаанд бид маш олон боломж алдсан. Түүнээс гадна олон боломж нь амин хувийнхаа төлөө, өөрийгөө дэвшүүлэхийн төлөө үнэнийг хөсөрдүүлэх юмуу эсвэл шүүхийг хөнгөвчлөх боломж байдаг. Гэхдээ бид үнэнийг зангуугаа болгож, нөхцөл байдал хичнээн хүнд байсан ч, үүнээсээ зуурсаар байсан.

“Тэгвэл энэ нь надад тайтгарал болж, Хөнөөлт өвчиндөө ч би баярлахсан. Учир нь би Ариун Нэгэний үгсээс урваагүй юм” (Иов 6:10). Би алдаа гаргахдаа (би зөндөө алдаа гаргасан), Бурханаас ч, хүнээс ч бушуухан уучлал гуйж гэмшдэг байсан. Одоо үнэнд тууштай дуулгавартай явсныхаа ерөөлийг хараад юу гэж хэлэхээ мэдэхгүй байна. Бурхан үнэхээрийн нигүүлсэнгүй ажээ” гэж хэлсэн юм.

ТОСОЛГОО

Үнэнд тууштай захирагдахыг дагасан аугаа ерөөл нь “тосолгоо” болой. Үүнийг ойлгохын тулд аугаа томилгоо руу эргэе - Бурхан Аав нь Есүсийг тэнгэр, газрын Хаанаар тохоон томилсон тэр өдөр рүү эргэе.

Та зөвт байдлыг хайрласан бөгөөд Ёс бусыг үзэн яджээ. *Тиймээс* Бурхан, Таны Бурхан, *Нөхдийн тань дээгүүр* Таныг баяр баяслын тосоор *тослов*. (Еврей 1:9)

Тиймээс гэдэг үгийг анхаарна уу. Учир нь энэ үг танд түлхүүр үнэнийг ойлгуулж тусална. Есүс хоёр зүйл дээр бат зогсдог байсан нь эргээд Түүнд ач тусаа өгсөн бөгөөд бид ч Есүсийг даган дуурайх ёстой. Есүс *зөв шударга ёсыг* хайрласан. Үүнийг Грекээр *дайкайосуне* гэх бөгөөд “дээд эрх мэдлийн шаардлагад нийцэх” гэж тодорхойлно.²³ Тийм боловч Есүс нэгэн зэрэг *хуульгүй байдлыг* үзэн ядсан. Хуульгүй байдалд *дургүй* итгэгчид олон чиг, Есүс ийм зүрх сэтгэлтэй байгаагүй: Есүс хуульгүй байдлыг *үзэн яддаг*. Үүнийг Грекээр *аномиа* гэдэг бөгөөд “Бурханы эрх мэдэлд дуулгаваргүй байх” гэсэн утгатай. Хичнээн хэцүү байлаа ч туж дуулгавартай байсных нь ачаар л Есүсийн амьдрал дээр тосолгоо оршиж, бүх нөхдөөсөө хүчирхэг байв.

Би үржлийн талаарх энэхүү номоо яагаад *тосолгооны* талаарх яриагаар төгсгөх болов? Хариулт нь энгийн боловч, чухал юм: *Тосолгоо нь Бурханаас бидэнд өгсөн чадварыг мөнхийн үржилтэй болгон цэнэглэж байдаг*. Таны бэлгийг өсгөгч л гэж бодчих. Хоёр товч жишээ хэлье.

Хоолойнхоо хүчээр бишрүүлдэг дуучид олон чиг, тэднээс сул хоолойтой дуучид зүрх сэтгэлийг минь хавьгүй хүчтэй хөндөж, амьдралыг маань өөрчлөх тохиолдол байдаг. Ялгаа нь *тосолгоондоо* л бий. Супер илтгэл тавьдаг хүмүүс олон чиг, тэднээс зөөлөн үгтэй хүмүүс зүрхийг минь олзолж, зан авирыг маань өөрчлөх тохиолдол бас байдаг. Ялгаа нь *тосолгоондоо* л бий.

Бурханы зарц нар бүгдээрээ засаг барих, бизнес, урлаг, боловсрол гэх мэт аль талбарт дуудагдсанаасаа үл хамааран, яг ижилхэн үр нөлөө үзүүлж чадна. Давид хаан ингэж хэлсэн:

Харин Та эврийг минь (хүч, эрхэмсэг тааллын сүлдийг минь) зэрлэг үхрийнх мэт өргөмжилсөн. Та над дээр шинэхэн *тос цутгасан*. (Дуулал 92:10)

Олон илчлэлтэй үг байна. Энэ эшлэлийн талаарх хэд хэдэн гол тайлбарыг үзэхэд, бүгдээрээ л “зэрлэг үхэр” гэдэг үг дээр бус, харин “Та намайг маш хүчирхэг болгосон” гэсэн санаан дээр гол төвлөрөл нь оршиж байгааг харилцан зөвшөөрсөн байдаг. Тосолгоо нь баяр хөөрийг авчирдаг. Бурхан үүнийг *жаргалын* буюу *баяслын тос* гэдэг бөгөөд Бичээсээс үзбэл, энэ нь бидний хүч ажээ (Нехемиа 8:10-г үзнэ үү). Үндсэндээ тосолгоо биднийг хүчтэй болгодгийг магтаалч хэлжээ. Тосолгоо мөнхийн үр жимс ургуулах авьяас бэлгийг маань дэмжиж, улам бэхжүүлж өгдөг.

Тосолгоо нь талант, минагийн сургаалт үлгэр дээр дурьдагдаагүй боловч, тоглоомын явцыг өөрчилсөн, чухал тал гэдэгт би итгэдэг: Үржүүлсэн зарц нар нь тосолгоогоор хүчижсэн байжээ. Энэ нь бичээсийн үндэслэлтэй үнэн учраас л би “дурьдагдаагүй” гэж хэлсэн учиртай. Тэдний хувьд, үржихийн төлөө эзнийхээ зааврыг зөрчихийг үзэн ядаж, туж дуулгавартай байх нь амин чухал байв. Ингэж байж л бэлгээ хүчжүүлэх тосолгоог татна.

Давид тос *шинэ* байх талаар дурьдсан. Тосолгоо нь ганц удаагийн үйлдэл биш, харин Бурханд туж захирагдаж амьдардаг хүний дотор эхэлж, үргэлжилдэг ерөөл болой. Амьдралдаа ганц удаа тослогдоод л, дархлаа тогтчихно гэж байхгүй. Самсон тослогдсон боловч, шинэ тосолгоогоор сэлгэж чадаагүй. Тэр байнга найраанд автаж, дуулгаваргүй загнадаг байсан. Тэр хуульгүй байдлыг үзэн ядаагүй. Тэр хэд хэдэн удаа аргалаад өнгөрсөн ч, эцэстээ нүгэлдээ дөнгөлүүлсэн.

... Самсон суларч сулдайн хүч нь *арилжээ*. Мөнөөх эмэгтэй (Делила) —Самсон, дээрээс чинь филистчүүд гэж бархирав. Самсон нойрноосоо сэрж —Би өмнөх шигээ гарч яван, биеэсээ тэднийг таягдан сэгсэрье хэмээв. Харин ЭЗЭН түүнийг орхисныг тэр мэдсэнгүй. (Шүүгчид 16:19-20)

Тосолгоо нь авагдсаныг Самсон мэдээгүй. Тиймээс л Давид Батшебагийн тал дээр дуулгаваргүй авирласан хойноо:

“Бурхан, миний дотор цэвэр зүрхийг бүтээж, Миний дотор зөв сүнсийг шинэчлэн авчраач. Оршихуйгаасаа намайг бүү холдуулаач. Ариун Сүнсээ надаас бүү аваач. Авралынхаа баясгаланг надад сэргээж өгч, Хүсэл зоригийнхоо сүнсээр намайг тэтгээч” (Дуулал 51:10-12) хэмээн үнэн голоосоо залбирсан.

Давид амьдрал дээрх тосолгоогоо алдахгүйн төлөө уйлан хайлан, чин зүрхнээсээ залбирсан бөгөөд тосолгоо нь Бурханд *туждаа* бөгөөд үнэнчээр дуулгавартай байхаас л хамаарахыг тэрбээр мэдэж байжээ.

Бүгдээрээ тосолгооныхоо талаар, тосолгоо нь хэнд өгөгддөг талаар үргэлжлүүлэн судлая. Бүлгийнхээ эхэнд цохон тэмдэглэсэн Паулын мэдэгдлийг дахин харна уу:

Христ дотор биднийг та нартай хамт бататгаж *тосолсон нь* Бурхан мөн. (2Коринт 1:21)

“Тослогдсон” гэхийг Грекээр *крио* гэдэг. Энэ нь “хүнд зөвшөөрөл, ерөөл, соёрхлын хамт даалгавар хүлээлгэх - тослох, товлох, томилох”²⁴ гэсэн утгатай.

Энд хайхралгүй өнгөрч болохгүй, хэд хэдэн түлхүүр үг байна. *Зөвшөөрөл* гэдэг үгийг “Эрх мэдэлтний зүгээс үйлдэх зөвшөөрөл, баталгаа олгох” гэж тодорхойлдог. Товчхондоо, *тосолгоо нь үйлдэхийг зөвшөөрсөн тэнгэрийн батламж* ажээ. Есүс “Над дээр Эзэний Сүнс байна. Учир нь... *Намайг Эзэн тосолсон*” (Лук 4:18) гэсэн. Тосолгоо нь Есүст ямарваа нэгэн зүйлийг *үйлдэхийг зөвшөөрсөн батламж* байжээ. Элч Петр ч үүнтэй адил “Энэ нь Бурхан хэрхэн Назарын Есүсийг Ариун Сүнс ба хүч чадлаар *тосолсон* хийгээд Тэрээр диаволд дарлагдсан бүгдийг эдгээн, сайныг *үйлдэж явсан* тухай юм. Учир нь Бурхан Түүнтэй хамт байсан” (Үйлс 10:38) хэмээн мэдэгдсэн. Энд мөн л аливаа үйлсийн төлөө гэж байна.

Криогийн өөр нэгэн түлхүүр бүтэц нь товлох буюу томилох гэсэн *тодорхой* үгс юм. Бурханд үйлчилж байхад, шалгуулах үе заавал байна. Бид тохоон томилогдохоосоо өмнө заавал дуулгавартай эсэхээ шалгуулна.

Есдүгээр бүлэгт гарсан Майкт Бурхан эцсийнхээ 200 долларыг

өргө гэх үед Майк хамгийн том шалгалтаа өгчээ. Лиза, бид хоёрын хувьд, ном бичих тэнгэрийн тушаалд үнэнчээр зориулагдах уу, үгүй юу гэдгээ шалгуулсан. Манай эхний хоёр номыг хэвлэлийн газрууд ч, уншигч хүмүүс ч сонирхоогүй.

Есүс “Олон хүн дуудагдсан ч, цөөх нь сонгогдсон” (Матай 20:16, 22:14) хэмээн нэг бус удаа хэлсэн. *Олон* гэдэг үг нь Түүнд хамаатай бүх хүнийг хэлж байгаа гэдэгт би итгэдэг. Хүн бүр тэнгэрийн дуудлагатай. Тийм боловч, сонгогдсон гэдэг нь “томилогдсон” гэсэн үг бөгөөд Есүсийн хэлснээр энэ тоо нь цөөхөн байх нь. Яагаад? Учир нь давж гарах ёстой, батламжлуулах үйл явц гэж байна. “Христ дотор (*мэрийгээд*) сайшаагдсан (*батламжлуулсан*) Апелд мэнд хүргээрэй” (Ром 16:10-ыг үзнэ үү) гэдэг үгийг анхааралтай уншина уу.

Бид бүгдээрээ л хувь тавилангаа биелүүлэх аялалд гарахыг хүсдэг шиг Апел ч шалгуураар орсон. Тэгээд мэдээж *сонгогдож, батламжлуулахаасаа* өмнө шалгалтаа давжээ. Апел тослогдсон гэдгийг бид Бичээсийн зарчмаас хэлүүлэлтгүй мэднэ. Яагаад гэвэл Апелийн бэлэг дээр Бурханы, өсгөгч хүрэлт байжээ.

Жинхэнэ дуудлагатай атлаа цагаасаа өмнө өөрийгөө толгой мэдэн томилсон хүмүүс олон байдаг ч, хүн өөрийнхөө бус, тэнгэрийн батламжийн төлөө хичээх ёстой юм:

Учир нь өөрийгөө сайшаадаг нь бус, харин Эзэнээр сайшаагддаг нь шалгарна (Учир нь (болбоос) өөрийгөө магтдаг бөгөөд сайшаадаг (хүн) нь зөвшөөрөгддөг *бөгөөд* хүлээн авагддаг бус, харин Эзэний магадлан итгэмжилсэн *бөгөөд* сайшаасан хүн... (2Коринт 10:18)

Бүгдээрээ нөгөө Талархлын баярын оройн зоог руугаа буцъя. Би тэнд байсан гэр бүлдээ ч, багийнхаа гишүүдэд ч зөв шударгыг хайрлаж, хуульгүй байдлыг үзэн ядаж, туж дуулгавартай явах нь хувь тавилангаа биелүүлэхэд амин чухал болохыг аминчлан захисан билээ. Яагаад гэвэл ийм тууштай байдал л биднийг Бурханы тосолгоонд хүргэдэг.

Туулсан амьдралаа эргээд харахад, Лиза, бид хоёр үнэхээрийн хүнд цаг дундуур ч Бурханыг дуулгавартайяа дагасан байдаг юм. Тэр дуулгавартай байдал маань ямар ч үр бүтээлгүй, тэр бүү хэл бидний өсөлт, сайн сайхан, нэр алдарт хор уршигтай юмуу амин

хувьд маань ашигтай алтан боломжуудыг алдахад хүргээд байгаа мэт харагдуулах ч үе байв. Тийм боловч, богины замд сул тал мэт харагдаж байсан зүйл хувь тавиланд маань ач холбогдолтой хаалгыг тайлах зөв түлхүүр болж таардаг байсан юм.

ТАНЫ ЗОРИУЛАЛТ

Та итгэлийн том, том баатруудын нэгэн адил дуудагдсан. Магадгүй та чуулганы ертөнцөд дуудагдаагүй байж болох. Учир нь энэ давхаргад маш цөөхөн хүн л дууддагддаг. Тийм боловч та илгээгдсэн талбартаа онцгойрон манлайлж чадна.

- Даниел Вавилоны төрийн албанд *өөрийгөө онцгойруулсан* (Даниел 6:3-ыг үзнэ үү).
- Иосеф Египетийн их гүрэнд *өөрийгөө онцгойруулсан* (Эхлэл 41:39-ийг үзнэ үү).
- Фойбе Генхрей дэхь сайн мэдээний үйлчлэлд *онцгойрсон* (Ром 16:1).
- Таны дуудлага ч юугаараа ч дутахгүй.

Та *хосгүй онцгой бэлэгтэй*. Бурхан таны дээр даалгавраа биелүүлэхэд шаардлагатай чадварыг байршуулсан.

Безалел болоод түүний хамт олны талаар Бичээс юу гэж бичсэнийг л үз: “Ариун газрын үйлчлэлийн бүх төрлийн ажлыг хэрхэн гүйцэтгэхийг мэдэх *мэргэн ухаан*, ойлголтыг (*чадварыг*) ЭЗЭНээс авсан Безалел, Охолиаб, мөн *ур авьяаст* хүн болгон ЭЗЭНий тушаасан бүхнийг ёсоор гүйцэтгэхээр болов” (Гэтлэл 36:1). Энэ эрчүүд Мосе, Аарон, түүний хөвгүүд шиг Бурханы Үгийг ярьж, хүмүүст үйлчлэх чадвартай байгаагүй ч, майхан сүмийг барьж босгох гарын уртай хүмүүс байжээ.

Та ч бас Бурханы майхан сүмийг Түүний өгсөн ураар байгуулах бэлэгтэй. Тийм боловч, энэ ариун газар нь алт, мөнгө, хүрэл, үнэт чулуу, доргын арьс, нарийн даавуу, хуайс мод зэрэг Хуучин гэрээний майхан сүм юмуу Иерусалим дахь сүмийн барилгын материалаар хийгдээгүй. Өнөөдөр Бурханы майхан сүм нь амьд чулуу болох хүмүүсээр баригдаж буй бөгөөд эдгээр амьд чулуу нь Бурханы сууц болон сүндэрлэж байна (1Петр 2:5, Ефес 2:20-22-ыг үзнэ үү). Та Бурханы алдрын төлөө хүмүүсийг барьж байгуулах бэлэгтэй.

Та үржих хүчтэй. Бид Бурханы өгсөн бэлэг авьяасын нярвууд бөгөөд Бурхан та, бид хоёрыг бэлгээрээ ургуулж, үржүүлсэн үр жимсээ Өөрт нь эргүүлж бариасай гэж хүсдэг. Үржүүлэхийн тулд бид тэнгэрийн стратегийг хайх ёстой. Зарчмыг удирдагч нараасаа сурч болох. Тэгвэл тэнгэрийн онцгой стратеги нь бичиг номоос юмуу анги танхимд сурдаггүй, Бурханаас хувьчлан сурдаг зүйл.

Удирдагч - бид таныг гагцхүү Бурханыг эрэлхийлж, дуу хоолойг нь сонсоход л ятган уриалж чадна. Бурханыг дага - нэг их чухал бус харагдаж байсан ч, дага. Ихэвчлэн нэг их ач холбогдолгүй гэмээр харагдаж байсан зүйлс л үржиж таардаг. Үр үрээс хамгийн өчүүхэн нь болох гичний үр л хамгийн том мод болдгийг бүү март.

Хөрөнгө оруулж үрж. Энэ олон хэлбэртэй үйлдлийг хэрэгжүүлбэл, ерөөлийн ургац бууна. Тариагүй (хөрөнгө оруулаагүй) үр ганц хэвээрээ л байна. Харин хөрөнгө оруулах юм бол, үржсэн их ургац гаргана. Дараа нь та ургацаа нөөцөлнө эвсэл дахин хөрөнгө оруулна. Гагцхүү хөрөнгө оруулахаа хэзээ ч бүү зогсоо - энэ бол дараачийн шатанд гаргах түлхүүр.

Үйлчлэх нь өөрчлөгч хүчин зүйл. Үйлчлэхээс өөр сэдэлтэй байвал, та хүсээгүй газраа газардаж таарна. Бусдын нүдэнд гялтагнаж байв ч, дотроо гал алдана. Дэнлүү шиг бүрсийсээр, бүүдийсээр таг унтарна. Гэвч Есүс бүүдийсэн дэнлүүг бөхөөхгүй учраас тайвшир. Тэрбээр галыг чинь өрдөхийн тулд анхаарлыг чинь байнга татна (Исаиа 42:3). Та юу ч хийсэн, үйлчлэхийн төлөө яв, хоёр нүүргүй хайрла, бэрхшээлтэй улаан нүүрээрээ тулаад, залгиад гар.

Тосолгоог хүс. Тосолгоо нь таныг тамиржуулагч юм. Тосолгоо нь таны ажлыг мөнхийн болгохын тулд амьд байлгана. Тосолгоо таны хүчийг нэмэгдүүлж, таныг дуудлагын чинь талбар дээр онцгойруулна. Энэ нь таныг дэлхийн хүмүүсээс, тэр бүү хэл Бурханы өгсөн бэлгийг амин хувийнхаа юмуу газрын зорилгоор хэрэглэдэг чуулганы хүмүүсээс тусгаарлана.

Танд итгэл байх ёстой. Энэ бол Бурханы өгсөн хүчин чадлыг үржүүлэх цорын ганц зам. Итгэлгүйгээр “Бурханд таалагдах боломжгүй” (Еврей 11:6). Өсөхийн тулд та Бурханы Үгийг сонсох ёстой. “Тиймээс итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг” (Ром 10:17) гэсэн. Сонсох тэгээд сонсох бас дахин сонсох нь Бурханы Үгийг зүрхэнд маань бат тогтоодог. Тиймээс л энэ номыг ахин дахин унших нь ухаалаг болно. Гэхдээ зүгээр нэг уншаад өнгөрч болохгүй! Номоо тавиад, доторх үнэн нь

танд хэрхэн хэрэгжихийг тунгаан бодоод, хэрэгжүүл. Энэ номд системтэй гаргаж тавьсан Бурханы Үгийг унших, тунгаан бодох, залбирлаараа дамжуулан сүнсэндээ “нөхцөл байдал ямар ч байсан, би үржүүлэхээр дуудагдсан” гэдэгтээ бат итгэдэг болтлоо нэвтрүүл. Үржүүлэх энэ дотоод бат үнэмшил чинь гадаад нөхцөл байдлын чинь дуу хоолойгоос томорч өснө.

Эцэст нь *Бурхан таны төлөө* гэдгийг мэдээрэй! Бурхан бидэнд тодорхой хэлсэн:

“Учир нь та нарт зориулж байгаа төлөвлөгөөнүүдийг Би мэдэх бөгөөд тэдгээр нь та нарт ирээдүй ба найдварыг өгөх гай гамшгийн бус, сайн сайхны төлөөх төлөвлөгөөнүүд юм.”
(Иеремиа 29:11)

Тэгвэл бид эдгээр зүйлийн тухайд юу хэлэх вэ? Хэрэв Бурхан бидний талд юм бол, хэн биднийг эсэргүүцэх вэ? Тэр Өөрийн Хүүг харамлалгүй, харин Түүнийг бид бүхний төлөө тушаасан юм. Тэгвэл Тэр яаж бүх юмыг Түүний хамт бидэнд сул өгөхгүй байх билээ? (Ром 8:31-32)

Урам хугалагч, тэргүүн ялагч болох энэ дэлхийн бурхнаас гаралтай гутаагч үгсийг бус, Бурханы дээрх үгсийг сонс. Бүтээгч тань таны Аав бөгөөд таныг дуудагдсан ажил үйлсдээ амжилт олохыг босон суун хүсдэг.

Эдүгээ жар хүрсэн, итгэл доторх аав хүнийхээ хувьд би ч бас таны төлөө байна! Бидний үеийнхэнээс алс бөгөөд өндөр явахыг чинь үзмээр байна. Бид нэг л Хаанд үйлчилдэг, нэг л хаанчлалын иргэд, нэг л бүлийн гишүүд, нэг л итгэлтэй, Бурханы мөнхөд оршин суух өргөө гэрийг барих нэг л даалгавартай.

Гар нийлэн ажиллацгаая. Нэг байж, нэгдлээ хадгалъя. Бурханы алдар оршин суух газартаа дахин бялахыг нь үзье. Дэлхийн асуудлыг шийдэх өөр арга байхгүй.


Би танд хайртай. Гэхдээ Бурхан Аав, Бурханы Хүү Есүс Христ, Ариун Сүнс танд бүр ч их хайртай. *Тэдний хайр мөнхийн хайр.*

“Та нарыг бүдрэхээс хамгаалж, Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, өө сэвгүйгээр зогсоож чадах Түүнд, бидний Аврагч болох цорын ганц Бурханд, бидний

Эзэн Есүс Христээр алдар суу, сүр жавхлан, сүр хүч, эрх мэдэл нь бүх цагаас өмнө, эдүгээ болоод мөнхөд байх болтугай. Амен.” (Иуда 24-25)

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

1. Тосолгоо нь Бурханы өгсөн чадварыг үржүүлэх шатахуун юм. Тосолгоог хэрхэн боловсруулдаг вэ? Бэлэг авьяасыг хэрэгжүүлэхэд тосолгоо ямар өөрчлөлт авчирдаг вэ?
2. Тосолгоогоог хэрхэн шинээр нь хадгалах вэ? Тосолгоонд дархлаа шиг хандбал, юу болох вэ?
3. Та амьдралын аль талбар дээр өөрчлөлт авчрахаар дуудагдсан бэ? Тосолгоо таныг нөлөөллийн чинь хүрээнд хэрхэн онцгойруулах вэ?



*Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч,
Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ
итгэвэл, аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд
хүрч, амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрнэ.*

— Ром 10:9-10

Хавсралт

Бүгдэд нээлттэй аврал

Бурхан таныг бүрэн дүүрэн амьдраасай гэж хүсдэг. Тэрбээр таныг гэхээр л сэтгэл нь дүрэлздэг бөгөөд амьдралд чинь хандсан төлөвлөгөө зэхсэн байдаг. Гэхдээ хувь тавиландаа хүрэх замыг эхлүүлэх цорын ганц арга нь: Бурханы Хүү Есүс Христээр дамжин авралыг хүлээн авах.

Есүсийн үхэл, амиллаар дамжуулан Бурхан таныг Өөрийнхөө хайртай хүү, охин болгон хаанчлалдаа угтан авах зам гаргажээ. Есүсийн загалмай дээрх тахил нь танд мөнхийн баялаг амьдралыг нээж өгчээ. Аврал нь танд өгсөн Бурханы бэлэг бөгөөд та авралыг юугаар ч олж авч чадахгүй.

Энэ үнэт бэлгийг хүлээн авахын тулд эхлээд Бүтээгчээсээ тусгаар, дураараа амьдарсан нүглээ хүлээн зөвшөөр. Энэ нь таны хийсэн нүглийн хамаг үндэс юм. Энэ гэмшил нь авралыг хүлээн авахад амин чухал хэсэг болно. Үйлс ном дээр таван мянган хүн аврагдсан тэр өдөр Петр үүнийг тодорхой хэлсэн: “Иймээс гэмшицгээ. Гэм нүглээ үгүй болгохын тулд эргэцгээ” (Үйлс 3:19). Хүн бүр нүглийн боол болж төрснийг Бичээс мэдэгддэг. Энэ боолчлол нь санаатай дуулгаваргүй байдлын үлгэр загварыг эхлүүлсэн Адамын нүглээс үндэстэй. Гэмшил нь өөртөө бөгөөд худалчдын эцэг Сатанд дуулгавартай байх явдлаас салж, таны төлөө амиа өгсөн, шинэ Эзэнтэн Есүс Христ рүүгээ дуулгавартай эргэх сонголт юм.

Та Есүсийг Эзэнээ болгож, амьдралынхаа жолоог атгуулах ёстой. Есүсийг “Эзэн” болгоно гэдэг нь өөрт байгаа, өөрийн гэх бүхнээ - амьдралынхаа (сүнс, сэтгэл, биеийнхээ) мэдлийг өгнө гэсэн үг юм. Тэр таны амьдрал дээр төгс мэдлээ тогтооно. Үүнийг хиймэгц, Бурхан таныг харанхуйгаас чөлөөлж, Хаанчлалынхаа гэрэл, алдарт гаргана. Та үхлээс амь руу нэвтэрч, Түүний хүүхэд болно!

Хэрэв та Есүсээр дамжих авралыг хүлээн авмаар байвал, дараах залбирлыг хэлнэ үү:

Тэнгэрийн Бурхан минь, би өөрийгөө нүгэлтэн бөгөөд Таны зөвт байдлаас хол дутна гэдгээ хүлээн зөвшөөрч байна. Би нүглээсээ болж мөнхийн шийтгэл авах зохистой хүн. Гэхдээ Та намайг энэ чигээр минь үлдээгээгүйд баярлалаа. Та миний төлөө Өөрийнхөө цорын ганц хайртай Хүү Есүс Христийг илгээсэн. Тэр онгон Мариагаас мэндлэж, миний төлөө миний шийтгэлийг үүрэн Загалмай дээр үхсэн. Гэвч Тэрбээр гурав дахь өдрөө дахин амилуулагдаж, одоо миний Эзэн бөгөөд Аврагч болон Таны баруун гарт залран суугаа гэдэгт би итгэж байна. Тиймээс энэ өдөр би Танаас тусгаар, дураараа байдлаа гэмшин, амьдралаа бүхлээр нь Есүс Эзэний мэдэлд өргөж байна.

Есүс ээ, Та одоо миний Эзэн бөгөөд Аврагч. Сүнсээрээ амьдралд маань ирээд, намайг Бурханы хүүхэд болгооч. Би урьд нь холбоотой байсан харанхуйн юмсаасаа бүрэн салж, өнөөдрөөс эхлэн өөрийнхөө төлөө амьдралгүй, харин нигүүлслээрээ намайг мөнх амьдруулахын төлөө Өөрийгөө өгсөн Таны төлөө амьдарна.

Эзэн минь, баярлалаа. Одоо миний амьдрал бүхлээрээ Таны гарт очлоо. Тиймээс Таны хэлснээр би одоо хэзээ ч ичихгүй. Есүсийн нэрээр. Амень.

Бурханы гэр бүлд тавтай морилно уу! Өөрийнхөө баярт мэдээг бусад итгэгч нартайгаа хуваалцаарай. Библид итгэдэг нутгийн чуулганд хамрагдаж, шинэ итгэлийг чинь урамшуулан дэмждэг хүмүүстэй холбогдох нь чухал шүү.

Ийнхүү та хамгийн ер бусын аян замд гарлаа. Өдөр өдрөөр Бурхантай илчлэл, нигүүлсэл, нөхөрлөлөөр өсөх болтугай!

Талархал

Таны гар дээрх энэ ном хамтын бүтээл учраас, хувь нэмрээ оруулсан хамтран зүтгэгч нартаа талархлаа илэрхийлмээр байна:

Брюс Нугренд: Номын маань агуулгыг хянан тохиолдуулах их ажилд туршлагаа хайрласанд баярлалаа. Чи энэ удаа ч бас миний эх бичмэлийг аваад, дуу хоолойг минь хадгалсан атлаа хэл бичгийн талаас нь мэргэжлийн төвшинд боловсруулжээ. Түүнчлэн надад тавьсан хүнд, хүнд асуултынхаа хүчээр номыг маань хавьгүй жинтэй бас тодорхой болгож өгсөнд баярлалаа.

Кори Емберсон, Лаура Виллбур, Лоран Жонсон гуравтаа: Номын маань дүрэм, цэг таслал, зохиолын хэлбэрийг нэг төвшинд, оновчтой байлгасанд баярлалаа. Та гурвынхаа бэлэг авъяасыг биширье.

Крис Пэйст: Гар бичмэлийг маань бүлэг, бүлгээр нь уншихдаа, тасралтгүй урамшуулж байсанд баярлалаа. Мөн 14-ээр бүлэг дээр туслаж, үнэлэшгүй хувь нэмрээ оруулсанд баярласан шүү.

Аддисон Бивэрт: Хүүгийн минь хянан тохиолдуулах ур чадвар, нэгийг бодогдуулсан асуултын ачаар ном маань илүү оновчтой болж, чанаржжээ. Гэхдээ үүнээс чухал нь аавдаа урам хайрладаг, итгэмжтэй хүү байдагт баярлалаа.

Аллан Нугренд: Номын маань загвар, хавтсыг шилдэг урлаж өгсөнд баярлалаа. Бэлэг авъяасыг чинь биширье!

Мессенжер Интернэйшнэл багийнхандаа: Та нар минь Бурханы хаанчлалыг байгуулах гэж нүднээс далдуур мөн ч их хичээн ажилладаг. Бусдын төлөөх үйлчлэлийг чинь хожим Эзэн маань гараа гарган шагнахыг харахдаа, ханатлаа баярлая.

Бурханы Ариун Сүнсэнд: Хамгийн том талархлаа Тандаа өргөе! Таны удирдамж, цэц ухаангүйгээр энэ үг бүтэхгүй байсан. Миний Эзэн бөгөөд амь амьдралын маань хамгийн том хайр болох Есүс Христийн тухай ар араас нь ундруулан илчилдэгт баярлалаа. Би Тандаа хайртай. Тантай мөр зэрэгцэн үйлчлэх шиг хүндэтгэл үгүй.

Зүүвэр

1. Zodhiates, Spiros. *The Complete Word Study Dictionary: New Testament*. Chattanooga, TN: AMG Publishers, 2000.
2. Arndt, William, Frederick W. Danker, and Walter Bauer. *A Greek—English Lexicon of the New Testament and Other Early Christian Literature*. Chicago: University of Chicago Press, 2000.
3. Louw, Johannes P., and Eugene Albert Nida. *Greek—English Lexicon of the New Testament: Based on Semantic Domains*. New York: United Bible Societies, 1996.
4. Louw, Johannes P., and Eugene Albert Nida. *Greek—English Lexicon of the New Testament: Based on Semantic Domains*. New York: United Bible Societies, 1996.
5. Louw, Johannes P., and Eugene Albert Nida. *Greek—English Lexicon of the New Testament: Based on Semantic Domains*. New York: United Bible Societies, 1996, and Zodhiates, Spiros. *The Complete Word Study Dictionary: New Testament*. Chattanooga, TN: AMG Publishers, 2000.
6. Zodhiates, Spiros. *The Complete Word Study Dictionary: New Testament*. Chattanooga, TN: AMG Publishers, 2000.
7. Louw, Johannes P., and Eugene Albert Nida. *Greek—English Lexicon of the New Testament: Based on Semantic Domains*. New York: United Bible Societies, 1996.
8. Zodhiates, Spiros. *The Complete Word Study Dictionary: New Testament*. Chattanooga, TN: AMG Publishers, 2000.
9. Louw, Johannes P., and Eugene Albert Nida. *Greek—English Lexicon of the New Testament: Based on Semantic Domains*. New York: United Bible Societies, 1996.
10. Louw, Johannes P., and Eugene Albert Nida. *Greek—English Lexicon of the New Testament: Based on Semantic Domains*. New York: United Bible Societies, 1996.
11. “Enthusiasm.” Merriam-Webster.com. Accessed March 18, 2020. <https://www.merriam-webster.com/dictionary/enthusiasm>.
12. “Breakthrough.” Dictionary.com. Accessed May 5, 2020. <https://www.dictionary.com/browse/breakthrough>.
13. Baker, Warren, and Eugene E. Carpenter. *The Complete Word Study Dictionary: Old Testament*. Chattanooga, TN: AMG Publishers, 2003.
14. Zodhiates, Spiros. *The Complete Word Study Dictionary: New Testament*. Chattanooga, TN: AMG Publishers, 2000.

15. <https://www.barna.com/research/digital-babylon/>. Accessed January 10, 2020.
16. Zodhiates, Spiros. *The Complete Word Study Dictionary: New Testament*. Chattanooga, TN: AMG Publishers, 2000.
17. Louw, Johannes P., and Eugene Albert Nida. *Greek—English Lexicon of the New Testament: Based on Semantic Domains*. New York: United Bible Societies, 1996.
18. Myles Munroe, *Maximizing Your Potential* Expanded Edition, Kindle. Shippensburg, PA: Destiny Image, 2013, 145.
19. Zodhiates, Spiros. *The Complete Word Study Dictionary: New Testament*. Chattanooga, TN: AMG Publishers, 2000.
20. Arndt, William, Frederick W. Danker, Walter Bauer, and F. Wilbur Gingrich. *A Greek—English Lexicon of the New Testament and Other Early Christian Literature*. Chicago: University of Chicago Press, 2000.
21. Anders Ericsson, Peak: *Secrets from the New Science of Expertise*. New York: Houghton Mifflin Harcourt, 2016, 22.
22. “Cultivate.” Dictionary.com. Accessed February 1, 2020. [https:// www. dictionary.com/browse/cultivate](https://www.dictionary.com/browse/cultivate).
23. Zodhiates, Spiros. *The Complete Word Study Dictionary: New Testament*. Chattanooga, TN: AMG Publishers, 2000.
24. Louw, Johannes P., and Eugene Albert Nida. *Greek—English Lexicon of the New Testament: Based on Semantic Domains*. New York: United Bible Societies, 1996.

ӨНӨ МӨНХӨӨР ХӨТЛӨГДӨХҮЙ

*Өнөөдөр ч, үүрд мөнхөд ч
үнэ цэнэтэй байх амьдрал*



Энэ амьдралын нөгөө талд юу ч байхгүй гэж хүмүүс боддог. Гэтэл Бичээс “Хүн энэ ертөнцөд хэрхэн амьдарснаараа нөгөө ертөнцөд хэрхэн амьдрахаа шийднэ” гэх. Энд л хэрхэн амьдарснаараа, тэнд авах шагнал, шийтгэлээ шийдүүлнэ.

Жон Бивэр бидэнд 2Коринт 5:9-11 дээрх зарчмыг сануулаад, хүн бүр Христийн өмнө үйлсийнхээ дагуу шүүгдэж, олон хүн мөнх насгүй зүйлд хамаг амьдралаа зориулсанаа ойлгоод цочирдохыг хэлжээ. Тэгвэл хүн яаж ач холбогдолтой амьдрах вэ? “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” ном таныг амьдралынхаа дуудлагыг олох, хүлээж авсан бүхнээ өсгөн үржүүлэх мөнхийн зарчимд сургаж, өөрийгөө өнө мөнхөд үнэлэгдэх ажилд зориулахад чинь чиглүүлнэ.

Татаж аваарай:  MessengerX.com

АФФАБЕЛ

Өнө мөнх рүү өнгийх цонх
(Сонсдог жүжиг)



“Аффабел” нь Жон Бивэрийн бичсэн сонсдог жүжиг юм. Үүнд энэ дэлхийн амьдралаас цаашхи бодит амьдралыг өгүүлэх бөгөөд үүгээр Бурханы хаанчлалын олон үнэнийг тусган харуулдаг. Итгэгч хүмүүс өнө мөнхийн хараатай амьдрах ёстой ч, олон хүн өнө мөнх гэж юу болохыг ч мэддэггүй.

Энд та Аугаа хаан Жэйлинтэй, харанхуйн хар санаат эзэн Дагонтай, Өгөөмөр, Бие даагч тэргүүтэй гол дүүрдтэй, Аффабел хэмээх ер бусын нутагтай бас Ганц хэмээх аймшигт хөсөр газартай танилцаарай. Гол дүүрүүдийн амьдралаар дамжин зүрхний чинь үнэн төрх илчлэгдэх үед та өөрийнхөө амьдралын талаар нэгийг бодох буй за. “Аффабел” сонсдог жүжиг нь сонсогчийг нэгэнт ухааруулахын төлөө бүтээгдсэн “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” номын жүжигчилсэн хэлбэр болно.

Татаж аваарай:  [MessengerX.com](https://messengerx.com)

САТАНЫ УРХИ

*Өстөн дайсныхаа үхлийн занганаас
эрх чөлөөтэй амьдар*



“Сатаны урхи” ном нь ерөөсөө л гомдлын талаар өгүүлнэ. Гомдол нь итгэгч хүмүүсийг Бурханы хүслээс гаргахдаа тогтмол ашигладаг, дайсны хайртай урхи ажээ. Олон хүн энэ урхинд мэдээгүй явж орчихоод, орсон хойноо ч мэддэггүй.

Хүн энэ дэлхий дээр байгаа цагтаа гомдлоос дархлаатай оршиж чадахгүй ч, гомдох эс гомдохоо сонгож чадна. Гомдлыг шийдвэрлэсэн хүн л хорслыг даваад, улам хүчирхэгжиж, Бурхантай саадгүй харилцана.

Хорсол, бухимдал, хар сэр, үл итгэлцлээс чөлөөлөгдөж, Бурханы хүсэл дор алхлан, амьдралаа Бурханд бүрэн даатгаж, уучлал, эвлэрэл, баяр хөөрөөр дүүрэн амьдрахын нууцыг эндээс сураарай.

Татаж аваарай:  MessengerX.com

САТАНЫ УРХИ

*Өстөн дайсныхаа үхлийн занганаас
эрх чөлөөтэй амьдар
(Монгол бичгээр)*



“Мараната” үйлчлэл Өвөр Монгол дахь Христийн чуулганы итгэгч хүмүүсийг итгэлд бэхжүүлэхийн төлөө мөн Монгол бичгээр унших хүсэлтэй бүх хүнд зориулж зохиолч Жон Бивэрийн Монгол хэл дээрх (кирилл бичиг дээрх) номуудыг Монгол бичиг дээр хөрвүүлэн буулгаж байгаа бөгөөд анхны бүтээл болох “Сатаны урхи” номоо та бүхэнд өргөн барьж байна.

Энэ номыг CloudLibrary.org хаяг дорх “Монгол бичиг” гэсэн хэсгийг сонгоод, үнэ төлбөргүй татаж авна уу. Монгол чуулганы энэ бэлэгийг Өвөр Монгол дахь Христийн итгэл нэгт ах, эгч дүүдээ болоод Монгол бичигт нэвтэрсэн бүх хүнд түгээн дэлгэрүүлээрэй!

Татаж аваарай:  MessengerX.com

САЙНЫГ УУ, БУРХАНЫГ УУ?

Бурхангүй “сайн” сайн биш байдгийн учир



Сайн л бол, Бурханаас байх учиртай. Тийм үү? Өнөөдөр “сайн” хийгээд “Бурхан” гэдэг хоёр үгийг ижил утгатай үгс шиг хэрэглэх болжээ. Бид “сайн” гэж үздэг зүйлсээ Бурханы хүсэлтэй төгс эгнэх учиртай гэж итгэдэг. Өгөөмөр, даруу, шударга зан чанар нь сайн юмс. Амиа хоохойлох, тоомжиргүй зан, харгислал нь муу юмс. Ядах юмгүй ялгачихмаар харагдаж байна. Гэхдээ ингээд л боллоо юу? Сайныг ялгахад тийм амархан юм бол, Библи яагаад сайн, мууг ялгах хараатай бай гэж хэлсэн юм бол?

Энэ ном нь бас л нэгэн төрлийн хувь хүний хөгжлийн гарын авлага биш юм. Энэ ном танаас зүгээр нэг сайн сайхан, зөв хүн болохыг шаардахгүй. Энэ ном таны Бурхантай тогтоосон харилцааг хэзээ ч байгаагүй өндөрлөгт гаргаж, амьдралыг чинь эд эсээр нь ширхэглэн сэгсэрч, үндсээр нь эргүүлнэ.

Татаж аваарай:  MessengerX.com

ГЭРЛЭЛТИЙН ТҮҮХ

Гэрлэлтээ авар



Эртээ урьдын цагт... Гэрлэлт бол үүрд өнө зүйл. Энэ нь нэг эрэгтэй, нэг эмэгтэйг холбож зангиддаг гэрээ бүхий харилцаа юм. Энэ холбоо тэднийг бүтээгдсэн анхны зорилгоор нь хөглөж, хүчирхэгжүүлнэ. Тэд тусдаа биш, хамтдаа байхдаа л хүчтэй. Харин энэ бүхний эхлэл нь хурим юм. Хурим нь амар сайхандаа жаргахын төлөө амьдралын босгыг давж буй, ариун нандин үйл явдал болой. Энэ амьдралын төлөөх сонголт бүр, үйлс бүр чухал. Зүрхээрээ нийлж, гараараа хөтлөлцсөн нөхөр, эхнэр хоёр тааж мэдэшгүй ирээдүйг чиглэн Бүтээгчийн хайраар амьдралаа сүндэрлүүлнэ.

Гэтэл бид энэ хайрын түүхээс хагацжээ. Тэгвэл “Гэрлэлтийн түүх” номоороо Жон, Лиза хоёр гэрлэлтэд хандсан Бурханы анхны төлөвлөгөөг дэлгэж байна. Та гэрлэсэн байна уу, гэрлэж амжаагүй байна уу, сүй тавьсан байна уу – Бурханы их хайрын түүхийн нэгээхэн хэсэг мөн болой.

Татаж аваарай:



MessengerX.com

АРИУН СҮНС

Түүнтэй танилцахуй



Анхны дагалдагч нар Есүстэй 3 жил хамт байж, Түүний заасан бүхнийг сонсож байсан. Харин загалмайд цовдлогдохынхоо өмнө Есүс: “Би явж Ариун Сүнс ирэх нь та нарт илүү дээр юм” гэжээ. Хэрэв Есүстэй өдөр бүр байсан дагалдагч нарт Ариун Сүнс амин хэрэгтэй байсан юм бол, бидэнд бүр их хэрэгтэй бус уу?

Жон Бивэр танд Ариун Сүнснийг танилцуулж, Ариун Сүнсний мөн чанар, хүч чадлыг заажээ. Таны итгэлийн төлөвшил ямар ч төвшинд байсан “Ариун Сүнс: Түүнтэй танилцахуй” ном танд Бурханыг улам ихээр дотно танин мэдүүлнэ.

СЭЛЭМТЭЙ ОХИД

Загалмайгаа жинхэнэ баатар шиг үүрье



Бурханы Үг болох илдний тухай судлах нь илдийг сугалж хэрэглэхээс амархан бөгөөд таатай байдаг. Охид бид тэнгэрийг газартай холбох цаг болжээ. Дэлхий даяар эмэгтэйчүүд алив гадуурхал, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлийн бай болсоор байна.

Лиза Бивэр энэ номдоо эмэгтэйчүүдийн өнгөрснийг биш, харин ирээдүйг өгүүлжээ.

Тиймд Бурханы дайчин охид оо, эр зоригтойгоор босоод, ялгах чадвараа ашиглан, уучилж, мэргэн байж, сэлмээ эргүүлэн баатарлаг үйлсийг бүтээгээрэй.

Татаж аваарай:  MessengerX.com

КРИПТОНИТЫГ УСТГА

Хүчийг чинь сорогч зүйлийг устга



Супермэнд дайснаа дарах ер бусын хүч байдаг шиг, Христийн дагалдагч бидэнд ч тийм нэгэн хүч бий. Гэвч криптонит гэгч нэгэн бодис Супермэний хүчийг ч, дагалдагч бидний хүчийг ч ховх сордог. Мэдээж Супермэн, криптонит хоёр зохиомол зүйлс боловч, сүнсний криптонит нь жинхэнэ зүйл юм.

Анхны чуулганы итгэгч нарт байсан тэнгэрийн хүч яагаад өнөөгийн бидэнд байхгүй байгааг энэ ном тайлбарлана. Түүнчлэн криптонит гэж юу болох, яаж үйлчилдэг болох бас үүнийг хэрхэн устгахыг зааж өгнө.

Энэ номыг амьдралаа жинхэнээсээ өөрчлөх хүсэлтэй Христийн дагалдагч нарт зориулав. Уншсан шиг уншаарай!

БУРХАН МИНЬ, ТА ХААНА БАЙНА?!

Цөл дунд зорилготой бөгөөд хүчтэй байх



Өмнө нь Бурхан ярьдаг байснаа одоо таг дуугүй болжээ. Өмнө нь та итгэлээр явдаг байсан бол, одоо Бурханы оршихуй бараа сураггүй болжээ. Тэгвэл Бурханаас амлалт хүлээж аваад, энэ амлалт биелэхийг харах хоёрын дунд оршдог дамжин өнгөрөхөд тавтай морил.

Гэхдээ энэ нь ямар ч зорилгогүй хөсөр газар биш юм. Бурхан цөлөөр дамжуулан биднийг хувь тавиланд маань бэлтгэн, боловсруулдаг - гэхдээ ганцхүү та зөв хариу үйлдсэн тохиолдолд шүү. Олон хүний боддог шиг - энэ улирлаар туулах нь зүгээр л Бурханыг хүлээгээд суух явдал биш юм. Цөл дундуур жолоогоо зөв залахад таны үүрэг оройл их. Морин тойруулгаар эргэлдэж цагаа гарздах гээгүй л юм бол, цөлийг мэддэг байх хэрэгтэй.

Нүд тайлсан энэхүү номоороо бестселлер зохиолч Жон Бивэр таныг хуурай, бэрх улиралдаа жолоогоо зөв залсаар, Бурханы зэхсэн бүхэнд нэвтрэхэд чинь туслах Библийн түлхүүр болсон ухаарал, гүн түүхээр өсгөн боловсруулж байна.

Татаж аваарай:  MessengerX.com



МЕССЕНЖЕР ИНТЕРНЭЙШНЭЛ нь Бурханы өөрчлөгч хүчийг хувь хүн, гэр бүл, чуулган, үндэстэнд ухааруулж, бодитоор харахад нь туслах зорилготой байгууллага болно. Энэ ухаарал нь хүчирхэгжсэн амьдрал, өөрчлөгдсөн нийгэм, дэлхий дээрх шударга бус зүйлст хариу барих эрч хүчтэй үйлсийг дагуулдаг.





[MessengerX.com](https://messengerx.com)



Бүх төрлийн төхөөрөмж дээр үзэх, унших, сонсох боломжтой цахим ном, сонсдог ном, богино хэмжээний кино, видео сургаал, библи зэрэг дагалдагч бэлтгэхэд нэн шаардлагатай бүх материалыг Messenger сангаас хүлээн авна уу.

MessengerX app

гар утас, таблетдаа татаж авах заавар



1 iPhone, iPad дээрээ **AppStore**-аас апп-ыг татаж авна.

Хэрэв Андроид утастай бол **Google Play Store** -аас апп-ыг татаж авна.

2 Апп-ад бүртгүүлж, Монгол хэлээ сонгосноор Жон Бивэр, Лиза Бивэрийн Монгол хэл дээрх бүх ном, сонсдог ном, видео хичээлийг үзэх боломжтой.

3 Та хүссэн материалгаа утсандаа татаж аваад интернэтгүй орчинд ч унших, үзэх, сонсох боломжтой. Мөн найз нөхөддөө шэйрлэх боломжтой.

MessengerX.com

цахим хуудаснаас 110+ улсын хэл дээрх Жон Бивэр, Лиза Бивэрийн материалыг үзэх боломжтой.



App Store is a trademark of Apple Inc., registered in the U.S. and other countries. Google Play and the Google Play logo are trademarks of Google LLC.

Х: Бурханаас хүлээж авсан хүчин чадлаа үржүүл цогт сургалтын материал

Таны уншиж байгаа ном нь Жон Бивэрийн бичсэн “Х: Бурханаас хүлээж авсан хүчин чадлаа үржүүл” цогц сургалтын материалын нэг хэсэг юм. Номоо уншиж, **MessengerX.com** болон **MessengerX app** -ыг гар утас, таблетдаа татаж авснаар дараах чухал материалыг интернэттэй орчинд болон гар утсандаа татаж аваад интернэтгүй орчинд ч үзэх, сонсох, унших боломжтой юм.

“Х: Бурханаас хүлээж авсан хүчин чадлаа үржүүл” цогц сургалтын материалд дараах зүйлс багтсан болно:



“Х: Бурханаас хүлээж авсан хүчин чадлаа үржүүл” ном

Цаасан хэвлэл бүхий ном

PDF цахим ном



“Х: Бурханаас хүлээж авсан хүчин чадлаа үржүүл” видео

MessengerX.com болон **MessengerX app** -ыг гар утас, таблетдаа татаж авснаар дараах чухал материалыг интернэттэй орчинд болон гар утсандаа татаж аваад интернэтгүй орчинд ч үзэх, сонсох, унших боломжтой юм.



“Х: Бурханаас хүлээж авсан хүчин чадлаа үржүүл” сонсдог

ном

Монгол хэл дээр уншигдсан, MP3 форматтай, 15 бүлэг бүхий ном болно.



“Х: Бурханаас хүлээж авсан хүчин чадлаа үржүүл” видео

сургаал

MP4 форматаар бичсэн, 12 бүлэг бүхий видео хичээл.

— Нэмэлт материал

MessengerX.com болон **MessengerX app** -ыг гар утас, таблетдаа татаж авснаар дараах чухал материалыг интернэттэй орчинд болон гар утсандаа татаж аваад интернэтгүй орчинд ч үзэх, сонсох, унших боломжтой юм.


Татаж аваарай:



MessengerX.com

X MessengerX

Газар газрын хүн бүрт зориулсан дагалдагчийн аян




- 110 гаруй хэл дээр үнэ төлбөргүй үзэх боломжтой.
- App хэлбэрээр ч, онлайн хэлбэрээр ч хэрэглэх боломжтой.
- Таны өсөлт төлөвшилд зориулагдсан материал.
- Өөрийн түүх, дагалдагчийн аяныг хянах боломжтой.



Бүх төрлийн төхөөрөмж дээр үзэх, унших, сонсох боломжтой цахим ном, сонсдог ном, богино хэмжээний кино, видео сургаал, Библи зэрэг дагалдагч бэлтгэхэд нэн шаардлагатай бүх материалыг Messenger сангаас хүлээн авна уу.

MessengerX.com



Дэлхий даяар App Store болоод Google Play дээр үзэх боломжтой.

“ЮУГАА Ч ХАРАМЛАЛГҮЙ, ӨӨРСДИЙГӨӨ БУРХАНД БУЦААЖ БҮРЭН ЮҮЛЭЭД, ҮХЭХДЭЭ ХООСОН ҮХЭЦГЭЭЕ ... ИНГЭСЭН ЦАГТ Л БИД ЖИНХЭНЭ АМЬД БАЙЖ, БҮРЭН ДҮҮРЭН АМЬДАРНА.”


– ЖОН БИВЭР

Та өөрөө өөртөө Бурханы хаанчлал дотор үзэгч шиг л байгаа юм шиг санагддаг уу? Магадгүй танд нэг зүйл хийх ёстой юм шиг санагдаад байгаа хэрнээ чухам юу гэдгийг нь зааж хэлж мэдэхгүй байна уу? Хүмүүс бүгдээрээ л том амьдрахыг хүсдэг ч, дараах асуудлуудтай зөрчилддөг:

- Надад хандсан Бурханы хүслийг алдаагүй гэдэгтээ би яаж баталгаатай байх вэ?
- Бурханы хаанчлалын бүтээн байгуулалтад миний онцгой бэлэг ямар үүрэгтэй вэ?
- Би Бурханы өгсөн хүчин чадал дотор амьдарч чадаж байгаа гэдэгтээ яаж баталгаатай байх вэ?
- Би “үйлчлэгч” биш. Тэгэхээр, миний дуудлага чухал бус гэсэн үг үү?
- Хэрхэн нэгэн зэрэг Бурханы хаанчлалын төлөө дорвитой ажиллаж, Бурханы нигүүлсэл дотор амрах вэ?
- Тодорхойгүй, эрсдэлтэй санагдах үед хэрхэн айдсыг эвдэж, давшсаар байх вэ?

Шилдэг борлуулалттай номын зохиолч Жон Бивэр энэхүү чухал номоороо Бичээсийг нягт нарийн судлангаа, танд дуудлагаа өөрөөр үзэж, дуудлага чинь ямар учраас Бурханд чухал байдгийг ойлгуулах үүднээс хүчирхэг, хүчирхэг түүх өгүүлжээ. Та номынхоо хуудсыг эргүүлэхдээ, Бурханаас өгөгдсөн бэлгийг үржүүлэх хүч чадлаар цэнэглэгдэж, өөрийнхөө хүчин чадал руу нэвтэрч орно.

Үлбэгэр байдлаа том зорилгоор сольмоор байвал, аян зам чинь эндээс эхэлж байна.



Олон улсын номлогч, шилдэг борлуулалттай номын зохиолч **ЖОН БИВЭР** маань Бурханы Үгийг ямар ч найраагүй, зоригтой заадаг билээ. Жон гэргий Лизатайгаа дэлхийг өөрчлөгч Христийн үнэнч дагалдагч нарыг хөгжүүлэх зорилготой Мессенжер Интернэйшнэл байгууллагыг үүсгэн байгуулсан болно. Харин тэрбээр Колорадо дахь гэртээ байхдаа гэр бүлтэйгээ өрсөлдөөнтэй картан тоглоом тоглож, Лизаг гольф руу урвуулах гэж оролддог.



Үнэ төлбөргүй материал, видео дамжуулалтыг
MessengerX.com хаягаас хүлээн авна уу.

MessengerX



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

Энэхүү ном нь Зохиолчийн бэлэг бөгөөд ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.

Илүүг эндээс

